

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ
2025 ОНЫ НАМРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН



УЛСЫН ИХ ХУРЛЫН
ТАМГЫН ГАЗАР

2025 ОНЫ 12 ДУГААР САРЫН 25-НЫ ӨДӨР, ПҮРЭВ ГАРАГ

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ
НЭГДСЭН ХУРАЛДААН

ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ГАЗАР

Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дээрх
QR кодыг уншуулан танилцах боломжтой.

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
2025 ОНЫ НАМРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАНЫ
12 ДУГААР САРЫН 25-НЫ ӨДӨР /ПҮРЭВ ГАРАГ/-ИЙН
НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН
АГУУЛГА**

2025 оны 12 дугаар сарын 25-ны өдөр, Пүрэв гараг

<i>Хуралдааны тэмдэглэлийн агуулга</i>	
<i>Хуралдааны товч тэмдэглэл:</i>	1 – 9
<i>Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:</i>	10 – 249
1. <i>“Төрийн өмчит хуулийн этгээдийн хувьцааг 2026-2028 онд биржээр олон нийтэд нээлттэй худалдах, төрийн өмчийг хувьчлах, өөрчлөн байгуулах үндсэн чиглэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Засгийн газар 2025.12.18-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/</i>	11 – 116
2. <i>Монгол Улс болон Европын сэргээн босголт, хөгжлийн банк хоорондын Зээлийн хэлэлцээр соёрхон батлах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2025.12.18-ны өдөр өргөн мэдүүлсэн, соёрхон батлах/</i>	116 – 133
3. <i>Монгол Улс болон Азийн хөгжлийн банк хоорондын Санхүүжилтийн ерөнхий хөтөлбөр соёрхон батлах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2025.12.18-ны өдөр өргөн мэдүүлсэн, соёрхон батлах/</i>	133 – 157
4. <i>“Засгийн газарт чиглэл өгөх тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл</i>	157 – 173
5. <i>Төлбөрийн чадваргүйдлийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2025.05.27-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/</i>	173 – 204
6. <i>Хянан шалгах түр хорооны тайлан, санал, дүгнэлт, Улсын Их Хурлын тогтоолын төсөл /үргэлжилнэ/</i>	205 – 249

**Монгол Улсын Их Хурлын 2025 оны намрын ээлжит чуулганы
12 дугаар сарын 25-ны өдөр /Пүрэв гараг/-ийн нэгдсэн
хуралдааны товч тэмдэглэл**

Улсын Их Хурлын дарга Н.Учрал ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 126 гишүүнээс 64 гишүүн хүрэлцэн ирж, 57.9 хувийн ирцтэйгээр хуралдаан 10 цаг 11 минутад Төрийн ордны “Их хуралдай” танхимд эхлэв.

Томилолттой: О.Амгаланбаатар, М.Бадамсүрэн, Д.Батбаяр, Ж.Баясгалан, Ш.Бямбасүрэн, Т.Доржханд, П.Мөнхтулга, Ц.Туваан;

Чөлөөтэй: О.Алтангэрэл, Д.Амарбаясгалан, С.Амарсайхан, Х.Баттулга, П.Батчимэг, Б.Баярбаатар, П.Наранбаяр, М.Нарантуяа-Нара, Ч.Номин, Л.Оюун-Эрдэнэ, Б.Пунсалмаа, Д.Энхтүвшин;

Эмнэлгийн чөлөөтэй: Ц.Баатархүү, Д.Батлут, Х.Болормаа, Х.Булгантуяа, Л.Гантөмөр, С.Лүндэг, Б.Мөнхсоёл, Б.Түвшин, Б.Чойжилсүрэн, Р.Эрдэнэбүрэн;

Тасалсан: М.Мандхай;

Хоцорсон: Ч.Анар – 29 минут, Х.Баасанжаргал – 03 минут, Э.Батшугар – 09 минут, Ж.Баярмаа – 3 цаг 43 минут, Э.Болормаа – 2 цаг 54 минут, Г.Ганбаатар – 40 минут, Д.Ганбат – 39 минут, П.Ганзориг – 01 минут, М.Ганхүлэг – 06 минут, Б.Жавхлан – 2 цаг, Х.Жангабыл – 05 минут, Б.Жаргалан – 5 цаг 59 минут, Б.Заяабал – 1 цаг 18 минут, Ж.Золжаргал – 06 минут, Г.Лувсанжамц – 20 минут, Ц.Мөнхтуяа – 49 минут, З.Мэндсайхан – 2 цаг 58 минут, Н.Наранбаатар – 2 цаг 54 минут, А.Ундраа – 32 минут, Н.Учрал – 03 минут, Г.Уянгахишиг – 37 минут, Д.Цогтбаатар – 7 цаг 32 минут.

Нэг. “Төрийн өмчит хуулийн этгээдийн хувьцааг 2026-2028 онд биржээр олон нийтэд нээлттэй худалдах, төрийн өмчийг хувьчлах, өөрчлөн байгуулах үндсэн чиглэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Засгийн газар 2025.12.18-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга С.Бямбацогт, Улсын Их Хурлын гишүүн, Сангийн сайд Б.Жавхлан, Улсын Их Хурлын гишүүн, Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд Г.Дамдинням, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын салбарын бодлого зохицуулалтын газрын дарга Ш.Мөнхцэрэн, Зам, тээврийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Б.Насантогтох, Эрчим хүчний яамны Төрийн нарийн бичгийн дарга Б.Ерөн-Өлзий, Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамны Төрийн нарийн бичгийн дарга Б.Мягмарнаран, Сангийн яамны Санхүүгийн бодлогын газрын Хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга Ш.Бат-Эрдэнэ, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын дарга Б.Цэнгэл, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын Төрийн өмчийн удирдлага, зохицуулалтын хэлтсийн дарга Ц.Баяр-Эрдэнэ, Санхүүгийн зохицуулах хорооны Үнэт цаасны газрын дарга Б.Дөлгөөн, Эрчим хүчний яамны Эрчим хүчний бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Д.Батзориг,

Эрчим хүчний яамны Стратеги, төлөвлөлтийн хэлтсийн дарга Г.Энхтүвшин, Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын зөвлөх П.Тамир, “Эрдэнэс Монгол” ХХК-ийн Гүйцэтгэх захирал Б.Даваадалай, “Эрдэнэс Монгол” ХХК-ийн нэгдлийн Хууль, эрх зүйн зөвлөлийн зохицуулагч Б.Гэрлээ, “Эрчист Монгол” ХХК-ийн Стратеги, бизнес хөгжлийн газрын захирал Ж.Мөнхсайхан, “Эрдэнэт үйлдвэр” төрийн өмчит үйлдвэрийн газрын Ерөнхий захирал Г.Ёндон, “Эрдэнэт үйлдвэр” төрийн өмчит үйлдвэрийн газрын Санхүүгийн албаны дарга Р.Очбадрах, “Монголын Хөрөнгийн Бирж” ХК-ийн гүйцэтгэх захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгч Д.Мөнхбат, “МИАТ” төрийн өмчит хувьцаат компанийн Гүйцэтгэх захирал Т.Тэлмэн, “МИАТ” төрийн өмчит хувьцаат компанийн Санхүү, удирдлагын газрын захирал Н.Цэгц, “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн Гүйцэтгэх захирлын үүрэг гүйцэтгэгч Н.Цэрэнсамбуу, “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн Стратеги төлөвлөлт, төслийн газрын дарга Ц.Анх-Од, “Цемент шохой” төрийн өмчит хувьцаат компанийн Стратеги төлөвлөлт, бизнес хөгжлийн газрын дарга Н.Ганхуяг, “Үндэсний давхар даатгал” ХК-ийн Гүйцэтгэх захирал Б.Жавхлант, “Монголын цахилгаан холбоо” ХК-ийн Гүйцэтгэх захирал Б.Чинбат, Төрийн банкны Бизнес хариуцсан гүйцэтгэх захирлын Тэргүүн орлогч Д.Сугар, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын Удирдлага, төлөөллийн албаны дарга В.Дарханбаатар, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Салбарын бодлого, зохицуулалтын газрын ахлах референт Д.Нямдэлгэр нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга Л.Өлзийсайхан, Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга П.Батбаатар, Хуулийн газрын дарга Ч.Дондогмаа, Байнгын хороодын асуудал эрхлэх газрын Эдийн засгийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Д.Мягмарцэрэн, зөвлөх Б.Нандингэрэл, М.Мандхай, Хяналт шалгалтгын газрын ахлах зөвлөх Ч.Онончимэг нар байлцав.

Хууль санаачлагчийн илтгэлийг Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга С.Бямбацогт, төслийн талаарх Эдийн засгийн байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Д.Үүрийнтуяа нар танилцуулав.

Хууль санаачлагчийн илтгэл болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдорж, Ө.Шижир, О.Цогтгэрэл, Б.Найдалаа, Б.Хэрлэн, Н.Алтаншагай, О.Номинчимэг, Л.Мөнхбаясгалан, П.Сайнзориг, Ж.Ганбаатар, Ц.Сандаг-Очир, С.Эрдэнэбат, С.Зулпхар, Да.Цогтбаатар нарын тавьсан асуултад Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга С.Бямбацогт, Улсын Их Хурлын гишүүн, Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд Г.Дамдинням, Эрчим хүчний яамны Төрийн нарийн бичгийн дарга Б.Ерөн-Өлзий, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын дарга Б.Цэнгэл, Санхүүгийн зохицуулах хорооны Үнэт цаасны газрын дарга Б.Дөлгөөн, “Монголын Хөрөнгийн Бирж” ХК-ийн гүйцэтгэх захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгч Д.Мөнхбат, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын Төрийн өмчийн удирдлага, зохицуулалтын хэлтсийн дарга Ц.Баяр-Эрдэнэ, “Цемент шохой” төрийн өмчит хувьцаат компанийн Стратеги төлөвлөлт, бизнес хөгжлийн газрын дарга Н.Ганхуяг, “Эрдэнэт үйлдвэр” төрийн өмчит үйлдвэрийн газрын Ерөнхий захирал

Г.Ёндон, “Монголын цахилгаан холбоо” ХК-ийн Гүйцэтгэх захирал Б.Чинбат, “МИАТ” төрийн өмчит хувьцаат компанийн Гүйцэтгэх захирал Т.Тэлмэн, Төрийн банкны Бизнес хариуцсан гүйцэтгэх захирлын Тэргүүн орлогч Д.Сугар нар хариулж, тайлбар хийв.

Үдээс өмнөх хуралдаан 2 цаг 54 минут үргэлжилж, 13 цаг 05 минутад завсарлав.

Үдээс хойших хуралдаан 14 цаг 07 минутад эхлэв.

“Төрийн өмчит хуулийн этгээдийн хувьцааг 2026-2028 онд биржээр олон нийтэд нээлттэй худалдах, төрийн өмчийг хувьчлах, өөрчлөн байгуулах үндсэн чиглэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн хэлэлцэх эсэх асуудлыг үргэлжлүүлэн хэлэлцэв.

Хууль санаачлагчийн илтгэл болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ж.Галбадрах, Д.Энхтуяа, Ц.Мөнхтуяа, Х.Баасанжаргал, Ч.Анар, Г.Ганбаатар нарын тавьсан асуултад Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга С.Бямбацогт, Сангийн сайд Б.Жавхлан, “МИАТ” төрийн өмчит хувьцаат компанийн Гүйцэтгэх захирал Т.Тэлмэн нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Б.Бат-Эрдэнэ, Л.Энх-Амгалан, С.Цэнгүүн нар үг хэлэв.

Н.Учрал: “Төрийн өмчит хуулийн этгээдийн хувьцааг 2026-2028 онд биржээр олон нийтэд нээлттэй худалдах, төрийн өмчийг хувьчлах, өөрчлөн байгуулах үндсэн чиглэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалтыг явуулья.

Зөвшөөрсөн: 51
Татгалзсан: 42
Бүгд: 93
54.8 хувийн саналаар дэмжигдлээ.

“Төрийн өмчит хуулийн этгээдийн хувьцааг 2026-2028 онд биржээр олон нийтэд нээлттэй худалдах, төрийн өмчийг хувьчлах, өөрчлөн байгуулах үндсэн чиглэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг санал хураалтад оролцсон гишүүдийн олонх дэмжсэн тул төслийг анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Эдийн засгийн байнгын хороонд шилжүүлэв.

Уг асуудлыг 15 цаг 11 минутад хэлэлцэж дуусав.

Хоёр.Монгол Улс болон Европын сэргээн босголт, хөгжлийн банк хоорондын Зээлийн хэлэлцээр соёрхон батлах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2025.12.18-ны өдөр өргөн мэдүүлсэн, соёрхон батлах/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Сангийн сайд Б.Жавхлан, Улсын Их Хурлын гишүүн, Эрүүл мэндийн сайд Ж.Чинбүрэн, Сангийн яамны Санхүүгийн бодлогын газрын дарга С.Тулга, мөн яамны Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга Ж.Дэлгэржаргал, Санхүүгийн бодлогын газрын Өрийн удирдлагын хэлтсийн дарга Л.Гантогтох, Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын Хөгжлийн санхүүжилтийн хэлтсийн дарга Б.Ганзориг, Эрүүл мэндийн яамны Санхүү, эдийн засгийн бодлогын хэрэгжилтийн газрын Санхүү, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга Н.Хүрэлбаатар, Улсын гуравдугаар төв эмнэлгийн захирал Ц.Төмөр-Очир, Гуравдугаар төв эмнэлгийн Эмнэлзүй эрхэлсэн дэд захирал Б.Нандинцэцэг нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга Л.Өлзийсайхан, Улсын Их Хурлын Тамгын газрын Хуулийн газрын дарга Ч.Дондогмаа, Байнгын хороодын асуудал эрхлэх газрын Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Ш.Шишигсүрэн, зөвлөх С.Дунжидмаа, М.Отгон нар байлцав.

Хууль санаачлагчийн илтгэлийг Хот байгуулалт, орон сууцжуулалтын сайд Э.Бат-Амгалан, хуулийн төслийн талаарх Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Г.Очирбат нар танилцуулав.

Хууль санаачлагчийн илтгэл болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдорж, Ц.Мөнхбат, А.Ариунзаяа, С.Эрдэнэбат, Б.Бейсен, Д.Ганмаа нарын тавьсан асуултад Эрүүл мэндийн сайд Ж.Чинбүрэн, Сангийн яамны Санхүүгийн бодлогын газрын дарга С.Тулга нар хариулж, тайлбар хийв.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.12-т заасны дагуу хуулийн төслийн санал хураалтыг 2025 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн Баасан гарагт явуулахаар тогтов.

Уг асуудлыг 15 цаг 48 минутад хэлэлцэж дуусав.

Гурав.Монгол Улс болон Азийн хөгжлийн банк хоорондын Санхүүжилтийн ерөнхий хөтөлбөр соёрхон батлах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2025.12.18-ны өдөр өргөн мэдүүлсэн, соёрхон батлах/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Монгол Улсын Шадар сайд Х.Ганхуяг, Улсын Их Хурлын гишүүн, Сангийн сайд Б.Жавхлан, Улсын Их Хурлын гишүүн, Эрүүл мэндийн сайд Ж.Чинбүрэн, Сангийн дэд сайд Б.Хулан, Боловсролын яамны Төрийн нарийн бичгийн дарга

Х.Батжаргал, Сангийн яамны Санхүүгийн бодлогын газрын дарга С.Тулга, мөн яамны Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга Ж.Дэлгэржаргал, Өрийн удирдлагын хэлтсийн дарга Л.Гантогтох, Эрүүл мэндийн яамны Санхүү, эдийн засгийн бодлогын хэрэгжилтийн газрын Санхүү, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга Н.Хүрэлбаатар, Онцгой байдлын ерөнхий газрын дарга Г.Ариунбуян, Онцгой байдлын ерөнхий газрын Санхүү, ар талын газрын дарга Т.Мөнхдорж, Онцгой байдлын ерөнхий газрын Бодлого, төлөвлөлтийн газрын дарга Б.Баяннэмэх нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга Л.Өлзийсайхан, Улсын Их Хурлын Тамгын газрын Хуулийн газрын дарга Ч.Дондогмаа, Байнгын хороодын асуудал эрхлэх газрын Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Ш.Хишигсүрэн, зөвлөх С.Дунжидмаа, М.Отгон нар байлцав.

Хууль санаачлагчийн илтгэлийг Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Монгол Улсын Шадар сайд Х.Ганхуяг, хуулийн төслийн талаарх Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Г.Хосбаяр нар танилцуулав.

Хууль санаачлагчийн илтгэл болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ц.Идэрбат, Д.Бум-Очир, П.Сайнзориг, А.Ариунзаяа, Ж.Галбадрах, Г.Лувсанжамц, Э.Болормаа нарын тавьсан асуултад Эрүүл мэндийн сайд Ж.Чинбүрэн, Сангийн дэд сайд Б.Хулан, Боловсролын яамны Төрийн нарийн бичгийн дарга Х.Батжаргал нар хариулж, тайлбар хийв.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.12-т заасны дагуу хуулийн төслийн санал хураалтыг 2025 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн Баасан гарагт явуулахаар тогтов.

Уг асуудлыг 16 цаг 44 минутад хэлэлцэж дуусав.

Дөрөв. “Засгийн газарт чиглэл өгөх тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл

Хуралдаанд Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга Л.Өлзийсайхан, Улсын Их Хурлын Тамгын газрын Хуулийн газрын дарга Ч.Дондогмаа, Байнгын хороодын асуудал эрхлэх газрын Эдийн засгийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Д.Мягмарцэрэн, референт М.Мандхай, Х.Шижирмөнх нар байлцав.

Тогтоолын төслийн талаарх Эдийн засгийн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн М.Энхцэцэг танилцуулав.

Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзориг, С.Эрдэнэбат, Г.Очирбат нарын тавьсан Улсын Их Хурлын гишүүн М.Энхцэцэг хариулж, тайлбар хийв.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.12-т заасны дагуу хуулийн төслийн санал хураалтыг 2025 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн Баасан гарагт явуулахаар тогтов.

Уг асуудлыг 17 цаг 18 минутад хэлэлцэж дуусав.

Тав.Төлбөрийн чадваргүйдлийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2025.05.27-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Хууль зүй, дотоод хэргийн сайд Б.Энхбаяр, Хууль зүй, дотоод хэргийн дэд сайд Д.Мөнх-Эрдэнэ, Хууль зүй, дотоод хэргийн яамны Хууль зүйн бодлогын газрын дарга Я.Жавхлан, мөн газрын Хувийн эрх зүйн хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч О.Оюунзул, Монголбанкны Хууль, эрх зүйн газрын Банк, санхүүгийн хэлтсийн захирал Ө.Мөнх-Ундарга, Монголын өмгөөлөгчдийн холбооны гишүүн өмгөөлөгч Амгалангийн Энхболд нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга Л.Өлзийсайхан, Улсын Их Хурлын Тамгын газрын Хуулийн газрын дарга Ч.Дондогмаа, Байнгын хороодын асуудал эрхлэх газрын Хууль зүйн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Г.Золжаргал, зөвлөх Г.Алтанцэцэг, Д.Нямбаяр, Хяналт шалгалтгын газрын ахлах зөвлөх Ч.Онончимэг нар байлцав.

Хууль санаачлагчийн илтгэлийг Хууль зүй, дотоод хэргийн сайд Б.Энхбаяр, хуулийн төслийн талаарх Хууль зүйн байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн О.Номинчимэг нар танилцуулав.

Улсын Их Хурлын дэд дарга Б.Пүрэвдорж 14 цаг 03 минутаас хуралдааныг даргалав.

Хууль санаачлагчийн илтгэл болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдорж, Х.Тэмүүжин, О.Номинчимэг, П.Сайнзориг, Л.Соронзонболд, Д.Ганмаа, Х.Баасанжаргал нарын тавьсан асуултад Хууль зүй, дотоод хэргийн сайд Б.Энхбаяр, Хууль зүй, дотоод хэргийн дэд сайд Д.Мөнх-Эрдэнэ, Хууль зүй, дотоод хэргийн яамны Хууль зүйн бодлогын газрын Хувийн эрх зүйн хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч О.Оюунзул нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзориг үг хэлэв.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.12-т заасны дагуу хуулийн төслийн санал хураалтыг 2025 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн Баасан гарагт явуулахаар тогтов.

Уг асуудлыг 18 цаг 33 минутад хэлэлцэж дуусав.

Зургаа.Хянан шалгах түр хорооны тайлан, санал, дүгнэлт, Улсын Их Хурлын тогтоолын төсөл /үргэлжилнэ/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Сангийн яамны Санхүүгийн бодлогын газрын дарга С.Тулга, Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Уул уурхайн бодлогын газрын дарга Г.Намчинсүрэн, Монголбанкны Санхүүгийн зах зээлийн газрын захирал А.Энхжин, Хянан шалгах түр хорооноос томилогдсон хянан шалгагч И.Уянга, Х.Баярмаа, Б.Батчимэг, Ж.Наранпүрэв, Б.Батбаатар, С.Ганбаяр, Хянан шалгах түр хорооноос томилогдсон шинжээч М.Ихэртөр, Д.Бат-Эрдэнэ, Д.Доржнамжим, П.Хишигбаяр, А.Мөнхбадрал, О.Саруул, Э.Энэрэл, Ч.Бат-Эрдэнэ, С.Номин, С.Амарбат, Ц.Энхбаяр, Д.Хуланхүү нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга Л.Өлзийсайхан, Хуулийн газрын дарга Ч.Дондогмаа, Байнгын хороодын асуудал эрхлэх газрын Эдийн засгийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Д.Мягмарцэрэн, зөвлөх Б.Нандингэрэл, Хяналт шалгалтгын газрын дарга Ч.Онончимэг нар байлцав.

“Оюу Толгойн бүлэг ордын ашиглалтад Монгол Улсын эрх ашгийг хангуулах, хүртэх өгөөжийг нэмэгдүүлэх хүрээнд хийсэн тусгай шалгалт, нээлттэй сонсголын мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн талаарх Хянан шалгах түр хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн О.Батнайрамдал танилцуулав.

Улсын Их Хурлын дарга Н.Учрал 18 цаг 50 минутаас хуралдааныг даргалав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдорж, Ц.Идэрбат, Л.Мөнхбаясгалан, Б.Уянга, Ц.Сандаг-Очир, Л.Соронзонболд, С.Ганбаатар, С.Эрдэнэбат, О.Саранчулуун, Х.Баасанжаргал, Г.Лувсанжамц, Б.Жаргалан, С.Эрдэнэболд, У.Отгонбаяр, Ж.Батжаргал, С.Бямбацогт нарын тавьсан асуултад Улсын Их Хурлын гишүүн О.Батнайрамдал, Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Уул уурхайн бодлогын газрын дарга Г.Намчинсүрэн, Монголбанкны Санхүүгийн зах зээлийн газрын захирал А.Энхжин, Хянан шалгах түр хорооноос томилогдсон шинжээч Д.Бат-Эрдэнэ хариулж, тайлбар хийв.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.12-т заасны дагуу хуулийн төслийн санал хураалтыг 2025 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн Баасан гарагт явуулахаар тогтов.

Уг асуудлыг 20 цаг 23 минутад хэлэлцэж дуусав.

Чуулганы нэгдсэн хуралдаанаар 6 асуудал хэлэлцэв.

Бусад. Улсын Их Хурлын гишүүн Б.Заяабалын урилгаар Увс аймгийн Хөдөлмөр халамж, үйлчилгээний газрын албан хаагчид, Улсын Их Хурлын гишүүн

Д.Батбаяр, С.Эрдэнэболд нарын урилгаар Сэлэнгэ аймгийн Сүхбаатар сумын ерөнхий боловсролын сургуулийн 12-ын “б”, “в” ангийн багш, сурагчид, Улсын Их Хурлын гишүүн Ж.Энхбаярын урилгаар Шарын голын уурхайчид, “Буяны хөсөг” компанийн ажилчид, Улсын Их Хурлын гишүүн Б.Жавхлангийн урилгаар Дархан-Уул аймгийн ерөнхий боловсролын “Оюуны ирээдүй” сургуулийн 12 дугаар ангийн 1 дүгээр бүлгийн багш, сурагчид, Улсын Их Хурлын гишүүн Ж.Алдаржавхлангийн урилгаар Хан-Уул дүүргийн иргэд, Улсын Их Хурлын дарга Н.Учралын урилгаар Сүхбаатар дүүргийн 135 дугаар цэцэрлэгийн багш, ажилчид, бизнес эрхлэгч эмэгтэйчүүдийн төлөөлөл, Гадаад хэлний “Master Brain” сургалтын төвийн төгсөгч сурагчид, Улсын Их Хурлын гишүүн Х.Баттулгын урилгаар Орхон аймгийн Эрдэнэт хотын ерөнхий боловсролын сургуулийн 12-ын “д” ангийн багш, сурагчид Улсын Их Хурлын чуулганы үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцав.

Чуулганы нэгдсэн хуралдааны зохион байгуулалтыг Улсын Их Хурлын Тамгын газрын Чуулганы хуралдааны хэлтсийн дарга Н.Наранцогт, мөн хэлтсийн шинжээч Ш.Мөнхцоож, С.Энхзаяа, ахлах мэргэжилтэн С.Золжаргал нар хариуцан ажиллав.

Хуралдаан 5 цаг 58 минут үргэлжилж, ирвэл зохих 126 гишүүнээс 83 гишүүн ирж, 65.9 хувийн ирцтэйгээр 20 цаг 24 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:

ЕРӨНХИЙ НАРИЙН
БИЧГИЙН ДАРГА

Л.ӨЛЗИЙСАЙХАН

Тэмдэглэл хөтөлсөн:
ХУРАЛДААН ЗОХИОН
БАЙГУУЛАХ ГАЗРЫН
ШИНЖЭЭЧ

Ц.АЛТАН-ОД

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2025 оны 12 дугаар сарын 25-ны өдөр, Пүрэв гараг
Төрийн ордон “ИХ ХУРАЛДАЙ” танхим
10 цаг 11 минут

ЧУУЛГАНЫ НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Н.Учрал: Улсын Их Хурлын гишүүдийн өдрийн амгаланг айлтгаж мэндчилье.

73 гишүүн ирж 57.9 хувиар ирц бүрдсэн байна.

Улсын Их Хурлын 2025 оны намрын ээлжит чуулганы 12 дугаар сарын 25-ны өдрийн нэгдсэн хуралдаан нээснийг мэдэгдье. /алх цохив/

Чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя.

Өнөөдрийн хуралдаанаар дараах 6 асуудлыг хэлэлцэнэ.

Нэгдүгээрт, “Төрийн өмчит хуулийн этгээдийн хувьцааг 2026-2028 онд биржээр олон нийтэд нээлттэй худалдах, төрийн өмчийг хувьчлах, өөрчлөн байгуулах үндсэн чиглэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг явуулна.

Хоёрдугаарт, Монгол Улс болон Европын Сэргээн Босголт, Хөгжлийн Банк хоорондын зээлийн хэлэлцээр соёрхон батлах тухай хуулийн төслийг хэлэлцэнэ.

Гуравдугаарт, Монгол Улс болон Азийн хөгжлийн банк хоорондын санхүүжилтийн ерөнхий хөтөлбөр соёрхон батлах тухай хуулийн төслийг хэлэлцэнэ.

Дөрөвдүгээрт, “Засгийн газарт чиглэл өгөх тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэнэ.

Тавдугаарт, Төлбөрийн чадваргүйдлийн тухай хуулийн төслийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг явуулна.

Зургадугаарт, Хянан шалгах түр хорооны сонсголын тайлан, санал, дүгнэлт, Улсын Их Хурлын тогтоолын төслийг үргэлжлүүлэн хэлэлцэнэ.

Хэлэлцэх асуудалд оръё.

**Нэг. “Төрийн өмчит хуулийн этгээдийн хувьцааг
2026-2028 онд биржээр олон нийтэд нээлттэй худалдах, төрийн өмчийг хувьчлах,
өөрчлөн байгуулах үндсэн чиглэл батлах тухай”**

Улсын Их Хурлын тогтоолын төсөл

/Засгийн газар 2025.12.18-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/

“Төрийн өмчит хуулийн этгээдийн хувьцааг 2026-2028 онд биржээр олон нийтэд нээлттэй худалдах, төрийн өмчийг хувьчлах, өөрчлөн байгуулах үндсэн чиглэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг явуулна.

Хууль санаачлагчийн илтгэлийг Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Сандагийн Бямбацогт танилцуулна.

Индэрт урья.

С.Бямбацогт: Улсын Их Хурлын дарга, Эрхэм гишүүд ээ,

Монгол Улсад өмч хувьчлалын бодлогыг хэрэгжүүлж эхэлснээс хойш 35 жил өнгөрчээ.

1991 оноос хойш нийт 2019 аж ахуйн нэгж үл хөдлөх хөрөнгө, хувьцааг бүхэлд нь эсвэл тодорхой хувийг хувьчилж улсын төсөвт 278.0 тэрбум төгрөг төвлөрүүлсэн нь зах зээлийн эдийн засгийг хөгжүүлэх, хувийн хэвшлийг бэхжүүлэхэд чухал хувь нэмэр болсон.

2025 оны байдлаар уул уурхай, эрчим хүч, дэд бүтэц, зам тээвэр, банк санхүү, мэдээлэл, харилцаа зэрэг салбаруудад толгой компани 84, тэдгээрийн охин хараат компани 17, нийт 101 төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой компани, үйлдвэрийн газрууд үйл ажиллагаа явуулж байна.

Тэдгээр компани, үйлдвэрийн газруудаас 100 хувь төрийн өмчийн 73, төрийн өмчийн оролцоотой 22, олон нийтийн нээлттэй хувьцаат компани 6 байна.

Төрийн өмчит компани, үйлдвэрийн газрууд нь 2024 оны жилийн эцсийн аудитлагдсан санхүүгийн нэгдсэн тайлангаар 59.4 их наяд төгрөг буюу дотоодын нийт бүтээгдэхүүний 74.3 хувийг эзлэх хөрөнгөтэй байна.

Нийт орлого 26 их наяд буюу дотоодын нийт бүтээгдэхүүний 32.5 хувь, нийт өр төлбөр 23 их наяд буюу дотоодын нийт бүтээгдэхүүний 29.0 хувьтай тус тус тэнцэж байна.

Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр болон урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичигт төрийн өмчит компанийн засаглалыг сайжруулах, үр ашгийг нэмэгдүүлэх, үе шаттай хувьчлахыг хэрэгжүүлэх зорилт тусгагдсан бөгөөд “Шинэ итгэл, эрс шинэтгэл”, Монгол Улсыг 2026-2030 онд хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэлд төрийн өмчит компанийн засаглалыг олон улсын компанийн засаглалын зарчимд шилжүүлэх, төрийн болон орон нутгийн өмчийн үр ашиг, хариуцлагыг нэмэгдүүлэх, өмчийн харилцааны бүртгэл, мэдээллийн ил тод байдлыг бүрэн хангуулах, цахим шилжилт хийх зорилтыг хэрэгжүүлэхээр тусгагдсан.

Иймд төрийн өмчит хуулийн этгээдийн төрийн эзэмшлийн болон стратегийн хөрөнгө оруулагч санал болгох хувьцааны хувь хэмжээг үндсэн чиглэлээр тодорхойлсны дагуу нээлттэй хувьцаат компани болгох, төрийн мэдэлд байх өмчийн хүрээг дахин тодорхойлох, төрийн өмчит компани үйлдвэрийн газруудыг тодорхой шалгуурын хүрээнд ангилж авч үзэж ангилал тус бүрийн онцлогт тулгуурлан төрийн зүгээс тухайн компанид оролцох өмчлөлийн бодлогыг ялгамжтай авч хэрэгжүүлэх шаардлагатай гэж үзлээ.

Мөн давхардсан чиг үүрэгтэй үр ашиггүй хуулийн этгээдийг өөрчлөн байгуулах, цэгцлэх үүднээс чиг үүргийн давхардлыг арилгах, бүтэц, орон тоог оновчлох замаар төрийн өмчит компани, үйлдвэрийн газруудыг нэгтгэх, нийлүүлэх, өөрчлөн зохион байгуулах, шаардлагатай тохиолдолд татан буулгах арга хэмжээг үргэлжлүүлэн хэрэгжүүлэхээр төсөлд тусгасан.

Төсөлд эхний ээлжид олон нийтэд нээлттэй болгох, хувьцааг биржээр арилжаалах, төрийн мэдлийн хувьцааг худалдах болон өөрчлөн байгуулахаар дараах компаниудыг тусгасан.

Төрийн өмчит дараах 18 хуулийн этгээдийн энгийн хувьцааг нэмж гарган биржээр олон нийтэд нээлттэй худалдана. Үүнд:

- “Монголын цахилгаан холбоо” компани,
- “Хөдөө аж ахуйн бирж” компани,
- Үндэсний давхар даатгал,
- “Монголын Хөрөнгийн Бирж”,
- Хөдөө аж ахуйн корпорац,
- Шивээ-Овоо, Багануур, МИАТ зэрэг төрийн өмчит компани,
- Төрийн банк,
- “Эрдэнэс Тавантолгой”,
- Эрдэнэт үйлдвэр,
- “Эрдэнэс критикал минералс,

- Дулааны III цахилгаан станц,
- Дулааны IV цахилгаан станц,
- Эрдэнэтийн ДЦС,
- Дорнод бүсийн эрчим хүчний систем,
- Дарханы ДЦС,
- Амгалан дулааны станц.

Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой дараах 8 компанийн төрийн эзэмшлийн хувьцааг худалдана.

- Дулааны Шарын гол ТӨХК,
- Цемент шохой,
- Монгол шуудан,
- Багануурын дулааны станц,
- Налайхын дулааны станц,
- Хөвсгөл дулааны станц,
- Ховд дулааны станц,
- Улаангомын дулааны-II станц.

Дараах 7 төрлийн төрийн өмчит хуулийн этгээдийг өөрчлөн байгуулах, татан буулгах, бүтэц зохион байгуулалтыг өөрчлөх арга хэмжээ авна. Үүнд:

- “Эрдэс Монгол” ЦДҮС,
- “Улаанбаатар цахилгаан түгээх станц”,
- Мэдээлэл технологийн үндэсний парк,
- Авто импекс,
- Төвийн бүсийн хүнс, хөнгөн үйлдвэрийн технологи технологийн корпорац,
- Авто зам засвар арчлалтын нэгтгэл.

Дээрх компаниудын хувьд нээлттэй хувьцаат компани болгохын тулд компанийн засаглалыг шинэчлэх, санхүүгийн тайланд нь хөндлөнгийн аудит хийлгэх, ил тод мэдээллийн тогтолцоог нэвтрүүлэх арга хэмжээг хэрэгжүүлэх шаардлагатай.

Үүний зэрэгцээ өмнөх жилүүдийн хувьчлалын хэрэгжилтийг нэгтгэн дүгнэж, зайлшгүй төрийн мэдэлд байх өмчийн хүрээг дахин тодорхойлсны үндсэн дээр давхардсан чиг үүрэгтэй, үр ашиггүй хуулийн этгээдийг өөрчлөн байгуулах, цэгцлэх асуудлыг шийдвэрлэх зайлшгүй шаардлагатай байна.

Тодруулбал Монгол Улсын Их Хурлаас 2001-2022 оны хооронд төрийн өмчийг хувьчлах, өөрчлөн байгуулах үндсэн чиглэлийг 5 удаа баталсан боловч хэрэгжилт хангалтгүй 33 хувьтай, давхардсан тоогоор нийт 115 хуулийн этгээдийг хувьчлах, өөрчлөн байгуулахаар заасан ч дийлэнх хувь нь хэрэгжээгүй байх тул

дээрх үндсэн чиглэлүүдийн хэрэгжилтийг хангуулах чиглэлээр авах арга хэмжээний саналыг мөн төсөлд тусгалаа.

Төрийн өмчийн хувьчлах бодлогыг хөрөнгийн зах зээлийн чиг хандлага, эрэлт нийлүүлэлт, хөрөнгө оруулагчдын сонирхол, хуулийн этгээдийн бодит үнэ цэн, үнэлгээнд тулгуурлан тогтоож, үе шаттай, ил тод, хөрөнгө оруулагчдын сонирхолд нийцүүлэн хэрэгжүүлэх нь зүйтэй байна.

Төсөлд төрийн өмчит хуулийн этгээдийн хувьцааг биржээр олон нийтэд нээлттэй худалдах, төрийн өмчийг хувьчлах, өөрчлөн байгуулах, эхний ээлжид авах арга хэмжээний саналыг тусгасан болохыг энэ ташрамд дурдъя.

Улсын Их Хурлын дарга эрхэм гишүүд ээ,

Төрийн өмчийг хувьчлах, өөрчлөн зохион байгуулах, хувьцааг 2026-2028 онд биржээр олон нийтэд нээлттэй худалдах үндсэн чиглэлийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг Та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Н.Учрал: С.Бямбацогт гишүүнд баярлалаа.

Төслийн талаарх Эдийн засгийн байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Доржсүрэнгийн Үүрийнтуяа танилцуулна.

Индэрт урья.

Д.Үүрийнтуяа: Улсын Их Хурлын дарга, Эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2025 оны 12 сарын 18-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн “Төрийн өмчит хуулийн этгээдийн хувьцааг 2026-2028 онд биржээр олон нийтэд нээлттэй худалдах, төрийн өмчийг хувьчлах, өөрчлөн байгуулах үндсэн чиглэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг Эдийн засгийн байнгын хороо 2025 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн хуралдаанаараа үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг явууллаа.

Байнгын хорооны хуралдаанаар тогтоолын төслийг хэлэлцэх үед –

- Улсын Их Хурлын гишүүн Л.Энх-Амгалан сүүлийн 30 жилд өмч хувьчлалын талаар хэдэн улсаас зөвлөх үйлчилгээ, хэдэн удаа бодлогын зөвлөмж авсан талаар,
- Улсын Их Хурлын гишүүн Л.Соронзонболд өмч хувьчлалын жагсаалтад орсон компаниуд хувьчлалтай холбоотойгоор бизнес төлөвлөгөө

гаргасан эсэх талаар,

- Улсын Их Хурлын гишүүн Б.Уянга өмч хувьчлалын чиглэлээр гарсан тогтоолуудын хэрэгжилт яагаад хангалтгүй байгаа талаар,
- Улсын Их Хурлын гишүүн Г.Очирбат ямар шалгуураар эхний ээлжид 33 компанийн нэмэлт хувьцааг гаргаж, нээлттэй хувьцаат компани болгох зорилгоор хувьцааг нь биржээр арилжих, өөрчлөн байгуулах асуудлыг судалж, хувьчлалын арга хэлбэр, баримтлах зарчмыг тогтоох үндсэн чиглэлийг боловсруулсан талаар,
- Улсын Их Хурлын гишүүн Ч.Анар “Монголын Хөрөнгийн Бирж” хувьцаат компанийг хувьчлах талаар болон менежментийг нь өөрчлөх бэлтгэл ажил хийгдсэн эсэх талаар,
- Улсын Их Хурлын гишүүн Г.Лувсанжамц “Монголын Хөрөнгийн Бирж” хувьцаат компанийн төрийн эзэмшлийн хувь 51 хувиас багагүй, “Хөдөө аж ахуйн бирж” ХХК-ийн төрийн эзэмшлийн хувь 34 хувиас багагүй байна гэж заасныг тодруулж төрийн эзэмшилд байх ёстой гэж үзэж байгаа үндэслэлийн талаар, мөн хувьчлалын үр дүнд татан төвлөрүүлсэн хөрөнгө оруулалтаар хийх ажлын төлөвлөгөө байгаа эсэх талаар,
- Улсын Их Хурлын гишүүн О.Номинчимэг бэлтгэл ажлын хүрээнд төлөвлөсөн ажлын талаар болон мөн өмч хувьчлалыг хийснээр ямар хэмжээний хөрөнгө оруулалт орж ирэх талаар тооцож байгаа эсэх,
- Улсын Их Хурлын гишүүн Б.Жаргалан хувьчлах гэж байгаа компаниудын өөрийн хөрөнгө 42.3 их наяд төгрөг. Үүнээс манай хөрөнгийн биржийн зах зээл 10 их наяд орчим байна. Энэ 42.3 их наяд төгрөгийг шингээх зах зээл байгаа эсэх талаар. Мөн Санхүүгийн зохицуулах хорооноос жижиг хувьцаа эзэмшигчдийн эрх ашгийг хамгаалах асуудал дээр ямар ахиц дэвшил гарсан талаар,
- Улсын Их Хурлын гишүүн Н.Батсүмбэрэл “Монголын Хөрөнгийн Бирж” хувьцаат компанийн удирдлагуудаас өмч хувьчлал, үнэт цаасны талаарх ард иргэдийн ойлголт ямар түвшинд байгаа талаар тус тус асуулт асууж, хариулт авсан болно.
- Байнгын хорооны хуралдаанаар тогтоолын төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Г.Очирбат тогтоолын төслийг намын бүлгүүд дээр хэлэлцэх шаардлагатай талаар,
- Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзориг татсан хөрөнгө оруулалтаа хэрхэн зарцуулах, хяналт хаана байх зэрэг хууль эрх зүйн орчин сул

байгаа учир бодлогын хувьд дүн шинжилгээ болон бэлэн байдлын үнэлгээ хийх ёстой талаар,

- Улсын Их Хурлын гишүүн Э.Одбаяр хууль эрх зүйн орчин бэлэн биш учраас энэхүү тогтоолын төслийг хойшлуулах нь зүйтэй талаар,
- Улсын Их Хурлын гишүүн Н.Батсүмбэрэл шаардлагатай өмнөх оны өмч хувьчлалуудтай холбоотой нээлттэй сонсгол явуулах талаар,
- Улсын Их Хурлын гишүүн Д.Үүрийнтуяа тогтоолын төслийг хэлэлцэх эсэхийг дэмжээд цаашид сайжруулаад явах талаар тус тус саналуудаа хэлсэн болно.

Байнгын хорооны хуралдаанаар тогтоолын төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжих эсэх асуудлаар санал хураалт явуулахад 54.5 хувийн саналаар хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжиж, тогтоолын төслийг Улсын Их Хурлын нэгдсэн чуулганаараа хэлэлцүүлэх нь зүйтэй гэж үзлээ.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

“Төрийн өмчит хуулийн этгээдийг 2026-2028 онд биржээр олон нийтэд нээлттэй худалдах, төрийн өмчийг хувьчлах, өөрчлөн байгуулах үндсэн чиглэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг явуулсан талаарх Эдийн засгийн байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг Та бүхнээс хүсье.

Анхаарал хандуулсанд баярлалаа.

Н.Учрал: Д.Үүрийнтуяа гишүүнд баярлалаа. Ажлын хэсгийг танилцуулъя.

Сандагийн Бямбацогт Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга, Шаравын Мөнхцэрэн Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын салбарын бодлого зохицуулалтын газрын дарга, Болдын Цэнгэл Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын дарга, Цэнддаваагийн Баяр-Эрдэнэ Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын Төрийн өмчийн удирдлага, зохицуулалтын хэлтсийн дарга, Баттулгын Дөлгөөн Санхүүгийн зохицуулах хорооны Үнэт цаасны газрын дарга, Батмөнхийн Насантогтох Зам, тээврийн яамны Төрийн нарийн бичгийн дарга, Бавуужавын Мягмарнаран Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамны Төрийн нарийн бичгийн дарга, Дамдинпүрэвийн Батзориг Эрчим хүчний яамны Эрчим хүчний бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга, Ганбаатарын Энхтүвшин Эрчим хүчний яамны Стратеги, төлөвлөлтийн хэлтсийн дарга, Шаравын Бат-Эрдэнэ Сангийн яамны Санхүүгийн бодлогын газрын Хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга, Пүрэвсүрэнгийн Тамир Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын зөвлөх, Батсуурийн Даваадалай “Эрдэнэс Монгол” ХХК-ийн Гүйцэтгэх

захирал, Балжиннямын Гэрлээ “Эрдэнэс Монгол” ХХК-ийн нэгдлийн Хууль, эрх зүйн зөвлөлийн зохицуулагч, Жаргалсайханы Мөнхсайхан “Эрчист Монгол” ХХК-ийн Стратеги, бизнес хөгжлийн газрын захирал, Гэлэнгийн Ёндон “Эрдэнэт үйлдвэр” төрийн өмчит үйлдвэрийн газрын Ерөнхий захирал, Раднаарагчаагийн Очбадрах “Эрдэнэт үйлдвэр” төрийн өмчит үйлдвэрийн газрын Санхүүгийн албаны дарга, Даваацэрэнгийн Мөнхбат “Монголын Хөрөнгийн Бирж” ХК-ийн гүйцэтгэх захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгч, Тунсагийн Тэлмэн “МИАТ” төрийн өмчит хувьцаат компанийн Гүйцэтгэх захирал, Нарангэрэлийн Цэгц “МИАТ” төрийн өмчит хувьцаат компанийн Санхүү, удирдлагын газрын захирал, Нүрэнзэдгомбын Цэрэнсамбуу “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн Гүйцэтгэх захирлын үүрэг гүйцэтгэгч, Цагаанчулууны Анх-Од “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн Стратеги төлөвлөлт, төслийн газрын дарга, Насанбаярын Ганхуяг “Цемент шохой” төрийн өмчит хувьцаат компанийн Стратеги төлөвлөлт, бизнес хөгжлийн газрын дарга, Батмөнхийн Жавхлант “Үндэсний давхар даатгал” ХК-ийн Гүйцэтгэх захирал, Баатаржавын Чинбат “Монголын цахилгаан холбоо” ХК-ийн Гүйцэтгэх захирал, Дэмбэрэлийн Сугар Төрийн банкны Бизнес хариуцсан гүйцэтгэх захирлын Тэргүүн орлогч, Вандангийн Дарханбаатар Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын Удирдлага, төлөөллийн албаны дарга, Дамбын Нямдэлгэр Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Салбарын бодлого, зохицуулалтын газрын ахлах референт.

Ажлын хэсгийг танилцууллаа.

Ажлын хэсэгт нэр нь дурдагдсан ажлын хэсгийн гишүүдийг танхимд урьж байна.

Улсын Их Хурлын гишүүн Б.Заяабалын урилгаар Увс аймгийн Хөдөлмөр халамж, үйлчилгээний газрын албан хаагчид Улсын Их Хурлын үйл ажиллагаа Төрийн ордонтой танилцаж байна.

Та бүхэнд ажлын амжилт, сайн сайхныг хүсье. /алга ташив/

Мэндчилгээ дэвшүүлье.

Өнөөдөр Монголын уул уурхайн салбар үүсэж хөгжсөний 103 жилийн түүхт ой тохиож байна.

Эдийн засгийг нуруундаа үүрч яваа нийгэм, эдийн засгийн өсөлтөд чухал хувь нэмрээ оруулж ирсэн уул уурхайн салбарынхандаа, уурхайчдадаа уул уурхайн салбар үүсэж хөгжсөний түүхт 103 жилийн ойн мэндийг өргөн дэвшүүлье.

Та бүхэнд ажлын амжилт сайн сайхан бүхнийг хүсье. /алга ташив/

Аж үйлдвэр, уул уурхайн сайд Г.Дамдиннямын зүгээс уул уурхайн салбарынхандаа мөн мэндчилгээ дэвшүүлж байна.

Улсын Их Хурлын гишүүд Байнгын хорооны санал, дүгнэлт, хууль санаачлагчийн илтгэл болон тогтоолын төслийн үзэл баримтлалтай холбогдуулж намын бүлэг болон бүлэгт харьяалагдаагүй гишүүдээс урьдчилан ирүүлсэн нэрсийн дагуу асуулт асууж, хариулт авна.

Нэрс ирүүлсэн байна. Баярлалаа. /алх цохив/

Олон хүн нэрээ өгөх юм. Дандаа Б.Пүрэвдорж гишүүнээр л эхлээд байгаа юм даа. Бөхчулууны Пүрэвдорж гишүүн асуулт асууна.

Б.Пүрэвдорж: 1992 оноос 2000 он хүртэл нэлээн хувьчлаад явсан. Энэ хувьчлалыг Ардчиллынхан хамаг юмыг нь авлаа гэдэг яриа маш их байдаг. Зарим Их Хурлын гишүүн үүнийг ярьж байгаа.

Тэгэхээр энд суугаа Их Хурлын гишүүдээрээ төлөөлүүлэн энэ үед хувьчлал яаж явагдсан талаар би Ховд аймгийн жишээн дээр би Та бүхэнд хэлье.

Тэгэхээр Ховд аймаг 16 сумтай. Бүх суманд нэгдэл байсан, ахуйн үйлчилгээ байсан, худалдаа бэлтгэлийн анги байсан. Энэ хувьчлалуудыг бүгдийг нь тухайн үед нэгдлийн дарга байсан, тэр ахуй үйлчилгээний дарга байсан, худалдаа бэлтгэлийн ангийн дарга байсан тэр бүх хүмүүс бүгдийг нь хувьчилж авсан.

Дээрээс нь Ховд аймагт 40 үйлдвэр аж ахуйн нэгж байсан. Бүгдийг нь Монгол Ардын намын гишүүд авсан. Тэндээс хоёрхон хүн. Өөрөөр хэлбэл Ардчилсан намын н.Бямбаа, н.Мурат хоёр өөр өөрийнхөө ажиллаж байсан газраа авсан. Дээрээс нь н.Мягмардорж, н.Түвдэндорж нарын. Эхлээд Монгол Ардын Хувьсгалт Намын гишүүн байж байгаад сүүлд Ардчилсан намд орж ирсэн хоёр нөхөр бас энэ хувьчлалд авсан. Ингээд тооцоход нийт аж ахуйн нэгжийн 94 хувийг нь тухайн үеийн Монгол Ардын Хувьсгалт Намын гишүүд байсан ийм хүмүүс хувьчилж авсан нь түүхтэй юм.

Дээрээс нь Ховд аймагт 1200 орон сууц байсан. Энд нь дандаа тухайн үеийн дарга нар байсан. Дээрээс нь Монгол Ардын намын Хувьсгалт намын гишүүд байсан. Ийм идэвхтэй нэр хүндтэй тэр хүмүүс авсан. Мэдээж эндээс олон хүмүүс сүүлд намаа солиод манайх руу орсон байх.

Жишээ нь, тухайн үед аймгийн Засаг дарга байсан н.Галбадрах, орлогч дарга байсан н.Хайдав нар гаалийн байрнаас байр аваад сүүлдээ тэндээсээ хөөгдсөн байгаа. Тэгээд түүх сөхөхөд ийм байна.

Тэгэхээр энэ дээр манай ажлыг танилцуулж байгаа Ховдоос сонгогдсон С.Бямбацогт үүнийг сайн мэдэж байгаа. Худлаа гэвэл худлаа гэж хэлээрэй.

Тэгэхээр үүгээр ер нь хувьчлалыг Ардчилсан намынхан хамтарсан Засаг тухайн үед байсан. Дээрээс нь сүүлд 1996-2000 оны хооронд Ардчилсан нам байсан. Тэр үед хийсэн боловч үр дүнг нь Монгол Ардын намынхан авсан гэсэн үг.

Ер нь төрийн өмчийн томоохон компанийн хувьчлалын асуудлыг түүх сөхөхөд намайг гурван удаа суухад гурван удаа орж ирж байна.

2018 онд орж ирсэн. 2022 оны төсвөөр бас дахиж орж ирсэн. Хоёуланд нь амжилтгүй болсон.

Тэгээд үүнийгээ амжилттай хийхийг Та бүхэнд хүсье. Гол нь.

Тэгэхдээ энэ хувьчлалд миний хардаж байгаагаар 2016 оноос хойш маш их олон хулгайг өнөөдөр Монгол Ардын намын гишүүд ЖДҮ-ийн хулгай, төсвийн хулгай, ковидын хулгай, нүүрсний хулгай гээд бүх зүйлээр хулгайд холбогдсон тэр хүмүүсийн гудсан доороо хийсэн мөнгө яг энэ хувьчлал дээр албан ёсны хөрөнгө болж орж ирэх ийм магадлал маш их өндөр байгаа юм.

Тийм учраас энэ хувьчлалд орж байгаа хувьчлалын асуудлыг маш ил тод хийх, тэр хулгайн мөнгийг албан ёсны болгохгүй байх ийм асуудал дээр маш хариуцлагатай байх ёстой.

Мэдээж энэ төрийн өмчийн компанийг хувьчлах, энэ иддэг уудаг Их Хурлын гишүүд, сайд дарга нар өөрсдийгөө цүнх баригч нарыг аваачиж тавьж байгаад хулгайлдаг ийм зүйл маш их байгаа. Үүнийг хувьчлах нь зөв. Тэгэхдээ энэ дээр Та бүхний хулгайлсан мөнгө албан ёсны болохоос бид үнэхээр үхтлээ айж байна. Ард түмэн ч гэсэн айж байгаа.

Тийм учраас энэ дээр ялангуяа сөрөг хүчний хүмүүсийг оролцуулж хяналттай байлгах, хоорондоо нийлж байгаад хуйвалдаад бүгдийг нь авахааргүй нөхцөл байдалд оруулах талаар маш хариуцлагатай ажиллана шүү гэж хэлмээр байна. Баярлалаа.

Н.Учрал: С.Бямбацогт сайд хариулна.

С.Бямбацогт: Ер нь яах вэ, тодорхой бас хувь нь үнэний ортой. Монголчууд өнгөрсөн хугацаанд явуулсан өмч хувьчлалын үр дүнд Монгол Улсын иргэн болгон өмчтэй болсон.

Урьд нь төрийн өмч, нийтийн өмч гээд иргэд өмчгүй байсан бол Үндсэн хуулиар хувийн өмчийг хуулиар хүлээн зөвшөөрч Үндсэн хуулиар хүлээн зөвшөөрсөн. Үүний үр дүнд монголчууд бизнес эрхлэх, орлого олох, өмчтэй байх, өмчөө захиран зарцуулах, өмчөө бас өв уламжлуулж үлдээх, өв залгамжлуулах боломжтой болсон. Энэ нь өнгөрсөн хугацаанд өмч хувьчлалын тодорхой үр дүн.

Малчид маань малтай болсон. Иргэд маань төрийн өмчийн орон сууцад амьдардаг. Түүнийгээ худалдаж борлуулж чаддаггүй байсан бол өнөөдөр бүгд хувийн орон сууцтай, хувийн өмчтэй болсон. Монгол Улсын иргэн болгон 0.07 га газрыг өмчилдөг болсон. Ийм олон давуу талууд бий.

Гарсан алдаа завхрал бий. Тухайн үед мэдээлэлд ойрхон, мэдээлэл хаалттай байдлыг ашиглаж сая ярьж байгаа Б.Пүрэвдорж гишүүний асуудлыг зөвхөн Ховд аймаг ч биш Монгол Улсын 21 аймаг, 330 сум, Улаанбаатар хотын томоохон аж ахуйн нэгжүүдийг хувьчлах асуудал дээр хувьчлах нэрээр хуйвалдах, хулгайлах иймэрхүү алдаа завхрал гарсан.

Энэ алдаа завхралуудыг засаад залруулаад л улам сайжруулаад л өдийг хүртэл явж байгаа.

Ярих юм бол 1996-2000 онд төрийн өмчит олон компаниуд ямархуу байдлаар яаж дансандаа мөнгөтэй байж байгаад хулгайлагдсан, хувьчлагдсан билээ гэдгээс авхуулаад яривал зөндөө л юм байдаг.

Гэхдээ бид хойшоогоо харж өнгөрснөө яримааргүй байна.

- ▶ Урагшаагаа харж өнгөрсөн хугацаанд гарсан алдаа завхралыг яаж давтахгүй байх вэ,
- ▶ цаашдаа төрийн өмчийг яаж үр ашигтай болгох вэ,
- ▶ төрийн хувийн хэвшил, эдийн засагт оролцож байгаа оролцоог яаж багасгах вэ.

Ингэхдээ төрийн өмчит компаниудыг ил тод, нээлттэй хөрөнгийн биржээр дамжуулж хувьцааг нь худалдаж –

- ▶ илүү үр ашигтай болгоё,
- ▶ хувийн хэвшлээ эдийн засагт оролцох оролцоог нэмэгдүүлье,
- ▶ иргэдээ аж ахуй бизнес хийхэд нь төрийн өмчит компаниуд оролцохгүй байх боломжийг л бүрдүүлье –

гэсэн зорилгоор барьж ирсэн. Улам сайжруулж байгаа.

Энэ удаа ч гэсэн Улсын Их Хуралд өргөн барьж байгаа тогтоолын төсөл илүү нээлттэй, илүү либерал, илүү Их Хурлын гишүүдийнхээ санал бодлыг тусгаад өмнөх алдаанд дүгнэлт хийгээд, цаашаа олон нийтийн оролцоо, олон нийтийн хяналт доор өмнөх алдааг давтахгүй байх зорилгоор оруулж ирсэн. Тогтоолоо.

Тэгээд Их Хурал дээр Их Хурлын гишүүд маань хэлэлцээд илүү сайжруулаад явна гэдэгт итгэж байна. Баярлалаа.

Н.Учрал: Өлзийхүүгийн Шижир гишүүн.

Ө.Шижир: Бүгдэд нь өдрийн мэнд хүргэе.

Ер нь төрийн өмчийн хуулийн этгээдийн хувьцааг биржээр дамжуулж хувьчлах асуудлыг зарчмын хувьд дэмжиж байгаа. Гэхдээ бид хэд хэдэн юм анхаарах хэрэгтэй.

Төр нь ер нь бүгдийг хийдэг, бүгдийг чаддаг, бүгдийг авдаг байж болохгүй.

Дотоодын нийт бүтээгдэхүүнийх нь 74 хувийг төр үйлдвэрлэж байна гэдэг чинь бараг социалист улс байгаа байхгүй юу. Бид чинь социалист улс биш шүү дээ. Чөлөөт эдийн засгийг сурталчилсан Үндсэн хуульдаа заасан улс байдаг. Гэтэл социалист улс шиг дотоодын нийт бүтээгдэхүүнийхээ 74 хувийг төр үйлдвэрлээд байна. Үүнийг болих хэрэгтэй.

Өнөөдөр төрд 120 их наядын хөрөнгө байна. Үүнээс гадна төсвөөс гадуур төрийн өмчит аж ахуйн нэгжүүдээр маш их хэмжээний хөрөнгө байна. Үүнийг дагасан хулгай луйвар мөнхийн яригддаг.

Ер нь **“дэд сайд болж байхаар төрийн өмчит компанийн захирал болъё”** гэдэг ийм аман яриа ч хүртэл байдаг шүү дээ.

Тэгэхээр энэ юу вэ гэхээр төсвөөс гадуур маш их хэмжээний мөнгө үрэн таран хяналтгүй байгаа гэдгийг л харуулж байгаа юм.

Хариуцлага тооцдоггүй. Хариуцлага тооцох гэхээр бие биенийгээ чагталдаг. Энэ миний хүн, энэ чиний хүн гээд. Хэрвээ миний хүнийг хөндөх юм бол чиний хүн хөндөгдөнө гэдэг байдлаар эрх баригчид ханддаг.

Төрийн өмчит компанийн захирлууд нь бүгдээрээ намаас хамааралтай. Намаас томилогддог.

Ийм байдалтай байхад бид хэзээ ч төрийн өмчит компанийг үр ашигтай ажиллуулна гэж тооцохгүй.

- Сайдаас буугаад төрийн өмчит компанийн захирал болдог.
- Төрийн өмчит компаниасаа буугаад сайд болдог.

Ийм гажиг тогтолцоог эрх барьж байгаа нам сүүлийн 10 жил хийлээ л дээ.

Тэгээд үүнийгээ одоо харж ухаарч байгаа нь яамай л гэж бодож л байна.

Жишээ нь, “Эрдэнэт үйлдвэр”, “Эрдэнэс Тавантолгой” гэдэг хоёр компанийн нэг жилийн худалдан авалт улсын төсвийн хөрөнгө оруулалтын нэг жилийн хөрөнгө оруулалтын зардалтай тэнцэж байгаа шүү дээ.

Нөгөө Та бүгдийн тойргууддаа суулгах гээд байдаг сургууль, цэцэрлэг, зам гээд нийгмийн байгууламжууд чинь нэг жилд 3 их наяд төгрөгөөр худалдан авалт, хөрөнгө оруулалтын зардал хийдэг бол нэг жилд 3 их наядын худалдан авалтыг төрийн өмчит компаниуд хийж байна.

Тэгэхээр үндсэндээ улсын төсөв хөрөнгө оруулалт, төрийн өмчит компаниудын худалдан авалтууд тэнцсэн гэсэн үг.

Ийм байгаа байдалд бид хэзээ ч чөлөөт эдийн засаг, төрийн оролцоог хасна гэж юм байхгүй.

- Тэгээд төрийн өмчит компаниуд энэ утгаараа тэр чигээрээ мафи болсон.
- Төрийн өмчит компанийн захирлууд төрийн өмчит компанийн хөрөнгө нь сонгуульд зарцуулагддаг.
- Тухайн сайдынхаа үйл ажиллагаанд явагддаг.
- Сонгуулиас өмнө сурталчилгааны материал тараадаг.
- Төрийн өмчит компанийн нь захирлууд нь томилсон Их Хурлын гишүүн, сайд нарынхаа үүргийг өмнөөс нь гүйцэтгэж тэнд уулзалт хийдэг.

Ийм болсон байгаа тохиолдолд бид өнөөдөр төрийн өмчит компанийг нэг сэгсрэхээс өөр аргагүй.

Тэгээд ер нь яг хувьчлах жагсаалтад байгаа аж ахуйн нэгжүүдийг үнэхээр хэр бодитой хийсэн юм бэ гэдэг нэг асуудал байгаад байгаа юм.

Одоо жишээ нь үүнтэй холбоотой надад ганцхан асуулт байгаа юм. Жишээ нь, Хөдөө аж ахуйн корпорацаас хүн байна уу, захирал нь байна уу? Хөдөө аж ахуйн корпорац хамгийн сүүлд, манай Г.Дамдинням сайд өдөр болгон шатахууны проблемтой янз бүрээр хэлүүлээд байх шиг байна.

Тэгтэл хөдөө аж ахуйн корпорац дээр чинь буруу санаагүй бол 7 мянган тонны шатахууны нөөцийн сав байгаа. 7 мянган тонны шатахууны нөөцийн сав гэдэг бол Улаанбаатар хотын ердийн хэрэглээний нэг долоо хоногийн нөөц гэсэн үг.

Гэтэл Онцгой байдлын ерөнхий газар дээр 17 мянган тонн нөөцийн сав байдаг. Үүний 6 мянга нь ашиглах боломжгүй болсон. Тэгээд нөөцийн сав байна гээд Их Хурлаар тогтоол гаргуулаад мөнгө хайгаад яваад байдаг.

Гэтэл нөгөө талдаа төр өөрт байгаа одоо хэвийн ашиглаж байгаа 7 мянган тонн нөөцийн савыг хувьчлах гээд байгаа юм уу?

Засгийн бодлого чинь ийм юм уу? Би энэ логикийг ойлгохгүй байгаа юм.

Тэгээд бөөн юм болж үнэлгээг нь авсан. Энэ шатахуун түгээх 7 мянган тонныхоо нөөцийн савыг 11-хэн тэрбум төгрөгөөр үнэлсэн байна шүү дээ. Үнэгүйдүүлж авах гээд байна шүү дээ. Энэ чинь захиалгатай хувьчлал байна шүү дээ.

Тэгээд бид ийм байдлаар хувьчлалын асуудалд хандаад байж болохгүй. Тэгээд төрд нийтдээ 120 их наядын хөрөнгө байгаад байдаг. Энэ хөрөнгө дээр хөрөнгийн менежмент маш буруу, маш муу хийгддэг учраас нийгмийн бухимдал үүсдэг.

Тийм учраас энэ хувьчлалыг чинь дагаж хардлага сэрдлэг үүсээд байна. Үүнийгээ нэг талд нь цэгцлээч ээ. Та асуултдаа хариулт аваад тодруулъя.

Н.Учрал: С.Бямбацогт гишүүн хариулна.

С.Бямбацогт: Ө.Шижир гишүүн төрийн өмчит компаниуд дээр байгаа нийтлэг олон нийтийн, ард иргэдийн шүүмжлээд байгаа, хардаж байгаа хардлагын талаар ярьж байна. Бодитой иймэрхүү асуудал байгаа.

Энэ асуудлууд өмнө нь байсан. Үүнийг цэгцлээд л явж байгаа. Цэгцлээд.

Тийм болохоор юу гэдэг юм. Түрүүн ярьсан дотоодын нийт бүтээгдэхүүний 74 хувьтай тэнцэх хөрөнгөтэй байна. Төрийн өмчит компаниуд 74 хувьтай тэнцэх. Энэ хэтэрхий өндөр байна гэж үзэж байгаа. Үүнийг бууруулахын тулд өнөөдрийн энэ өмч хувьчлах үндсэн чиглэл орж ирж байгаа.

Ер нь Монгол Улсын нийт иргэд, аж ахуйн нэгж, төрийн өмчит компаниуд хөрөнгө хэд вэ гээд тоолох юм бол хэдэн их наядаар хэмжигдэх байх.

Тийм болохоор дотоодын нийт бүтээгдэхүүний шүү гэдгийг Ө.Шижир гишүүнд залруулж хэлье. Ийм харьцаатай байгаа. Нийт хувийн хэвшлийнхний иргэдийн өмчилж байгаа өмч хөрөнгөтэй төрийн өмчийн хөрөнгийн харьцуулах юм бол харьцангуй бага байх. Үүнийг бид харьцуулж тоог нь гаргаж өгье.

Худалдан авалттай холбоотой асуудлууд байдаг байсан.

Одоо жишээ нь Эрдэнэт үйлдвэр дээр шахаа хийдэг, бараа материал нийлүүлдэг гээд маш олон жил яригдсан худалдан авалтын хулгай байсан. Энэ алга болсон. Г.Ёндон захирлын үед. Энд хиймэл оюун ухаан ашиглаж сонгон шалгаруулалтыг хувь хүний оролцоогүй болгосон. Одоо энэ шахааны хулгай алга болсон.

Нөгөө баяжмалын хулгай гэж ярьдаг. Нууцаар шууд гэрээ хийгээд баяжмалыг худалдаж аваад цааш нь өндөр ашиг олж зардаг байсан бол үүнийг биржээр дамжуулж зардаг болсон. Энэ шахааны хулгай алга болсон. Одоо овоолгын хулгай гэж ярьдаг. Нөгөө Эрдэнэтийн үүсмэл ордууд дээр хувийн хэвшлийнхэн ажиллаад асуудал болдог байсан бол үүнийг төрд тодорхой хувийг нь авч овоолгын хулгайг цэгцэлж байгаа.

Мөн “Эрдэнэс Тавантолгой” нүүрсний хулгайн асуудал. Урьд нь шууд гэрээ хийгээд хэтэрхий бага үнээр нүүрс нийлүүлдэг байсан. Энэ 584 гэрээг бүгдийг нь ил тод болгосон. Одоо цөөхөн ганц хоёрхон гэрээ үлдсэн байгаа. Үүгээрээ урьд нь хэн яаж зах зээлийн үнээс доогуур хямд үнээр нүүрс худалдаж аваад ямар өндөр үнээр зардаг байсан нь ил болсон.

Иймэрхүү байдлаар төрийн өмчит компаниудын засаглалыг сайжруулах, үр ашгийг нэмэгдүүлэх, худалдан авалтыг ил тод болгох ийм ажлууд хийгдэж байгаа.

Энэ үндсэн чиглэл батлагдах юм бол өшөө цаашаа хийгдэнэ. Хөрөнгийн үнэлгээг хувийн хэвшлийн гадаад дотоодын хөндлөнгийн байгууллагаар хөрөнгийн үнэлгээ хийлгэнэ. Ингээд үүнийгээ Засгийн газрын хуралдаанаар оруулж ийм үнэ цэнтэй байна, ийм үнээр хувьчилж болох уу гэдгээ олон нийтэд ил тод танилцуулж зарлаж байж цаашаагаа яаж худалдах вэ, хувьчлах вэ, хувьцааг нь гаргах вэ гэдэг дээр шийдэх юм.

Тийм болохоор хөрөнгийн үнэлгээ хийгдэнэ, аудит хийгдэнэ, үүний дараа олон нийтэд ил тод зарлана. Тэгж байгаад Засгийн газрын хуралдаанд оруулж ийм процессоор үндсэндээ... /минут дуусав/

Н.Учрал: Алдагдалтай ажиллаж байгаа компани дээр иргэд, олон нийтээс хөрөнгө оруулалт татна гэсэн тийм логик байхгүй шүү.

Тэгээд наад жагсаалт дотор чинь алдагдалтай ажиллаж байгаа компаниуд олон байна. Алдагдалтай ажиллаж байгаа компаниуд дээр хөрөнгө оруулалт татна гэж ярих чинь зохимжгүй байна.

Тэгээд тэрийг Төрийн өмчийн хороо ч гэсэн өөрсдөө тайлбарлах хэрэгтэй. Хувьцаа маш бага хувийг л биржээр гаргадаг. Том хувьцаа эзэмшигч нь хэвээрээ үлддэг.

Бид хэд хэдэн удаа ийм тогтоол гаргаж байсан шүү дээ. Тийм биз дээ. Одоо тэгээд л тэр “Монголын цахилгаан холбоо”-г хувьчилна гээд л оруулаад ирдэг юм. Хэд дэх ч удаа юм. Угаасаа энэ чинь ийм бага хувийг нээлттэй болгоод хувьцааг нь зараад наадах чинь үр дүнд хүрнэ гэж байхгүй. Үнэнээ ярина шүү. Төрийн өмчийн хорооныхон бас нэмж тайлбарлах хэрэгтэй.

Г.Дамдинням сайд тайлбарлах уу? Г.Дамдинням сайд.

Г.Дамдинням: Ө.Шижир гишүүндээ талархал илэрхийлье.

Бидний тулгамдаад байгаа гол асуудал бидний хэрэглээ сүүлийн 4 жил 4 дахин өссөн. Хатахууны хэрэглээ. Харамсалтай нь шатахууны савны маань хэмжээ огт өсөөгүй. Үүнээс шалтгаалаад бид нэг сарын уналт, босолтыг дийлэхгүй ийм л эмзэг байдал руу орсон байгаад байгаа.

Тэгэхээр шатахууны сав гэдэг бол маш чухал зүйл болоод байна бидний хувьд.

Тэгэхээр тэр Хөдөө аж ахуйн биржийн тэр 7 мянган тонны савыг Аж үйлдвэр, эрдэс баялгийн яам авъя гэж 6 сард хүсэлтээ тавиад Хөдөө аж ахуйн яамтай маргаантай явж байгаа. Тэгээд Төрийн өмчийн хорооноос яг тэр савны хэсгийг нь ялгаад Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны харьяанд шилжүүлбэ гэдэг энэ ажиллагаа явагдаж байгаа. Ямар ажиллагаанууд хийгдэж яваа талаар хариуцах асуудлын хүрээнд Төрийн өмчийн хорооныхон илүү тодорхой хариултыг хэлэх байх.

Н.Учрал: Б.Цэнгэл дарга...

- Энэ олон жагсаалтад байгаа компаниуд чинь яг нээлттэй компани болох юм уу?
- Хэн тэр underwriter-ийнх нь мөнгө төгрөгийг нь шийдэх юм?
- Хэн үнэлгээ хийх юм?
- Тэр зардал мөнгө нь шийдэгдсэн юм уу?

Б.Цэнгэл: Гишүүдийн асуултад хариулъя.

Тэгэхээр бид Засгийн газрын тогтоол гараад хөдөө аж ахуйн корпорацийн үл хөдлөх хөрөнгийг дуудлага худалдаагаар худалдах Засгийн газрын шийдвэр гарсан.

Ингээд бид зарим яамны саналыг харгалзаж үзээд тэр агуулахын хэсгийг нь дуудлага худалдаанд оруулахгүйгээр салгаад авсан байгаа.

Хамгийн сүүлийн мэдээгээр Хүнс, хөдөө аж ахуйн сайд үлдэж байгаа тэр хөдөө аж ахуйн корпорацийн дуудлага худалдаанд оруулах гэж байгаа үл хөдлөх болон нефтийн агуулахуудыг дуудлага худалдаанд оруулахгүй байя гэдэг саналыг манайд ирүүлсэн байж байгаа. Тэгээд одоо бид энэ дээр ажиллаж байна. Баярлалаа.

Н.Учрал: Ө.Шижир гишүүн тодруулна.

Ө.Шижир: Тэгэхээр ямар ч байсан хөдөө аж ахуйн корпорац дээр байгаа бүх дэд бүтэцтэй 7 мянган тонн шатахууны савыг хувьчлахгүй юм байна гэж ойлголоо. Зөв үү?

Тийм ээ. Б.Цэнгэл дарга аа?

Тэгэхгүй бол логик нь юу гэж хараад байна вэ гэхээр төр агуулах сав байхгүй гэж гонгиноод байдаг. Нөгөө талдаа өөртөө байгаа саваа хувьчлах жагсаалтад оруулаад ирсэн байна шүү дээ. Одоогийн байдлаар бол.

Тэгэхээр үүнийгээ салгаж авах юм байна. Нэгдүгээрт.

Хоёрдугаарт, хүний эрхэлж байгаа албан тушаалыг янз бүрээр ярих нь ч бас хэцүү л юм л даа. Гэхдээ төрийн өмчит компанийн захирлаас буугаад сайд болдог, сайдаас буугаад төрийн өмчит компанийн захирал болдог энэ гажиг тогтолцоог хэзээ болгох юм бэ? Монгол Ардын намынхан, эрх баригч нар аа.

→ Ажлыг нь авахдаа сайдыг нь амладаг юм уу?

→ Эсвэл ажлыг нь авахдаа төрийн өмчит компанийн захирлыг нь амладаг юм уу?

Нэгдүгээрт, мэдэгдэхгүй юм.

Хоёрдугаарт, Дэлхийн банкнаас өгөөд байгаа зөвлөгөөг нь энд гоё цаасан дээрээ бичсэн байна лээ л дээ. Тэгтэл энэ дээр чинь хэд хэдэн зөвлөгөө нь огт дагалдаагүй байна. Жишээ нь, үнэлгээг олон улсын байгууллагаар илүү бодитой хийх, хууль эрх зүйн орчныг боловсронгуй болгох гэсэн заалтууд нь нэгдүгээрт алга. Энэ дээр хариулт авмаар байна. Дахиад тодруулмаар байна.

Н.Учрал: С.Бямбацогт сайд хариулна.

С.Бямбацогт: Их Хурлын дарга түрүүн ярьсан. Алдагдалтай ажиллаж байгаа компаниуд яагаад алдагдалтай байна вэ гэдэг дээр нөгөө шахаа байдаг, хулгай байдаг, өртөг зардлаа бууруулахгүй байдаг, хэтэрхий нүсэр данхар бүтэцтэй байдаг. Хувийн хэвшлийнхэн маш бага орон тоогоор, маш бага бүтэц, зохион байгуулалтаар илүү үр ашигтай худалдан авалт хийгээд ашигтай ажиллаж болоод байхад адилхан төрийн өмчит компани алдагдалтай ажиллаад байгаа юм.

Ийм алдагдалтай ажиллаж байгаа компаниуд дээр л олон нийтийн оролцоо, хувийн хэвшлийн оролцоог бий болгоё. Эргээд олон нийтийн хяналтад оруулъя. Ингэх юм бол илүү үр үр ашиг нь нэмэгдэнэ гэдэг зорилгоор алдагдалтай ажиллаж байгаа компаниудаа худалдъя. Төрд ашиггүй, орлого оруулдаггүй хөрөнгө байх шаардлагагүй. Үүнийг хувьд шилжүүлээд илүү үр ашигтай болох байх гэдэг бодлого явж байгаа гэдгийг нэгдүгээрт хэлье.

Хоёрдугаарт нь, Ө.Шижир гишүүн ээ, тэр нээлттэй арилжаалах, үнэлгээ хийх дээр хөндлөнгийн хяналт, аудит орно. Хөндлөнгийн аудит орно. Олон улсын болон дотоодын хөндлөнгийн байгууллагаар төрийн өмчийн хөрөнгүүд дээр үнэлгээ хийгдэнэ.

Ингэж байж бодитой үнэ цэн бий болгож... /минут дуусав/

Н.Учрал: Бодит байдал дээр иргэдийн буюу “рэтэйл хөрөнгө оруулагч”¹ (Retail Investor) нарт л нээлттэй болгохоор орж ирж байгаа.

Яг мэргэжлийн хөрөнгө оруулагч нар орж ирдэггүй байхгүй юу. Бид засаглал сайжруулъя гэвэл мэргэжлийн хөрөнгө оруулагч нарыг оруулж ирэх хэрэгтэй. Тийм биз.

Төрийн өмчит компанийн бүтээмж, засаглал, ил тод байдлыг сайжруулах хууль хийж байхад мэргэжлийн хөрөнгө оруулагч нарыг хэрхэн оруулж ирж засаглал сайжруулах вэ л гэж ярьсан. Тэгээд тэр хууль чинь энэ Их Хурал дээр жил боллоо.

Тэгээд П.Сайнзориг гишүүнээр ахлуулсан тэр Нийтийн өмчийн хуулийг нь О.Номинчимэг гишүүнээр ахлуулсан.

Ингээд Д.Үүрийнтуяа гишүүн энэ хоёр хуулийг нэгтгэж байгаа том ажлын хэсгийн ахлагчаар томилсон.

Одоо энэ хуулиа гаргамаар байна. Тийм. Тэгэхгүй наадах чинь зүгээр нээлттэй болгоно гэхээр алдагдалтай ажиллаж байгаа компаниуд дээр иргэд хувьцаа аваад яах юм. Алдагдал үйлдвэрлэж байгаа компани дээр хэн хувьцаа авах юм бэ л гэдэг ийм асуулт байна шүү дээ.

Ө.Шижир гишүүн нэмэлт тодруулга.

Ө.Шижир: Одоо энэ жагсаалтад байгаа компаниудыг чинь харахаар 2 сая 470 мянган төгрөгийн ашигтай компани ч байна, 28 сая төгрөгийн ашигтай ч компани байна.

Үүнийг тайлан дээрээ харахаар ашигтай компани гээд үзээд жагсаалтад оруулаад үр дүнтэй хөрөнгө оруулалт хийж үзэхгүй. Энэ чинь буруу шүү. Н.Учрал даргын саналтай нэг байна.

¹ Рэтэйл хөрөнгө оруулагч (Retail Investor) гэдэг нь хувийн хөрөнгөөрөө өөрийн нэр дээр санхүүгийн зах зээлд арилжаа хийж буй хувь хүнийг хэлнэ.

Хоёрдугаарт нь, нөгөө Хөвсгөлд байгаа бяслагийн үйлдвэр, Булганд байгаа сүүний үйлдвэрийг яах юм? Хувьчлах юм уу? Энэ зөвхөн төрийн хөрөнгөл яригдаж байгаа болохоос орон нутгийн өмчит хөрөнгүүдийг яах юм?

- Хөвсгөлд сүүний үйлдвэр ашиглалтад орохоор яах юм?
- Булганд сүүний үйлдвэр орохоор яах юм?
- Хөвсгөлд бяслагийн үйлдвэр орохоор яах юм?
- Хувьчлах юм уу, төр эзэмшээд яваад байх юм уу?

Эхний асуулт.

Хоёр дахь нь, дөнгөж бид төр өөрт байгаа хөрөнгөөсөө сална, зах зээлд өрсөлдөхгүй, төр зах зээлд хувийн хэвшилтэй өрсөлдөхгүй байх зарчмыг барина гэж байх хооронд Нийслэлийн иргэдийн Хурлын тогтоолоор Улаанбаатар хот чинь өөрөө такси компанитай болох гэж байна шүү дээ.

26.0 хувийг нь төр эзэмшинэ. 77.0 тэрбумын хөрөнгө оруулалт хийнэ гээд.

Энэ чинь нөгөө яриад байгаа логиктой чинь дахиад зөрчилдөөд байна шүү дээ.

- Төр ажлын уялдаа чинь хэзээ хангагдах юм бэ?

Н.Учрал: Ажлын хэсгээс хариулах уу? Б.Цэнгэл дарга.

Шинэ хуулиар чинь Та нар одоо орлоо гэж юу өөрчлөгдөх вэ? SOE² (State-Owned Enterprise), нэг нь Public Institution³ гэж хоёр ангилах гээд байгаа шүү дээ. Тийм ээ.

Б.Цэнгэл дарга аа. 4 дүгээр микрофон.

Б.Цэнгэл: Орон нутгийн өмчит болон орон нутгийн болон төсвийн хөрөнгөөр хийж бий болгосон үйлдвэрүүд бий.

Үүнийг үр ашигтай байлгах талаас нь тухайн орон нутгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргаас Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт зөвшилцөх санал ирүүлж байгаа. Тухайлбал, Баянхонгор аймаг, Баян-Өлгий зэрэг аймгуудаас зарим үр дүнгүй байгаа өмч хөрөнгүүд дээр дуудлага худалдаа явуулъя гэдэг саналууд ирсэн.

² Төрийн өмчит үйлдвэрийн газар (Аж ахуйн нэгж).

³ Нийтийн үйлчилгээний байгууллага.

Тэгээд заримыг нь бид зөвшилцөөд дэмжээд явуулж байгаа. Энэ бол нэг ёсондоо өмчийн ашиглалтыг сайжруулах чиглэлээр авч байгаа арга хэмжээ байгаа юм.

Бүрэн эрх нь тухайн орон нутгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд байгаа.

Бид төрийн өмчийн компаниудыг ер нь ангилж авч үзэхгүй явж ирсэн нэг ийм дутагдал байж байгаа.

Тэгэхээр бид гол үндсэн чиглэл дээрээ... /минут дуусав/

Н.Учрал: Б.Цэнгэл даргад нэмэлт 1 минут.

Б.Цэнгэл: Төрийн өмчийн компаниудыг гурван үндсэн бүлэгт ангилж –

- стратегийн ач холбогдолтой компани,
- бизнесийн үйл ажиллагаа явуулж байгаа өрсөлдөөнт зах зээл дээр байгаа компани,
- нийгмийн дэд бүтцийн чиглэлээр ажиллаж байгаа ашгийн төлөө явах шаардлагагүй компаниуд –

гэж бүлэглэж хувааж авч үзсэн байгаа.

Үүнийгээ үндсэн чиглэлийн үзэл баримтлалдаа тусгаж оруулж байгаа юм.

Тэгэхээр энэ гурван ангилал тус бүрд нь тохирсон өмчлөлийн бодлогыг хэрэгжүүлээд явна гэдэг концепц барина.

Засгийн газар дээр яриад бид эхлээд 10 компани байсан. Засаг дээр яриад ер нь компанийн тоог нэмж оруулах нь зүйтэй, тэгээд Их Хурал дээр нээлттэй энэ асуудлаа ярья гэдэг зарчмыг баримталж оруулж ирж байгаа.

Ерөнхийдөө компаниудыг оруулж ирж байгаа гурван бүлэг асуудал оруулж ирж байгаа. /минут дуусав/

Н.Учрал: Засгийн газар төрийн өмчит компани дээр баримтлах чиглэлээ оруулж ирж байгаа нь маш сайн хэрэг. Энэ зөв хандлага.

Гэхдээ хууль батлагдах ёстой. Тийм биз. Д.Үүрийнтуяа гишүүн ахалж байгаа энэ хуулийг 3 дугаар сарын 15-нд чуулган эхлэхэд эхний хоёр долоо хоногт хэлэлцсэн шүү. Хаврын чуулган бол хувийн эрх зүйн шинэчлэл хийх ёстой чуулган байх ёстой. Тийм биз.

Тийм учраас хаврын чуулганы эхний хоёр долоо хоногт энэ хуулийг батлахгүй бол чиглэл оруулж ирээд үр дүн бага.

Тэгэхээр хуулиа баталъя. Төрийн өмчийн хороо ч гэсэн ажил хийхэд хэцүү байгаа шүү дээ. Энэ хууль батлагдахгүй учраас.

Одонгийн Цогтгэрэл дарга асуулт асууна.

О.Цогтгэрэл: Гишүүддээ өглөөний мэнд хүргэе.

Төрийн өмчийг олон нийтийнх болгох, алсуураа төрийн оролцоог бууруулъя гэдэг зарчмын бодлогын баримт бичиг орж ирж байгааг талархаж байна.

Тэгэхдээ энэ нь хэлбэрийн төдий зүйл биш байгаасай гэж хүсэж байна. Өмнө нь олон удаа ийм баримт бичгүүд гарч байсан. Миний л мэдэхийн тунхгийн шинжтэй, хэлбэржсэн олон зүйлүүд гарч байсан гэдгийг бас хэлье.

Тэгээд аливаа муу зүйлд сайн тал байдаг гэдэг. Яг өнөөдөр эдийн засгийн нөхцөл байдал хөрсөн дээрээ бууж байна.

Тийм ч учраас өөрийгөө социал демократ үзэлтэй гэдэг улс төрийн хүч нь төр том байх ёстой, төрийн өмчөөр асуудлыг шийдэх ёстой гэдэг улс төрийн хүч нь анх удаагаа ингэж төрийн оролцоог бууруулъя, хувьчилъя, олон нийтийнх болгоё гэж байгаа нь нөхцөл байдал хөрсөн дээрээ бууж байгаагийн илрэл болов уу гэж бодож байна.

Яагаад хэлбэрийн төдий гэж хэлж байна гэхээр Төрийн банкиг хувьчилсан. Хувьчилсан, олон нийтийнх болгосон гэдэг нэртэй 5 хувийг хувьчилсан. Хүн сонсоход Төрийн банк хувьчлагдсан гэж хэлэгддэг. Нөгөө талдаа 5-хан хувь. Гэтэл тэнд гарсан хувьцаа миний санаж байгаагаар нэгж хувьцаа нь 600-аад төгрөгөөр гарсан. Одоо бараг 20, 30 хувь унасан. Ийм байдалтай л байгаа. Тэр засаглал энэ тэрд нь өөрчлөлт орсон ямар ч зүйл байхгүй.

Тэгэхээр энэ хувьчлал гэж байгаа зүйл, олон нийтийнх болгох гэж байгаа зүйл дээр эдгээр асуудлаа жинхэнээс нь нэгдүгээрт нь яаж хийх гэж байгаа юм?

Хоёрдугаарт нь, эрчим хүчний баахан компаниуд энд дурдагдсан байна лээ.

Тэгэхээр мянга хувьчиллаа гээд үр дүнд хүрэхийн тулд тэр ашигтай байх, менежмент хийх. Гол нь үнэ чөлөөтэй. Үнэ дээр бусад зохицуулалтуудыг яаж хийж байгаа юм?

Эрчим хүчний салбар үнийг нь хатуу барьсан. Алдагдалтай. Аль эсвэл өртөг ашиг нь менежмент хийх боломжгүй байдаг. Тэгээд сайхан хувьчиллаа гэдэг. Тэгээд гадна дотноос хэдэн хүн орж ирдэг. Тэгээд баахан хөрөнгө

оруулагчдын итгэлийг алдсан. Эцсийн дүндээ ямар ч үр дүнгүй нэг ийм зүйл болоод хувирах нөхцөл байдал үүний цаана гарахаас яаж сэргийлж байгаа юм. Жинхэнээсээ. Хэлбэр хөөлгүйгээр яаж энэ ажлыг үр дүнтэй болгох гэж байгаа юм. Үүний цаана яривал олон зүйл байна л даа. Давхар татвар, суутган татвар. Олон олон асуудлыг хийж байж л энэ чинь үр дүнтэй л болно. Хөрөнгийн захтайгаа яаж холбогдож байгаа юм. Олон олон зүйл.

Жишээ нь, хамгийн чухал нь тэр үнэтэй холбоотой асуудал. Эрчим хүчний салбарт үнэ чөлөөлөх юм уу? Үнэ чөлөөлөхгүйгээр хувьчлал гэдэг бас үлгэр шүү. Өмнө нь Багануур дээр хөрөнгө оруулагчид орж ирээд бүгдээрээ гараад л. Тэр “Институционал хөрөнгө оруулагчид”⁴ (Institutional Investors) чинь Монголыг хаяад л гарч байсан бэлээхэн жишээнүүд байж л байдаг.

Тэгэхээр энэ зүйлүүд дээр жинхэнээсээ хийх хүсэл зориг байна уу? Тэгвэл саяын зүйлүүдийг яг яаж харж байгаа юм? Энэ дээр нэг хариулт өгөөч.

Н.Учрал: С.Бямбацогт гишүүн хариулна.

С.Бямбацогт: О.Цогтгэрэл гишүүнд баярлалаа. Дэмжиж байгаад.

Тэгээд энд яах вэ, бид юу гэдэг юм намын үзэл баримтлал ярих биш, илүү Их Хурал, энэ төр төлөөлж байгаа хүмүүс бид бүхэн ард түмнийхээ амьдралд нийцсэн, хөрсөн дээрээ буусан бодитой, хэрэгжих боломжтой ийм л шийдвэрүүд гаргах ёстой байх. Энэ бидний чиг үүрэг байх гэж боддог. Хэт улс төржиж талцаж хуваагдах нь чухал биш.

Тэр ч үүднээсээ таны хувьд ч, миний хувьд ч хоёулаа хувийн хэвшлээс төрд орж ирсэн. Би төрд нэг өдөр ажиллахгүй байж байгаад Их Хурлын гишүүн болсон. Төрийн хүнд суртал, төрийн данхар бүтэц. Үүний эсрэг байдаг. Энэ ч үүднээсээ энэ удаа үндсэн чиглэлийг оруулж ирэхдээ аль болох эдийн засагт төрийн оролцоог багасгая, хувийн хэвшлээ дэмжье, илүү либерал байя гэсэн хүрээндээ бодлого оруулж ирж байгаа.

Тэр хүрээндээ таны сая хөндөж ярьж байгаа Төрийн банкны болон эрчим хүчний салбаруудын хувьчлал чинь ёс төдий, нэр төдий юм биш байгаа гэдэг асуудлууд байгаа.

Тэгээд 5-хан хувь хувьчилдаг. Тэр хяналтын багцыг нь эзэмшихгүй байж 5 хувь дээр орох, үнэ цэнтэй болгох, илүү дуудлага худалдаагаар өндөр үнээр худалдаж авах сонирхол байхгүй. Яагаад гэвэл оролцоо хяналтын багц байхгүй учраас.

⁴ Мэргэжлийн хөрөнгө оруулагчид.

Тийм болохоор бид 50 хувийг нь гэдэг юм уу, 100 хувь хувьчилъя гэх юм бол бас эргээд яагаад ганц Төрийн банкаа өгөх гээд. Ганцхан Төрийн банк байгаа шүү дээ гээд асуудал үүсэх гээд.

Эрчим хүчийг 100 хувьд хувийн хэвшилд шилжүүлъя гэх юм бол энэ эрчим хүч чинь стратегийн ач холбогдолтой салбар. Үнэ чинь талийгаад өгвөл яах юм бэ гээд.

Тийм болохоор бид тодорхой хэмжээнд хөндөж байгаа юм. Улсын Их Хурал төрийн эрх барих, төрийн бодлого тодорхойлох дээд байгууллага. Энэ дээр Улсын Их Хурлын 126 гишүүн тал талаасаа ярилцаж байгаад хамгийн зөв, хамгийн хэрэгжих боломжтой хувилбар энэ гэдгийг хараач ээ.

Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр 2026-2030 онд Монгол Улсыг хөгжүүлэх үндсэн чиглэл. Энэ бүхэнд үндсэндээ эрчим хүчний салбарын үнийг чөлөөлөх ёстой, эрчим хүчний салбарт либералчлал хийх ёстой гэсэн бодлого байгаад байдаг. Гэтэл үүнийг бид хийж чадахгүй байна.

Үүнийг хувийн хэвшлийн оролцоотой болгож байж тэр салбарт үр ашиг бий болгоё. Тэр салбарт хаалттай байгаа цонх, хаалгыг онгойлгоё нээе. Ингэх юм бол илүү зардлыг нь бууруулах бололцоо боломж бий болох байх. Энэ салбарт өрсөлдөөн бий болгоё. Хувийн хэвшлийг оруулж ирье. Ингэх юм бол тэр хэмжээгээр эрчим хүчний үнэ буурах бололцоотой болох байх.

Энэ бодлогыг бид хамтраад тал талаасаа гаргаад явах юмсан гэдэг агуулгаар Их Хурал дээр илүү сайн хөндөж ярилцаасай гэж хүсэж байна.

Мөн Төрийн банкны 5 хувь ч гэсэн бид хуулиар хязгаарлагдаад байгаа. 20 хувь, 20, 20 хувиар нь багцлаад Төрийн банк байх шаардлагатай юу, шаардлагагүй юу гэдэг дээр ч гэсэн бас ярих нь нээлттэй байгаа.

Н.Учрал: Амьдралгүй их олон хуультай шүү. Тэр 01 сарын 01-нээс тэр Банкны хууль чинь хэрэгжиж эхлэх гэж байгаа. Иэр хууль чинь хэрэгжих юм уу, үгүй юм уу гэдгийг ярих л цаг болоод байна.

О.Цогтгэрэл дарга.

О.Цогтгэрэл: Тэгээд агуулгыг нь харахаар төр бизнесийн үзэл баримтлал дээр тодорхойгүй олон зүйл байгаад байна л даа. Төр энэ бизнесээс 100 хувь гарах ёстой гэж үзэж байгаа юу? Тодорхой хэмжээний засаглалыг нь сайжруулахын тулд 34-өөс дутуугүй хувийг олон нийтийнх болгох гэж байгаа юу? Яагаад гэдэг. Аль эсвэл хөрөнгө босгох зорилготой юм уу, иргэдийгээ хувьцаажуулах, хөрөнгөжүүлэх зорилготой юм уу гээд. Яг үзэл баримтлалын түвшинд хэт ерөнхий нэг ийм.

Надад хэлбэрийн төдий гэдэг нь яагаад ийм нэг тийм жаахан аргацаасандуу л ийм баримт бичиг орж ирж байна. Илүү сайжраасай гэдэг үүднээс харж байна. Нэгдүгээрт нь.

Хоёрдугаарт нь, дахиад л хэлбэр гэдэг үгэн дээр үнэхээр төрийн зардлыг бууруулъя л гэж байгаа бол дахиад л өнөөдөр яригдаж байгаа зардал, орон тоо, дэд сайдын орон тоо ч гэсэн үүний л нэг хэрэг шүү дээ. Яг ингэж асуудлыг дандаа хэлбэр талаас нь хөөцөлддөг. Яг орж ирж байгаа тогтоолын төсөл ч гэсэн уг нь хуулийн түвшинд энэ асуудлыг ярих ёстой. Илүү тийм тодорхой асуудал дээр үзэл баримтлал... /минут дуусав/

Н.Учрал: С.Бямбацогт дарга.

С.Бямбацогт: Тэгэхээр төрийн өмчит компаниудыг бид –

- бизнесийн болон өрсөлдөөнд тулгуурласан салбарт үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгжүүд,
- стратегийн ач холбогдол бүхий салбарт үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгжүүд,
- нийгмийн чиглэлийн.

Яах аргагүй төр ачааг нь үүрэхээс өөр аргагүй байгаа аж ахуйн нэгжийг 3 ангилж байгаа.

Эндээс бид бизнесийн өрсөлдөөнд суурилсан аж ахуйн нэгжүүд дээр илүү 100 хувь, 51 хувь хувьчлах бодлого барьж байгаа.

Стратегийн чиглэлийн аж ахуйн нэгжүүд дээр төр байх нь илүү ач холбогдолтой учраас 34 хүртэлх хувийг нь хувьчлах нь зүйтэй юм гэсэн бодлого оруулж ирсэн.

Нийгмийн чиглэлийн аж ахуйн нэгжүүд. Нэгэнтээ хувийн хэвшил хэзээ ч оролцдоггүй, сонирхдоггүй, төр Үндсэн хуульд заасан иргэдийнхээ эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийн баталгааг хангах үүднээс төр зайлшгүй ачааг нь үүрэх ёстой нийгмийн чиг үүрэгтэй компаниудыг хувьчлахгүй байх, гэхдээ өөрчлөн зохион байгуулах, илүү үр ашигтай... /минут дуусав/

Н.Учрал: Тийм. О.Цогтгэрэл даргын асуултад тодорхой хариулна шүү. Ажлын хэсгээс.

Наадах чинь үр дүнд хүрэх юм уу л гээд байна шүү дээ. О.Цогтгэрэл дарга. Энэ чинь зөв хандлага. Гэхдээ наад олон жагсаалт чинь гурав дахь удаагаа орж ирж байгаа юм.

Засгийн газар зориг гаргаад оруулж ирж байгаа нь сайн хэрэг. Гэхдээ яг үр дүнд хүрэх юм уу нөхөд өө гэдгийг л асуугаад байгаа юм байна.

С.Бямбацогт даргад нэмэлт 1 минут өгье.

С.Бямбацогт: Тийм. Өмнө нь 5 удаа үндсэн чиглэл баталсан. Түүний биелэлт нь дунджаар аваад үзэхэд 33 хувьтай. Ялангуяа 2000 оноос хойш өмч хувьчлал зогссон юм билээ. Яагаад ийм болсон бэ гэхээр хувьчлах нэрээр хулгай хийдэг гээд харддаг. Тэгээд мушгидаг. Түүнээсээ болоод асуудлууд гацдаг. Хувьчилж авахаас айдаг болсон.

Тийм болохоор гацсан гацааг гаргая. Үр дүнтэй болгохын тулд оруулж ирж байгаа. Их Хурал Засгийн газарт үүрэг өгсөн. Өнгөрсөн 2024 оны 12 сарын 12-нд. Энэ үүргийн дагуу оруулж ирж байна.

Оруулж ирж байгаа асуудлыг үр дүнтэй болгохын тулд Их Хуралд сайжруулаад илүү боловсронгуй болгоод сайн хяналтаа тавиад явах бүрэн эрх нь байгаа.

Тийм болохоор хэрвээ жоохон дутуу байна гэж үзэх юм бол хэлэлцэх эсэхийг нь шийдээд цаашаа сайжруулаад явах тал дээр О.Цогтгэрэл дарга анхаарч ажиллаасай гэж хүсье.

Н.Учрал: О.Цогтгэрэл дарга, С.Бямбацогт дарга бидний итгэл үнэмшил яг нэг юм. Зах зээл дэх төрийн оролцоог бууруулъя гэж бүгдээрээ л хичээгээд байгаа. Тийм.

Тэгэхээр яаж үр дүнд хүрэх вэ гэдэг дээр ажлын хэсэг дээр аль аль намын төлөөллийг оруулаад үр дүнтэй ажил болгох ёстой.

Б.Найдалаа гишүүн асуулт асууна.

Б.Найдалаа: Төрийн өмчит компаниудыг хувьчлах энэ ажлыг бүрэн дэмжиж байгаа. Яах аргагүй цаг нь хоцорчхоод байгаа зүйл.

Гэхдээ нэг асуулт байгаад байна. Хэдэн асуулт байна.

▷ **Нэгдүгээрт,** 2001-2022 онд 5 удаа хувьчлах тогтоол, шийдвэр гарсан байгаа. Түүний биелэлт нь 33 хувь байна.

Ялангуяа сүүлийн 2022 онд 26 компанийг хувьчилна гээд 2-ыг нь л хувьчилсан байгаа юм.

→ Яг үүн дээр яагаад энэ тогтоол, шийдвэр биелэхгүй байгаа юм?

- Эсвэл угаасаа тийм итгэл үнэмшилгүй, үзэл баримтлалгүй шийдвэр гаргасан юм уу, эсвэл болохгүй байгаа юм уу?
- Энэ дээр дүн шинжилгээ хийсэн үү?

Энэ дээр дүн шинжилгээ хийгээгүй бол өнөөдрийн гаргаж байгаа шийдвэр бас л биелэхгүй.

Тэгэхээр утгагүй шийдвэр болох гээд байгаа юм. Энэ дээр нэг хариулт өгөөч.

▷ **Хоёрдугаарт**, эрчим хүчний салбар.

Эрчим хүчний салбарт цахилгаан эрчим хүч үйлдвэрлэл, дамжуулах, түгээх эдгээр үе шатууд.

- Компаниуд дээр төр ямар оролцоотой байх, ямар бодлого баримталж байна вэ?

Үүнээс хамаараад хувьчлалын бодлого нь хамаарах гээд байна л даа. Либералчилна ч гэдэг юм уу, чөлөөлнө ч гэдэг юм уу ер нь хараад байхад замбараагүй, ямар ч бодлого чиглэлгүй яваад байгаа.

Тэгэхээр үүнийгээ шийдэхгүйгээр хувьчлах руу ханцуй шамлаад орох юм бол бас засаж болохгүй алдаа гарч болно. Бусад улсуудын жишээн дээр ч бас яг тийм юм байна.

Монгол Улсад эрчим хүчний тэр дамжлагууд дээр төрийн өмчийн оролцоо нь яг ямархуу байх юм гэдгийг одоогоос тодорхойлчихоод, түүнийхээ хувьд хувьчлалаа хийхгүй бол дутуу буруу юм вий гэж санаа зовж байна. Энэ дээр яг ямар бодлого байгаа вэ?

▷ **Гуравдугаарт**, Төрийн банкны 51 хувийг төрд үлдээх тухай төсөл байна. Сайн муу, зөв буруу гээгүй.

- Төрийн банк 51 хувь байх нь бид нарт ямар бодлогын хэрэгцээ шаардлага байгаа юм бэ?
- Арилжааны банк эзэмших шаардлага байгаа юу?

Үүнийг яагаад асууж байна гэхээр хэрвээ энэ дээр зөвхөн 49 хувийг нь хувьчлаад 51 хувийг үлдээх юм бол дараа нь хувьчилна гэх юм бол энэ чинь бас нэг хувьчлалын үе шатын хувьд, тактик стратегийн хувьд буруу болоод явдаг. Үр дүнгүй болдог. Хувьчлах сонирхолтой этгээдүүдийн дунд сонирхлын зөрчил ч бий болгодог сургамж ч өмнө байгаа.

Тэгээд энэ дээр анхнаасаа байх ёстой эсэхээ шийдээд, зөв тактик, стратегиа анхнаасаа сонгохгүй бол алдаанд хүрнэ гэж бодож байна.

▷ **Дөрөвдүгээрт**, хөрөнгийн биржээр хувьцаа гаргана гээд гоё ярьж байгаа бид. Үнэхээр сайхан сонсогдож байгаа. Олон нийтэд нээлттэй болно гээд. Энд бас ажлын хэсэгт Хөрөнгийн биржээс, Санхүүгийн зохицуулах хорооноос ч хүмүүс байх шиг байна.

- Хөрөнгийн бирж дээр бүртгэлтэй байгаа төрийн өмчит компаниудын хувьцааны хөрвөх чадвар хэр байдаг юм?
- Мэдээлэл нь нээлттэй байж чадаж байгаа юм уу?
- Түүнийх нь дагуу засаглал нь сайжирч байна уу?

Харахад сайжраад байгаа юм байхгүй. Харин ч том хувьцаа эзэмшигчдээ хөтлөгдөөд амьгүй, хөрвөх чадваргүй, хэн ч авдаггүй, хэнд ч зардаггүй нэг ийм хиймэл хувьчилсан нэртэй болоод байгаа юм.

Энэ дээр хувьцаа гаргана гээд байдаг.

- Яг бодитой биелэх боломж нь байгаа юм уу?
- Хувьцаа нь зарагдах юм уу?
- Ялангуяа цөөхөн 5, 10, 49 хувийг хэн аваад, алдагдалтай компаний ямар хувьцааг нь аваад сууж байх юм бэ?
- Өмнөх тэр хувьчилсан төрийн өмчит компаниудын хувьцааг эзэмшиж байгаа, засаглал нь сайжирч байгаа, хувьцаа гаргасны үр дүн гаргаж байгаа үр дүн дээр дүн шинжилгээ хийсэн юм байна уу?

Эдгээрт хариулж өгнө үү.

Н.Учрал: С.Бямбацогт сайд хариулна.

С.Бямбацогт: Б.Найдалаа гишүүний асуултад хариулъя.

Яагаад биелээгүйдээ дүгнэлт хийсэн үү гэдэг дээр манай Төрийн өмчийн бодлого зохицуулалтынхан хариултаа бэлдэж байгаарай.

Төрийн банкны 51 хувь төрд хэрэгтэй юм уу, яагаад ингэсэн юм бэ гэдэг дээр Төрийн банк, Сангийн яамныхан үндэслэлээ тайлбарлаж бэлдээрэй гэдгийг хэлье.

Энэ дээр нэмээд хэлэхэд бид Төрийн банкиг аль болох илүү хувьчилъя. Урьд нь “Монголын цахилгаан холбоо” гэж компани байсан. Монгол Улсын 330 сум, 21 аймагт үйл ажиллагаа явуулдаг салбартай. Энэ төрд байх ёстой, стратеги аж холбогдолтой салбар гэж үзсээр байгаад бид хувьчлахгүй явсаар байгаад

сүүлд нь хажуугаар нь зэрэгцээд Мобиком, Скайтел, Юнител гээд л компаниуд гарч ирээд өрсөлдөөд өнөөдөр хамгийн жижигхэн, хамгийн ашиггүй компани болсон.

Тэр үед Мобиком дөнгөж байгуулагдаж байсан. Юнител дөнгөж байгуулагдаж байсан. Скайтел дөнгөж байгуулагдаж байсан.

Хувийн хэвшлийнхэн маань өрсөлдөөн дээрээ өрсөлдөөд үйлчилгээ нь илүү хүнд хүрсэн, илүү чанартай болсон, илүү хямдхан болсон. Гэтэл бидний хамгийн их нүдний цөцгий мэт хайрлаж байсан “Монголын цахилгаан холбоо” компани өнөөдөр тэр үед ганцхан салбартай компани байх үед 330 суманд салбартай, 21 аймагт салбартай байсан компани өнөөдөр ингээд ганцхан салбартай болтлоо жижгэрч байгаа юм.

Тийм болохоор бид төрд өмч байх нь зөв үү, буруу юу гэдэг дээр хувийн хэвшилдээ нээлттэй өрсөлдөөнд суурилах юм бол илүү үнэ хямдардаг, чанартай болдог. Энэ бодлогоо анхаарах ёстой байх.

Тэгэхээр Төрийн банк заавал байх хэрэгтэй байна. Хаан банк хажууд нь, бүх банкнууд хоорондоо өрсөлдөөд үйлчилгээ нь иргэдэдээ сайн хүрч байна. Эндээс бодох ёстой.

Гэхдээ Сангийн яам энэ дээр өөрийнхөө байр суурийг тайлбарлах ёстой байх гэж бодож байна.

Эрчим хүчний салбар дээр дамжуулах нь төрд байя. Үйлдвэрлэх, түгээхийг нь бид тодорхой хэмжээнд либералчлал хийе. Тэртээ тэргүй өнөөдөр эрчим хүчний үйлдвэрлэл дээр цахилгаан станцуудыг хувийн хэвшлийнхэн бариад эхэлсэн.

Тийм болохоор төрд байгаа цахилгаан станцын тодорхой хувийг нь хувьд шилжүүлбэ. Ингээд үр ашгийг нь нэмэгдүүлбэ, зардлыг нь бууруулъя, менежментийг нь сайжруулъя, илүү ил тод болгоё, илүү олон нийтийн хараа хяналттай олон нийтийн оролцоотой болгоё.

Ингэх юм бол эрчим хүчний өртөг зардал буурах болов уу гэдэг үүднээс үйлдвэрлэл дээр. Ингээд цаад талд нь дамжуулах дээрээ төрд байж байгаа учраас хэрвээ хэт өндөр үнэтэй үйлдвэрлэх юм бол дамжуулахгүй. Хэрвээ түгээх дээр хэт өндөр үнэтэй худалдах гээд байвал тоогоор хангахгүй. Дамжуулж өгөх тог өгөхгүй. Ийм байдлаар үндсэндээ дамжуулах сүлжээ нь төрдөө байя.

Ингээд түгээх, үйлдвэрлэх хоёр дээрээ тодорхой хэмжээний либералчлал явуулах нь зөв байх гэдэг бодлогыг оруулж ирсэн. Гэхдээ Их Хурал дээр гишүүд маань ярилцаад эцсийн шийдлийг Та бүхэн маань гаргана гэдгийг дахин хэлбэ.

Ингээд манай Б.Цэнгэл дарга, Сангийн яам, Төрийн банкныхныхаа нэмэлт хариулт өгье.

Н.Учрал: Улсын Их Хурлын гишүүн Далайн Батбаяр, Сүхбаатарын Эрдэнэболд нарын урилгаар Сэлэнгэ аймгийн Сүхбаатар сумын ерөнхий боловсролын сургуулийн 12-ын “б”, “в” ангийн багш, сурагчид Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна.

Багш сурагч нартаа сурлагын өндөр амжилтыг хүсье. /алга ташив/

Манай сурагчид их цоглог хөөрхөн харагдаж байна шүү. Баярлалаа.

Улсын Их Хурлын гишүүн Б.Найдалаагийн асуултад Б.Цэнгэл дарга хариулна. 4 дүгээр микрофон.

Б.Цэнгэл: 2022-2023 оны үндсэн чиглэлд 25 компани орсон. 25 компанийн 20 нь АЗЗА /Авто Зам, Засвар, Арчлалт/ байсан. Нэг компани нь 1.5-аас 2 тэрбум төгрөгийн активтай учраас энэ бол нөгөө 5 хувийн гэдэг босго нь үндсэндээ тэглээд энэ фэйлдэх магадлал өндөр байсан учраас бид энэ АЗЗА-г гаргаагүй.

Тэгээд харин активыг нь өсгөх зорилгоор 20 АЗЗА-г нэгтгэж нэг нэгдэл болгож бэлтгэл ажлын хүрээнд энэ зохион байгуулалтын өөрчлөлтийг хийсэн.

Нөгөө нэг асуудал гэвэл цахилгаан холбоо, мэдээлэл холбооны сүлжээ зэрэг компаниудад мэдээлэл холбооны сүлжээг бид стратегийн дэд бүтцийн компани юм байна гэдэг ийм дүгнэлтэд хүрсэн.

Тийм учраас үүнийг ер нь дахиж ярих нь зүйтэй юм гэдэг агуулгаар бид үндэсний оператор компаниудтай хэд хэдэн удаагийн уулзалт хийж байгаад ийм дүгнэлтэд хүрсэн байгаа.

Төрийн банк, Хөрөнгийн бирж хоёр гарсан... /минут дуусав/

Н.Учрал: Ажлын хэсгээс нэмж хариулах уу? Б.Цэнгэл дарга.

Б.Цэнгэл: Та бүхэн мэдэж байгаа. Монголын хөрөнгийн биржээр 34 хувийг гаргасан. Энэ удаад бид 15 хувь буюу 49 хувийг нь нээлттэй болгоё гэдэг байдлаар орж ирж байгаа.

Зүгээр Их Хурлын гишүүд Байнгын хороон дээр 49-өөс илүү хувийг нь биржээр явуулах нь зүйтэй гэдэг санал гарч байгаа. Үүнийг ажлын хэсгийн хүрээнд авч үзэх бололцоотой гэж үзэж байгаа.

Эрчим хүчний салбарын хувьд бид үндсэн чиглэлийн үзэл баримтлал дээр маш тодорхой тусгасан байгаа. Яаж байна гэхээр бид эрчим хүчний салбарын

өсөлтийг нь дэмжиж либералчлах, эрчим хүчний салбарыг чөлөөт зах зээлийн зарчимд шилжүүлж, үнэ тарифыг зохистой түвшинд хүргэх, цаашид тогтмол индексжүүлж байх тогтолцоог нэвтрүүлэх, мөн салбарын эрх зүйн орчныг боловсронгуй болгох гэдэг байдлаар үндсэн чиглэлийн үзэл баримтлалд тусгасан байгаа.

Нэг худалдан авагчын загвараас татгалзаж өрсөлдөөнт зах зээлийн хэлбэр лүү шилжих гэдэг ийм томъёоллоор... /минут дуусав/

Н.Учрал: Б.Цэнгэл дарга нэмж хариулах уу?

Б.Цэнгэл дарга аа, Та ер нь “Монголын цахилгаан холбоо” компанийг хэд дэх удаа хувьчлах гэж оруулж ирж байна? 4 дүгээр микрофон.

Б.Цэнгэл: Монголын цахилгаан холбооны хувьд ерөнхийдөө зах зээлийн зарчмаараа өрсөлдөөнт зах зээлд түрэгдэж үйл ажиллагаа нь үндсэндээ нэлээн хоцрогдсон байдалтай байж байгаа шүү дээ.

Тийм учраас бид үүнийг цаашид төрд байлгаад байх нь зохимжгүй.

Тийм учраас үүнийг үе шаттайгаар нээлттэй болгох, олон нийтийн болгох арга хэмжээг үе шаттай авах нь зүгээр зүйтэй гэдэг байдлаар л оруулж ирсэн юм. Баярлалаа.

Н.Учрал: Тийм. Хөрөнгийн биржийг энэ чинь 100 хувь хувьчилъя гэж орж ирж байгаа. Мөн үү? С.Бямбацогт дарга аа. Тийм ээ. 100 хувь хувьчилъя гэж орж ирж байгаа юу? айн?

Хэдэн хувь хувьчлах гэж орж ирж байгаа юм? Гишүүддээ үүнийг ойлгомжтой яриадхаач. С.Бямбацогт гишүүн.

С.Бямбацогт: Хөрөнгийн биржийн 15 хувийг нь хувьчилъя гэж орж ирж байгаа.

Энэ дээр –

– “Эрдэнэс Тавантолгой” дээр	10 хувь,
– Эрдэнэт үйлдвэр	10 хувь,
– Эрдэнэс критикал минералс	10 хувь,
– Дулааны 3 дугаар цахилгаан станцын	49 хувь,
– Дулааны 4 дүгээр цахилгаан станцын	49 хувь,
– Эрдэнэт ДЦС-ын	49 хувь,
– Дорнод бүсийн эрчим хүчний систем	49 хувь,
– Дарханы дулаан ДЦС-ын	49 хувь,
– Амгалан дулааны станц	49 хувь,

- Төрийн банкны 45 хувь,
- Үндэсний давхар даатгал компанийн 34 хувь,
- Хөдөө аж ахуйн корпорацын 49 хувь,

МИАТ компанийн 10 хувийг нь стратегийн хөрөнгө оруулалт хувьчлаад үнэ цэнтэй болсных нь дараа 24 хувийг нь,

- Шивээ-Овоо компанийн 39 хувь,
- Багануур компанийн 24 хувь.

Үүний урд талд нь тодорхой хувь нь хувьчлагдсан учраас 49 хүртэл хувь болгож үлдсэн хувийг нь хувьчилж байгаа.

“Монголын цахилгаан холбоо” компанийн 44 хувь. Бас 5 хувь нь очсон учраас ингэж оруулж ирж байгаа.

- Хөдөө аж ахуйн биржийн 66 хувь.
- Монголын хөрөнгийн биржийн 15 хувь гэсэн.

Энэ дээр Сангийн яам, Хөрөнгийн бирж, Төрийн банкаас саналаа өгөх ёстой байгаа юм.

Миний хувийн байр суурь Хөрөнгийн биржийг аль болох либерал болгоё, хувьчилъя гэсэн тийм байр суурьтай байдаг.

Гэтэл манайхан Хөрөнгийн биржийг хувьчлах юм бол байр байшин, түүх, соёлын дурсгалтайгаа хамт маш сайн байршилтай газар нь алга болно гэсэн тийм явцуу юм боддог. Бид энэ байрыг нь, энэ газрыг нь төрдөө аваад үлдье. Харин тэр хөрөнгийн биржийн технологи, менежмент, тоног төхөөрөмж, тусгай зөвшөөрөл энэ бүгдийг нь хувьчлаад илүү либерал болгох бололцоотой. Ийм байдлаар шийдэх бололцоотой гэж харж байгаа.

Гэтэл Сангийн яам энд хамаагүй хувьчилж болохгүй гэсэн байр сууриа өгсөн учраас ийм байдлаар орж ирж байгаа гэдгийг Та бүхэндээ хэлье.

Төрийн мэдлийн хувьцааг нь худалдах компаниуд дээр –

- “Монгол шуудан” компанийн 66 хувь,
- Цемент шохой компанийн 100 хувь,
- Дулааны Шарын гол компанин 100 хувь

гээд тодорхой.

Ховд дулааны станц, Налайх дулааны станц, Хөвсгөл дулааны станц. Тэртээ тэргүй хувийн дулааны станц үйл ажиллагаа явуулж байхад түүнтэй төр

өрсөлдөөд өрсөлдөөд байх шиг шаардлагагүй. Үүнийг хувьчлаад, хоёр хувийн компани хоорондоо өрсөлдөөд үнэ тарифаа зохицуулаад илүү үйлчилгээ нь чанартай байх гэдэг үүднээс энэ хувьчлалуудыг оруулахаар оруулж ирсэн гэдгийг хэлье.

Н.Учрал: Хувьчилж болно. Хувьчлаад олсон тэр орлогоо юунд зарцуулах вэ гэдэг нь л тодорхой байхгүй бол энэ чинь ард түмэн хардах эрхтэй гэдэг л ийм л шүүмж яваад байна.

Б.Найдалаа дарга нэмэлт 1 минут.

Б.Найдалаа: Баярлалаа. Энэ дотроос эрчим хүчний салбар дээр үнэхээр эргэлзээ байна.

Яагаад гэвэл энэ дээр жишээлбэл либералчлал гэж ярьж байна. Чөлөөт зах зээл гэж ярьж байна. Цаана нь юу хэлж байгаа, юуг өөрчлөх тухай бид нарийн тодорхой төсөөлөлгүй, нэгдсэн бодлогогүй байгаа байхгүй юу.

Жишээлбэл, дамжуулахыг төрд аваад бусдыг нь хувь байх юм бол үнийг тогтооно гэж. Тэр худлаа. Одоо хувийн тоглогчдыг оруулах нь яах аргагүй зөв. Урих нь зөв. Бүр олноор нь нэмэх хэрэгтэй.

Гэхдээ яг одоо барьж байгаа цахилгаан эрчим хүчний үнийг бага барьж байгаа чинь яг шулуухан хэлэхэд ТЭЦ-4 шүү дээ. Тэгээд яг ТЭЦ-4-ийн жишээлбэл тэр төрийн өмчит үйлдвэрлэгчдийн хэдэн хувийг нь, тэр цөөхөн хувийг нь хэн ямар бодлоор аваад сууж байх юм бэ?

Түүний цаана ингэнэ тэгнэ гээд тодорхой бодлого байхгүй бол үнэхээр эргэлдэж байна. Эрчим хүчний салбар дээр улс төрийн манлайлал үнэхээр байхгүй байна.

Дарга аа, нэмээд минутаа авъя.

Н.Учрал: Энэ чинь юу болж байгаа билээ? Хугацаа дууссан биз дээ. Хоёр удаа тодруулаад байна.

Нэмэлт 1 минут.

Б.Найдалаа: Тийм. Одоо жишээлбэл энэ дээр бид дураараа төрийн өмчит компаниуд гээд асар үнэ цэнтэй хүн амьтан бүгдээрээ бизнесийнхэн булаацалдахын юм шиг төсөөллөөр хийгээд байх шиг байна л даа. Энэ чинь компани компаниасаа, салбар салбараасаа өөр.

Жишээлбэл, 15 хувийг нь хувьчилна гэсэн байгаа юм. 34 хувийг хувьчилна гэсэн байгаа юм. Хэн яг үүнийг сонирхоод биржээр дамжуулаад хувьцааг нь

аваад, дараа нь хувьчлагдахаар нь 51 хувийг нь авна, 100 хувийг нь авна гээд сууж байх юм бэ? Яг ингээд бодитой бодитой эрэлтийн санхүүгийн, тэр хөрөнгө оруулагчийн сонирхлын тооцоо байхгүй байгаа байхгүй юу.

Булаацалдаад авна гэсэн төсөөлөл байх юм. Яг үнэндээ 15 хувийг Та бүхэн төсөөл дөө. Төрийн өмчийн 15 хувийг аваад, мөнгөө оруулаад юуг нь өөрчилнө, юунд нөлөөлөөд, яаж үр өгөөжөө авна гээд сууж байх юм. Ингээд бодохоор энэ чинь бодитой биш байгаа байхгүй юу.

Тэгэхээр хувьчлал бараг пүл пал гэдэг юм уу, яг тодорхой хувьчлах юмаа хувьчилсан шиг хувьчлаад, хувьчлахгүй гээд хувьчлахгүй байсан нь дээрээ.

Тэгээд дээр нь дарга аа, Санхүүгийн засгийн хорооноос тэр биржийн талаар асуулт асуусан. Хариулаагүй байгаа. Түүнээс хариулт авъя. Бирж яг өөрөө бэлэн юм уу? Одоогийн компаниудын үр дүнтэй хувьцаат компаниуд. Төрийн өмчит ажиллаж байгаа юм уу?

Н.Учрал: Санхүүгийн зохицуулах хороо хариулъя.

Дээрээс нь Хөрөнгийн биржийн захирал гэж шинэ хүн хаана байна? Та нар хариул. Хөрөнгийн бирж гол нь бэлэн үү? Монголын хөрөнгийн биржээр компаниуд хувьцаагаа нээлттэй арилжаалах тийм потенциал байна уу? Үнэнээ хэлнэ шүү. 3 дугаар микрофон.

Б.Дөлгөөн: Та бүхэнд энэ өдрийн мэнд хүргэе.

Санхүүгийн зохицуулах хорооны үнэт цаасны газрын дарга Б.Дөлгөөн байна. Б.Найдалаа гишүүний асуултад хариулъя.

Гишүүний хэлсэнчлэн мэдээж 2022 оны батлагдсан үндсэн чиглэлийн дагуу 25 компани байгаа. Нэмээд Төрийн банк бас хувьчлах жагсаалт нь ороод гарсан.

Үүнтэй холбогдуулаад “Монголын Хөрөнгийн Бирж” болон Төрийн банк хоёр 2022 он болон 2023 онд амжилттайгаар хувьцаагаа олон нийтэд санал болгоод хувьчлах үйл ажиллагаа амжилттай хэрэгжиж дууссан байгаа.

Нөгөө талаас “Монголын Хөрөнгийн Бирж” дээр мөн “Монголын цахилгаан холбоо” болон үндэсний давхар даатгал хувьцаат компаниуд мөн адил хүсэлтээ өгөөд холбогдох шийдвэрүүдийг гаргасан байдаг.

Санхүүгийн зохицуулах хороонд үндэсний давхар даатгалыг 2023 онд, Монголын цахилгаан холбоог 2024 онд тус тус бүртгэх шийдвэр нь гарсан. Гэхдээ тус компанийн хувьд үндсэн хөрөнгө... /минут дуусав/

Н.Учрал: Хариултаасаа эхэлмээр байна. Оршилгүйгээр. 3 дугаар микрофон.

Б.Дөлгөөн: Одоогийн байдлаар “Монголын Хөрөнгийн Бирж” дээр нийтдээ 13 компани байгаа.

Тэгээд компаниудын хувьд бид бүхэн сүүлийн жилүүдэд оруулсан томоохон өөрчлөлтийн хүрээнд компанийн засаглалыг сайжруулах дээр компанийн засаглалын кодексыг баталсан байгаа.

Тэгэхээр энэ кодексын дагуу мөрдөж хэрэгжүүлэх шаардлагатай. Кодексын хувьд мөн адил төрийн өмчит болон хувийн хэвшлийн ямар ч компани ялгалгүй үйлчлэх зохицуулалттай буюу төлөөлөн удирдах зөвлөл, жижиг хувьцаа эзэмшигчдийн эрх ашгийг хамгаалах хүрээнд хийгдэх тодорхой шаардлагатай мэдээллийн ил тод байдлыг хангуулах. Эдгээр дүрэм журмууд нь олон улсын стандартад нийцсэн буюу IOSCO-гийн (International Organization of Securities Commissions) үндсэн зарчмууд нийцсэнээр баталсан байгаа юм.

Н.Учрал: Биржийн захирал хаана байна? Шинэ Хөрөнгийн биржийн захирал юу бодож санаж байна?

Хөрөнгийн биржийн захирал үнэнээ хэл. Боломж байгаа юм уу, байхгүй юм уу? Танай биржээр энэ олон компаниудыг хувьцааг нь гаргаад, гадна дотнын мэргэжлийн хөрөнгө оруулагч нар орж ирж чадах юм уу?

3 дугаар микрофон.

Д.Мөнхбат: “Монголын Хөрөнгийн Бирж” хувьцаат компанийн гүйцэтгэх захирлын үүрэг гүйцэтгэгч Д.Мөнхбат.

Б.Найдалаа гишүүний асуултад хариулья.

2025 оны 12 дугаар сарын байдлаар Хөрөнгийн биржийн нийт зах зээлийн үнэлгээ 13 их наяд 250 тэрбум төгрөг байна. Үүнээс хөрвөх чадвар ойролцоогоор 5-аас 6 жил буюу сүүлийн 3 жилийн дунджаар жилд 1.2-оос 1.3 их наяд төгрөгийн үнэт цаасыг арилжаалсан эргэлттэй байдаг.

2023 онд олон улсын KPMG⁵ (Klynveld Peat Marwick Goerdeler) байгууллагын хийсэн судалгаагаар нийт retail зах зээл дээрээс 2.8 хүртэл их наяд төгрөгийн эх үүсвэрийг татах боломжтой гэсэн судалгаа гарсан байдаг.

⁵ Дэлхийн аудитын 'Их дөрвөл'-ийн нэг KPMG нь олон улсын түвшинд санхүү, аудит, стратегийн зөвлөх үйлчилгээ, хөрөнгийн үнэлгээ болон зах зээлийн нарийвчилсан судалгаа хийдэг байгууллага.

Засаглалын хувьд хөрөнгийн бирж өөрөө IPO⁶ (Initial Public Offering) хийснээр 34.0 хувийг гаргасан төлөөлөн удирдах зөвлөлийн 9 гишүүнийх нь дийлэнх олонх буюу 5... /минут дуусав/

Н.Учрал: Баярлалаа. Боловсролтой чадалтай хүмүүс мэдээж төрийн өмчит компаниудыг удирдаж байгаа гэдэгт би итгэж явдаг.

Гэхдээ хариултаасаа эхэл гээд байна шүү дээ. Би. Оршил нь ихдээд хариулт нь 1 минутад багтахгүй байна. 3 дугаар микрофон. Хариултаасаа эхэлье. Шууд хариулъя.

Д.Мөнхбат: Ер нь олон улсын жишгээ харах юм бол ихэнх хөрөнгийн биржүүд олон нийтэд нээлттэй, хувийн хэвшлийн эзэмшил нь дийлэнх байдаг.

Тэгэхээр энэ жишгээ дагаад дийлэнх хувьцааг нь хувийн хэвшилд хувьчлах нь зөв гэж би хувь хүнийхээ хувьд үзэж байгаа.

Түрүүн засаглалын асуултад нэмж хариулахад 9 гишүүний 5 нь хараат бус байдаг. Мөн төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны хяналтыг жижиг хувьцаа эзэмшигчдээс бүрдсэн хяналтын зөвлөл бас давхар хийж явдаг.

Тэгэхээр засаглалын хувьд хувьцаат компани болсноороо давуу талууд бий болж байгаа.

Н.Учрал: Хөрөнгийн биржийг удирдах чадвар байна уу? Өмнөх Б.Дөлгөөнөөс дээрдэх юм байна уу? Өөрт чинь. Б.Дөлгөөн чинь айхтар муу ажиллаад явсан гээ биз дээ. Уг нь дажгүй ажиллаж байсан шүү дээ.

3 дугаар микрофон.

Д.Мөнхбат: Миний хувьд олон улсын зах зээл дээр болон дотоодын зах зээл дээр үнэт цаасны компаниудад ажиллаж байсан туршлагатай хүн байгаа. Тэгээд одоо өөрийн туршлагаа... /минут дуусав/

Н.Учрал: Сайн ажиллаарай. Амжилт хүсье.

Нөхцөл нь бүрдэж болохгүй байна шүү дээ.

Тэгэхээр бид дэмжих хэрэгтэй. Компанийнх нь хуулийг нь гаргаж өгмөөр байна. Тэгээд хүнээсээ болоод байгаа юм алга байна шүү дээ.

Тийм учраас компанийн хууль, тэр өмчийн хууль хурдан гаргаж өг гээд жил болж байгаа шүү дээ.

⁶ Хувьцаагаа анх удаа олон нийтэд санал болгох.

Тэгээд Б.Цэнгэл дарга ч гэсэн хууль нь гараагүй учраас ажил хийхэд нь үнэхээр нөхцөл хүнд. Тэгээд хуулийг нь Д.Үүрийнтуяа гишүүн ахална. П.Сайнзориг гишүүн, О.Номинчимэг гишүүн та гурав энэ 3 сарын 15-нд эхний хоёр долоо хоногт оруулж ирээд батлахгүй бол яг ийм байдалтай л байна. Хуулиа гаргая.

Бадарчийн Хэрлэн гишүүн асуулт асууна.

Б.Хэрлэн: Тэгэхээр төрийн өмчийн үйлдвэр аж ахуйн газруудыг хувьчлах замаар хөрөнгө оруулалтыг татах, үр ашгийг нь дээшлүүлэх, засаглалыг сайжруулах гэсэн бодлогыг зарчмын хувьд дэмжиж байгаа.

Гэхдээ хувьчлалын өгөөж, үр дүн хувьчлалын өмнөх бэлтгэл ажил, хувьчлалын дараах хяналт, хариуцлагын бодлогоос ихээхэн хамаарна гэж бодож байгаа. Тэгээд энэ хүрээнд хоёр асуулт асууя.

Тэгэхээр төрийн өмчийн үйлдвэрийн газруудад өнөөдөр Монгол Улсын ажиллах хүчний 10 хувь нь ажиллаж байгаа гэсэн ийм статистик тоо бий.

Тэгэхээр хувьчлалд бэлтгэх ажлын хүрээнд төрийн өмчийн үйлдвэрийн газруудад ажиллаж байгаа ажиллах хүчний талаар ямар бодлого авч хэрэгжүүлэх гэж байна вэ гэж би асуух гэсэн юм.

Ер нь ажилтай нь байлгах уу, эсвэл ажлаасаа өөрчлөгдөх болов уу? Энэ хүмүүсийг дахин сургаж ажлын байранд зуучлах, ажилтай орлоготой байх нөхцөл боломжийг нь хангах талаар тодорхой ямар бодлого энэ ажлын хүрээнд хийгдэж байгаа бол.

1990-ээд оны дундуур их хувьчлал, бага хувьчлалын үед олон мянган хүн ажилгүй гудамжинд гарч байсан. Тэр үед бүр “**бүтцийн ажилгүйдэл**” гэдэг нэр томъёо хүртэл гарч байсан.

Тэгэхээр энэ гашуун сургамжаа санасан ч тэр, бид энэ тухай асуудлыг онцгой анхаарч авч үзэхгүй болохгүй. Тэгээд ч Монгол Улсын 2026-2030 онд хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэлд “Хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх замаар ядуурлыг бууруулна.” гэсэн том зорилго орж ирсэн байгаа.

Тэгэхээр төрийн бодлого уялдаатай байх ёстой. Энэ утгаараа хувьчлалын асуудлын хүрээнд төрийн өмчийн үйлдвэрийн газар ажиллаж байгаа хүмүүсийн ажилтай орлоготой байх асуудлыг цаашид яаж шийдвэрлэх гэж байна вэ гэдэг дээр энэ асуултыг би асууя гэж бодож байна.

Хоёрдугаарт нь, эрчим хүч, тээвэр, дэд бүтэц, уул уурхай, санхүүгийн салбар гээд ард иргэдийн өдөр тутмын амьдралд шууд нөлөө үзүүлж байдаг, бас

улс үндэстний аюулгүй байдалд нөлөө үзүүлэх ийм стратегийн салбаруудад хувьчлал хийхээр орж ирж байгаа.

Тэгэхээр хувьчилсны дараа тавих хяналт, хариуцлагын тухай дээр ямар бодлого авч хэрэгжүүлэх гэж байна вэ гэж би хоёрдугаарт нь асуумаар байна.

Ялангуяа цахилгаан, дулааны үйлдвэрээ. Тийм ээ. Түгээх сүлжээгээ дэд бүтцийг нь салгаад хувьчлахаар орж ирж байна л даа. Ингээд салгаад хувьчлахаар чинь үйл ажиллагааных нь уялдаа нь алдагдвал яах вэ? Үүнээс болоод эцсийн хэрэглэгч иргэд, аж ахуйн нэгжүүдийн тоггүй, дулаангүй болбол яах вэ? Манайх чинь өвөлдөө хасах 30 хүрч хүйтэрдэг.

Тэгэхээр аягүй бол цонхоороо яндангаа гаргаад суух тийм хэмжээнд хүрэх вий дээ. Тийм ээ. Үнэ төлбөр нь өсөөд явах вий дээ.

Тэгэхээр үүнийг зохицуулах тухай дээр ямар бодлого авч хэрэгжүүлэх гэж байгаа юм бол?

Тэгэхээр ер нь хувьчилсаны дараа гарч болох энэ бүх эрсдэлүүдийг хэрхэн яаж урьдчилан тооцож байгаа юм бол? Энэ дээр тавих хяналт, хариуцлагыг хэрхэн яаж хэрэгжүүлэх гэж төлөвлөж байгаа юм гэж би хоёрдугаарт нь асуумаар байна.

Н.Учрал: Ц.Баяр-Эрдэнэ дарга хариулна. 3 дугаар микрофон.

Ц.Баяр-Эрдэнэ: Гишүүний асуултад хариулья.

Төрийн өмчит компаниудад нийтдээ 59 мянга гаруй ажилтан, албан хаагчид ажиллаж байгаа.

Бид биржээр худалдах, арилжих компаниуд дээр биржийн шалгуур шаардлагыг хангасан олон дүрэм журмын зохицуулалтууд, Санхүүгийн зохицуулах хорооны зөвшөөрөл зэрэг бэлтгэл ажлыг хангах тодорхой ажлууд хийгдэнэ.

Ер нь олон нийтийн болгох, биржээр хувьчлах, мөн төрийн мэдлийн хувьцааг худалдах үед ажиллагсад нэлээд сэтгэл түгшингүй асуудлууд байдаг. Яагаад гэхээр цомхотголд орох вий, биднийг бүтцийн өөрчлөлтөөр халах вий гээд.

Тэгэхээр энэ асуудлууд Хөдөлмөрийн хууль болон холбогдох хууль тогтоомжийн хүрээнд хэрэгжээд явах бололцоотой гэж үзэж байгаа.

Бид биржээр нээлттэй арилжих компаниудын нэмэлт хувьцаа гаргаж байгаа тохиолдолд нэмэлт төсөл, хөтөлбөрүүд орж ирэх, prospectus_{[үнэт цаасны}

танилцуулга] орж ирэх, түүнд нь хөрөнгө оруулагчид өгөөж, үр бүтээлийг нь үнэлж дүгнээд хөрөнгөө оруулж ирэх учир юу юугүй олон хүн ажлаасаа чөлөөлөгдөөд явах нь гайгүй байх гэж дүгнэж байгаа.

Зүгээр төрийн мэдлийн хувьцааг энгийн хувьцаа гаргах замаар арилжаад, түүний тодорхой хувийг төсөвт төвлөрүүлэх асуудал дээр хувьцаа худалдан авагч талтай энэ ажиллагсдын нийгмийн асуудлыг шийдвэрлэх чиглэлээр тухайн байгууллагын үйлдвэрчний эвлэлтэй нь хамтраад ажиллах бололцоотой гэж үзэж байгаа.

Ер нь өмнөх туршлагуудаас харахад шууд хувьцааг бүхэлд нь худалдаж авч байгаа тохиолдолд хөрөнгө оруулагч талтай худалдах, худалдан авах гэрээн дээр тодорхой зохицуулалт хийгээд явж ирсэн байдаг. Тухайлбал, Оргил рашаан сувиллыг хувьчлах үед ажиллагсдыг үндэслэлгүй чөлөөлөх асуудлыг байж болохгүй ээ гэдэг байдлаар тусгай зохицуулалтууд хийгээд явах бололцоотой гэж үзэж байна.

Ер нь хоёр дахь багц асуудал хувьчлалын дараах хяналт, мониторинг, хувьчлал хийгдээд тодорхой үр дүн, зорилтоо хэрэгжүүлж чадаагүй бол хувьчлалыг зогсоох, цуцлах зохицуулалтууд төрийн болон орон нутгийн өмчийн хуульд тодорхой зохицуулалтууд байгаа.

Бирж дээр гараад яг биржийн шалгуур шаардлага хангаад, хөрөнгө оруулагчид хувьцаагаа орж ирээд аваад явсан тохиолдолд нээлттэй хувьцаат компани хөрөнгө, үнэт цаасны зах зээлийн зарчмаараа явна.

7 компани байгаа. Орон нутагт үйл ажиллагаа явуулж байгаа дулааны станцуудын төрийн мэдлийн хувьцааг худалдахдаа худалдах, худалдан авах гэрээнд ажиллагсдыг үндэслэлгүй цомхотгох, чөлөөлөх, тэдний цалин цавгийг бууруулах, мөн ажил үйлчилгээг тасалдуулах, мөн үндсэн үйл ажиллагааны зорилт, чиглэлийг өөрчлөх зэрэг хориглосон хязгаарлалтуудыг тавьж өгөхөөр төлөвлөж байгаа.

Н.Учрал: Ц.Баяр-Эрдэнэ даргад баярлалаа. Одоо хэн бэ? Эрчим хүчний яамны Төрийн нарийн бичгийн дарга Б.Ерэн-Өлзий. 4 дүгээр микрофон.

Б.Ерэн-Өлзий: Б.Хэрлэн гишүүний асуултад хариулъя.

Ер нь эрчим хүчний салбар яг бүтцийн сегментийнхээ хувьд ямар байдаг вэ гэхээр –

- үйлдвэрлэх,
- дамжуулах,
- түгээх,
- хангах –

гэсэн 4 сегментэд байдаг юм.

Тэгэхээр үйлдвэрлэх, хангах дээр нь өрсөлдөөн үүсгэх гол боломж нь байдаг. Дамжуулах, түгээх дээр нь бас байгалийн энэ монопол бүтцүүд байдаг.

Манай улсын хувьд яг үйлдвэрлэх, хангах дээр өрсөлдөөн үүсгэх боломж байна гэж бид үзэж байгаа.

2015 онд Төрөөс эрчим хүчний талаар баримтлах бодлогын баримт бичиг Улсын Их Хурлаар батлагдан гарахад аль болохоор үйлдвэрлэлийн салбарыг хувийн хэвшилд хариуцуулсан өрсөлдөөнт зах зээлийн тогтолцоотой улс орон болно гэсэн алсын хараатай байсан.

Тэгэхээр одоо чуулганаар оруулж ирж байгаа энэ үндсэн чиглэл дээр цахилгаан үйлдвэрлэх компаниудын 49 хүртэл хувийг хувьчлах асуудал нь тухайн үед гарч байсан бодлогын баримт бичигтэйгээ нийцээд л явж байгаа гэсэн үг.

Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ... /минут дуусав/

Н.Учрал: Болсон уу? Ажлын хэсгээс хариулт. Гүйцээгээд 4 дүгээр микрофон хариулъя. Б.Ерэн-Өлзий дарга.

Б.Ерэн-Өлзий: “Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ” Улаанбаатар хотын бараг 95 хувийн айл, өрхөд хүрч ажиллаж байгаа. Цахилгаан, дулааныг түгээх, хангах үйл ажиллагааг эрхэлж байгаа компани.

Тэгэхээр энэ компаниасаа эхлээд түгээх, хангах үйлчилгээг нь хоёр тусад нь болгож жигдлээд, тэгээд хангах үйлчилгээг нь хувьчлах бүрэн боломжтой байгаа.

Тэгэхээр түгээх нь тодорхой хугацаанд төрийн хяналтад үлдэж болно. Хангах буюу хэрэглэгчтэй харьцдаг, хэрэглэгчдэд үйлчилгээ, борлуулалтыг нь хариуцдаг үйлчилгээг нь хувьчлах боломжтой.

Тэгээд яг энэ агуулгаараа “Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ” компанийн түгээх, хангахыг бүтцийн өөрчлөлт хийнэ гэсэн агуулгаар төсөл орж ирсэн байгаа.

Н.Учрал: Баярлалаа.

Улсын Их Хурлын гишүүн Жадамбын Энхбаярын урилгаар Шарын голын уурхайчид Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна.

Та бүхэнд уул уурхайн салбар үүсэж хөгжсөний түүхт 103 жилийн ойн мэндчилгээг өргөн дэвшүүлье. Ажлын амжилт хүсье. /алга ташив/

Н.Алтаншагай гишүүн асуулт асууна.

Н.Алтаншагай: Хэдэн тодруулах зүйл байна.

Өмч хувьчлалд их болгоомжтой хандаж байгаа юм. Учир юу вэ гэхээр 1992-2000 онд хийсэн өмч хувьчлал ерөнхийдөө бүгд л монголчуудын хуудуутай болсон гэсэн ойлголттой болсон. Тухайн үеийн эрх мэдэлтэй, мэдээлэлтэй дарга нар үүнийг ерөнхийдөө хувьчлаад авсан ийм л дүр зурагтай байдаг шүү дээ.

Тэгээд тэр компанид ажиллаж байсан, төрийн өмчид ажиллаж байсан бүх ажилчин, албан хаагчдыг нь бүгдийг нь ер нь гудамд гаргасан. Яг дампуурал болсон шүү дээ. Маш олон төрийн өмчит компаниуд хувьд шилжсэн.

Сая ярьж байгаа мэдээллээр энэ ажилчин, албан хаагчдыг нь аваад үлдэнэ, цомхотгохгүй ээ л гэж байна. Энэ ер нь маш бэрхшээлтэй шүү. Ерөнхийдөө авсан компани, тэр хувь эзэмшиж байгаа компанид менежмент хийгээд л үр ашгийг нэмэгдүүлнэ. Тэгээд л баахан ухаалаг юм яриад л, хавчиж гадуурхсаар байгаад л ажилчин, албан хаагчдыг нь цомхотгоод, бүр байж суух газаргүй болгоод өргөдлийг нь өгүүлээд бүгдийг нь гаргадаг шүү дээ.

Энэ стратегийн суурилсан төрийн өмчит компани гээд цахилгаан, дулаан, эрчим хүчтэй холбоотой компаниуд байна. 51 хүртэл төрд байна гэж байгаа юм. Эрдэнэт дээр бид бүхэн бас мэдэж л байгаа шүү дээ. 49, 51 гээд худалдаад авсан. Хоёр тал болсон. 49-ийнхэн 51-ийнхэн гээд л дотроо бөөн маргаантай байдаг. Тендер худалдан авалт нь бүгд хэрүүлтэй, маргаантай ийм л юм дуулддаг байсан шүү дээ. Энэ бол давтагдах магадлал нэгдүгээрт өндөртэй.

Хоёрдугаарт, яг өмч хувьчлал хийгдээд яг үр өгөөжөө өгсөн хамгийн сайн жишээг нэгийг хэлээдхээч.

2015 онд хувьчлагдсан цемент шохой. Хөтөлийнх билүү? Энэ үйлдвэр буруу өмч хувьчлал хийгдсэн байна гээд 2022 онд буцаагдсан. 1.3 тэрбум төгрөгөөр хувьчилсан юм билээ. Эргээд авсан чинь 800 тэрбум төгрөгийн өртэй. Бүх шатын шүүхийн маргаантай байгаа. Энэ хувьчлагдана гээд ороод ирсэн байна. Шүүхийн маргаан дуусаагүй байхад дахиад энэ процесс руу шилжиж болох юм уу?

Өмчгүй төр хүчгүй гэж нэг л өдөр энэ стратегийн ач холбогдолтой төрийн өмчит компаниудыг хувьчилдаг. Үнэ нэмлээ, ажил хаялаа гээд крантаа хаахад бид яаж ч чадахгүй шүү дээ. Царай алдаад л аманд нь багтаад л үнэ нэмэгдэнэ.

Тэгэхээр энэ дээр яг хамгаалалт хийж чадаж байгаа юм уу? Энэ орж ирж байгаа хуулиуд дээр.

Тэгээд энэ төрийн өмчит компаниудыг хувьчлаад хэдий хэмжээний төгрөг төвлөрч юунд зарцуулагдах юм? Энэ дээр хариулт авъя. Нэмэлт тодруулга авъя.

Н.Учрал: С.Бямбацогт сайд хариулна.

С.Бямбацогт: Н.Алтаншагай гишүүнээс болгоомжилж байгаа зөв өө.

Өмнө нь алдаа гарахаар тэр алдаа маань үнэхээр хар толбо болж цаашдаа дахиад ийм эрсдэл үүсэх вий гэж иргэд болгоомжилдог, эсэргүүцдэг, дургүйцдэг шалтгаан болсон.

Тийм болохоор энэ алдааг бид давтахгүй байх ёстой.

Тийм болохоор 2000 оноос хойш өмч хувьчлал нэг их тийм сайн яваагүй. Ялангуяа 2020 оноос хойш олигтой үр дүн гарахгүй байгаа. Үүнтэй холбоотойгоор.

Нэг талдаа төр данхайгаад байна, төрийн өмчит компаниуд томроод байна, үр ашиггүй байна. Дарга, Их Хурлын гишүүдийн цүнх баригч нар очиж томилогдоод байна. Хувийн хэвшлийн орон зайг булааж аваад байна гэдэг шүүмжлэл байгаад байдаг. Нэг талдаа.

Төр данхар байна шүү дээ. Төрийн өмчит компаниуд чинь хэтэрхий том байна шүү дээ. Үр ашиггүй байна шүү дээ гээд.

Үүнийг л бид олон нийтэд нээлттэй болгоё, олон нийтийн, тэр дундаа хувийн хэвшил, иргэдийн оролцоотой болгоё. Оролцоотой болох тусмаа тэр өмчийн эзэн болж байгаа хүн чинь илүү хяналтаа тавина, илүү үр ашигтай байлгаж, хөрөнгийн өгөөжийг хүртэхийг бодно.

Ийм боломжийг бий болгоод эхлэхээр тэр төрийн өмчит компаниуд дээр байж байгаа хулгайнууд тасарна, шахаанууд алга болно, элдэв дарга нарын цүнх баригч нар очихоо болино гэдэг үүднээс.

Одоо манай Их Хурлын гишүүдээс авхуулаад бүгд ярьдаг. Ерөөсөө л хэтэрхий төрийн өмчит компаниуд чинь арай л дэндүү байна шүү дээ, үр ашиггүй байна шүү дээ, үрэлгэн байна шүү дээ гээд. Үүнийг зохицуулах нэг шийдэл бол энэ гэж.

Тэгээд үүнтэй холбоотой. Энэ удаа бас нэг амжилттай болох болов уу гэж бодож байгаа бодол бол бид Нийтийн өмчийн тухай хуулийг Их Хуралд 2025 оны 1 сард өргөн барьсан. Төрийн өмчит компаниудын засаглал, ил тод байдал, үр

ашгийг нэмэгдүүлэх тухай хуулийг бид 2025 оны 5 сард Засгийн газраас өргөн барьсан.

Энэ 2 хуулийг сая Их Хурлын дарга хэлж байна. О.Номинчимэг гишүүн, П.Сайнзориг гишүүн, Д.Үүрийнтуяа гишүүд ахалж байгаа гэж байна. Хурдан энэ хаврын чуулганаар батлаад, энэ хууль дээр таны болгоомжилж байгаа бүх болгоомжлол, компанийн засаглалтай холбоотой, зардал орлоготой холбоотой, хөрөнгийн үнэлгээтэй холбоотой гээд бүхий л зүйлүүд бүгд орсон байгаа.

Энэ бүх зохицуулалтууд удирдлага, зохион байгуулалттай холбоотой. Энэ бүгдийг энд тусгасан учраас энэ дээр таны ярьж байгаа тэр 49, 51-ийн хоорондын зөрчил, 34 хувь эзэмшиж байгаа жижиг хувьцаа эзэмшигчдийн эрх ашгийг хэрхэн яаж хамгаалах вэ, хангах вэ. Энэ бүх асуудлууд орж байгаа.

Энэ хуулиар батлагдаад, араас нь энэ асуудал явах учраас энэ гурав маань хамтдаа явахаар илүү үр дүнтэй, үр өгөөжтэй, илүү өмнөх алдаанаас сургамж аваад алдаа давтагдахгүй, нээлттэй, ил тод явах боломж бүрдэнэ ээ л гэж харж байгаа.

Сайн жишээний талаар манайхан ярих ёстой байх. Хөтөлийн цемент шохойн үйлдвэр муу жишээ. Хэрвээ энэ өмч хувьчлал дээр өмнөхтэй адилхан ийм муу алдаа гарах юм бол хариуцлага тооцох, олон нийт мэдэх, эргээд хариуцлага тооцох бололцоо нь өмнөх цаг үеийн. 90-ээд он бол хаалттай, мэдээлэл багатай. Мэдээлэл багатайг далимдуулж юм хийдэг байсан бол одоо тийм цаг үе өнгөрсөн.

Тийм болохоор тийм алдаа давтагдахгүй байх.

Н.Учрал: Энэ ажил мэдээж үе үеийн Засгийн газрын хийж гүйцэтгэсэн үүргүүдийн нэгдэл.

Л.Оюун-Эрдэнийн Засгийн газрын үед Төрийн өмчит компанийн бүтээмж, засаглал, ил тод байдлыг сайжруулах хууль. Тухайн үед би Хэрэг эрхлэхийн сайд байхдаа энэ ажлын хэсгийг ахалж, манай Б.Цэнгэл дарга бид хамтран боловсруулсан.

Г.Занданшатар дарга шинэ Засгийн газар байгуулагдаад энэ Нийтийн өмчийн хуулийг өргөн мэдүүлсэн.

Тэгэхээр Нийтийн өмчийн хууль, Төрийн өмчит компанийн хууль бол Л.Оюун-Эрдэнийн засаг буюу хамтарсан засаг ажиллаж байхад боловсруулсан хууль.

Тэгэхээр энэ бол аль аль намын төлөөлөл энэ хуульд оролцсон гэсэн үг.

Тэгэхээр энэ бол маш олон санааг шингээсэн хууль учраас ямар нэгэн улс төржилтгүйгээр батлагдах бүрэн бололцоотой хууль.

Тэгэхээр хурдан хугацаанд бид батлах хэрэгтэй. Ингээд С.Бямбацогт даргын ажил хийх нөхцөлийг нь бүрдүүлж өгөх хэрэгтэй. Тэгээд араас нь Их Хурлын гишүүд шаардлагаа тавиад явах бололцоо бүрдэнэ. Гэсэн хэдий ч Засгийн газар хурдан хугацаанд хууль батлагдаагүй ч энэ үндсэн чиглэлийг оруулаад ирж байгаа нь маш сайн хэрэг.

Тэгэхээр үүнийг бид ажил болгоё.

Одсүрэнгийн Номинчимэг гишүүн. Н.Алтаншагай гишүүн тодруулах юм байна. Н.Алтаншагай гишүүн тодруулъя.

Н.Алтаншагай: Хөтөлийн цемент шохойн үйлдвэр дээр хангалттай мэдээлэл өгсөнгүй. Энэ дээр нэмэлт мэдээлэл, тайлбар авъя.

Төр хэдий алдагдалтай ч гэсэн алдагдлаа үүрээд ачаагаа үүрч явах бодлогын юмнууд байгаа шүү гэдгийг анхааруулан хэлье. Тэр нь зөв байх.

Төрийн өмчит компаниуд дээр менежментийг сайжруулах, улс төрөөс ангид байх дээр яг бодит ажил байна уу? Нэгдүгээрт.

Хоёрдугаарт, сонгон шалгаруулалт нь яг журмынхаа дагуу явж чадаж байна уу? Хэн нэгний захиалгаар л яваад байх шиг. Тэрний хүн томилогдсон юм гэнэ лээ, энэ тэрийг зүтгүүлж байгаад тавигдсан юм гэнэ лээ гээд л. Улс төрийн хүрээнд ийм ярианууд зөндөө л дуулдаж байдаг шүү дээ. Тэр тэрийг яваад лоббидоод байна гэнэ. Тэгээд сонгон шалгаруулалт нь ороод тэнцэж гэнэ ээ гээд л зөндөө л чихэнд дуулдаж байдаг шүү дээ. Энэ дээр би тайлбар, тодруулга авмаар байна.

Н.Учрал: Хөтөлийн цемент хариулах уу? Б.Цэнгэл дарга хариулъя. 4 дүгээр микрофон.

Б.Цэнгэл: Тухайн үеийн Хөтөл буюу “Бэйсмент” компани Хөгжлийн банкнаас 61.2 сая америк долларын зээл аваад өдий хүртэл төлөөгүй явж ирсэн.

Үүний хүү, торгууль, алданги нийлээд өнөөдөр 450 орчим тэрбум төгрөгт хүрсэн байгаа. Энэ нь Монгол Улсын Хөгжлийн банкны чанаргүй зээлийн 30 гаруй хувийг бүрдүүлж байгаа.

Зөвхөн энэ асуудалтай холбогдуулаад 300-аад орчим тэрбум төгрөгийн эрсдэлийн фонд үүсгэсэн явж байгаа юм.

Энэ асуудлыг бид Засгийн газар дээр яриад ажлын хэсгийн хүрээнд одоо засаг руу нэг асуудал оруулах гэж байна. Тэр нь Монгол Улсын Хөгжлийн банк, Хөтөлийн цемент шохойн тодорхой хувьцааг Хөгжлийн банк дээр шилжүүлж авах ийм хувилбар яригдаж байгаа.

Мөн хууль хяналтын байгууллага дээр явж байгаа шүүх маргаанууд байж байгаа. Энэ дээр бас итгэмжилсэн төлөөлөгчид Засгийн газрыг төлөөлөөд ажиллаж байгаа.

Н.Учрал: Манай төрийн өмчит компанийн бүтээмж, засаглал, ил тод байдлыг сайжруулах хуулиар төрийн өмчит компаниуд бие дааж ажиллах бололцоо хангагдана. Гол нь улс төрийн нөлөөллөөс ангид ажиллах бололцоо хангагдана.

Түүнээс төрийн өмчит компанийн удирдлагууд энд ажиллаж байгаа бүх хүн болохоо больсон юм байхгүй шүү. Алдагдал үйлдвэрлээд байгаа компаниуд байна. Болохгүй байгаа нөхдүүд байна. Гэхдээ энд урдах ажлаа, оногдсон ажлаа хариуцлагатай хийж байгаа олон хүмүүс байгаа.

Тийм учраас цаашдаа энэ компаниудыг бие дааж ажиллах бололцоогоор нь хангах ёстой. Улс төрчид бид өөрсдөө л үүнийг ийм байдалд оруулсан байхгүй юу. Тэгээд сүүлдээ төрийн өмчит компанид өндөр мэдлэг, боловсролтой хүмүүс авч ажиллуулах гэхээр одоо энэ компаниудад чинь ажиллахаас айдаг боллоо шүү дээ. Сүүлдээ.

Тэгээд төр ч хүнгүй боллоо. Төрийн өмчит компани ч хүнгүй боллоо. Тэгээд шийдвэр ч гаргахаа болилоо. Тэгээд улс төрчид өөрөө тал талаас нь янз бүрээр нь хэлсээр байгаад энэ компаниудад ажиллах хүмүүс байхгүй боллоо. Үүнд санаа зовох бид шаардлагатай. Тэгээд Н.Алтаншагай гишүүнд дахиад нэмэлт 1 минут тодруулъя.

Н.Алтаншагай: Нөгөө төрийн өмчит компанийн удирдлагуудыг сонгон шалгаруулалт хийж байна уу, шууд томилгоо хийгдэж байгаа юу? Энэ дээр тодруулга авъя. Болсон.

Н.Учрал: Б.Цэнгэл дарга.

Б.Цэнгэл: Засгийн газрын 84 дүгээр тогтоол байгаа.

Бид Засгийн газраас журам гаргасан. Яг төрийн өмчийн харьяа компаниудын хувьд бид төрийн төлөөллийг ч гэсэн өмнө нь зүгээр шууд томилдог байсан бол төрийн төлөөллүүдийг хэд хэдэн нэр дэвшигч дундаас яг журмаа барьж байгаад сонгон шалгаруулалтаар томилж байгаа.

Ер нь цаашдаа ямар бодлого баримталж байгаа гэхээр хараат бус гишүүдийн тоог нэмэгдүүлж байгаа. Тухайлбал, “Эрдэнэс Тавантолгой”, “Эрдэнэс Монгол” дээр хараат бусын тоог нэмж өгсөн.

Ер нь цаашдаа төлөөлөн удирдах зөвлөлийн даргаар хараат бус хүнийг томилох ийм зарчим баримталж ажиллана. Баярлалаа.

Н.Учрал: Түрүүн бас муугийн жишээ, сайны жишээ гээд яриад байна шүү дээ. Тэгээд С.Бямбацогт дарга түрүүн хариулсан. Тэр Хөтөлийн цемент нэмэлт тодруулга хийх үү? 4 дүгээр микрофон.

Н.Ганхуяг: Н.Алтаншагай гишүүний асуултад хариулъя.

Тэгэхээр 2015 оны хувьчлалтай холбоотойгоор өнөөдөр эрүүгийн, иргэний, захиргааны гурван төрлийн хэрэг маргаан мөрдөн байцаалтын болон шүүхийн шатдаа явагдаж байгаа.

Тэгэхээр эдгээр хэрэг маргааны асуудлууд хэрхэн шийдвэрлэгдсэн тодорхой үр дүнг тухайн үед нь танилцуулна.

2022 онд хууль бус хувьчлалын асуудлаар гэж буцааж авахад нийтдээ 342 тэрбум орчим төгрөгийн өртэй шилжиж ирсэн байдаг бөгөөд энэ нь өнөөдрийн манай компанийн нийт өрийн 92 хувийг одоог хүртэл эзэлсээр байгаа ийм зүйл байна.

Мөн Хөгжлийн банкн дээр тодорхой хэмжээний асуудал маргаан байгаа. 61.0 сая доллартой холбоотой. Энэ асуудал ажлын хэсэг явж байгаа. Ийм байна.

Тэр нөгөө хувьчлалын үр дүнгийн тухай дүгнэж би ярих нь зохимжгүй. Ер нь хувьчлалын дараах эрсдэлийн хяналт, тайлагналтын асуудал гэдэг бол өөрөө их чухал асуудал бөгөөд үүн дээр... /минут дуусав/

Н.Учрал: Нэмэлт 1 минут.

Н.Ганхуяг: Хувьчлалын дараах тайлагналт, хяналт. Үүн дээр онцгой анхаарал хандуулаад явахад гарах эрсдэлээс урьдчилан сэргийлэх боломжтой байх гэж бодож байна. Баярлалаа.

Н.Учрал: Хувьчлал дээр баримтлах үндсэн чиглэл. Дээрээс нь хуулийг баталсны дараа энэ шийдвэрийг нэг мөр хэрэгжүүлэхгүй алдаа гарна.

Тийм учраас анхааралтай ажиллах хэрэгтэй. Одсүрэнгийн Номинчимэг гишүүн асуулт асууна.

О.Номинчимэг: Төрийн өмчийн хувьчлалын асуудал дээр бид маш болгоомжтой хандаж байгаа.

Мэдээж өмч хувьчлалыг төрийн эдийн засгийн оролцоог багасгах, хувийн хэвшилд орон зай гаргаж өгөх гэдэг санаа нь зөв. Гэхдээ санаа нь зөв боловч шийдэл нь залхуу байж болохгүй. Хэрвээ деталийг нь сайн харахгүй, шийдэл нь залхуу байх юм бол одоо байгаа нөхцөл байдлаасаа ч улам дордох эрсдэл байгаа юм.

Тэгээд чөтгөр детальд нуугддаг гэхчлэн бид үүнийг маш няхуур сайн хэлэлцэж гаргах ёстой. Улсын Их Хурлын даргатай санал нэг байна. Энэ хууль суурь бодлогоо хийж байж, олон талаас нь сайн хэлэлцэж байж үндсэн чиглэлийг гаргах ёстой гэдэгтэй санал нэг байна.

Тэгээд ер нь өмч хувьчлал байдаг юм уу, төрийн өмчийг олон нийтэд нээлттэй болгож хувьчлах асуудал дээр эдийн засгийн суурь нөхцөлүүд бүрдсэн байх ёстой. Тэндээс гурван юмыг би маш тодорхой хэлмээр байгаа юм.

- ▷ **Нэгдүгээрт,** манай зах зээл чөлөөт зах зээл байгаад өрсөлдөөнтэй зах зээл байх ёстой.

Тодорхой хэмжээний өрсөлдөөнтэй зах зээл байж бид жинхэнэ утгаараа зорьж байгаа хувийн хэвшилд орон зайг нь нээж өгөх, зөв явах эхлэл нь бүрдэх юм.

Хэрвээ чөлөөт зах зээл байхгүй, өрсөлдөөн хязгаарлагдмал нөхцөл байдалд төрийн өмч маань эцсийн эцэст төрийн өмчийн монополоос хувийн өмчийн монопол руу л шилждэг. Төр байхаасаа илүү доор үр дагаврыг дагуулдаг.

Хүмүүсийн хэлээд байгаа тэр 1992-2000 оны хувьчлал ч гэсэн ийм л асуудал гарсан байхгүй юу. Өрсөлдөөнт зах зээлийн хэм хэмжээ, хууль нь байхгүй суурь нь байхгүй, зах зээл нь бүрдээгүй нөхцөл байсан.

Тэгэхээр бид төрийн өмчийг хувьчлаад, эсвэл зах зээл нээлттэй болгоод явахдаа монополын хууль, өрсөлдөөний зах зээлийн хэм хэмжээнүүд маань үнэхээр үйлчилж байна уу, бүрэн бүтэн байна уу, үүнийг хэрэгжүүлэх агентлагийнх нь хүчин чадал нь юу байна гэдэг дээр маш сайн анхаарах ёстой. Үүнийг давхар бас бодож авч явах ёстой

- ▷ **Хоёрдугаарт,** нэг том хүчин зүйл хөрөнгийн зах зээлийн дэд бүтэц өөрөө сайн байх ёстой.

Тэгээд сая Улсын Их Хурлын дарга ч гэсэн асуулаа шүү дээ. Хөрөнгийн зах зээлийн биржийн дарга, Санхүүгийн зохицуулах хорооноос энэ чинь та нар улс төрөөс хараат бус, тэгээд 33 төрийн өмчийн компанийг нээлттэй болгоод явахад

багтаамж чадал чинь байгаа юм уу гээд. Би хариултаас нь итгэлгүй, байгаа гэж хэлж чадахгүй, байхгүй л гэдгээ хэлээд байх шиг байна.

Б.Цэнгэл дарга хэлж байна л даа. Уг нь 10 компани байсан юм. Тэгээд ярьж байгаад 33 болголоо гээд.

Одоо нөхцөл байдалдаа бодитойгоор яг хийж чадахаа 2028 он, 2026 он хүртлээ хийж чадахаа шилж аваад тэрийгээ тэн дээрээ л анхаармаар байна. Тэгээд энэ нөхцөл байдал манай хөрөнгийн зах зээлийн дэд бүтцийн нөхцөл байдал чинь өөрөө институцийн чадавхаас хамаарч байгаа. Дээр нь тэр мэргэжлийн хөрөнгө оруулагчид байхгүй бол бас явдаггүй шүү дээ. Мэргэжлийн хөрөнгө оруулагч байхгүй бол ерөөсөө дахиад л баялгийн хуваарилалт тэгш бус байгаа энэ үед хэдхэн баялаг хуваарилалт төвлөрчхөөд байгаа нөхдүүдийн л сонирхол ашиг сонирхол тэн дээр нөлөөлж орж ирнэ л гэсэн үг болно.

Тэгэхээр жинхэнэ утгаараа бид нөгөө олон нийтийн хяналт гэдэг юмыг үнэхээр энэ дээр хийж чадах уу гэдэг дээр энэ маш чухал байгаа.

▷ **Гуравдугаарт**, төрийн өмчит компаниудын хөрөнгийн үнэлгээ маш чухал.

Хөрөнгийн үнэлгээг хараат бусаар хийж, аудит үнэлгээг хийх асуудлыг маш няхуур зохион байгуулах ёстой. Ингэхгүй бол нөгөө төрийн өмчийг үнэгүйдүүлж, эсвэл хямдруулж хувьчилж авах нөхцөл бүрдэнэ. Энэ дээр бэлтгэл ажлыг маш сайн хийх ёстой.

Би Эдийн засгийн байнгын хороон дээр асуухад энэ дээр бэлтгэл ажил одоогоор ерөөсөө эхлээгүй. Чиглэл гарсны дараа л гэж байгаа. Чиглэл гарна гэж тооцоод одоогоос Та бүхэн энэ дээрээ сайн анхаарч ажиллаж байх ёстой шүү гэдгийг хэлмээр байгаа юм.

Тэгээд ер нь бид нөгөө суурь бодлого хуулиа гараагүй байж байж яг зүй ёсны монопол байх буюу төр өөрөө эзэмшээд явах... /минут дуусав/

Н.Учрал: Нэмэлт 1 минут. О.Номинчимэг гишүүн.

О.Номинчимэг: Стратегийн салбар нь юу юм гэдгээ тодорхойлох ёстой. Тэгэхгүй бол энэ дээр нэг баахан дулааны станцууд ороод ирсэн.

- Үүнийг үнэхээр хувьчилж чадах юм уу?
- Хувьчлаад ямар үр дүн гарах юм?
- Авах хүн байгаа юм уу?

Эсвэл энэ чинь өөрөө зах зээлийн жамаараа зүй ёсны монопол төр оролцох ийм эд байна уу гэдгийг ч дүн шинжилгээ бас хийгдээгүй байна л гэж бид харж байгаа.

Тэгэхээр үүнийг маш няхуур харах ёстой. Нэг асуулт байна.

Ер нь яах вэ С.Бямбацогт сайдын танилцуулгаас үүнийг засаглалыг сайжруулах зорилгоор л хийж байгаа гээд байгаа юм. Гэхдээ би танилцуулгыг харахаар зарим үед нь засаглалыг сайжруулах зорилгоор нээлттэй болгоно гэж байгаа юм. Зарим дээр нь нэг төсөв бүрдүүлэх зорилготой хэд хэдэн компани байна. МИАТ-аас эхлүүлээд төсөвт авах гэж байгаа юм шиг. Яг энэ зорилгуудаа яагаад яагаад гэдгийг нь та бас нэг аль аль компани дээр нь төсөв бүрдүүлээд тэрийгээ юунд зарцуулах гээд байгаа гэдгийг бас нэг тодорхой хэлээд өгөөч ээ гэж хүсмээр байна.

Н.Учрал: Тийм. С.Бямбацогт дарга тэр мэргэжлийн хөрөнгө оруулагч нарыг оруулаагүйгээр засаглал сайжрахгүй. Зүгээр тэр бага хувьцаа 15 хувь гаргалаа гээд мэргэжлийн хөрөнгө оруулагч нар орж ирэхгүй. Тэр retail дэмжлээ гээд наадах чинь засаглал сайжрахгүй шүү дээ. Мэргэжлийн хөрөнгө оруулалт.

Тэгэхээр та тэр хувиа хэлээд бүгдээрээ Их Хурал дээрээ ажлын хэсгээ байгуулаад тал талаасаа ярьж байгаад тэр хувьцааны дээрийнхээ тоон дээр дахиж ярих хэрэгтэй юм шиг байна. Тэгээд С.Бямбацогт дарга хариулна.

С.Бямбацогт: О.Номинчимэг гишүүн маш чухал асуудал хөндөж байна.

Тэгэхээр шууд асуултад нь эхлээд хариулъя. Араас нь нэмэлт мэдээлэл өгье.

Төсөв бүрдүүлэх зорилготой аж ахуйн нэгжүүд нь аль вэ. Энэ 33 компаниас үндсэндээ дулааны станцууд байгаа. Тэдгээр нь тэгээд хувийн хэвшилтэй өрсөлдөх шаардлагагүй.

Тийм учраас дуудлага худалдаагаар нээлттэй худалдаад хувьд шилжүүлье. Ингэхээр төсөвт орлогууд нь орно. Тэнд 7, 8 компани байж байгаа.

“Эрдэнэс Тавантолгой”, “Эрдэнэс критикал минералс”, “Эрдэнэт үйлдвэр” гэсэн компанийн хувьцааг 10 хүртэл хувийг нь хөрөнгийн биржээр нээлттэй арилжаал гэж Ашигт малтмалын тухай хуульд заасан учраас оруулж ирсэн. Гэхдээ үүнийг Их Хурал дээр ярьж байгаад яаж шийдэх вэ гэдэг нь шийдэгдэх байх.

“МИАТ” компанийн тухайд бид стратегийн хөрөнгө оруулагчид 10 хувийг нь худалдаад, тэр хөрөнгө оруулагч маань үйл ажиллагаа, менежментийг нь сайжруулаад, тэр компанийн үнэ цэн өсөөд, үр ашиг нь нэмэгдээд, үнэхээр хүн

сонирхох бололцоотой болсных нь дараа 34 хувийг худалдъя. Ингээд үүнээсээ орох орлогыг төрд төсөвт оруулж авъя гэсэн маш цөөхөн зүйл дээр төсөв бүрдүүлэхэд анхааръя гэж. Маш цөөхөн компани дээр байгаа.

Бусад компаниуд гэвэл үйл ажиллагааг нь сайжруулъя. Нэмэлт хувьцаа гаргаад түүнээс бий болсон хөрөнгөөр нь буцаагаад тэр компанийн үйл ажиллагааг сайжруулах, хүчин чадлыг нэмэгдүүлэх, үр ашгийг нэмэгдүүлэхэд нь зарцуулъя гэсэн зорилготой орж ирж байгаа гэдгийг хариулъя.

Таны саяын хөндөж байгаа асуудлууд өөрчлөн байгуулах үндсэн чиглэл дээр маш тодорхой орсон.

Үндсэн чиглэлийн –

- Нэгдүгээрт нь, зорилго.
- Хоёрдугаарт нь, үндсэн зарчим.

Зарчим дээр таны ярьж байгаа тэр төрийн өмчит компанийн хувьцааг олон нийтэд нээлттэй санал болгохдоо нэмж хувьцаа гаргах, олон нийтэд нээлттэй хувьцаат компани болгох, нэмж хувьцаа гаргах замаар олон нийтийг хяналтад оруулах, засаглалыг сайжруулах, үр ашгийг нэмэгдүүлэх, санхүүгийн сахилга бат, ил тод байдлыг хангуулах, төрийн өмчийн хувьцааг биржээр олон нийтэд нээлттэй худалдах гэх мэтийн.

Мөн төрийн өмчит компанийн засаглал, ил тод байдлыг сайжруулахад олон улсын менежментийн багийг оролцуулах, зөвлөх үйлчилгээ авах. Эцсийн зорилго нь нээлттэй хувьцаат компани болох, үр ашиг баялгийн тэгш хуваарилалтыг нэмэгдүүлэх зарчим барих ёстой шүү.

Зах зээл дэх төрийн оролцоог багасгах, хувийн хэвшлийн бие даан гүйцэтгэх боломжтой салбар дахь төрийн аж ахуйн нэгжийн үйл ажиллагааг зогсоох, зах зээлийн өрсөлдөөний зарчмаар хөгжих боломжийг хангах зарчмыг барих ёстой шүү гээд заагаад өгсөн.

Мөн худалдах, хувьцааг нээлттэй борлуулах зарахдаа ямар арга хэлбэрүүд ашиглах юм бэ гэдэг дээр таны хэлж байгаа санхүү, эдийн засгийн нөхцөл байдлаа харгалзана. Тэгээд үнэхээр Монгол Улсын эдийн засаг, санхүүгийн нөхцөл байдал, хувийн хэвшлийнхний худалдан авах чадавх энэ бүгдийг харгалзаж байгаад хэзээ аль компанийг олон нийтэд нээлттэй зарлах вэ, хэзээ альныг нь зарлахгүй байх вэ гэдэг жагсаалтыг... /минут дуусав/

Н.Учрал: “Буяны хөсөг” компанийн ажилчид Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна.

Та бүхэнд ажлын амжилт хүсье. /алга ташив/

О.Номинчимэг гишүүн тодруулъя.

О.Номинчимэг: Тэгээд үүнийг Улсын Их Хурал дээр хэлэлцэхдээ нямбай чамбай дүн шинжилгээ хийж ажиллаад явах байх гэж харж байна.

Нэмэлт нэг асуухад энэ хөрөнгийн зах зээл дээр мэргэжлийн хөрөнгө оруулагч буюу хөрөнгө оруулалтын сангууд байхгүй бол засаглал сайжруулахгүй гэдэг асуудлыг хаа хаанаа ярьж байгаа.

Монгол Улсын хувьд мэргэжлийн хөрөнгө оруулагчид сайтар хөгжөөгүй шүү дээ. Зах зээл.

Тэгэхээр энэ дээр Та бүхэн ер нь гаднын хөрөнгө оруулагч, сангууд орно гэж тооцож байгаа юм уу? Хэрвээ тэгж тооцож байгаа бол эндээ “Монголын Хөрөнгийн Бирж” бэлэн юм уу? Та бүхний хууль, журам, Санхүүгийн зохицуулах хорооноос гарч байгаа энэ асуудал дээр мэргэжлийн хөрөнгө оруулагч, гаднын хөрөнгө оруулагчид хэр итгэлтэй байгаа юм? Энэ дэд бүтэц болон хууль эрх зүйн нөхцөл нь тэгээд шийдвэр нь биелдэг байдал нь хэр байгаа гэж дүгнэж байгаа вэ? Энэ дээр нэг хариулт авъя.

Н.Учрал: Санхүүгийн зохицуулах хороо хариулах уу? Мэргэжлийн хөрөнгө оруулагч нар бэлэн үү? Танай салбарыг л дэмжиж байж л энэ эдийн засаг чинь хоёр тулгууртай болох гээд байдаг. Та нар хичээмээр байдаг. Би очно. Санхүүгийн зохицуулах хороонд.

Хуульд авсан журмуудыг цэгцэлье гээд би очихоор өмнө нь Засгийн газар бидний ажилд орохгүй гээд намайг Эдийн засгийн сайд байхад нэг их хавьтуулдаггүй байсан юм. Одоо болох болов уу. Их Хурлын дарга болсон юм чинь.

3 дугаар микрофон.

Б.Дөлгөөн: О.Номинчимэг гишүүний асуултад хариулъя.

Хөрөнгийн зах зээл дээр түрүүн хэлсэн. 13 их наядын үнэлгээтэй 160, 170 компани үйл ажиллагаа явуулж байгаа. Гаднын болон дотоодын хөрөнгө оруулагч нарт нээлттэй байгаа.

Хамгийн сүүлд хөрөнгө оруулалтын сангийн хууль дүрэм журамд өөрчлөлт оруулаад шинээр сангууд үүсэж эхэлсэн. Сүүлийн 5 жилийн хугацаанд нийт 7 хамтын сан буюу mutual fund-ууд гарч эхэлсэн.

Нөгөө талаасаа 30 гаруй хувийн хөрөнгө оруулалтын сангууд үүсээд явж байгаа.

Мэдээж хөрөнгө оруулалтын сангийн, ялангуяа хөрөнгө оруулалтын сангийн эрх зүйн орчин бүрдсэнтэй холбогдуулаад одоо энэ бүтээгдэхүүнээр дамжуулж хөрөнгө оруулах нь нэмэгдэж байгаа.

Нөгөө талдаа манай дэд бүтэц болоод хөрөнгө оруулалтын дүрэм журмын хууль эрх зүйн орчин олон улсад нийцэлтэй буюу гаднын хөрөнгө оруулагч нь орж ирэх бүрэн боломжтой байгаа. Энд бүх талаар хангагдсан байгаа... /минут дуусав/

Н.Учрал: С.Бямбацогт дарга нэмж хариулна.

С.Бямбацогт: Худлаа ярьж байдаг юм. Тийм. Бүх талын боломж хангагдаагүй байгаа.

Энэ хөрөнгийн бирж, хөрөнгийн зах зээл өнөөдөр манай санхүүгийн зах зээлд эзэлж байгаа хувь байр суурь үнэхээр банктай харьцуулах юм бол аягүй жижигхэн, маш бага хувь эзэлдэг.

Сүүлийн 30 жил. 1990 онд хөрөнгийн бирж байгуулагдсан. 1990-ээс 2000 он, 2004, 2005 он хүртэл хөрөнгийн бирж дээр брокерын компаниуд, андеррайдерууд, дилерүүд гээд маш олон компаниуд үйл ажиллагаа явуулдаг. Үүнийг дагасан зах зээл харьцангуй хөгжиж байсан. Одоо бүгд хаалгаа барьсан, бүгд дампуурсан.

Сүүлийн 2 жил, 3 жил үндсэндээ уул уурхайн бирж, хөрөнгийн бирж дээр уул уурхайн бүтээгдэхүүн арилждаг болсноос хойш Хөрөнгийн биржийн орлого нэмэгдээд, үр ашигтай харагдаж байгаа болохоос биш бусдаар хөрөнгийн зах зээл, хувьцаа, үнэт цаасны арилжаа хийгдэх нь бараг амь тасарсан. Тэгж байхад бүх юм болж байгааг битгий хариул. Энэ үнэхээр өөрчлөх ёстой цаг нь болсон.

Н.Учрал: Тийм. Би бас ажлын хэсгийнхэнд хэлье. С.Бямбацогт дарга ч хэлж байна.

Бүгдээрээ болохгүй байна, бэлэн биш байна, дэд бүтэц хангалттай биш ээ гэвэл үнэнээ хэлэх хэрэгтэй. Та нар тэр даргаасаа ч юм уу, сайдаасаа ч юм уу эмээгээд байх юм байхгүй шүү дээ.

Их Хурлын даргын хувиар би энд үнэнийг л сонсьё гэж байгаа юм.

- Бид бэлэн биш байна.
- Санхүүжилт, хөрөнгө оруулалт хэрэгтэй.
- Хууль эрх зүйн орчин бид нарт алга.
- Улс төрөөс хараат бус ажиллахад хүнд байна гээд хэлээрэй.

Тэгээд Их Хурлын даргын хувиар би бас хамгаалж ажиллана. Та бүхний үнэн үгийг.

Зарчимтай, шударга үнэнээ яриад байвал хамгаална. Энд ингээд бүх юм болж байгаа юм шиг ярихаар хаана хаанаа бие биеэ хуураад байна шүү дээ.

Болохгүй байгаа, хүнд байгаа, бэлэн биш байгаа гэдэг үгийг үнэнээр нь хэлэх хэрэгтэй гэдгийг хэлье.

Лувсанбямбаагийн Мөнхбаясгалан гишүүн асуулт асууна.

Л.Мөнхбаясгалан: Өнөөдрийн хэлэлцэж байгаа асуудлаар төрийн өмчтэй 101 компанийн 33 компанийг нь худалдах, хувьчлах, татан буулгах, зарим статусыг нь өөрчлөх асуудлыг үндсэн чиглэл болгон оруулж ирж байгаа юм байна.

Энэ ядуу ч гэсэн Монголын ард түмний өмч гэдгийг бид бүгдээрээ мэднэ. Бид эзнийг нь солих гэж байна. Тийм үү? Ард түмний өмчийг өөр хүмүүст өгч эзнийг нь солих асуудлыг өнөөдөр Их Хурлаар хэлэлцүүлж байна.

Тэгэхээр бид энэ дээр болгоомжтой хандах ёстой.

Сая Улсын Их Хурлын даргын хэлдэг зөв шүү дээ. Ямар ч бэлтгэл ажил байхгүй байна. Энэ хэлж байгаа хүмүүс чинь өөрсдөө Байнгын хороон дээр сая Их Хурал дээр хэлэлцэж байгаа Улсын Их Хурлын гишүүдийн асууж байгаагаас харахад ерөөсөө бэлтгэл ажил хангагдаагүй байна.

Жишээ нь, цахилгаан станцуудыг Багануур, Шивээ-Овоо компаниудыг ДЦС-3, ДЦС 4-ийг хувьчлах гэж байна. Энэ бол нийгмийн нийтийн суурь үнэ дээр хамгийн их нөлөө үзүүлдэг. Эдийн засгийн замбараагүй нөхцөл байдлыг бий болгоход хөшүүрэг болдог. Инфляцыг нэмэхэд нөлөөлөх ёстой байгууллагууд.

Тэгээд яагаад яг ийм цаг үеийг сонгож байгаа юм? 2026-2028 он яг энэ үндсэн чиглэлийг батлуулахад хамгийн тохиромжгүй үе гэж үзэж байна. Яагаад гэвэл эдийн засаг муудсан, төсөв тасарсан.

Дээрээс нь 2026-2028 он сонгуулийн мөчлөг таарч байна. Тэгээд сая ярьж байгаа нь эхлээд бид энэ үндсэн чиглэл, Улсын Их Хурлын тогтоолоо батлуулъя. Араас нь хуулиа батлуулъя. Тэгээд араас нь бэлтгэл ажлаа хангая гэж байна шүү дээ.

Бид Оюу Толгой дээр яг ингэж алдсаныг сая монголчууд бүгдээрээ харлаа шүү дээ. Эхлээд гэрээгээ байгуулчихъя. Дараа нь ТЭЗҮ-ээ гэж л орсон. Алдаа тэндээс эхэлсэн. Тэгвэл өнөөдөр дахиад бид тийм алдаа хийх гэж байгаа байхгүй юу.

Дээрээс нь төрийн өмчит энэ компаниуд ашиггүй ажиллаад байна. Асар их өртэй. Одоо энэ бол төр муу менежерээ больё гэж байгаа юм. Тэгвэл ашиггүй ажиллуулж байсан хүмүүст тухайн Засгийн газарт яагаад хариуцлага тооцохгүй байгаа юм. Дахиад л нөгөө хариуцлагаа хаясан.

Муужруулж муужруулж үнэгүйдүүлж, ашиггүй ажиллуулж байгаад хувьчилдаг технологи чинь олон улсын хамгийн бест технологи. Яг одоо энэ технологиор дахиад явах гэж байна.

Ашиггүй ажилладаг, асар их өртэй энэ компаниудыг ямар байгууллага хувьчилж авдаг юм, ямар байгууллага худалдаж авдаг юм. Энэ бол оффшорт нуусан мөнгөө биежүүлж энэ компаниудыг худалдаж авах ямар нэгэн технологи байх магадлалтай. Тэгж харж байна.

Түүнээс ийм их өртэй компаниудыг шууд аваад л ашигтай ажиллуулдаг юм гэж байхгүй.

Дээрээс нь яг одоо ашиггүй байгаа ч гэсэн ирээдүйд ашигтай ажиллах компани бий. Жишээ нь, Эрдэнэт үйлдвэр байхгүй юу. Энэ бол ашигтай.

Тэгэхээр энэ нь хувийн компаниуд өрсөлдөгчгүйгээр худалдаж аваад монопол тогтоож болно. Бид ковидын үед хил хаасан үед хувийн компанид төр өөрөө бойкотлуулж байсан түүх байгаа. Би тэр компанийн нэрийг дурдаад яах вэ. Үүнийг тухайн үед төрд ажиллаж байсан хүмүүс бүгдээрээ мэдэж байгаа. Ийм байдал зарим нэг эмзэг байдал үүсдэг. Үүнийгээ харах хэрэгтэй.

Тийм учраас төрийн өмчит компаниудыг хувьчлах үндсэн чиглэлээ энэ удаа гишүүд дэмжихгүй буцаагаад бүх стратеги төлөвлөгөөтэй нь, бүх юмыг нь засаж сайжруулаад дахиад өргөн барь. Бид заавал шинэ жилийн өмнө ийм том юмыг шийдэх албагүй. Ямар нэгэн баяр ёслолын үеэр анхаарал суларсан үеэр ийм асуудлуудыг оруулж ирмээргүй байна.

Тэгэхээр Н.Учрал дарга аа, би таныг дэмжиж байна. Бүх нөхцөл байдлаа бэлтгээд, хуулиа батлаад, тэгсний дараа энэ үндсэн чиглэлээ оруулж ир. Тэгэхгүй бол энэ 2026-2028 онд Монгол Ардын нам... /минут дуусав/

Н.Учрал: Нөгөө Төрийн өмчит компанийн хууль чинь жил болоод байдаг. Их Хурал дээр. Тийм ээ. Нийтийн өмчийн хууль чинь 4 жил болоод байдаг. Анх орж ирсэн нь. Тийм ээ.

С.Бямбацогт дарга асуултад хариулъя.

С.Бямбацогт: Л.Мөнхбаясгалан гишүүн хардах эрхтэй. Тийм. Хардаад олон нийтэд ингээд хардлагыг нь тайлах нь ч бидний үүрэг байх.

Шинэ жил, баяр ёслол гээд ярьж байгаа юм. Үүнийг бид оруулж ирээд одоо батлуулах гээгүй. Хэлэлцэх эсэхийг нь шийдээд хаврын чуулганаар эхлээд хуулиудаа батлаад, үүний араас нь үндсэн чиглэлээ батлаад, тэгээд энэ ажлаа зохион байгуулъя гэж байгаа юм.

Тэгэхгүй та бол одоо шууд ингээд энэ шинэ жил далимдуулаад батлах гэж байгаа юм байна гэж ойлгоод байх шиг байна. Үгүй ээ.

Яагаад Засгийн газар оруулж ирсэн юм бэ гэж. Монгол Улсыг хөгжүүлэх 2027-2030 оны үндсэн чиглэл, нөгөө **“Хурдтай хөгжлийн төлөөх зориг”**. Ардчилсан нам, Ардын намын хамтран байгуулсан 2024-2028 оны Засгийн газрын мөрийн хөтөлбөр. Эд нар чинь ингээд ерөөсөө өрийн өмчит компанийн засаглалыг сайжруулах, төрийн өмчит компаниудыг энд эдийн засагт оролцоог нь багасга гээд ингээд зорилтууд тусгасан.

Энэ зорилтуудыг хэрэгжүүлэх хүрээнд 2024 оны 12 дугаар сарын 12-ны өдөр Монгол Улсын Их Хурлаас Засгийн газарт 2026-2028 онд өмч хувьчлах үндсэн чиглэлийг оруулж ирье гээд яг жилийн өмнө үүрэг өгсөн юм.

Улсын Их Хурлын өгсөн үүргийг л бид биелүүлж байгаа юм. Тэр үед Ардын нам, Ардчилсан нам хамтраад Засгийн газар байгуулаад мөрийн хөтөлбөрөө хийсэн. Тэр үед энэ тогтоолыг хамтад нь баталж өгсөн. Үүнийг л бид биелүүлэх гээд л. Биелүүлэхгүй бол Засгийн газар Их Хурлын үүрэг биелүүлсэнгүй гээд загнана. Биелүүлэх гээд оруулаад ирэхээр шинэ жил далимдуулаад Ардын нам хулгай хийх гэж байна гээд хардана. Ийм л юман дунд бид явж байна л даа.

Тийм болохоор үүнийг зөв ойлгооч ээ. Энэ ийм учиртай юм шүү. 5 жилийн үндсэн чиглэл, Засгийн газрын 4 жилийн мөрийн хөтөлбөр, Их Хурлаас үүрэг өгсөн тогтоол. Үүнийг л хэрэгжүүлэх гэж Засгийн газар оруулж ирж байгаа.

Эхлээд бид Нийтийн өмчийн тухай хуулиа баталъя. Дагаад Төрийн өмчит компаниудын засаглал, үр ашгийг нэмэгдүүлэх тухай хуулиа баталъя. Үүнийг батлах явцдаа үндсэн чиглэл дээр ажлын хэсэг байгуулаад, ажлын хэсэг маань энэ бүгдийг хамтад нь.

Урьд нь бид хууль баталчхаад хууль нь амьдрал дээр хэрэгждэггүй. Дараа нь асуудал болдог бол энэ хуулийг батлах зорилго чинь юу билээ. Энэ төрийн өмчит компанийн засаглалыг сайжруулах. Энэ хуулийг батлах зорилго чинь юу билээ. Хувийн хэвшил дэх эдийн засгийн оролцоог нэмэгдүүлэх, төрийн оролцоог багасгах. Тэгвэл энэ үндсэн чиглэлд тусгасан компаниуд чинь ийм учиртай шүү дээ гээд яг прагматик зэрэгцээд явах юм бол, ажлын хэсэг маань ажиллах юм бол илүү бодитой онол, практик хоёр нь зэрэгцэж яваад хууль боловсруулах, хуулийг хэрэгжүүлэх ажил чинь хамтдаа яваад илүү үр дүнтэй байх гэж харж байгаа юм.

Тийм болохоор хэлэлцэх эсэхийг нь одоо шийдээд хаврын чуулган хүртэл хугацаанд хуулиа боловсруулах, үндсэн чиглэлээ сайжруулах ажлуудыг зэрэгцүүлээд явахад илүү сайн хууль... /минут дуусав/

Н.Учрал: Л.Мөнхбаясгалан гишүүн тодруулна.

Л.Мөнхбаясгалан: Сүүлийн 8 жил Ардын нам төр барьсан. Энэ компаниуд чинь ямар ч ашиггүй ажиллаад байгаа учраас одоо бид үүнийг хувьчлах ёстой.

Тийм учраас хэлэлцэх эсэхийг нь одоо дэмжиж аль гээд байгаа байхгүй юу. Тэр ашиггүй ажиллуулсан тэр хүмүүстээ тэгээд ямар хариуцлага тооцох юм? Одоо цүнх баригчдыг бид томилохгүй. Дээрээс нь энд ямар нэгэн шахаа хийхгүй гээд гоё гоё юм яриад байгаа байхгүй юу. Улсын Их Хуралд даалгавар өгсөн. Тэр даалгаврыг биелүүлж байна. Тэгэхгүй бол та нар загнана гээд. Ямар ч хариуцлага тооцох юм байхгүй. Тийм биз дээ. Одоо яг хариуцлага тооцсон нь юу юу байгаа юм танд. Жишээ нь. Тэрийгээ хэлээд өг.

Н.Учрал: С.Бямбацогт сайд хариулна.

С.Бямбацогт: Хамгийн их харддаг, сэрддэг, нүд үзүүрлэдэг –

- “Эрдэнэс Тавантолгой” компани 2024 онд 10 их наяд төгрөгийн ашигтай ажиллажээ.
- “Эрдэнэт үйлдвэр” 4 их наяд төгрөгийн ашигтай ажиллажээ.
- “Эрдэнэс Монгол” компани 3.6 их наяд төгрөгийн ашигтай ажиллажээ.

Ашиггүй ажилласан, алдагдалтай ажилласан компаниудыг аваад үзэхээр нөгөө л нүдний цөцгий мэт бидний хардаад, харамлаад байгаа эрчим хүчний компаниуд.

Эрчим хүчний компаниуд яагаад ашиггүй ажиллаад байгаа юм бэ гэхээр –

- › төр хэтэрхий үнийг нь хатуу бариад,
- › төр хэтэрхий хаалттай бодлого явуулаад,
 - нээлттэй байх,
 - өрсөлдөөнд суурилах,
 - хувийн хэвшлийн оролцоотой байх.

Энэ хаагдсан учраас тэнд алдагдал бий болж байгаа юм.

Үндсэн шалтгаан нь төрийн оролцоо байна.

- › Олон нийтийн хяналт, олон нийтийн оролцоо алга.
- › Зардлыг бууруулах ямар ч менежмент алга.

Ийм учраас тэнд алдагдалтай ажиллаад байгаа юм.

Тийм болохоор хаана өрсөлдөөн байна тэнд... /минут дуусав/

Н.Учрал: Л.Мөнхбаясгалан гишүүн нэмэлт 1 минут тодруулна.

Л.Мөнхбаясгалан: Ямар хариуцлага тооцох юм бэ?

Н.Учрал: С.Бямбацогт гишүүн.

С.Бямбацогт: 108 компанийг цөөлөөд 101 болгосон.

Ашиггүй ажиллаж байгаа, алдаа гаргаж байгаа захирлуудыг халаад, чөлөөлөөд явж байгаа. Энэ оны жилийн эцсийн гүйцэтгэлээр алдагдалтай ажилласан бүх компаниуд дээр хариуцлага ярина. Хоёр дахь жилээсээ алдагдалтай ажиллах юм бол шууд хална. Алдагдалтай ажилласан ямар шалтгаан байна гэдгийг нь тодруулаад.

Гэтэл сая хэллээ шүү дээ. Яах аргагүй төр хатуу бариад байгаа учраас алдагдалтай ажиллаж байгаа АЗЗА-нууд байж байна. Жишээ нь. Эд нар дээр чинь хариуцлага тооцоход хэцүү байна. Бусад компаниуд дээр бол.

Нийгмийн ачаа үүрдэг компаниуд. Нийгмийн ачаа үүрдэг компаниуд ихэнхдээ алдагдалтай байна.

Яг ашигтай ажиллах боломжтой компаниуд алдагдалтай ажиллуулж байгаа бол шууд хариуцлага тооцоод хууль зөрчсөн байх юм бол хуулийн хариуцлага хүлээлгэнэ. Ийм зарчмыг барихыг ТУЗ-д чиглэл өгсөн байгаа. ТУЗ-ууд нь цаашаа ийм зарчим барьж энэ компаниуд дээр хариуцлага ярина. Жилийн эцэст ажлынх нь дүнгээр. Жилийн эцсийн дүн гараагүй байна. Одоохондоо хараахан.

Урьд нь тэгдэггүй байсан бол одоо тэгнэ.

Н.Учрал: Таны хугацаа болсон. Хоёр удаа тодруулсан байх.

Манай ажлын хэсгийнхэн байгаа шүү. Төр хувийн хэвшилтэй өрсөлдөх ёсгүй ээ гээд манай Засгийн газрын бүх гишүүд ярьж байгаа.

Тэгэхээр өрсөлдөж байгаа салбарын төрийн компаниудыг хувьчлахаар орж ирсэн гэж ойлгож байгаа. Мөн үү? Хувийн хэвшилд өрсөлдөх ёсгүй.

Хоёрт, Улсын Их Хурал дээр ажлын хэсэг байгуулагдана. Энэ шууд батлагдах гэж байгаа юм биш. Улсын Их Хуралд ажлын хэсгийг ахлах ажлын

хэсгийн гишүүнээр ажиллах Их Хурлын гишүүдийг хувийн ашиг сонирхлын мэдүүлгийг нь үзнэ. Энэ дотор байгаа салбар болгоны компаниудтай өрсөлдөж байгаа ямар нэгэн хувийн бизнестэй, энд хувьцаа эзэмшдэг Их Хурлын гишүүд энд орохгүй. Тэр байтугай санал хураалтад оролцохоос татгалзах хэрэгтэй шүү. Энэ хувьчлалтай холбоотой хардах эрх нийгэмд ч байгаа.

Тэгээд ер нь Их Хурлын гишүүд энэ санал хураалтад би оролцохгүй ээ. Энд надад ашиг сонирхол байгаа гээд хэлээд гардаг соёлд суралцах хэрэгтэй. Тийм биз дээ. П.Сайнзориг гишүүн. Тийм.

П.Сайнзориг гишүүн энэ хуулийн талаар их ярьдаг. Дээрээс нь одоо энэ хуулийг энэ 3 сарын 15-нд оруулж ирэх дээр Та энэ талаар байр сууриа хэлнэ үү?

Н.Учрал: П.Сайнзориг гишүүн.

П.Сайнзориг: Баярлалаа. Бүгдэд нь өдрийн мэнд хүргэе.

Улсын Их Хурлын дарга болон С.Бямбацогт сайдын хариултууд гараад тодорхой суурь хууль, эрх зүйн орчныг бүрдүүлсний дараа энэ тогтоол батлагдах ёстой гэдэг хариултууд явж байгаа учраас би энэ чиглэлийн асуултаа товчилъё гэж бодож байна.

▷ **Нэгдүгээрт,** яагаад үүнийг хэлээд байна гэхээр –

- Бэлэн байдлын үнэлгээг төр талаасаа бид хийх ёстой юм.
- Тухайн компани дээр эдийн засаг, санхүүгийн үзүүлэлт, засаглал талаас нь хийх ёстой юм.
- Зах зээлийн багтаамжаа бид харж тооцох ёстой юм.
- Тэнд оролцогч хөрөнгө оруулагч, жижиг хувьцаа эзэмшигчдийн эрх ашгийг хамгаалах ёстой юм.
- Хувьчлалын дараа үүсэх нөхцөл байдлаас өрсөлдөөн, монополын эсрэг арга хэмжээг нь яаж авах юм –

гэдэг зүйлийг тодруулж, эрх зүйн орчноо бүрдүүлж байж энэ хувьчлал чинь үр нөлөөтэй явах юм гэдэг зүйлийг яриад байгаа учраас л хийж байгаа шүү.

▷ **Хоёрдугаарт,** энэ хувьчлалыг чинь хөрөнгийн зах зээлээр гаргах 33 компанийг хүлээж авч чадахгүй ээ гэдэг зүйлийг би яагаад хэлээд байгаа гэхээр 2022 оны 4 сарын 29-ний өдөр нэг мундаг заалт орсон юм. Төрийн болон Орон нутгийн өмчийн тухай хууль дээр.

Төрийн болон орон нутгийн өмчийн компанийн 5 хувиас илүү хувьцааг нь авч болохгүй. Банкны реформ хийх гэж байна гэж байгаад хөрөнгийн зах зээлийг шууд унагааж байгаа байхгүй юу. Ийм хуулийг л өнгөрсөн парламент баталсан учраас энэ хөрөнгийн зах зээл чинь үндсэндээ унасан.

Тэгээд энэ Төрийн банкны чинь хувьчлал нь унасан. Хоёрдогч арилжаан дээр Төрийн банкны хувьцаа ямар ч үнэ цэнгүй байгаа. Энэ банкны реформ нэрээр хөрөнгийн зах зээлийг унагаасан шүү. Үүнийг бид аливаа зүйлийг гаргахдаа тооцоо, судалгаатай гаргаагүйн үр гор нь энэ.

Тэгэхээр үүнийг би хатуу хэлээд цаашаа явъя.

Ер нь энэ өмч хувьчлалын асуудлыг биржээр ч бай, тодорхой сонгон шалгаруулалттай ч бай хэн хөрөнгө оруулалт хийж, хэн худалдаж авах боломжийг олгох вэ гэдэг зүйлийг бид маш сайн тооцох ёстой.

Ялангуяа уул уурхайн компаниуд дээр энэ чиглэлийн хөрөнгө оруулалтыг хийх боломжийг иргэддээ олгох, ялангуяа орон нутгийн иргэддээ олгох, уул уурхайн баялгийнхаа үр өгөөжөөс иргэд хүртэх энэ боломжийг станы орнууд шиг, Казахстан шиг бид хийх ёстой.

“Ард түмний IPO” гэж маш том хөтөлбөр гаргаад тэргүүн ээлжид стратегийн бүтээгдэхүүн экспортод гаргадаг уул уурхайн компаниудын хувьцааг орон нутгийн иргэдэд авах ёстой. Сумын түвшинд. Дараа нь аймгийн түвшинд. Тэгээд аймгийн түвшний дараа тэр уул уурхайн бүсийн нөлөөллийн аймгууд болон бусад сонирхогч этгээд гэдэг зарчмаар явах ёстой.

Ингэж байж энэ уул уурхайн салбарыг орон нутаг хүлээн зөвшөөрнө. Орон нутгийн дэмжлэгийг авна. Иргэд баялагтаа эзэн байх энэ концепц бүрэн хэрэгжих юм.

Тэгэхээр энэ чиглэлдээ бас анхаараач.

Хоёрдугаарт, маш олон гишүүд маань санаа зовж байгаа асуудал. Энэ төрийн өмчит компанид ажиллаж байгаа ажиллагсдын асуудал. Яг үнэндээ хэлэхэд төрийн өмчит компаниудад даргал ихсээд байгаа болохоос биш мэргэжлийн боловсон хүчнүүд нь цөөрөөд байгаа шүү. Эрчим хүчний компаниуд дээр инженер олдохоо больсон. Уул уурхайн компаниуд дээр сайн инженерүүд нь бас хувийн хэвшилд гарч байна.

Тэгэхээр би энэ дээр юу хэлэх гээд байна гэхээр тогтвор суурьшилтай ажиллаж байгаа тэр боловсон хүчнийг барих бодлого нь бас хувьцааг нь эзэмшүүлэх асуудал байгаа. Ажиллаж байх хугацаанд.

Тэр ажиллаж байх хугацаанд хувьцааг нь эзэмшсэн ажилчин –

- дотоод хяналтыг маш сайн хийдэг,
- авлигалаас ангид байлгадаг,
- өндөр үнэтэй бараа шахахаас урьдчилан сэргийлж чаддаг.

Тэгээд тогтвор суурьшилтайгаар миний юм, бидний юм, хамтын юм гэдгээр маш үр өгөөжийг нь сайжруулахад идэвхтэй оролцдог.

Тэгэхээр бид энэ жишгээр явж байж төрийн болон орон нутгийн өмчийн хувьчлах асуудлын концепцыг гаргах ёстой юм. Ингээд дутуу хүтүү бараг 30, 40 компани оруулж ирчхээд та нар шийд гээд байхаар чинь ерөөсөө ойлгомжгүй байсан.

Тэгэхдээ энэ дээр мэдээж хуулиа гаргаад сайжруулаад явъя гэж байгаа учраас би дэмжиж байна.

Тэгэхээр миний энэ хэлж байгаа санаан дээр ажлын хэсэг буюу ялангуяа магадгүй уул уурхайн 2 компанийн ч юм уу, Б.Цэнгэл дарга ямар байр суурьтай байгаа вэ? Ийм боломж бий юу? Ялангуяа Эрдэнэт дээр энэ жишээг ярьж болно. Тэгээд хуулийг гаргах нэг шалтгааныг би бас Эрдэнэтийн жишээн дээр ярья. /минут дуусав/

Н.Учрал: Хэн хариулах вэ? Б.Цэнгэл дарга, энэ олон компаниуд яг нээлттэй болгоход бэлэн үү гэдгээ Та хэлэхгүй бол. 4 дүгээр микрофон.

Б.Цэнгэл: П.Сайнзориг гишүүний асуултад хариулья.

Ер нь системийн 5 банкны асуудал яригдаж байх үед яах аргагүй анхдагч зах зээл дээр нэг болон нэгдмэл сонирхолтой этгээдүүд 5 хувиас хэтрүүлэхгүй, хувьцаа хэтрүүлэхгүй гэдэг ийм заалт ороод, тэр нь түүнээсээ халиад Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд бүх компаниудад хамаарсан хэлбэрээр орсон юм.

Тэр 2022-2023 оны үндсэн чиглэлийн бас нэг олигтой яваагүйн шалтгаан нь үүнтэй шууд холбоотой байсныг бас онцлон тэмдэглэж хэлмээр байна.

Ер нь бид олон улсын байгууллагуудтай хамтарч ажиллаж байгаад судалгаанууд хийсэн. Хамгийн сүүлд KPMG (Klynveld Peat Marwick Goerdeler) гээд олон улсын судалгааны байгууллага хөрөнгийн биржийн бодит бололцоо нөхцөлийг судалсан байдаг. Энэ дээр ойролцоогоор 1.5-аас 1.8 их наядын орон зай байна гэж үзэж байгаа.

Бид үндсэн чиглэл дээр нэн ялангуяа МИАТ, Төрийн банк дээр стратегийн хөрөнгө оруулагч болон олон улсын сонирхогч байгууллагуудыг оролцуулж болно гэдэг агуулгаар орсон байж байгаа.

Ер нь хоёр бүлэг л юм явж байгаа шүү дээ.

→ Нэг нь, нэмж хувьцаа гаргах.

- Нөгөөх нь, нээлттэй дуудлага худалдаагаар орох.
- Нөгөөх нь, засаглалыг сайжруулах –

гэдэг ийм багц асуудлыг үндсэн чиглэлд тусгасан байж байгаа. Баярлалаа.

Н.Учрал: Өөр нэмэлт. Г.Ёндон захирал.

Ажилчдадаа хувьцаа эзэмшүүлэх гээд. Ер нь бага хувийг санал болгохдоо гаднын компаниуд ажилчдадаа эхлээд санал болгодог шүү дээ. Тийм жишиг бий. 3 дугаар микрофон.

Г.Ёндон: П.Сайнзориг гишүүний асуултад хариулья.

Өнөөдөр Эрдэнэт үйлдвэрийн 10 хувийг буюу ашигт малтмалын тухай хуулийн 5.6 дээр заасан стратеги ордын 10-аас доошгүй хувийг эзэмшүүлнэ гэсэн энэ заалттай орж ирж байгаа.

Ер нь Эрдэнэт үйлдвэрийн хувьд болон энэ төрийн өмчийн стратегийн уул уурхайн компаниуд дээр төр доод тал нь хэдэн хувийг эзэмших вэ гэдгээ бид маш тодорхой болгох зайлшгүй шаардлагатай байгаа.

Яагаад үүнийг хэлж байна вэ гэвэл сүүлийн үед дэлхий нийтээр “критикал минерал” гэдэг асуудал яригдаж байна. Улс орнуудын стратегийн буюу эдийн засгийн аюулгүй байдал, тусгаар тогтнолтой холбоотой ашигт малтмалын ашиглалт, түүнийг эргэлт дээр төр өөрөө хяналт тавих зайлшгүй шаардлага гарч ирж байгаа.

Яагаад гэвэл дэлхий нийт нэг улсаас түүхий эдийн хувьд хамааралтай болж ирсэн. Өнөөдөр нэг улс зарим нэгэн ашигт малтмалын 50-иас 90 хүртэл хувийг дэлхий нийтэд хянаж байгаа ийм нөхцөл байдал байж байгаа. Ийм тохиолдолд өнөөдөр Монгол Улс чухал ашигт малтмалын... /минут дуусав/

Н.Учрал: Г.Ёндон захирал. 3 дугаар микрофон.

Г.Ёндон: Зэс бол зайлшгүй чухал ашигт малтмалын жагсаалтад орж ирэх ёстой.

Саяын П.Сайнзориг гишүүний хэлсэн асуултад Эрдэнэт үйлдвэрийн уурхайчид бүгд дэмжиж хүлээж авна гэдгийг хэлэхийг хүсэж байна.

Яагаад гэвэл өмнө бас ийм асуудал яригдаж 1991 онд хувьчлах аж ахуйн нэгжүүдийн жагсаалтад Эрдэнэт үйлдвэр орж ирэхэд Эрдэнэт үйлдвэрийн уурхайчдын 10 мянган цэнхэр, ягаан тасалбар тухайн үедээ цуглуулагдсан байдаг.

Харин 1999 онд энэ жагсаалтаас Эрдэнэт үйлдвэр хасагдсан шалтгаанаар эдгээр хувьцаа нь тухайн үеийн Эрдэнэт хотод бүртгэлтэй байсан “Эрдэнэс инвест” компани руу шилжээд өнөөдөр холбогдох төрийн үнэт цаасны төв дээр цугларсан байдаг.

Тийм учраас ажилчид хэрвээ энэ хувьцааг эзэмших юм бол маш сайн хяналтыг тавина гэдэгтэй 100 хувь санал нэгтэй байна.

Н.Учрал: П.Сайнзориг гишүүн тодруулъя.

П.Сайнзориг: Тэгээд ямар ч байсан сайтар хэлэлцэнэ гэдэг зүйлүүд тал талаас ярьж байгаа учраас баярлаж байна.

Тэгээд хууль эрх зүйн орчин дээр бас энэ тэтгэврийн шинэчлэл зайлшгүй байгаа юм. Хувийн болон нийгмийн даатгалын сангийн шинэчлэлийг хийгээд, үүнийг мөнгөжүүлээд, энэ мөнгө нь өөрөө эргээд тодорхой үнэ цэн бүхий төрийн өмчид, ялангуяа уул уурхайн болон эрчим хүчний үр өгөөжөө өгөх компаниудын хувьцааг худалдаж авах юм бол энэ Хувийн тэтгэврийн сан болон Нийгмийн даатгалын сан чинь бас арвижих бололцоо байгаа юм.

Тэгэхээр энэ боломжуудыг буюу нэг мөнгөөр аль аль асуудлуудаа шийдэх энэ бололцоог бид энэ хувьчлалтай уялдуулж зайлшгүй шийдэх ёстой гэдэг зүйлийг би энэ ташрамд хэлмээр байна.

Франц жишээ нь нэг төрийн өмчит компанийг хувьчлахдаа “старт ап” компаниудын зөвхөн санхүүжилтийг ойлгохын тулд нэг компаниа хувьчилсан байхгүй юу. Ийм зорилготой хувьчилдаг. Түүнээс биш манайх шиг ийм бүдүүн тойм юм оруулж ирчхээд яах вэ болно доо гээд байж болохгүй. Үүнийг анхаарах ёстой.

Хоёрдугаарт, стратегийн хөрөнгө оруулагчийн асуудлыг хуульчлаагүй учраас хэцүү байгаа.

Тэгэхээр энэ бүх зүйлүүдийг зайлшгүй... /минут дуусав/

Н.Учрал: Хоёр удаа минут тодруулсан байгаа шүү. Нэмэлт 1 минут.

П.Сайнзориг: ... авч байгаа юм.

Тэгэхээр үүнийг бас анхаараач ээ гэдэг зүйлийг хэлье. Тэгээд эрчим хүчний компаниудыг монопол байх нь зүй ёсны байгаа. Яг үйлдвэрлэгч эх үүсвэрүүд нэмэгдээгүй тохиолдолд хувьчлалыг маш болгоомжтой явуулах ёстой.

Цаана нь монопол болон өрсөлдөөний хууль тогтоомжийг хувьчлалын дараах байдлаар яах вэ гэдэг зүйлүүд яригдаж байж энэ асуудал яригдах ёстой юм гэдэг зүйлийг хэлье.

Тэгээд төр өөрөө бизнесийн үйл ажиллагаанд оролцохгүй байх энэ дүрэм, журмыг зарим орнуудад шар хуудас гэж нэрлэдэг. Тэр шар хуудсан дээр нэрлэгдсэн... /минут дуусав/

Н.Учрал: Даргын зөвлөл дээр шийдсэн 120 минут дууссан. 120 минутын хугацаа дууссан. Хариулт их олон байлаа шүү дээ. Нийт 120 минутад бүлгүүдээс нэр ирсэн гэсэн үг.

Тэгэхээр дэгийнхээ хуулийн дагуу нэг цаг хүртэл сунгаж болно.

Тэгэхээр үг хэлж, асуулт асууж дуустал сунгалаа. Нэг цаг дотор багтах ёстой. Сунгалаа. /алх цохив/

Цэндийн Сандаг-Очир гишүүн асуулт асууна.

Ц.Сандаг-Очир: Баярлалаа. Би өглөө Б.Пүрэвдорж гишүүний хэлсэн үгтэй холбогдуулж ганц нэг тайлбар хэлэхгүй болохгүй гэж бодож байна.

Монголчууд юм хийж чаддаггүй, үйлдвэрлэж чаддаггүй улс биш шүү. Бас хийж чаддаг, үйлдвэрлэдэг байсан улс.

1990 оны өмч хувьчлалаар ямар булхай луйвар гарлаа. Талх, чихэр, гутлын үйлдвэр, гурилын үйлдвэр, арьс ширний үйлдвэр, оёдол, сүлжмэлийн үйлдвэр, архи, пивоны үйлдвэр, хивсний үйлдвэр, шилний үйлдвэр, чүдэнзний үйлдвэр, Баянгол, Мах импекс, Улаанбаатар зочид буудал, сум сууринуудад байсан гурил, тэжээлийн үйлдвэр, механикжсан фермерүүд гээд олон үйлдвэрүүдийг тухайн үеийн эрх мэдэлтэй, албан тушаалтай, мөнгө төгрөгтэй нөхдүүд, мэдээлэлд ойрхон нөхдүүд худалдаж авцгаасан, идэж ууцгаасан, найрлацгаасан.

Түүний үр дүнд юу боллоо гэхээр монголчууд хийж чаддаг байсан юмаа хийж чаддаггүй болсон. Үүнийг монголын ард түмэн бүгд мэдэж байгаа. Тэнд ажиллаж байсан ажилчид, хөдөлмөрчид олон арваараа ажилгүй, хөдөлмөргүй гудамжинд гарцгаасан.

Тийм учраас энэ удаагийн яригдаж байгаа өмч хувьчлалын асуудал дээр маш болгоомжтой хандахгүй бол эргээд үүнээс үүдэх эерэг, сөрөг үр дагавар нь дараа нь хэн хариуцах юм гэдэг асуудал гарна шүү.

Улс төрч нар нүүгээд бугаад явна. Дараа нь гарах сөрөг үр дагавар нь. Тухайлбал, энэ дотор орж ирж байгаа эрчим хүчний салбар анхаарахын аргагүй

салбар шүү. Энэ салбарыг хэн хувьчилж авах вэ гэхээр хөрөнгөтэй мөнгөтэй компаниуд худалдаж авна. Гадаадын компаниуд худалдаад аввал яах вэ. Энэ үндэсний аюулгүй байдлын асуудал хөндөгдөх үү, үгүй юу. Эрчим хүчний салбар нэг улсаас хараат байдалд орвол яах юм. Эх үүсвэрүүдээ гаднын компаниудад өгвөл яах юм. Энэ компаниуд чинь хувьцаа нэмэгдүүлнэ, нээлттэй болгоно гэдэг нэрийн доогуур цаашдаа ерөөсөө үнээ л нэмэгдүүлнэ, тарифаа л нэмэгдүүлнэ.

Өнөөдөр бид улс төрөөс, ард түмнээсээ айгаад үнэ өртгийг нь нэмэгдүүлж чадахгүй л яваа шүү дээ. Өртөгт нь хүргэж чадахгүй л яваа шүү дээ. Засгийн газар өөрөө улс төрөөс айсаар байгаад үнэ, тарифыг нь хатуу барьсан бодлогын үр дүнд 30-аад жилийн хугацааны үр дүнг чинь гор нь энэ шүү дээ. Энэ компаниуд ашиггүй ажиллаад байгаа ерөөсөө үр дүн нь энэ.

Сая Л.Оюун-Эрдэнийн Засгийн газар 2023 онд Багануурын уурхай, Шивээ-Овоогийн уурхайн үнэ тарифыг чөлөөлж өртөгт нь хүргэсэн. Тэгэхэд нэгхэн жилийн дотор Багануурын уурхай ашиггүй ажиллаж байсан. Сүүлийн 20 жилийн хугацаанд 2024 онд ашигтай л ажиллаж байгаа байхгүй юу. Анх удаа ногдол ашиг хуваарилах нөхцөл бүрдэж байна.

Тэгэхээр энэ асуудлын цаана юу байна вэ уу гэхээр ерөөсөө үнэ, тарифын л асуудал байдаг юм байна.

Тэгэхээр төр өөрөө үнэ, тарифыг нь нэмэгдүүлж энэ компаниудын үр ашгийг дээшлүүлэх юм уу, эсвэл хувийн хэвшилд аваачиж байгаад үнэ, өртгийг нь нэмэгдүүлэх юм уу. Энэ хувийн хэвшлийн компаниуд чинь хувьчилж аваад ерөөсөө үнэ, тарифаа л хамгийн эхэнд нэмэгдүүлдэг юм билээ. Тэр хувьчилж авсан гаргасан хөрөнгө оруулалтаа нөхөхийн тулд шууд үнэ, тарифаар оролдоно. Энэ нь шууд ард иргэдийн нуруун дээр ачаалал ирнэ. Ерөөсөө энэ.

Тийм учраас бид энэ олон станцуудыг хувьчлах гэж байна. Багануурын дулааны станцыг хувьчилж байсан гашуун түүх бий. Ингээд компани хувьчилж авангуутаа шууд тухайн жилдээ үнэ, тарифаа нэмэгдүүлж байсан. Пүү паа болоод шууд эргээд хэдэн жилийн дараа төр өөрөө өндөр үнээр хувьчилж авсан.

Өнөөдөр алдагдалтай ажиллаж байгаа гэдэг нэрийн доор цаана нь энэ төрийн өмчийг, ард түмний өмчийг үнэгүйдүүлж байгаад хямдхан байдлаар хувьчилж авах ийм арга тактик явдаг. Өнгөрсөн хугацаанд явсан.

Тийм учраас ийм байдлууд гарахгүй гэх баталгаа хаана байгаа юм. Гарахгүй гэх баталгаа. Тэгээд дараа нь асуудал хүндрээд ирэхээр ерөөсөө болохгүй юм байна. Буцаагаад хувьчилж авъя гэдэг асуудал үүсвэл яах юм. Үүний хариуцлагыг хэн хүлээх юм.

Европын олон улс орнууд ийм жишгээр өнөөдөр энэ эрчим хүчний салбаруудаа хувьчилчхаад өнөөдөр хор гайг нь үзээд буцаагаад төр.../минут дуусав/

Н.Учрал: Тийм. Ц.Сандаг-Очир гишүүнд нэмэлт 1 минут өгье.

Ц.Сандаг-Очир: Тийм учраас олон улс орон хувьчилчхаад буруу байсан юм байна гээд буцаагаад төр лүүгээ авах ийм нүүдэл явж байгаа шүү. Үүнийг Та бүхэн юу гэж судалж харж үзэж байгаа юм бэ? Энэ дээр нэг тайлбар өгөөч.

Энэ Орос, Украйны дайн, энэ дайн байлдаантай байдлын үүднээс эрчим хүчний салбар зайлшгүй төрийн мэдэлд байх ёстой юм байна гэдгийг олон улс орон олоод харсан байна шүү.

Тийм учраас би юу гэж хэлэх гээд байна вэ гэхээр энэ 18 дотор байгаа хувьчилж болох салбар байна, бас болохгүй салбар байгаа юм байна шүү. Үүнийгээ нэг эргэж хараад Та бүхэн хэлэлцүүлгийн шатад үүнийгээ харж үзээч ээ гэж би хувьдаа хэлэх гэж байгаа юм.

Н.Учрал: Тэгээд яг өнгөрсөн жил төсөв хэлэлцэж байх үеэр энэ компаниудын үнэлгээ хийх, аудит хийх, нөгөө underwriter, нөгөө нээлттэй компани болоход бэлтгэх ажлыг хангах дээр Засгийн газар жагсаалт батална, төсвийг нь шийднэ гэдэг заалт оруулахад гишүүд шүүмжилсээр байгаад хасуулсан байхгүй юу.

Наадах чинь үнэлгээ хийхээс эхэлж байгаа юм шүү дээ. Наад компаниудын чинь үнэлгээг яаж тогтоохоос эхэлж байгаа юм. Тэгээд үнэлгээг багаар хийгээд үнэгүйдүүлж байгаад хувьчлах вий гэдэг иргэдийн хардлага байна шүү дээ. Үнэлгээг. Тийм. С.Бямбацогт дарга.

С.Бямбацогт: Тийм. Бас эргэлзээтэй асуудал хөндөж байна. Манай Ц.Сандаг-Очир гишүүн.

Тэгэхээр сая хэлсэн. Энэ өмч хувьчлах үндсэн чиглэлийн зарчим хэрэгжүүлэх арга хэлбэр дээр эхлээд –

- Үнэлгээ хийнэ.
- Үнэ цэнийг нь тогтооно.
- Шаардлагатай бол менежмент оруулна.
- Илүү үнэд хүргэх бодлого барина.

Ингэж байж олон нийтэд нээлттэй, ил тод, чөлөөт өрсөлдөөнөөр худалдана.

Цаг үе нь биш байна, санхүү, эдийн засаг хүнд байна, үүнийг худалдаж авах дотоодын үндэсний компаниуд байхгүй байна гэж үзэх юм бол хойшлуулна. Үүнийгээ жил болгон Засгийн газар нөхцөл байдлаа харж байж хэрэгжүүлнэ. Улсын Их Хурлаар энэ тогтоолоо батлуулж, энэ зарчмыг барина гээд оруулсан байгаа.

Тийм болохоор тэр хуйвалдаад, хулгай хийгээд авах вий гэж хуучин өмнөх 90-ээд оны алдааг давтах вий гэдэг дээр хардаад хэрэггүй.

Өнөөдөр цаг үе өөр болсон. 90-ээд онд мэдээлэл байхгүй. Ганцхан “Үнэн” сонин уншдаг. Ганцхан сувгийн телевизийн мэдээ хардаг байсан бол өнөөдөр хүссэн бүх мэдээллээ хүссэн бүх хэлбэрээрээ Монгол Улсын иргэн болгон гар утаснаас авах бололцоотой болсон. Хүн болгон сэтгүүлч, хүн болгон хууль зөрчиж байгаа үйлдлийг нээлттэй, ил тод хардаг болсон.

- Шилэн болгоно.
- Ил тод байлгана.
- Олон нийтийн оролцоотой болгоно.
- Олон нийтийн хяналт доор хийнэ.

Тийм болохоор хулгай хийгээд, хуйвалдаад, үнэ цэнгүй болгоод авах вий гэдэг хардлага хэрэггүй гэдгийг хэлье.

Алдагдалтай ажиллаж байгаа асуудал дээр төр алдагдалтай ажиллуулаад байгаа шүү дээ гэж. Үнэн. Эрчим хүчний компаниуд үнийг бариад байгаа. Төр үнэ барьж байгаа учраас эрчим хүчний компаниуд алдагдалтай ажиллаж байгаа.

Энэ дээр төрийн эрчим хүчний компаниудын 51 хувь нь төрдөө байна. Тодорхой хувийг нь олон нийтийн оролцоотой, аж ахуйн нэгжийн оролцоотой болгоод тэр илүү өндөр зардал, элдэв янзын шахаа, элдэв данхар бүтцийг нь би байхгүй болгоё. Ингэх юм бол тэр өртөг, зардал нь буураад эрчим хүчний үнэ хямдрах боломж болж үүсэж болох юм гэж харж байгаа.

Дээрээс нь хувийн хэвшлийн компаниуд чинь өчнөөн олон цахилгаан станц бариад эхэлсэн. Зөндөө баригдаж байгаа. Үүнтэй өрсөлдөөд явна.

Ер нь хаана өрсөлдөөн байна тэнд үнэ хямдардаг. Хаана өрсөлдөөн байна тэнд тийм бараа, бүтээгдэхүүний үйлчилгээний чанар сайжирдаг.

Зах зээл дээр нийлүүлэлт нэмэгдэх юм бол үнэ хямдардаг. Нийлүүлэлт нь хомсдох юм бол үнэ өсдөг. Энэ л зах зээлийнхээ зарчмаар л явъя гэж байгаа юм. Өнөөдөр Багануурын станц, Багануурын уурхай, Шивээ-Овоогийн уурхай нэг тонн нүүрсийг 50 хэдэн мянган төгрөгөөр олборлож, дулааны цахилгаанд нийлүүлж байгаа.

Тэгвэл хувийн хэвшлийн Адуун чулууны станц 1 тонн нүүрсийг 35 мянгаар нийлүүлээд ашигтай ажиллаж байхад төрийн өмчийн Багануурын уурхай, Шивээ-Овоогийн уурхай 50 хэдэн мянгаар өгч байгаа мөртлөө алдагдалтай ажиллаж байгаа.

Энд үндсэндээ хувийн, төрийн ялгаа энд бас байж байгаа шүү дээ. Энэ болгоныг бид ялгаж, салгаж харах шаардлагатай. Энэ болгоныг үнэлж дүгнэж байгаад эцсийн шийдвэр Их Хурал дээр л гарна. Тэгээд Их Хурлын гишүүд нэлээн нээлттэй ярьж байгаад л... /минут дуусав/

Н.Учрал: Ц.Сандаг-Очир гишүүн тодруулна.

Ц.Сандаг-Очир: Багануурын уурхайд 60 хэдэн мянган төгрөгөөр олборлоод 50 хэдэн мянгаар нийлүүлж байгаа шүү. 1 тонн тутамдаа 10 хэдэн мянган төгрөгийн алдагдалтай ажиллаж байгаа учраас ингэж алдагдалтай ажиллаад байгаа гэдгийг хэлэхэд илүүдэхгүй байх.

Нөгөө талаар гурван зарчим л бариарай, Та бүхэн.

Нэгд, энд хувьчлалын асуудал яригдаж байхад хөдөлмөрийн хүний, ажилчин хүний цалин хөлс, урамшууллын асуудлыг, нийтээр хоморголон халахгүй байх асуудлыг нэг номерт үзэх ёстой.

Хоёрт, Та бүхэн энэ ажиллаж байгаа ажилчдад тэр нэмж байгаа хувьцаа гэдэг юм уу, хувийн эзэмшлийн хувьцааг нэмэгдүүлж байгаа тохиолдолд ажилчид нь давуу эрхтэйгээр хувьцааг нь эзэмшүүлэх байдлыг тэр хувьчлалын үйл ажиллагаа, процесстоо оруулж харгалзаж үзэх ёстой шүү гэж би хувьдаа хэлэх гэж байгаа юм.

Тийм учраас ер нь эрчим хүчний салбарынхны асуудлыг нээлттэй сонголт хийх асуудал үүсэхийг үгүйсгэхгүй шүү. Үгүйсгэхгүй шүү. Үүнийг илүү... /минут дуусав/

Н.Учрал: Санал хэллээ. Сүхбаатарын Эрдэнэбат гишүүн.

С.Эрдэнэбат: 70, 80-аад жил түүхэнд бий болсон төрийн томоохон өмчүүдийг хувьчлах асуудал орж ирж байна.

Тэгэхээр хувьчлалын зорилго нь мэдээж компанийн засаглалыг сайжруулах, нэмж хөрөнгө босгож үйлдвэрлэл технологийг сайжруулах гэдэг юмыг л ойлгож байна.

Гэхдээ өнөөдөр энэ хувьчлалыг нээлттэй биржээр гэж яриад байгаа. Сонсоход гоё сонсогдож байна. Тэгэхдээ түрүүний гишүүдийн хэлдэг шиг тэр 90

оноос хойш манай өнөөдрийн нийт иргэдийн хэдэн хувь нь энэ хувьцаа, бирж энэ талаар ойлголт мэдлэгтэй байна вэ? Нэгдүгээрт.

Хоёрдугаарт, хөрөнгө мөнгөнийх нь боломж хэр байна вэ. Ихэнх нь зээлээс зээлийн хооронд амьдарч байгаа.

Тийм учраас үүнийг түрүүний П.Сайнзоригийн гишүүний хэлдэг шиг тодорхой зорилтод хэсгүүдээр нь, боломж хязгаартайгаар хувьчлах энэ асуудлыг яривал яасан юм бэ гэдэг ийм санал байна.

1900 ерээд оны үед бүгдийг нь хувьчилъя. Ерөөсөө төрийн өмч гэж байхгүй гэдэг нэрийдлийн доор бүх үйлдвэр, аж ахуйн нэгж, байгууллагуудаа ихэнхийг нь хувьчилсан. Гутал үйлдвэрлэдэг байсан гутлын үйлдвэрийн ажилчин Эрээнээс гутал зөөдөг болсон шүү дээ. Гудамжинд гарцгаасан. Бүгдээрээ.

Тийм учраас тийм гашуун алдааг битгий давтаасай гэдэг хүсэл эрмэлзэл, санал байна.

Ажилчдад хувьцаа олгох асуудлыг Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд тодорхой хэмжээгээр оруулж ирэх хэрэгтэй байгаа юм. Бид ер нь ажилчид гэдэг чинь ард түмний л нэгээхэн томоохон хэсэг. Ажил хөдөлмөр эрхэлж байгаа хүмүүс. Эд нарт цалингаас гадна нэмэлт орлого бий болгох, үйлдвэр аж ахуйн нэгж, байгууллагадаа тогтвор суурьшилтай ажиллах, дээрээс нь олон улсын туршсан арга ESOP⁷ (Employee Stock Ownership Plan) гээд хөтөлбөр байдаг. Ажилчдад нь тодорхой хувьцаа олгохоор дотроос нь хулгай хийлгэдэггүй, тогтвор суурьшилтай ажилладаг.

Мөн дээрээс нь орлого нь нэмэгддэг. Ийм зүйлийг шинэ хууль орж ирсэн үед оруулж ирж байж шийдэх ёстой юм байна. Энэ тал дээр яг ямар байр суурьтай байгаа вэ? Би С.Бямбацогт сайдаас асуумаар байна.

Мөн Б.Цэнгэл дарга энэ талаар өмнө бид ярилцаж байсан. Тийм үү. Нэг захирал очоод хүнээ, багаа томилоод баахан тендер оруулах гээд. Хажууд нь хараад сууж байгаа инженер, техникийн ажилчид, компаниа гэсэн сэтгэлтэй олон мянган ажилчид бий. Төрийн өмчийн компаниуд, орон нутгийн өмчийн компаниуд бүгдээрээ хулгай хийдэг юм шиг популизм байдлаар ярьдаг нь би буруу гэж хардаг. Компаниа дампуурчхаасай, ашиггүй ажиллаасай гэсэн бодолтой нэг ч ажилтан байхгүй.

Тийм учраас ажилчид энэ хувьцаанаас хүртэх эрхтэй.

Би уулын баяжуулах Эрдэнэт үйлдвэр ГОК-ийг тэр цэнхэр, ягаан тасалбар нь авдартаа хадгалаад 30, 40 жил болж байна шүү дээ. Ийм гашуун түүх

⁷ Ажилчдын хувьцаа эзэмших хөтөлбөр.

давтахгүйн тулд Эрдэнэт үйлдвэрээс авхуулаад тогтвор суурьшилтай ажиллах тал дээр Эрдэнэт үйлдвэрийн захирал ямар бодолтой байдаг юм бэ? Энэ тал дээр. Ажилчидтайгаа ярилцаж үзсэн үү? Ер нь. Манай бусад төрийн өмчийн компаниуд. Тийм учраас ийм тодорхой саналыг хэлмээр байна.

Эрдэнэтийн хувьд 49 хувийн маргаантай байгаа гэж ойлгоод байгаа. 49-ийн маргаан нэг тал руугаа эцэслэн шийдэгдээгүй байхад дахиад 10 хувийн асуудал. Бүр доошгүй гэж ярьж байна. Эргээд алсдаа Эрдэнэтийг хувьчилъя гэдэг зүйл рүү орох вий дээ. Ганц манайхны саалийн үнээ, бүс нутгийн хамгийн чухал үйлдвэр.

Тийм учраас энэ тал дээр энэ 49 хувийн асуудал юу болоод байгаа юм бэ? Нэг хувийг ч гэсэн хувьчилмааргүй байгаа байхгүй юу. Энэ асуудал эцэслэн шийдэгдтэл. Үүнийг хэлмээр байна.

Цахилгаан холбоон дээр бас хэлье. Би энэ шуудан, харилцаа холбоо, энэ зарим салбарт ажиллаж байгаа хувьд мэдэх юм. Түүхийг нь. Цахилгаан холбоо компанийг үнэ цэнгүй болсон шалтгаан нь ерөөсөө үүрэн телефоны эрхийг өгөөгүй шүү дээ. Анхнаасаа. Тэгээд хувийн компаниуд нь лоббидоод өгүүлдэггүй байсан. Тэгж байж унагааж байгаад тэгээд одоо үр ашиггүй ажиллалаа гэдэг нэг талаас нь дүгнэлт их буруу шүү.

Тийм учраас төрийн өмчийн компанийг харин төр нь өөрөө унагаах лоббиг хийж ирсэн гашуун түүхүүд байгаа гэдгийг хэлмээр байна.

Монгол шуудангийн хувьд ч гэсэн ялгаа байхгүй дээ. Тодорхой хэм хэмжээг нь хувьчилсан. Дарга аа, 1 минут нэмээд авъя.

Н.Учрал: С.Эрдэнэбат гишүүнд нэмэлт 1 минут.

С.Эрдэнэбат: “Монгол шуудан”-г тодорхой хувь хувьчилсан. Тэгэхдээ “Монгол шуудан” чинь үндэсний манайх шиг тархай бутархай газар шуудангийн төрийн бүх харилцаа холбоо, сонгуулийн хуудасаас авхуулаад бүгд явдаг. Үүнийг 100 хувь хувьчилъя гэдэг дээр хэр зэрэг юу байгаа юм бэ?

Станцуудын хувьд хэллээ. Олон хүн хэлсэн учраас. Ялангуяа түгээхийг хувьчилж болохгүй гэдэгтэй санал нэг байна.

“МИАТ” компани гээд хэр зэрэг алдагдалтай ажиллаад байгаа юм? Би алдагдлыг нь асуусан. Нойтон түрээсээр хэдэн онгоцны түрээс төлсөн байж байгаа. Эргээд буцаад нэмэлт баахан орлого олох боломжтой. Харьцангуй боломжийн ажиллаж байна уу гэдэг зүйлийг би хараад байгаа. Ямар ч улс үндэснийхээ агаарын тээврийн компанид нэмэлтээр мөнгө өгдөг шүү дээ. Тэгж өрсөлдүүлж байгаа.

Одоо энэ “Korean Air”, “Air China”. Эд нар чинь бүгд нэмэлт төрөөс дэмжлэг үзүүлж байж дэлхийн зах зээл дээр өрсөлддөг юм.

Тийм учраас нээлттэй болон хувьцаат компаниудыг бий болгох асуудал дээр зарим компаниудаар ний нуугүй хэлэхэд дэндүү яарсан юм биш үү гэдэг санал байна.

Н.Учрал: Улсын Их Хурлын гишүүн Болдын Жавхлангийн урилгаар Дархан-Уул аймгийн ерөнхий боловсролын “Оюуны ирээдүй” сургуулийн 12 дугаар ангийн 1 дүгээр бүлгийн багш, сурагчид Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна.

Багш, сурагч нартаа сурлагын өндөр амжилтыг хүсэн ерөөе. /алга ташив/

С.Бямбацогт гишүүн хариулна.

С.Бямбацогт: Түрүүн Ц.Сандаг-Очир гишүүн бас хэлсэн. Багануурын уурхай үндсэндээ 65 мянгаар олборлоод 55 мянгаар зарж байгаа. Алдагдалтай нүүрсээ борлуулж байгаа гэж.

1 тонн нүүрс олборлож байгаа өртөг 65 мянга. Гэтэл хувийн хэвшлийн Дорнодын Адуун чулууны 1 тонн нүүрсээ 35 мянгаар борлуулаад ашигтай ажиллаад байгаа юм. Энд л менежмент ямар байна вэ гэдэг ялгаа байгаа юм. Үүнийг манай Их Хурлын гишүүд бодох ёстой. Цаашдаа бид үүнийг анхаарах ёстой.

С.Эрдэнэбат гишүүний ярьж байгаа ажилчид хувьцаа эзэмшүүлэх. Энэ маш чухал. Ялангуяа Эрдэнэт үйлдвэрийн ажилчид аль 90 онд цэнхэр тасалбараараа бид Эрдэнэт үйлдвэрийнхээ хувьцааг авна гээд одоог хүртэл хадгалаад сууж байгаа. Одоо хүртэл. Сая зун очиход бас л гуйж байна лээ. Нэхэж байна лээ. Одоо яах юм бол гэж.

Үүнийг Их Хурал дээр бид шийдмээр байгаа юм. Ямар ч компани нь хувьцаа эзэмшээгүй, ногдол ашиг аваагүй, өмчгүй болсон. Бусад иргэд бүгд тодорхой компанийн хувьцаа эзэмшээд, хувьцаагаа зарж борлуулаад орлого олсон, эсвэл зарим нь хувьцааг нь эзэмшээд одоо хүртэл ногдол ашиг аваад явж байгаа. Тэгвэл Эрдэнэт үйлдвэр дээр ийм асуудлууд байна.

Үүнтэй адилхан “Эрдэнэс Тавантолгой” дээр бас. Нас барсан иргэдийн хувьцааг яах вэ. Нас барсан иргэдэд ногдол ашиг өгөх ёстой. Ногдол ашиг байхгүй. Үүнийг шийдэх асуудал байгаа. Тэгээд Их Хурал энэ тогтоолыг хэлэлцэх явцдаа иргэдийн тулгамдсан хүсэн хүлээж байгаа асуудлыг хамтад нь шийдээсэй.

Энэ бол Их Хурлаас шийдвэр гарах учраас, бүрэн эрх учраас бид оруулж ирж чадахгүй байгаа. Үүнийг анхааралдаа аваасай гэж хүсэж байгаа.

Хувьцааны мэдлэг. 90 онд бүгдээрээ хувьцаатай болсон. Тэгвэл 2011 онд бүгдээрээ “Эрдэнэс Тавантолгой”, “Эрдэнэс Монгол” компанийн 1072 хувьцаа, “Эрдэнэс Монгол”-ын нэг хувьцаа гээд бүгд хувьцаа мэддэг болсон. Ногдол ашгаа Үндэсний баялгийн сангаар дамжуулаад авдаг болсон. 90 оны иргэдийн ойлголт, өнөөдөр иргэдийн ойлголт өөр болсон.

Үүнийг манай гишүүд ялгаж салгаж хараасай. Их Хурал дээр асуудал хэлэлцэж байгаа болохоор “МИАТ”-тай холбоотой асуудал дээр алдагдлаа нэмээд хэлчхээрэй. Алдагдалтай байгаа юм уу, ашигтай байгаа юм уу.

Миний хувьд Зам, тээврийн сайдаар ажиллаж байх үед “МИАТ” компани түүхэн дээд ашигтай ажиллаж байсан.

- ▶ Орон нутагт нислэгийн үнийг 2 дахин бууруулж байсан.
- ▶ Гадаад нислэгийн үнийг 3 дахин бууруулж байсан.

Гэсэн мөртөө түүхэндээ л ашигтай ажиллаж байсан. Ингэж ажиллуулж болдог юм байна лээ. Болдог юм байна лээ.

Гэтэл өнөөдөр ямар гээд байна. Мэдэхгүй. Өнөөдөр сүүлийн үед ямар болоод байгааг би сайн мэдэхгүй байна. Ашигтай ажиллуулъя гэвэл төрийн өмчит компаниудыг ашигтай ажиллуулж, илүү ард иргэддээ ээлтэй ажиллуулж болдог юм байна лээ.

2-хон аймагт нисдэг байсан бол 8 аймагт нисдэг болсон. Билетийн үнэ 2 сая байсан бол хоёр талдаа 1 сая болсон. Сөүл рүү 3 саяар нисдэг байсан бол 1 саяар нисдэг болсон.

Тэгсэн мөртөө түүхэндээ олж байгаагүй ашигтай ажиллаж байсан. Ийм менежмент... /минут дуусав/

Н.Учрал: Түрүүн “Монголын цахилгаан холбоо”-г асуугаад байсан. “МИАТ”-ийг асуугаад байна.

Цахилгаан холбоог ярих уу? Б.Чинбат захирал. Аан..? “МИАТ”. Дараа нь Б.Чинбат захирал. Та хэл дээ. Олон жил зүтгэлээ. Ер нь ажил сайжруулах гээд үзээд байгаа захирлуудын нэг шүү дээ. Тэгээд бэлтгэл ажлыг хангуулах гээд хэд хэд ч гэж удаагаа орж ирэв. Өмнө нь ч бэлэн IPO гаргах гээд л бэлдсэн байсан. Тэгээд тогтоол нь, хугацаа нь дууссан. Тийм ээ.

4 дүгээр микрофон.

Б.Чинбат: “Монголын цахилгаан холбоо” компанийн гүйцэтгэх захирал Б.Чинбат. Гишүүдийн асуултад хариулъя.

“Монголын цахилгаан холбоо” компани салбарын 100 жилийн түүхтэй ууган компани.

Korea Telecom (КТ) олон улсын хөрөнгө оруулагч манай салбарт орж ирж манай компанийн 40 хувийг авч байсан. Тэгээд 2019 онд Korea Telecom компаниас төр өөрийнхөө хувьцааг аваад, одоо 94.6 хувь нь төрийн эзэмшил, 5.7 хувь нь 4 мянга орчим жижиг хувьцаа эзэмшигчид байдаг.

Компанийн үйл ажиллагааны хувьд 4 жилийн өмнө 17 тэрбумын орлоготой ажиллаж байсан бол өнгөрсөн онд 26 тэрбумын орлоготой явж байгаа. Нэгж хувьцааны үнэ... /минут дуусав/

Н.Учрал: 4 дүгээр микрофон. Нэмэлт 1 минут.

Б.Чинбат: Нэгж хувьцааны үнэлгээ сүүлийн 4 жилд 40 орчим хувиар өссөн явж байгаа.

Өмнө нь Их Хурлын тогтоол гарсантай холбоотой компани 34 хувь хүртэл нэмж хувьцаа гаргахаар бэлтгэл ажил хангагдсан. Тэгээд одоо энэ 49 хувь хүртэл нэмж хувьцаа гаргах энэ ажил манай компани хийх боломжтой гэж үзэж байгаа.

Н.Учрал: “МИАТ” компанийн захирал Т.Тэлмэн. 3 дугаар микрофон.

Т.Тэлмэн: Сайн байцаана уу? Та бүхэнд энэ өдрийн мэндийг хүргэе.

“МИАТ” компанийн гүйцэтгэх захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгч Т.Тэлмэн байна.

“МИАТ” компанийн хувьд 2024 онд 12.5 тэрбумын ашигтай ажиллаж байсан бол энэ жилийн хувьд бид 3 дугаар улирлын байдлаар 9.6 тэрбумын алдагдалтай ажиллаж байгаа.

Гол алдагдалд нөлөөлж буй хүчин зүйл гэх юм бол нэгд бид орон нутгийн 8 чиглэлд нислэг хийж байгаа. Үнийн тарифыг хатуу тогтоосонтой холбоотой бид энэ жилийн хувьд хүлээгдэж байгаа гүйцэтгэлээр 16.2 тэрбумын алдагдал орж ирж байгаа. Орон нутгийн нислэгийн.

Мөн Оросын Холбооны Улсын дайн байлдаантай холбоотой нөхцөл байдлаас үүдээд бид түлш, шатахууны хувьд тодорхой хэмжээний үнэ, тариф өссөн. Үүнтэй холбоотой зардал нэлээн өндөр орж ирж байгаа. Тэгээд 10, 11 сарын гүйцэтгэл харьцангуй тасарч байгаатай холбоотой хүлээгдэж байгаа алдагдал оны эцэст нэлээн өндөр байхаар байна.

Н.Учрал: Сархадын Зулпхар гишүүн асуулт асууна.

С.Зулпхар: Улсын Их Хурлын дарга, гишүүд, ажлын хэсгийнхний өдрийн амгаланг айлтгая.

Төрийн өмчит хуулийн этгээдийн хувьцааг биржээр олон нийтэд нээлттэй худалдах, төрийн өмчийг хувьчлах, өөрчлөн байгуулах, үндсэн чиглэл батлах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэх эсэх асуудлыг бүрэн дэмжиж байна.

Бид 1990 онд Үндсэн хуулиа өөрчлөхдөө улс төрийн тогтолцоогоо, нийгмийн байгууллага, эдийн засгийн тогтолцоогоо шинэ хэлбэрээр зохион байгуулаад, олон улсын жишгээр, дэлхийн жишгээр өөрчлөгдөнө, хөгжинө гэдэг зорилт тавьсан. Тэгээд түүн дотроо эдийн засгийн бүтцээ бид хувийн өмчид суурилсан байдлаар цааш нь хөгжүүлнэ гэдгээ их тодорхой зорилт болгосон.

Тэгэхээр энэ бол манай хөгжлийн үзэл баримтлал, манай хөгжлийн зорилго гэдгийг бид бүгдээрээ мэдэж байгаа.

Сая тодорхой хэлж байна шүү дээ. Манай Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрт төрийн өмчит хуулийн этгээдийг хувьчлах, засаглалыг нь сайжруулах томоохон зорилт тавьсан байгаа. Эдийн засгийн бүтэц өөрөө үүнийг тодорхой харуулж байна шүү дээ. Төрийн өмчит хуулийн этгээд чинь эдийн засгийнхаа бүтцийн 74 хувьд нь байж байдаг. Ажиллах хүчнийхээ 4.6 хувьд байж байгаа юм.

Тэгэхээр энэ байдлаас нь аваад үзэх юм бол үүнийг дагалдсан зарим нэг бэрхшээлүүд байна.

Төрийн өмчит хуулийн этгээдүүд дээр засаглалтай нь холбоотой, үйл ажиллагааных нь үр дүн, үр ашигтай холбоотой маш томоохон сорилтууд байгаа. Үүнийг давахын тулд байж болох сонгодог шалгарсан аргуудынх нь нэг гэж хэлэх ёстой. Энэ бол олон улсад туршигдаад угаасаа бид үүнийг авч хэрэглэж байгаа. Бид үүнийг өөрсдөө бодож явсан биш, олон улсын бусад улсуудын туршлага учраас өөртөө нийцүүлж хэрэглэж байгаа ийм зүйл учраас бид энэ шинэчлэлийг сүүлийн 25, 26 жилд хийсэн шигээ бид цаашдаа ч гэсэн хийсээр байх болно гэдгийг энд хэлэх ёстой.

Үүнтэй холбоотой тогтоолын төсөлтэй холбоотой тодорхой асуултууд байна. Сая хариултууд өгч байна.

Төрийн өмчийн хуулийн этгээдийг хувьчилсантай холбоотойгоор гарч болох засаглалын эерэг үр дүнгүүд байна гэж байгаа юм.

Түүнээс гадна эрсдэлүүд бий. Үүнийг яг өнгөрсөн хугацааныхаа туршлага дээрээ тулгуурласан байдлаар хэр судалсан бэ? Энэ өөрөө их чухал. Өнгөрсөн хугацаанд чинь бидэнд бас нэг туршлага бий болсон, сургамжууд бий болсон байгаа шүү дээ.

Сая би хэллээ. Үзэл баримтлал нь зөв. Зорилго нь зөв. Гэхдээ бид арга дээрээ асуудалтай байгаа. Арга дээрээ алдаж байгаа. Тэр асуудалтай байгаа зүйлээ бид сайжруулаад явах үүднээс энэ асуудал хэр судлагдсан бэ гэдэг ийм асуулт байна.

Хоёр дахь асуулт. Алдагдалтай ажиллаж байгаа хэчнээн төрийн өмчит үйлдвэрийн газрыг энд хувьчлахаар, хувьцааг нь нээлттэй худалдахаар шинээр зохион байгуулахаар оруулж ирсэн бэ? Үүнийг Та бүхэн хэлж өгөөч. Үүнийг тодорхой хэлэх ёстой. Энэ алдагдлыг л бид даван туулах боломжийг эрэлхийлж байгаа байх.

- Алдагдлыг үүний үр дүнд арилгах урьдчилсан тооцооллууд хийгдсэн үү?
- Хэр алдагдал нь буурах юм?
- Түүнээс гадна хэр ашигтай ажиллах юм?

Үүнийгээ дагалдсан байдлаар тодорхой тэнд чинь үйл ажиллагаа, үйлчилгээ явж байгаа шүү дээ. Нийгмийн суурь үйлчилгээнүүд. Энэ тогтвортой цаашдаа үргэлжлэх урьдчилсан судалгаа хийгдсэн үү гэдгийг би зориуд Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газраас асууж байна.

Судалгаа байхгүйгээр бид болохгүй ээ.

Сая зарим гишүүд маань хэлж байна. Бид их болгоомжиж байна гэж. Зөв. Болгоомжилж байгаа. Болгоомжилж байгаа шалтгааныг Та бүхэн “болгоомжлохгүй байж болно” гэдгийг судалгаа, тооцоогоор л тайлбарлана. Хэрвээ судалгаа, тооцоолол байхгүй оруулаад ирэх юм бол бид үүнийг харахуй баталж чадахгүй шүү гэдгээ хэлж байгаа нь зарчмын хувьд зөв гэж бодож байна.

Би эхний хоёр асуултдаа хариулт авъя. Тэгээд залгаад тодруулгаар гурван асуулт асууя.

Н.Учрал: Хэн хариулах вэ? 4 дүгээр микрофон. Ц.Баяр-Эрдэнэ дарга.

Ц.Баяр-Эрдэнэ: Гишүүний асуултад хариулъя.

Ер нь 1990 оноос хойш өнөөг хүртэл явж ирсэн энэ өмч хувьчлал, түүний үр дүнд Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар үнэлэлт дүгнэлт хийгээд Засгийн газарт танилцуулсан. 2019 онд.

2019 онд Засгийн газраас энэ өмч хувьчлалд хийсэн үнэлэлт дүгнэлтийн талаар авч хэлэлцээд тодорхой тэмдэглэл гаргасан байдаг. Үүнийг маш товчоноор дүгнэж хэлэх юм бол ер нь өнгөрсөн хугацааны өмч хувьчлалын үйл явц, алдаа оноо, сургамж, туршлага хуримтлуулжээ.

Гэхдээ энэ хувийн хэвшлийн эдийн засаг бүрдсэн хэв маяг, энэ загварыг бий болгоход гол үүрэг гүйцэтгэжээ гэж дүгнэсэн.

Тухайн үед ажиллагсад, томоохон байгууллагын хамт олон хувьцаа авна гэж тооцоод тодорхой хэлбэрээр сан байгуулаад. Тухайлбал, Эрдэнэт үйлдвэрийн хувьцааг авна гэсэн хүлээлт үүсгэсэн ажиллагсдын эрх ашиг хөндөгдөөд явж байгаа асуудал бий.

Тухайн үед цэнхэр, ягаан тасалбараар хувьцаа аваад, хувьцааныхаа үр өгөөжийг тодорхой хэмжээнд авч чадаагүй 10 гаруй тэрбум төгрөг хуримтлагдсан байдалтай байж байгаа асуудал бий. Тэгээд энэ асуудлуудыг цэгцэлж холбогдох арга хэмжээ авч ажиллах чиглэлээр ажлууд хийгдсэн.

Одоо өмч хувьчлалын асуудал үндсэндээ төрийн болон орон нутгийн өмчийн хуульд 4 үндсэн арга, хэлбэр байгаа.

Энэ дотор “тусгай хувьцаа гаргах”, “хаалттай хүрээнд худалдах” гэсэн энэ арга хэлбэрээр өмнө нь тодорхой хуулийн этгээд, аж ахуйн нэгжүүдийг хувьчилж ирсэн юм билээ.

Энэ хаалттай хүрээнд тусгай хувьцаа гаргах хэлбэрээр худалдаж арилжсан, менежментийн хувьчлал, сонгон шалгаруулалт нэрээр арилжиж хувьчилсан үр дүнг нь харгалзаж хувьчилсан асуудлууд дээр тодорхой шүүмжлэл байдаг. Үүнийг анхаарах ёстой гэж үзэж байгаа.

Бид одоо энэ орж ирж байгаа 8 компанийн хөрөнгийг нь нээлттэй дуудлага худалдаагаар худалдах, 18 компанийг ерөөсөө биржээр нээлттэй арилжихаар оруулж ирж байгаа.

Тэгэхээр хувьчлалын хамгийн зохистой арга хэлбэрийг оруулж ирж байгаа гэж үзэж болно.

Бид өнөөдөр 101 төрийн өмчит компанийг бизнесийн болон өрсөлдөөний, стратегийн, тэгээд нийгмийн чиглэлийн гэсэн 3 ангилалд хуваасан байгаа.

Бидний өнөөдөр оруулж ирж байгаа компаниуд ямар нэг байдлаар ашигтай ажиллаж байгаа. Үүн дотор тодорхой хэмжээнд орон нутагт үйл ажиллагаа явуулж байгаа дулааны станцууд маань тарифын зохицуулалт, үнийн бодлогоос хамаараад өөрийнхөө өртөг, ашгийн маржаар нь /Profit Margin/ тооцоод явуулах боломж байдаггүй.

Гэхдээ энэ өрсөлдөөнт зах зээлийг бий болгох асуудлыг өмч хувьчлалын үндсэн чиглэлийн хэрэгсэлтэй цуг явуулах ёстой гэсэн бодлого чиглэл явж байгаа.

Ер нь ашиггүй ажиллаж байгаа компанийг бирж дээр гаргана гэж байхгүй.

Н.Учрал: Болсон. Даваагийн Цогтбаатар гишүүн асуулт асууна.

Да.Цогтбаатар: Баярлалаа. Та бүхэнд энэ өдрийн мэнд хүргэе.

С.Бямбацогт сайдын ярьж байгааг нэлээн чагналаа. Зарим зүйл нь жоохон инээдтэй л юм яриад байна. Та өөрөө 5 сонгогдсон дархан төрийн түшээ. Би 5 сонгогдсон Улсын Их Хурлын гишүүнийг хүндэтгэж байна.

Одоо би таныг Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга, сайд гэдэг утгаар чинь үг хэлнэ шүү.

Нэгдүгээрт, энэ Төрийн банк байна. Төрд байх ёстой л гээд байгаа юм. Одоо Монголд 12 банк өрсөлдөж байхад төр тэр дотор өрсөлдөж яг яах гэж байгаа юм.

Анх хувьцаа нь 590 төгрөгөөр гарч байсан. Одоо 476 төгрөг. 55 тэрбум төгрөгийг тавиад туусан. Тэнд захирлууд нь юугаа хийж сууж байгаа юм. Ямар гавьяа байгуулсан гэж наанаа сууж байгаа юм.

Одоо нөгөө захирал нь ирж чадахаа байсан. Хоёр загнуулаад алга болсон. Цагаан байрны хамаатны үеэл. Цагаан байрны даргынх нь үеэл. Тэгээд дэд захирал нь нөгөө дэд сайд гэдэг шиг асуултад хариулна гээд. 2016 оноос хойш Төрийн банканд ажилласан Д.Сугар гэдэг захирал тэнд баахан алдагдал. Та нар ашиг, алдагдал гэдэг юм яриад байх шиг байгаа юм. Хувьцаат компани дээр хувьцааных нь үнийг ярина шүү дээ. Хэдүүлээ. Өнөөдрийн зах зээлийн ханшаар байгуулагдаж байсан үеийнхээ, нөгөө IPO гаргаж байсан үеийнхээсээ 55 тэрбум төгрөг алдсан сууж байна шүү дээ. Наад хүмүүс чинь.

Яагаад та нар хариуцлага тооцоогүй энд ингээд толгойг нь илээд л, гавьяа байгуулсан юм шиг тэнд индэрт ирээд л хийх юм байхгүй ингээд цаг үрээд сууж байна шүү дээ. Наана чинь.

Өрсөлдөгч нь 1 их наяд гараад явсан. Одоо яг өөрийнх нь энэ Төрийн банкныг өнөөдрийн хувьцааных нь үнээр тооцох юм бол 360 тэрбум төгрөг л хүрэхээр байна.

Өрсөлдөгч ерөөсөө 70 хувиар сугараад хоцорсон. Тэгээд ийм хариуцлагагүй байгаад байхад та нар Б.Цэнгэл дарга, энэ С.Бямбацогт сайд хариуцлага чинь хаана байгаа юм.

Бүгдийг нь бараг хөөж явуулна гэхэд ч багадааар юмнууд хуулийн хариуцлага хүлээгээд явуулах хэрэгтэй шүү дээ. 55 тэрбум төгрөг.

Тэгээд хоёрдугаар асуудал. Эрдэнэтийн шахааны, эсвэл баяжмалын тэр тендерчдийнхээ хулгайчийг олохгүй байна гээд би таны амнаас энэ үгийг нэлээн хэд сонслоо. Та 5 сонгогдсон төрийн түшээ. Мэдээлэлд маш ойр байгаа хүн. Цагаан байрнаасаа очоод хулгайчуудаа хайгаач.

Сүүлийн 10 жилд танайх дангаараа засаг барьсан шүү дээ. Тэгээд яагаад нийгэмд худлаа мэдээлэл өгөөд, нэг гоё ганган, хэнээс айгаад байгаа юм. Та ер нь хулгайч аа. Энэ Авлигатай тэмцэх газар гэж байгаа бол ажлаа хиймээр байна. Яг улс төрчдийн захиалгаар гарч ирж ганц нэг хүн намнасан болоод алга болдог. Авлигатай тэмцэх газрын дарга нь ер нь Монголд байдаг юм уу? Ажил хийж авлига бууруулж байгаа юм нэг ч алга байна шүү дээ. Бодит байдал дээр захиалгаар л ажиллаж байна.

Яг жинхэнээсээ ажлаа хийгээд энэ Төрийн банкны захирлуудаас өгсүүлээд аваачаад шалгаач. Хамаарал бүхий болохоор нь Та нар чадахгүй байгаа байхгүй юу.

Тэгээд энэ Төрийн банкны захирал хариулаадах. Тэр 55 тэрбум төгрөг хаачсан. Танай захирал өөрөө хаачсан. Яахаараа танай банкны асуудал энд хувьчлагдах гээд сууж байхад нүдэн балай, чих нь дүлий хаагуур дэмий тэнэж явдаг юм. Тэгээд дараад нь тодруулга авъя.

Н.Учрал: С.Бямбацогт дарга хариултаасаа эхэлье.

С.Бямбацогт: Төрийн банк 12 банкттай өрсөлдөх үү гэж. Би өөртэй чинь санал нэг байгаа.

Тэртээ тэргүй хувьд шилжүүлэх бололцоотой хувийн 12 арилжааны банк байж байхад зэрэгцээд явах шаардлагагүй гэдэг үүднээс аль болох ахиу хувьцааг хувьчилъя гэсэн санал оруулсан.

- Сангийн яамнаас татгалзсан.
- Төрийн банкнаас татгалзсан.

Тийм болохоор Төрийн банкныхан өөрсдөө энэ асуултад хариулах ёстой байх.

Тэгээд ямар захирал байдаг юм, хэний гар хөлийн гэдгийг би мэдэхгүй. Үр ашигтай ажиллах ёстой. Сангийн яам хувьцаа эзэмшигч нь. Адилхан төрийн өмчит компани гэдэг үүднээсээ би шаардлагаа тавина. Танаас харин мэдэж авлаа. Гар хөлтэй юм байна. Их муу юм байна гэдгийг нь мэдэж авлаа. Хариуцлагыг анхааръя.

Эрдэнэтийн тухайд хулгайчдыг олохгүй байна гэх юм. Тэр зэсийн баяжмалын хулгайчийг олсонгүй. Тэр барааны шахааны хулгайчийг олсонгүй гэж. Би олоогүй биш ээ. Хулгайгүй болгосон гэж ярьсан.

Таны мэдэх үед, таны мэддэг үед хулгайтай байсан байж магадгүй.

- Одоо тэгвэл хулгайгүй болсон.
- Шахааны хулгай байхгүй болсон.
- Бараа, бүтээгдэхүүн шахахаа больсон.
- Хиймэл оюун ухаанаар худалдан авалт, тендер шалгаруулдаг болсон.
- Хувь хүний оролцоогүй болсон. Ингээд хулгайгүй болсон.
- Хулгайг таслан зогсоосон гэсэн гэсэн үг.

Хоёрдугаарт нь, тэр зэсийн баяжмалын хулгайг бид бага үнээр нууцаар гэрээ хийдэг байсан бол бирж дээр дуудлага худалдаагаар гэрээ хийдэг болсон. Ингээд зэсийн баяжмалын хулгайг таслан зогсоосон.

Дээрээс нь, тэр овоолгын хулгайг үндсэндээ таслан зогсоож байна. Төрд, Монголын ард түмэнд ногдох баялгийн өгөөжийг авчирч байгаа. Аль болох 50 хүртэл хувийн өгөөжийг авчрах гээд ажиллаж байна.

Ингээд үндсэндээ Эрдэнэтийн хулгай алга болж байгаа.

Ер нь төрийн хяналт сайжрах тусмаа, Их Хурлын хяналт сайжрах тусмаа ард түмний мэдэх эрх хангагдаж байна. Хулгайч хийдэг, энд тэнд байдаг тэр таны ярьдаг цагаан байр, энд тэндээс хулгай хийдэг асуудал чинь байхгүй болж байгаа.

- Бид нүүрсний сонсгол хийсэн. Хэн хулгайч байсныг нь харсан.
- Хөгжлийн банкны сонсгол хийсэн. Хэн хулгайч байсныг харсан.

Сая Оюу Толгойн сонсгол хийлээ. Хаана ямар алдаа байгааг харсан.

Тийм болохоор цаашдаа бүх юм нээлттэй, ил тод, олон нийтийн хараа хяналт доор, Их Хурлын хараа хяналт доор явдаг болохоор цаашдаа ийм хулгайнууд гарахгүй.

Энэ бол 2019 оны Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн үр дүн. Бид Их Хурлын хянан шалгах бүрэн эрхийг нэмэгдүүлсэн. Үүнтэй холбогдуулж 2020 онд

би Хяналт шалгалтын тухай хуулийг санаачилж батлуулсан. Үүний үр дүнд нээлттэй сонголт хийдэг болсон. Ард түмний мэдэх эрх хангагдсан. Энэ бас хэдэн удаа сонгагдсаны үр дүн. Ингэж 2019 оны Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлт хийснээрээ Их Хурлын хянан шалгах бүрэн эрхээ хэрэгжүүлэх бололцоог нэмэгдүүлж, ард түмний мэдэх эрхийг хангаснаараа би бахархдаг.

Үүний үр дүнд цаашдаа энэ төрийн өмчийн компаниуд дээр, энэ өмч хувьчлал дээр хулгай гарахгүй. Ил тод, нээлттэй, хараа хяналт доор энэ асуудлууд шийдэгдэнэ. Урьд нь нууцаар, хаалттай, хуйвалдаж явдаг байсан бол энэ зүйл давтагдахгүй.

Н.Учрал: Ажлын хэсгээс хариулъя.

Төрийн банк уу? Ажил, албан тушаалаа.

Д.Сугар: Төрийн банкны Тэргүүн орлогч Д.Сугар.

Гүйцэтгэх захирал эрүүл мэндийн шалтгаантай. Эмнэлэгт хэвтэж байгаа.

Хувьцааны ханшийн хувьд анх 2022 онд 590 төгрөгөөр хувьцаагаа гаргаж байсан. Түүний дараа хамгийн дээд тал нь 1200 төгрөг хүрч байсан тохиолдлууд байгаа. Өнөөдрийн байдлаар 476 төгрөгийн өчигдрийн хаалтын ханшаар тийм байсан байна.

Ер нь хувьцаа нь өөрөө ер нь өсөлт, бууралттай л явдаг. Ганц Төрийн банк биш, бусад арилжааны банкнуудын хувьцаа бас ерөнхийдөө бага зэргийн хувьцааны ханш нь уналттай байгаа.

Төрийн банк нь сүүлийн 3 жилийн хугацаанд... /минут дуусав/

Н.Учрал: Та чинь Тэргүүн орлогч гэсэн үү? Тэргүүн орлогч юм уу? Бүтээмжийн менежер юм уу? Хяналтын менежер юм уу?

Танай хяналтын менежерүүд байгаа юу? Танайд. 3 дугаар микрофон.

Хяналтын менежер, бүтээмжийн менежерүүд тэр бөөн юм болоод байна гэсэн шүү дээ. 3 дугаар микрофон өг дөө.

Д.Сугар: Хяналт хариуцсан дэд захирал, Бүтээмж хариуцсан дэд захирал гээд 2 захирал байгаа.

Н.Учрал: Хяналтын менежер байгаа юм байна. Тийм ээ?

Д.Сугар: Байгаа.

Н.Учрал: Да.Цогтбаатар гишүүн тодруулъя.

Да.Цогтбаатар: С.Бямбацогт сайд аа, та төр газраа авч үлдээд, барилгаа авч үлдээд гээд буруу юм яриад байна. Наадах дээр чинь л хулгай гарна.

Хувийн хэвшилд наад газрыг чинь өгөөд, барилгыг чинь өгөх юм бол өшөө гоё гоё байшин барилга, хөрөнгө оруулалт татна.

Та сая энэ Монголын цахилгаан холбооных дээр яриад байх шиг байна. Энэ буруу бол буруу. Өөрсдөөс нь асуухаар хувьчилъя гэхгүй шүү дээ. Төрийн банкиг жишээлэхэд. Сангийн сайд сайн мэдэж байгаа. Төрийн банканд хэн хэн ямар албан тушаал хашдаг, хэний хамаарал бүхий вэ гэдгийг нь. Дандаа Цагаан байрны хамаарал бүхий.

Даа ялангуяа Цагаан байрны даргынх нь үеэл гүйцэтгэх захирал хийдэг. Одоо ингээд танд худлаа ярина, энд нэг нь худлаа ярина. Ийм том толгойтой болсон нөхдүүд шүү дээ. Тэгээд үүнийг чинь ил гаргаж хэлээд байхад та нар хариуцлага тооцож чадахгүй өдий болтол эвий минь гээд л явж байна шүү дээ.

Тэгээд Д.Сугар захирал аа, хувьцааны үнэ ханш яахаар унадаг, яахаар өсдөгийг худлаа үнэн гадарлана шүү дээ би. ХААН банкны хувьцаа одоо өсөлттэй байна. Хичээл заах гэж байгаа юу та надад. Монголын ард түмэнд. Төрийн банкны хувьцаа... /минут дуусав/

Н.Учрал: Энэ Цагаан байрны даргын гэхээр бас эвгүй сонсогдоод. Надад тийм юм байхгүй байгаа шүү. Тийм.

С.Бямбацогт дарга хариулъя.

С.Бямбацогт: Би Цагаан байрны даргыг олж байгаад тийм юм байгаа юм уу. Асууж тодруулж танд хариулт өгье. Нэг.

Хоёрдугаарт нь, тэр газар, байшинг нь авч үлдэнэ гэж байна. Хөрөнгийн биржийг бид ахиухан хувьчилъя. Энэ Хөрөнгийн биржийг хөрөнгийн зах зээл дээр гол зангилаа болсон hub нь болж байгаа.

Тийм болохоор энд их асуудал байгаа гэж бид ярьж байгаа. Гэтэл энэ Хөрөнгийн биржийг хувьчлахаар цаад талд нь нөгөө Сүхбаатарын талбайн баруун талын газар, тэр Сүхбаатарын талбай нь түүхэн үнэ цэнтэй дурсгалтай Элдэв-Очирын нэрэмжит хүүхдийн кино театр байсан барилга. Үүнийг л шунаад авах вий гээд. Тийм болохоор бид харамлаад өгөхгүй байгаа юм, хувьчлахгүй байгаа юм гэж байгаа.

Тийм болохоор тэр барилгаа, тэр газраа төрдөө аваад үлдье. Ганцхан энэ хөрөнгийн зах зээлийг хөгжүүлэхийн тулд Хөрөнгийн биржийг нь өөрийнх нь тэр

тусгай зөвшөөрөл, өөрийнх нь менежменттэй нь, өөрсдийнх нь тоног төхөөрөмж, боловсон хүчин, энэ бүгдийг нь хөрөнгийн зах зээлээ хөгжүүлэхийн тулд олон улсын гаднын сайн туршлага оруулж ирвэл яасан юм бэ л гэсэн тийм агуулгаар хариулт өгсөн шүү. Ийм ялгаатайг зөв ойлгоорой, та.

Н.Учрал: Үдээс өмнөх чуулганы нэгдсэн хуралдаан өндөрлөж байна.

14.00 цагт чуулган үргэлжилнэ.

Санал хураалтаар үргэлжлэх юм байна шүү. Эдгээр гишүүд асуултаа асуугаад, тэгээд шууд санал хураалттай. Үг хэлэх нэрсээ өгсөн гишүүд байгаа.

Чуулганы хуралдаан түр завсарлаж байна. 14.00 цагаас чуулган үргэлжилнэ.

ЗАВСАРЛАГА

Үдээс хойших чуулганы хуралдаан эхэлж байна. Урьдчилсан ирүүлсэн нэрсийн дагуу асуултууд үргэлжилнэ. Ажлын хэсгийн гишүүдийг танхимд урья.

Жанчивын Галбадрах гишүүн асуулт асууна.

Ж.Галбадрах: Өдрийн мэнд хүргэе.

Энэ тогтоолын төслийг бүрэн дэмжиж байгаа. Төрийн өмчийн компаниудыг хувьчилъя. Хувьцааг нь худалдъя. Олон нийтийн болгоё гэж байгаа нь уг компаниудын үр өгөөжийг дээшлүүлэх, менежментийг нь сайжруулах, хөрөнгө оруулалтыг татах, нээлттэй болгоход маш чухал.

Өнөөдөр бид төсвийн орлого 2 их наяд төгрөгөөр тасраад байгаа энэ цаг үед бид энэ хувьчлалыг хийснээр төсөвт орлого нэмэгдүүлэхэд үр дүнг өгөх болов уу гэж бодож байгаа. Тэгээд үүнтэй холбогдуулаад ер нь энэ хувьчлалаар төсвийн орлого бүрдүүлэхэд хэчнээн төгрөг төсөвлөж, төлөвлөж байгаа вэ гэдгийг нэгдүгээрт асууя.

Өмнө нь бид 26 компани аж ахуйн нэгж хувьчлах ийм заалтууд орж ирээд дөнгөж хоёр нь хувьчлагдсан гэж түрүүн яригдаж байна. Тэгээд энэ ямар учиртай юм. Эндээс бид ямар сургамж авсан бэ гэдэг талаар Төрийн өмчийн хорооноос асууя.

Мөн алдагдалтай компаниудыг хувьчилж байна гэж бид ярьж байна. Энд 18 компани байна. Тэгээд энэ дотор олон нийтийн анхаарлын төвд байдаг олон компаниуд бас байна. Жишээ нь, одоо манай “МИАТ” компани байна.

Тэгээд би “МИАТ” дээр төвлөрөөд хэдэн асуулт асууя гэж бодож байна. “МИАТ”-ийн ашиг, алдагдлыг сонсьё.

Ер нь ашигтай ажиллаад байгаа гэж сонсоод байсан. Түүрүүн ярихад нэлээн алдагдалд ороод байгаа гэсэн.

- Алдагдлынх нь учир шалтгаан нь юунд байна?
- Улсад хэчнээн төгрөгийн татвар төлдөг юм?
- Хэдэн тэрбум төгрөгийн ашигтай ажиллаж байсан юм?

Хэдийнээс ашиггүй ажиллаж байгаа юм гэдэг талаар “МИАТ”-ийн хүмүүсээс асууя гэж бодож байна.

Миний гол асуух зүйл үндсэн чиглэл байгаа. Одоо энэ тогтоолын төслийн дагаж орж ирж байгаа. Тэрний 4.2 дээр “МИАТ”-ийн хувьцааны 10 хувийг “стратегийн хөрөнгө оруулагч” нарт санал болгож, нээлттэй компани болгох гэж заасан байгаа.

Тэгэхээр “Стратегийн хөрөнгө оруулагч” гэж хэнийг хэлж байна вэ? Түүрүүн ярьж байсан. “Мэргэжлийн хөрөнгө оруулагч” нарыг хэлж байна уу гэдгийг асууя.

Дээр нь 4.2.1 дээр олон улсын биржээр нээлттэй худалдана гэж заасан байсан. Тэгээд аль улсын ямар биржээр худалдахаар төлөвлөж байна вэ? Энэ нь энэ цаг үед тодорхой байдаг уу гэдгийг. Дотооддоо худалдаалах юм бол. Гишүүд маань ч анхааруулаад хэлээд байгаа. Мөнгөн төвлөрөл хэдэн компани дээр байдаг. Тэгээд түүнийгээ дагаад дотоодынхоо. Бид бас яриад байдаг. Олигарх компани энэ тэрд алдчих эрсдэл байх болов уу гэж бодож байна.

- Хувьчилснаар өрсөлдөөн хэр нэмэгдэнэ гэж харж байгаа вэ?
- Үнэд өөрчлөлт орох уу?

Манай “МИАТ” монопол үнэтэй гэж яригддаг.

Дараагийн нэг юм бол 10 хувийн хувьцаагаа худалдаж олох орлогыг улсын төсөвт оруулна гэсэн байгаа. Энэ нь ер нь хэдэн тэрбум төгрөгийн тооцоолол байгаа юм? Тэгээд “МИАТ” маань өөрөө ямар учир шалтгаанаас тэр алдагдалд ороод ажиллаж байгаа гэдгийг нь сонсвол тэнд нь буцаагаад нэмэлт хөрөнгө оруулалт хийгээд, онгоцоо шинэчлэх, засвар үйлчилгээгээ сайжруулах зэрэгт нь зориулбал ямар байсан юм бэ гэдэг асуултыг асуумаар байна.

Хувьчлал явагдсанаар ажилчдад нөлөөлнө гэж бид яриад байна. Тэгвэл өнөөдөр манайд үнэхээр сэтгэлээрээ ажиллаж байгаа олон хүмүүс “МИАТ”-д ажилладаг гэж би боддог. Сайн нисгэгч нар байдаг. Сайн инженер, техникийн ажилтнууд гадаадад гараад ажиллавал өндөр цалинтай ажиллах хүмүүс ажилладаг.

Тэгэхээр энэ хүмүүсдээ бид энэ хувьчлал хийснээр манай гишүүдийн ярьдаг... /минут дуусав/

Н.Учрал: Ц.Баяр-Эрдэнэ дарга хариулъя. 4 дүгээр микрофон.

Ц.Баяр-Эрдэнэ: Гишүүний асуултад хариулъя.

Энэ удаа төрийн мэдлийн хувьцааг арилжиж байгаа 3 компанийн хувьцаанаас олсон орлогыг улсын төсөвт тодорхой хувийг төвлөрүүлэхээр байгаа.

Төрийн мэдлийн 3 компанийн нийт 10 хувиар тооцоод бодох юм бол 2.2 их наяд төгрөгийг орлогын аргаар буюу орлогын хандлагаар авч үзэхээр 10 хувьд нь татан төвлөрүүлэх бололцоотой гэж үзэж байгаа.

34-өөс 66 хувь хүртэл гаргах тодорхой нэр бүхий компаниудын хувьд үндсэндээ 400 орчим тэрбум төгрөгийг татан төвлөрүүлээд тухайн компаниудын өөрсдийнх нь үйл ажиллагааг сайжруулах, шинэ төсөл, хөтөлбөр бий болгох, шинэ ажил, үйлчилгээ бий болгох чиглэл рүү орно.

Бид 2026 оны төсвийн хуульд Төрийн банкнаас орж ирэх тодорхой төрийн мэдлийн хувьцааны ногдол ашиг, мөн “МИАТ”-ийн 10 хувийн хувьцааны тодорхой хэмжээний төлбөр буюу 120 орчим тэрбум төгрөг улсын төсөвт төвлөрүүлэх бололцоотой гэж тооцож төсвийн хуульд суусан.

Ер нь төрийн болон орон нутгийн өмчийн хууль дээр хувьчлалын орлогыг улсын төсөвт төвлөрүүлнэ гэж заасан байгаа. 2017 онд төсвийн хуульд хувьчлалаас орсон орлогыг төсвийн орлогын бүрдэл хэсэгт оруулахгүйгээр. Хэрэв төсөв алдагдалтай тохиолдолд төсвийн алдагдалд бас оруулж болох юм гэсэн ийм эрх зүйн зохицуулалт орсон байгаа.

Энэ үндсэн чиглэл дээр үндсэндээ бид 2026 онд 120.0 тэрбум төгрөг оруулахаар тооцсон байгаа.

Хоёр дахь асуудал. Ер нь 2023 онд нэр бүхий 25 компани, дээр нь нэмээд Төрийн банкиг IPO гаргахаар шийдвэрлэсэн. Үүний 20 нь АЗЗА байсан. Энэ 20 АЗЗА маань үндсэндээ бизнесийн байгууллага биш. Нийгмийн үйлчилгээ чиглэлийн үйл ажиллагаа явуулдаг байгууллага, компаниуд байгаа.

Тэгээд дээр нь төрийн болон орон нутгийн өмчийн хуульд орсон нэмэлт хувьцаа гаргахад 5-аас дээш хувийг нэгдмэл сонирхолтой этгээд авахгүй гэсэн асуудлуудаас үүдээд энэ арга хэмжээ үндсэндээ хэрэгжилт тун удаан байгаа. Энэ тооцоо судалгаа муу, үнэлэлт дүгнэлт муутайгаар ийм шийдвэр гарчээ гэж бид үзэж байгаа.

Ер нь цаашид Төрийн өмчит компаниудын талаар тухайлсан, нэлээн сайн судалж үзсэн, шийдвэр гаргахад тодорхой хүчин зүйлүүдийг харгалзаж үзэх хэрэгцээ шаардлага бий.

Төр өөрийнхөө 100 хувь мэдэлд монопол байдал үүсгэж болохуйц хувийн хэвшлийнхэн орж ирж чадахгүй энэ чиглэл дээр төр 37... /минут дуусав/

Н.Учрал: Ж.Галбадрах гишүүн тодруулна.

Ж.Галбадрах: Би уг нь “МИАТ”-ийн ашиг алдагдлыг сонирхоод байгаа юм.

Тэгээд 10 хувь нь 100 тэрбум орчим төгрөг гэсэн тоог танаас сонслоо. Үндэсний ганц агаарын тээвэрлэгч маань байж байгаа. Түүрүүн гишүүд ч гэсэн хэлж байсан. Бүр бодлогоор дэмжиж явах ёстой.

Өнөөдөр 10 хувиа гаргаад, гадаадын олон улсын бирж дээр гаргаад, стратегийн хөрөнгө оруулагч гэж хэнийг хэлээд байна гэдгийг нь би асуусан. Тэгээд тэр хөрөнгө оруулагчдыг орж ирээд менежмент, засаглал дээр нь өөрчлөлт гаргаад явах, парк шинэчлэл хийх, онгоцоо шинэчлэхэд нь үүнийг нь буцаагаад зориулаад нэг найдвартай, үндэсний ганц агаарын тээвэрлэгч гэдэг утгаар нь баталгаатай тэр менежмент, засаглал дээр нь аваачих, парк шинэчлэл хийхэд үүнийгээ зориулах байсан юм биш үү гэдэг талаас нь би асууж байгаа юм. Энд хариулт авъя.

Н.Учрал: 4 дүгээр микрофон. Ц.Баяр-Эрдэнэ дарга.

Ц.Баяр-Эрдэнэ: Нэмэлт ч хариулъя.

“МИАТ”-ийг эхний 10 хувийг хаалтын хүрээнд төрийн мэдлийн хувьцааг гаргая гэж байгаа юм. Тэгэхдээ энэ орж ирсэн мөнгийг ер нь төрийн мэдлийн хувьцааг нэмж гаргаагүй зүгээр энгийн хувьцаа гаргаж байгаа тохиолдолд улсын төсөв рүү тодорхой хувийг нь авъя.

Яагаад гэхээр тэр 10 хувиа хөрөнгө оруулагчид хийчхээд нэмж гаргаж байгаа хувьцаан дээр нөгөө prospectus-т үндэслэсэн шинэ төсөл, хөтөлбөрүүдийг үнэлээд түүний өгөөжийг хүртэх ёстой.

Тэгэхээр үүнийг үндсэндээ тэр “МИАТ”-ийн менежментийг сайжруулах, олон улсын засаглал бий болгох, зах зээл дээр гаргах тэр нөхцөлийг бүрдүүлэх гэж хийж байгаа. 10 хувиа дагаж орж ирсэн хүмүүс маань компанийн засаглал, менежментэд оролцоод, үнэ цэнийг сайжруулж байгаад 24 хувийг олон улсын хөрөнгийн бирж дээр гаргая гэж байгаа.

Энэ олон улсын хөрөнгийн бирж дээр гаргах асуудал Казахстаны авиа компанийн жишиг яг ийм байдлаар явсан. Олон улсын хөрөнгийн биржээс... /минут дуусав/

Н.Учрал: 3 дугаар микрофон. “МИАТ” компанийн захирал Т.Тэлмэн

Т.Тэлмэн: Сайн байна уу? Ж.Галбадрах гишүүний асуултад хариулъя.

Би давхардахгүй байдлаар хэлье.

Стратегийн хөрөнгө оруулагч гэж хэнийг хэлж байна гэж байна. Өнгөрсөн хугацаанд “МИАТ” компанийн удирдлага болон “Эрчис Монгол” компанийн удирдлагууд EBRD-ийн (European Bank for Reconstruction and Development) холбогдох хүмүүстэй уулзсан.

Тэгээд “стратегийн хөрөнгө оруулагч” гэдэг нь олон улсын санхүүгийн байгууллагын хэлээд байгаа. Европын Сэргээн Босголт, Хөгжлийн Банк болон IFC (International Finance Corporation) буюу Олон Улсын Санхүүгийн Корпорацийн холбогдох хүмүүстэй уулзаж тодорхой хэмжээний хөрөнгө оруулалт татаад, тухайн байгууллагууд орж ирснээр компанийн засаглал, тайлагнал, ил тод байдалтай нэлээн ажиллана.

Дээр нь бид дотоодын болон олон улсын хөрөнгийн зах зээлд гарахын тулд тухайн биржийн болон зохицуулах байгууллагуудын олон шалгууруудыг хангах, давах ёстой.

Тэгэхээр олон улсын стратегийн партнерууд гол нь түүн дээр ажиллах юм.

Тэгэхээр бид олон улс болон дотоодын хөрөнгийн зах зээл рүү гарах бэлтгэл ажил дээр нэлээн тусалж, дэмжиж ажиллах тийм зорилготой байгаа.

Өнгөрсөн хугацаанд манай компанийн санхүүгийн газар болон “Эрчис Монгол”-ын... /минут дуусав/

Н.Учрал: Мэндчилгээ танилцуулъя.

Улсын Их Хурлын гишүүн Жуковын Алдаржавхлангийн урилгаар Хан-Уул дүүргийн иргэд Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна.

Та бүхэнд эрүүл энх, аз жаргал, сайн сайхан бүхнийг хүсэн ерөөе. /алга ташив/

Улсын Их Хурлын гишүүн Доржзовдын Энхтуяа асуулт асууна.

Д.Энхтуяа: Өдрийн мэнд хүргэе.

Тэгэхээр энэ хувьчлалын хэлэлцүүлгийг сонсож байхад ер нь “бушуу туулай борвиндоо баастай” гэж бид бас ярьдаг. Нэг тийм зүйл болох гээд байна уу л гэж харагдаад байна л даа.

Хуулийг өргөн барьж байгаа Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас үнэхээр энэ хувьчлалыг явуулахыг хүсэж байгаа нь илт байна. Хариулж байгаа төрийн өмчит компанийн захирлууд, удирдлагууд яг энэ хувьчлалд бэлэн байгаа юм уу гэдгийг харахаар бэлэн биш ийм дүр зураг харагдаад байна. Гишүүдийн зүгээс ч гэсэн бас нэлээн шүүмжлэл дагуулж байна.

Тэгэхээр өнгөрсөн 35 жилийн хугацааны хугацааны одоо энэ хувьчлал алдаа оноогоо бид дүгнэх ёстой. Тэгээд бүтэн 35 жилээр дүгнэх боломжгүй юм чинь би нэг зүйлийг энэ дотроос асууя.

Өргөн барьсан тогтоолын төсөл дээр жишээлбэл Хөтөлийн цемент шохойн үйлдвэрийг хувьчилсан байна. Хувьчлахдаа өр төлбөртэй нь хамт хувьчлах Улсын Их Хурлын тогтоол гарсан юм байна. Энэ хувьчлал дампуурсан.

АТГ-д болон бусад хуулийн байгууллагаар шалгагдаж байгаа. Ингээд Улсын Их Хуралд 2022 онд шийдвэрлүүлэхээр оруулж ирсэн юм байна. Харамсалтай нь энэ асуудлыг одоо хүртэл шийдээгүй байгаа.

Хамгийн сүүлийн жишээ. Б.Цэнгэл дарга 2022 оноос хойш энэ байгууллагын дарга хийж байгаа байх. Тийм ээ. 2022 онд хувьчлалын тоо гарсан байна.

Тэгэхээр энэ дээр 26 байгууллагыг хувьчлах жагсаалтад оруулсан. Хувьчлагдсан нь 2 ширхэг. Хэрэгжилтийн хувь 8 хувьтай байгаа.

Тэгэхээр одоо бидний энэ ярилцаж байгаа Улсын Их Хурлын тогтоол батлагдах юм бол хувьчлалаа Засгийн газар явуулаад Улсын Их Хуралд тайлагнах үүрэгтэй байгаа.

Тэгэхээр яг энэ өнгөрсөн хугацаанд би хамгийн сүүлийн 2022 оны энэ хувьчлалын асуудлаар Улсын Их Хуралд ажлаа тайлагнасан уу гэдэг нэгдүгээр асуулт байна.

Хоёрт нь, жагсаалтад орсон манай хамгийн том л байгууллагууд байна л даа.

Тэгэхээр төр мэдээжийн хэрэг өмчөө задлах ёстой. Хувийн хэвшил үүнийг хийх ёстой. Гэхдээ энэ дээр бас нэг нюанс байж магадгүй.

- Хуулийн ямар нэгэн маргаантай компаниуд энэ дотор байна уу?
- Санхүүгийн өр төлбөр нь ямар байдалтай байна?
- Олон улсын арбитрын шүүх дээр очсон компаниуд байна уу?

Яагаад ингэж асууж байна гэхээр дулааны 3 дугаар цахилгаан станц гэж байна. Тийм ээ.

Тэгэхээр энэ чинь өнгөрсөн жил 1.3 тэрбум долларын хөрөнгө оруулалт Оросын Холбооны Улсаас оруулж ирнэ ээ гээд зээлийн хэлэлцээр бид баталсан байгаа.

Тэгэхээр энэ бүх ажил нь хийгдээгүй байхад одоо энэ жагсаалтад оруулж ирж болж байна уу гэсэн ийм асуулт байна.

Хоёр дахь асуулт нь, сая 2025 оны 11 сард Засгийн газар дээр орон сууцжуулах банк байгуулах ажлын хэсэг байгуулсан байгаа.

Тэгэхээр энэ ажлын хэсгийг Хэрэг эрхлэх газрын дарга, сайд ахалж байгаа. Одоо энэ орж ирсэн жагсаалт дотор Төрийн банкиг хувьчилна гээд ороод ирсэн байгаа юм. Тэгээд нэг гараараа Төрийн банкиг хувьчлаад төрд банк байх хэрэггүй юм. Үүнийг бага багаар хувьчилъя гэж байгаа хэрнээ нөгөө гараараа орон сууцжуулалтын банк байгуулна, төрд байх хэрэгтэй гээд Засгийн газар үзсэн байгаа нь философийн хувьд зөрөлдөж байгаа юм биш үү. Энэ дээр Хэрэг эрхлэх газрын дарга хариулт өгөөч. Тэгээд тодруулъя.

Н.Учрал: Мэндчилгээ дэвшүүлье.

Улсын Их Хурлын дарга Н.Учралын урилгаар Сүхбаатар дүүргийн 135 дугаар цэцэрлэгийн багш, ажилчид, бизнес эрхлэгч эмэгтэйчүүдийн төлөөлөл Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна.

Сүхбаатар дүүргийнхээ иргэд Та бүхэнд эрүүл энх, аз жаргал, сайн сайхан бүхнийг хүсэн ерөөе. /алга ташив/

С.Бямбацогт гишүүн хариулна.

С.Бямбацогт: Манай гишүүд, зарим нь ч бүр LIVE хийсэн байж байна. Ерөөсөө л хувьчлах нэрээр хулгай хийх гэж байна. Тэнд Ч.Лодойсамбуу гишүүн оролцож байна гээд. Үг хэлэх эрх хаалаа гээд.

Тэгэхээр нь би бас нэг мэдээлэл өгөхгүй бол болохгүй байгаа юм.

2024-2028 оны Ардын нам, Ардчилсан намын хамтарсан Засгийн газрын баталсан “Хурдтай хөгжлийн төлөөх зориг” гээд мөрийн хөтөлбөр байгаа.

Энэ мөрийн хөтөлбөрийн –

- ▶ 3.1.2.4-д төрийн болон орон нутгийн өмчит компаниудын засаглал, ил тод байдлыг сайжруулж, олон улсын менежментийн багаар удирдуулж, нээлттэй хувьцаат компани болгон, үр ашиг, баялгийн хуваарилалтыг нэмэгдүүлнэ.
- ▶ 3.3.1-д эрчим хүчний салбарын өсөлт, либералчлах, эрчим хүчний салбарыг чөлөөт зах зээлийн зарчимд шилжүүлж, үнэ тарифыг зохистой түвшинд хүргэн, цаашид тогтмол индексжүүлэх тогтолцоог нэвтрүүлж, салбарын эрх зүйн орчныг шинэчилнэ гэж.

Мөн “Засгийн газарт чиглэл өгөх тухай” 2024 оны 12 дугаар сарын 12-ны өдрийн 52 дугаар тогтоолоор “Төрийн өмчийг хувьчлах үндсэн чиглэл, төрийн өмчит хуулийн этгээдийн хувьцааг биржээр олон нийтэд нээлттэй худалдах асуудлаар холбогдох санал боловсруулж, Монгол Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхийг Засгийн газарт даалгасугай.” гээд.

Өөрөөр хэлэх юм бол Засгийн газарт даалгасан Их Хурлын тогтоолыг л Засгийн газар хэрэгжүүлэх гээд л оролдоод байгаа юм.

- Улсын Их Хурал хууль тогтоодог.
- Засгийн газар хуулийг хэрэгжүүлдэг.

Үндсэн хуулиар ийм чиг үүрэгтэй. Засгийн газар хуулиар хүлээсэн чиг үүргээ биелүүлэхгүй бол, хуулийг хэрэгжүүлэхгүй бол Үндсэн хууль зөрчсөн, хууль зөрчсөн гээд огцруулна.

Тийм болохоор бид энэ асуудлыг оруулж ирж байгаа.

Мөн “Эрдэнэс Тавантолгой”, “Эрдэнэт”, “Эрдэнэс критикал минералс” гээд компаниудын 10 хувийг Ашигт малтмалын хуулийн 5.3-д заасны дагуу олон нийтэд нээлттэй биржээр арилжаа л гэсэн хуультай.

Энэ хуулийг хэрэгжүүлж энэ компаниудын 10 хувийг хувьчилъя гэж оруулж ирж байгаа юм. Олон нийтэд нээлттэй хувьцаа гаргая гэж. Олон нийтэд нээлттэй.

Ийм Ашигт малтмалын тухай хууль, Засгийн газрын мөрийн хөтөлбөр, Улсын Их Хурлаас өгсөн тогтоолуудыг л хэрэгжүүлж Засаг Их Хурлаас өгсөн үүрэг даалгаврыг биелүүлж Засгийн газар энэ үндсэн чиглэлийг Их Хуралд өргөн барьсан. Одоо хэлэлцэж байна.

Гэтэл үүнийг хулгай хийх гээд байна. Хуйвалдаж хувьчилж авах гээд байна. Эсвэл их яараад байна гэдэг талаас нь битгий хараач ээ. Энэ бол хуулийг

хэрэгжүүлэх үүргээ Засгийн газар биелүүлж байгаа. Хэрвээ хуулийг Засгийн газар биелүүлэхгүй бол огцруулах асуудлыг Их Хурал, Их Хурлын гишүүдэд тавина.

Оруулаад ирэхээр юу хийх гээд байгаа юм. Яагаад яараад сандраад хуйвалдах гээд байна гээд харддаг. Оруулахгүй болохоор хууль зөрчлөө гэдэг. Мөн шинэ жилээр далимдуулж... /минут дуусав/

Н.Учрал: Д.Энхтуяа гишүүн тодруулна.

Д.Энхтуяа: Таны ахалсан тэр орон сууцжуулалтын банкны асуудал юу болж байна? Та энэ Төрийн банкиг хувьчлах ёстой гээд нөгөө гараараа бас банк байгуулах гээд байгаа байхгүй юу. Тэрийг чинь хэлээд байна.

Дээрээс нь энэ хуулийн асуудалтай, хөрөнгө мөнгөний асуудалтай ийм маргаантай байгаа компаниудыг энэ хувьчлалд оруулж байгаа нь эргээд хэл ам дагуулахгүй юу? Яагаад гэвэл урд нь Хөтөлийн цемент шохойн үйлдвэрийн асуудал чинь одоо хүртэл асуудал нь шийдэгдээгүй. 2022 онд Улсын Их Хуралд тайлагнах ёстой. Тайлагнах үүргээ биелүүлэхгүй байгаа байхгүй юу.

Тэгэхээр Б.Цэнгэл дарга тухайн үед байсан байх. Ажлаа тайлагнах эрх, үүргээ биелүүлсэн юм уу?

Н.Учрал: С.Бямбацогт дарга хариулна.

Төрийн банк бол арилжааны бус банкнуудтай адилхан ашгийн төлөө хувийн хэвшилтэй өрсөлдөж байгаа банк. Үндэсний орон сууцжуулалтын банк бол орон сууцгүй иргэдээ бага хүүтэй ипотекийн зээлээр орон сууцжуулах бодлого хэрэгжүүлэх, Засгийн газрын бодлого хэрэгжүүлэх ийм зохицуулалт хийх банк.

Өнөөдөр ипотекийн зээл авах гээд хэдэн жилээр очерлож байна. Ипотекийн зээл авах гээд авлигал өгч байна. Хувийн банкнуудад. Үүнийг л таслан зогсоох гэж Үндэсний орон сууцын банкиг байгуулах гэж байгаа гэдгийг нэгдүгээрт хэлье.

Хоёрдугаарт нь, Эрдэнэт үйлдвэр, Монрос дээр 49 хувийн энгийн хувьцааг Хөгжлийн банк болон Монголбанкнаас Худалдаа, хөгжлийн банкинд байршуулсан мөнгөн хөрөнгө, ногдол ашиг, вексель зэрэг эх үүсвэр суутган тооцох асуудлыг шийдвэрлэж. Өөрөөр хэлэх юм бол шүүх дээр явж байгаа маргааныг хурдан түргэн яаралтай шийдье. Ингэсний дараа тодорхой хувийг нь хувьчилъя гэсэн, олон нийтэд үнэ хувьцаа гаргая гэсэн ийм зарчим явж байгаа шүү. Энэ бас нэг ялгаа байгаа юм.

Тэгэхээр өөрөөр хэлэх юм бол энэ 49 хувийг нь өгчхөөд дээрээс нь 10 хувийг нь... /минут дуусав/

Н.Учрал: Б.Жавхлан сайд нэмэлт тодруулга хийнэ.

Б.Жавхлан: Гишүүний асуулт дээр нэмж мэдээлэл өгье.

Төрийн банкиг хувьчлах гээд байна гэж байгаа нь энэ бас жоохон буруу ойлголт шүү. Одоо аль хэдийн хувьцаат компани болсон. Бирж рүү буюу олон нийтийн болгосон байгаа тэр хувийг нь нэмэгдүүлж байгаа л асуудал байхгүй юу. Тэгээд хяналтын багц нь 51 хувь нь төр дээрээ өөр дээр нь үлдэнэ. Нэгдүгээрт.

Хоёрдугаарт, орон сууцын банк гэж байгаа чинь бөөний зах зээл дээр ажиллах банк байгаа юм шүү. Өөрөөр хэлбэл банкууд дээр эх үүсвэр дутагдаад байгаа учраас тэд нарт илүү их хүртээмжтэй олон хүнд хүргэхийн тулд эх үүсвэрийг нь хямдруулж оруулж ирэх, тэд нарт эх үүсвэрийг нь нэмж өгөх ийм зорилготой. Одоо үндсэндээ бараг банкуудын банк шахуу зохицуулалтын банк байгуулагдах юм. Тийм. Түүнээс биш Дорж, Дулмаад жижиглэнгийн зах зээл дээр... /минут дуусав/

Н.Учрал: Хүрэлбаатарын Баасанжаргал гишүүн асуулт асууна.

Ер нь нөгөө сунгасан цаг маань дуусаж. Энэ цагийг яах вэ. Дундуур нь мэндчилгээ дэвшүүлсэн цагуудаа тооцъё.

Ингээд Гомбын Ганбаатар гишүүн асуулт асууж дуустал цаг сунгалаа. /алх цохив/

Хүрэлбаатарын Баасанжаргал гишүүн.

Х.Баасанжаргал: Засгийн газрын оруулж ирж байгаа тогтоолын хувьд бүхэлд нь бөөний маягийн л тогтоол ороод ирлээ. Бөөндөх маягтай.

Гэхдээ энэ дотор чинь бид бөөнөөр нь ярих боломжгүй олон асуудлууд байгаа. Монголын хөрөнгийн биржийн асуудал нэг тусдаа, МИАТ-ийн асуудал нэг тусдаа, Эрдэнэт үйлдвэрийн асуудал нэг тусдаа.

Тэгэхээр бид яг нэг ийм бөөндөх аргаар явж болох юм уу, үгүй юм уу. Дэмжихэд хэцүү, дэмжихгүй байх хэцүү л тогтоол орж ирж байна гэсэн үг.

Гол нь хөрөнгө оруулалтыг татахын тулд бид хэд хэдэн урьдач нөхцөлийг манай улс өөрөө хангасан байх ёстой. Энэ дээр ямар бодлого байгаа талаар тодруулж асууя.

Нэгдүгээрт, хөрөнгийн бирж хамгийн чухал. Одоо энэ хөрөнгийг эргэлтэд оруулах хамгийн чухал бидний гол хэрэгсэл. Манай Монголын хөрөнгийн бирж. Хөрөнгийн биржийн 15 хүртэл хувийг гаргахаар нөгөө гадаадын хөрөнгө

оруулагчдын үүнийг хэр сонирхох юм бэ? Ялангуяа би Хөрөнгийн биржийг dual listing буюу давхар Хонгконгийн ч юм уу, өөр бусад улс орны хөрөнгийн бирж дээр давхар гаргах ёстой гэж харж байгаа. Ийм бодлого ер нь явж байгаа юу? Хөрөнгийн биржийнхэн хариулах байх.

Хоёрдугаарт, хөрөнгө оруулалтыг татах бодлогын хувьд давхар татварын гэрээ, өөр бусад татварын хөшүүргүүд байдаг.

Тэгэхээр энэ татварын хөшүүргүүд энэ татварын бодлогууд нь ер нь хаана байгаа вэ? Бид чинь нөгөө оффшор бүс гээд Хонгконгийг оффшор бүсэд зарласан. Тэгсэн мөртөө хамгийн их хөрөнгө татах боломжтой газар нь тэнд байгаад байдаг. Тэгээд дотооддоо болохоор хөрөнгө татах тухай яриад байдаг. Ингээд хоорондоо ерөөсөө авцалдахгүй. Хөрөнгө оруулалт татах урьдач нөхцөл ерөөсөө бүрдэхгүй байгаа байхгүй юу.

Тэгэхээр энэ дээр ямар бодлого байгаа вэ гэдэг ийм асуулт үндсэн нэг гол үндсэн ба багц асуулт.

Хоёрдугаарт, Улсын Их Хурал үндсэндээ хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлээд компаниар ТУЗ-д одоо энэ эрхээ шилжүүлэх гэж байна гэсэн үг. Тийм ээ. Та нар хувьчил гэдэг эрхээ шилжүүлэх гэж байна. Тэгэхдээ хувьцаа эзэмшигч энэ шийдвэрийг гаргахынхаа өмнө заавал due diligence хийсэн материалтай танилцдаг, заавал санхүүгийн хөндлөнгийн аудитын дүгнэлттэй танилцдаг. Гэтэл бид ерөөсөө ийм одоо дүгнэлтүүдтэй танилцахгүй. Нэг ийм нийтэд нь дүгнэсэн тоонуудыг нь тоонуудыг хараад л бид шийдвэр гаргах гээд байна л даа.

Тэгэхээр ийм шийдвэр гаргахад хангалттай материал Улсын Их Хурлын гишүүдэд ирсэнгүй. Эсвэл манай гишүүд дотроо мэдэж байгаа юм болов уу, ямар учиртай юм гэж бодож байна.

Тэгэхээр ялангуяа зах зээлийн үнэлгээ, эрэлт зэргийн судалгаа гээд энэ компани болгоны чинь судалгаанууд өөр байгаа. Компани болгоны due diligence-үүд бүгд өөр гарч байгаа. Тэгээд энэ болгоныг бид харж байж энэ хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэх ийм шийдвэрийг гаргамаар байна.

Тэгэхээр энэ дээр Засгийн газрын зүгээс гишүүдийг хэзээ энэ бүх мэдээллээр хангах вэ гэдэг ийм асуулт байна.

Гуравдугаарт нь, хамгийн сүүлийн асуулт байна. Ер нь энэ ихэнх ингээд компаниудыг харахаар энэ жагсаалтыг харахаар төрд 51 хувийг үлдээнэ гээд байдаг. Тэгээд төрд 51 хувийг үлдээхээр хөрөнгө оруулагч үүнийг чинь сонирхох юм уу? Менежментэд орох боломж ерөөсөө байхгүй. 15 хувийг хувьчилж авсан, 10 хувийг хувьчилж авсан хөрөнгө оруулагч менежментэд оролцох нөхцөл ерөөсөө байхгүй шүү дээ.

Тэгэхээр энэ чинь өөрөө нөгөө хөрөнгө оруулагчийн сонирхлыг татахгүй. Менежмент өөрөө ерөөсөө сайн болохгүй гэсэн үг. Тийм ээ.

Тэгэхээр ингээд яг энэ тоонууд чинь яг улс төрийн зорилготой гараад байгаа тоо юу, эсвэл эдийн засгийн тооцоолол дээр үндэслэж байгаа тоо юу гэдэг дээр эргэлзэхэд хүргээд байгаа гэсэн үг.

Тэгэхээр энэ дээр хариултаа өгөөч гэж хүсье. Тэгээд нэмж тодруулгаа хариултын дараа авъя.

Н.Учрал: С.Бямбацогт сайд хариулна.

С.Бямбацогт: Бөөндсөн юм биш үү гэж. Тэгэхээр гурван чиглэлээр энэ компаниудаа ангилсан байгаа.

- ▷ **Нэгдүгээрт нь,** бизнесийн өрсөлдөөнд байгаа компаниудыг аль болох 100 хувь гэх юм бол та нар 100 хувь өгөх гээд байна гээд. Тийм болохоор 66 хувь хүртэл гээд оруулаад ирсэн байгаа. Үүнийг Та бүхэн маань 100 хувь болгоод худалд гэх юм бол худалдах бололцоотой. Ийм нэг бүлэг.
- ▷ **Хоёрдугаарт нь,** стратегийн ач холбогдол бүхий учраас төрд 51 хувь нь, 51-ээс дээш хувь нь байж байх ёстой юм гэсэн компаниудын 49 хүртэл хувийг хувьчилъя гэсэн хоёр дахь бүлэг.
- ▷ **Гуравдугаарт нь,** бүтцийн өөрчлөлт хийе. Энэ нийгмийн ачаа үүрдэг, дээрээс нь гарцаа байхгүй ач холбогдолтой учраас байх ёстой гэсэн компаниуд дээр өөрчлөн зохион байгуулах, бүтцийн өөрчлөлт хийх, засаглалыг сайжруулах гэсэн ийм гурван бүлэглэлээр компаниудыг бүлэглэж оруулж ирсэн байгаа гэдгийг танд хэлье.

Хөрөнгө оруулалтыг татах нөхцөл. Энэ хөрөнгийн биржүүд 15-хан хувь дээр хүн орж ирэх үү гэж. 34 хувийг нь хувьчилсан байгаа. Одоо нэмээд 15 хувийг нь хувьчилъя. Ингээд 49 хувь нь гэж байгаа. Гэхдээ үүнийг Та бүхэн Улсын Их Хурал дээр ярилцаад 100 хувь, 66 хувь гээд өөрчлөх эрх нь нээлттэй байгаа.

Ер нь олон улсын жишгийг хараад байхад Хөрөнгийн биржүүд бүгд л хувьд байдаг юм билээ. Хувьд.

Хятад зэрэг ганц нэгхэн улсын хөрөнгийн бирж төрд байдаг. Бусдаар бүгд хувьд байдаг юм билээ. Үнэхээр Хөрөнгийн биржээ бид гадаад, дотоодын хөрөнгө оруулалт, менежмент оруулж ирж байж хөрөнгийн зах зээл хөгжих том суурь болно.

Энэ үүднээс Их Хурал дээр 49 хүртэл хувь гэдгийг цааш нь 51, цаашлаад 66, 100 хүртэл болгох боломж нээлттэй байгаа.

Хөрөнгө оруулалтыг татах урьдач нөхцөл. Энэ дээр хөрөнгө оруулалт зөвхөн энэ хэдэн компаниуд дээр хөрөнгө оруулалтын асуудал яригдахгүй. Энэ компаниуд дээр бид үнэхээр санхүү, эдийн засгийн нөхцөл байдал тааруу байх юм бол заавал худалдахгүй, үнэ хүрэхгүйгээр зарах гээд байхгүй. Нөхцөл байдлаа харж байгаад үнэлж дүгнэж байгаад, хөрөнгийн үнэлгээ хийж байгаад үнэхээр үнэ цэнд хүрэхээр байна гэсэн үед л олон нийт хувьцааг нь гаргах, хувьчлах ийм асуудал яригдана. Үнэ цэнд хүрэхээргүй байх юм бол үүнийг хувьчлахгүй ийм бодлого барина.

Үүнийг Засгийн газар жил болгон нөхцөл байдлаа харж байж шийднэ. Том утгаараа бид Хөрөнгө оруулалтын тухай хууль Их Хуралд Засгийн газар өргөн барих гэж байгаа.

Эдийн засгийн эрх чөлөөний тухай хууль, бизнес эрхлэгчийг дэмжих, бизнес эрхлэгчдээ дэмжих, баялаг бүтээгчдийг дэмжих багц хууль гээд энэ том эрх зүйн орчнууд маань Монгол Улсад хөрөнгө оруулалт орж ирэх боломжууд бий болох байх.

Зөвхөн энэ хэдэн компаниуд дээр биш Монгол Улсын бүхий л салбарт, уул уурхайн салбарт боловсрол, аж үйлдвэрийн салбарт импортыг орлох үйлдвэрүүдийг дэмжих, экспортыг дэмжих гээд бидэнд бодлогын томоохоныг тулгамдсан олон асуудал байгаа. Энэ дээр зайлшгүй гадаад, дотоодын хөрөнгө оруулалт хэрэгтэй байна.

Тийм болохоор гадаад, дотоод гэхгүй компаниудаа дэмжсэн, хувийн хэвшлээ дэмжсэн, бизнес эрхлэгчээ дэмжсэн томоохон бодлогын асуудлыг Засгийн газар Их Хуралд ойрын үед өргөн барихаар бэлдэж байна. Энэ зайлшгүй хийх шаардлагатай болсон байгаа юм.

Н.Учрал: Х.Баасанжаргал гишүүн тодруулна.

Х.Баасанжаргал: Яах вэ, хувьцаа эзэмшигчийн шийдвэр гаргахдаа хамгийн түрүүнд харж үзэх ёстой, танилцах ёстой материалууд бидний гарт байхгүй байна л гэж хэлээд байна л даа.

Одоо тэгээд тэр нөхцөл байдлаа харж байгаад жил бүр шийдвэрлэнэ гэхээр бид нийлүүлээд өгөх гээд байгаа юм уу, ямар учиртай юм гэдгийг сайн ойлгохгүй байна.

Тэгэхээр яг энэ жилийн тухайд яг одоогийн одоо энэ он гаргаад хувьчлах яг бэлэн байдалтай болсон due diligence нь хийгдсэн, аудитын дүгнэлт нь гарсан,

зах зээлийн судалгаа нь хийгдсэн ямар ямар компаниуд байгаа юм бэ гэдэг ийм асуулт байна.

Яг дотоодын тоглогчдоо харах юм бол ер нь дотоодын хөрөнгө оруулалт дээр тоглож байгаа тоглогчдын нөөц үндсэндээ шавхагдаад дууссан байгаа С.Бямбацогт сайд аа.

Тэгэхээр бид гаднын хөрөнгө оруулалтыг л татахаас өөр арга байхгүй.

Тэгэхээр нөгөө хөрөнгийн бирж чинь өөрөө яг хамаг гол юмныхаа ингээд боомлоод ингээд суулаар хөрөнгийн биржийн асуудлаа гадагшаа гадаад зах зээл дээр давхар гаргах тухай бодож байгаа, төлөвлөж байгаа зүйл байгаа юу л гэж асуугаад байгаа юм. Тэгээд хамгийн сүүлд нэмэлт нэг юугаа авъя дарга.

Н.Учрал: Нэмэлт 1 минут. Х.Баасанжаргал гишүүнд өгье.

Х.Баасанжаргал: Хамгийн сүүлд нэг юмыг нөгөө Их Хурлын Тамгын газар болоод Улсын Их Хурлын даргад нэг хүсэлт байгаа юм. Юу гэвэл одоо энэ жишээ нь энэ тогтоолын хүний эрхэд үзүүлэх үр нөлөө гээд хүснэгтэлсэн ийм материал ирж байна.

Бид хавар Хууль тогтоомжийн тухай хуулийг батлахдаа Улсын Их Хуралд орж ирж байгаа бүх хууль тогтоомжууд дээр хүний эрхийн үр нөлөөний үнэлгээг сайжруулах ийм хэд хэдэн зохицуулалтыг баталсан. Одоо болтол Хууль зүйн яам энэ холбогдох журмыг нь батлаагүй байгаа. Үндсэндээ Хууль тогтоомжийн тухай хуульд заасан хүний эрхийн нөхцөл байдлыг хангасан байх энэ хуулийн зохицуулалтууд ерөөсөө амилаагүй өнөөдрийг хүртэл явж байгаа.

Тэгээд одоо яг энэ тогтоолын хавсралт дээр ч гэсэн яг харагдаж байна. Хүний эрхэд үзүүлэх үр нөлөө гэнгүүт хүний эрхэд ямар нэгэн сөрөг үр нөлөө байхгүй, байхгүй, эсвэл хамааралгүй гээд л ингээд л хүснэгтлээд ороод ирж байгаа байхгүй юу. Гэтэл дулааны цахилгаан станцыг хувьчлах чинь өөрөө хүний суурь үндсэн эрх, дулаан байх, эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхэд шууд нөлөө үзүүлнэ. Түүнээс яаж бууруулах юм бэ гэдэг бодлого ямар нэгэн зүйл энэ дээр огт судалгаа орж ирээгүй байна.

Тэгэхээр цаашид... /минут дуусав/

Н.Учрал: Х.Баасанжаргал гишүүний асуудлыг анхаарах хэрэгтэй.

Хүний эрхийн зөрчилтэй хууль тогтоомжийг Их Хурал цаашдаа хүлээж авахгүй шүү. Одоо parliament.mn дээр ороод үзээрэй. Нөгөө AI шинжилгээ гээд булан нээгдэж байгаа. Туршилтын 3 сар эхэлсэн. Тэр AI шинжилгээн дээр хуулиа upload хийгээд оруулахаар хүний эрх зөрчиж байгаа бүх заалтууд, наад эдийн

засгийн эрх чөлөө зөрчиж байгаа, улс төрийн эрх, эрх чөлөөг зөрчиж байгаа заалтууд чинь гарч ирнэ.

Тэгэхээр Засгийн газраас хууль мэдээлээд хэрвээ хүний эрхийн зөрчилтэй бол хуулийг шууд буцаах арга хэмжээ авна.

Хууль зүйн яам энэ журмыг гаргаж чадахгүй байгаа бол Их Хурал өөрөө гаргаад шаардаад явна шүү гэдгийг хэлье.

Асуултад хариулт авлаа. Чинбаатарын Анар гишүүн асуулт асууна.

Ч.Анар: Би нэг юм гайхаад байх юм. Нэр бүхий эдийн засгийн эрх чөлөө ярьдаг үзэл баримтлалтай намын гишүүд төр том байна, данхар байна, танай нам төрийн өмчит компаниудаараа намын санхүүжилтээ хийж байна гэж яриад байдаг, тэгээд эдийн засгийн эрх чөлөөгөө ярьдаг мөртөө энэ тогтоолыг дэмжихгүй, ер нь хувьчилж хэрэггүй гэдэг юм яриад байх юм. Тийм. Тэгээд тэрийг нь ерөөсөө ойлгохгүй байна л даа. Жишээ нь, Б.Пүрэвдорж дарга аа. Тийм.

Б.Пүрэвдорж дарга аа, та бас намайг гомдоож болохгүй шүү гэж юм ярьж байна лээ шүү дээ. Тэр нь юу гэсэн ч үг юм. Тийм.

Тэгэхээр С.Бямбацогт сайдаас асуулт асууя.

Тэгэхээр нөхцөл байдлаа харж байгаад хувьчлах эсэхээ шийднэ. Төлөвлөгөө байхгүй байгаа гэж яриад байх юм.

Тэгэхээр энэ байж болохгүй шүү дээ. Салбар нэгжээр нь ямар судалгаа хийгээд, яаж хөрөнгө оруулалт зах зээлийн орчноо тэлэх юм бэ, хөрөнгө оруулагчаа татах юм бэ гэдэг судалгаагаа хийгээд, стратегиа боловсруулаад, цаг хугацааныхаа төлөвлөгөөтэй. Энэ дээрээ хууль, эрх зүйн ийм ийм саад гацаанууд байна. Үүнийгээ ингэж Их Хурал нь засъя. Бид энэ төрийн өмчит компаниуд дээрээ аудитаа ингэж хий гэдэг ийм хувиар ядаж орж ирмээр байгаа байхгүй юу. Тэр байхгүй.

Үүнийг гишүүд асуухаар тэгээд тухайн үедээ нөхцөл байдлаа харж байгаад шийдье. Эдийн засгийн багтаамж, хөрөнгийн зах зээлээ харж байгаад шийдье гэх юм.

Тэгж харсан тогтоол хэд байна?

- ✦ 2001 оны 10 дугаар тогтоол.
- ✦ 2005 оны 48 дугаар тогтоол.
- ✦ 2010 оны 15 дугаар тогтоол.
- ✦ 2022 оны тогтоол.

Баахан хувьчилна гээд тогтоол гаргаад л байдаг, гаргаад л байдаг. Тэгээд ерөөсөө судалгаа байхгүй. Тэгээд дараад нь яагаад тогтоолын хэрэгжилт ийм бага хувьтай байна гэхээр нөгөө нөхцөл байдлаа харж байгаад шийдсэн чинь зах зээлийн багтаамж байсангүй, бас болохгүй байна гээд судалгаагүй оруулж ирмээргүй байх юм.

Тэгээд энэ чинь дахиад л нэг тогтоол болж үлдэх гээд байдаг. Яаж хөрөнгийн зах зээлээ тэлэх вэ?

Дахиад бас нэг дараагийн юм нь. Энэ өмнөх тогтоолууд хэрэгжээгүй, алдаа, оноог дэнсэлсэн үү? Тэр дүгнэлтүүд байгаа юу? Тэр тайлангууд ерөөсөө огт байхгүй.

- Юун дээрээ алдсан юм?
- Юун дээрээ сайжирч байгаа юм?
- Яаж явуулах юм бэ? –

гэдэг саналуудаа ерөөсөө танилцуулахгүй ингээд л нэг тогтоол тоотой орж ирээд явдаг асуудал болох гээд байна.

Ер нь агуулгын хувьд төрийн өмчийн компани, орон нутгийн өмчит компаниудыг эдийн засгийн хувьд үр ашигтай, хувийн хэвшилдээ орон зай өгсөн, төрийг ингээд данхар бүтцээс нь салгая гэдэг тогтоолыг оруулж ирж байгааг дэмжиж байгаа.

- Судалгаа нь хаана байна?
- Төлөвлөгөө нь хаана байна?

Цаг үе нөхцөл байдлаа харж байж шийднэ гэж байж болохгүй шүү дээ. Хариулт авъя.

Н.Учрал: С.Бямбацогт сайд хариулъя.

С.Бямбацогт: Б.Пүрэвдорж гишүүн, манай Ч.Анар гишүүд бас хэлж байна.

Баялаг бүтээж үзээгүй, татвар төлж үзээгүй, ажлын байр бий болгож үзээгүй. Тэгээд төрийн өмчит компаниуд дээр эрх мэдлээ ашиглаад, албан тушаалаа ашиглаад нэг цүнх баригч тавьдаг. Түүнийгээ сааж тэндээсээ хувь авч ажиллаж амьдардаг ийм хүмүүсээс төрийн өмчит компаниуд салахад зарим гишүүд дургүй байх шиг байна.

Тийм болохоор шинэ жил далимдуулж хулгай хийх гэж байна гэж хардаж ярьж байна. Үүнийг чинь бид батлах гээгүй шүү дээ.

Хэлэлцэх эсэхийг нь Их Хурлаар шийдье. Одоо шийдье. Тэгээд тэр Нийтийн өмчийн тухай хууль, дээрээс нь Төрийн өмчит компаниудын засаглал, ил тод байдал, үр ашгийг сайжруулах тухай хууль.

Хуулиудын хэлэлцэх эсэхийг ажлын хэсэг ажиллах явцдаа хамтад нь хэлэлцээд –

- хуулиуд дээр ямар асуудал байна,
- компаниуд дээр ямар асуудал байна,
- хуулиа яаж бичих вэ,
- компанийнхаа хувьчлалыг яаж хийх вэ –

уялдуулж явж байгаад Их Хурал л хаврын чуулганаараа хуулиа баталъя. Хууль баталсныхаа дараа араас нь энэ үндсэн чиглэлээ баталъя.

Ингээд явах юм илүү үр дүнтэй болно. Илүү Монголын төрд, Монголын ард түмэнд ашигтай болно гэдэг бодлогоор л өнөөдөр оруулж ирж байгаа юм.

Хэлэлцэх эсэхийг нь одоо шийдэх гэж байгаа юм. Тэгж байхад л шинэ жил болох гэж байхад хулгай хийх гэж байна гээд л хардаад л, ард түмнийг бухимдуулаад л, худлаа хийрхээд л. Ингэж ярьдаг чинь харамсалтай байна.

Судалгаанууд хаана байна вэ гэж. Их Хурлын гишүүдэд судалгаанууд тараагдсан. Хууль тогтоомжийн төслийн үр нөлөөний үнэлгээ, зардлын тооцоо гээд судалгаа тараагдсан байгаа.

Мөн хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандах судалгаа гээд тараагдсан байгаа.

Мөн зузаан материал. Надад ирээгүй мөртөө Их Хурлын гишүүд ирсэн байгаа. Ийм олон тоо баримтуудыг тараасан. Нэмэлтээр материал хэрэгтэй гэх юм бол хэлэлцэх эсэх нь шийдэгдсэний дараа хүссэн мэдээллээ хүссэн хэлбэрээрээ Их Хурлын гишүүд авах бүрэн эрхтэй. Энэ мэдээллүүд нээлттэй. Шаардлагатай үндэслэл, ач холбогдол юмнуудаа нэмэлтийг хүсэхэд бид гаргаад өгөх бололцоотой.

Ийм байдлаар хэдүүлээ аль болох үр өгөөжтэй, аль болох ил тод, аль болох нээлттэй олон нийтийн хараа хяналт доор, Их Хурлын гишүүдийн хараа хяналт доор л энэ урьд өмнө явж байсан алдаа сургамждаа дүгнэлт хийгээд нэг зөв юм хийгээд энэ удаагийн парламент үнэхээр өмч хувьчлал дээр, төрийн өмчийн компанийн засаглал дээр түүх бүтээлээ шүү, сайн юм хийлээ шүү гэдэг юмыг хийх юм бол энэ Их Хурлын л нэр хүндийн асуудал болох байх.

Эцэст нь Их Хурал баталж өгөх учраас Их Хурал батлахгүй бол тэгээд л энэ буцаагдана. Батлах юм бол Их Хурлын маш сайн хийсэн ажил болж үр дүн нь үлдэх байх. Үнэлж дүгнэгдэж түүхэнд үлдэх байх.

Тийм болохоор хэдүүлээ нэг сайн л юм хийе. Засгийн газар боломжоороо хичээгээд юмаа оруулаад ирсэн. Та бүхэн маань илүү сайжруулаад өгөөсэй л гэж хүсье.

Н.Учрал: Ч.Анар гишүүн тодруулъя.

Ч.Анар: С.Бямбацогт сайд аа, би танаас асуулт асуусан шүү дээ. Та тэгсэн чинь үг хэлээд байх юм.

Та бид хоёр адилхан л үг хэлээд байна шүү дээ. Үүнийгээ явуулъя гээд.

Тэгээд энэ ном надад байгаа л даа. Би бүгдийг нь уншаад нөгөө төлөвлөгөө байхгүй байна. Яаж, ямар арга хэлбэрээр салбар болгон дээрээ яаж хийх юм. Дүгнэлтүүд нь байхгүй. Энд зүгээр л тайлангууд, танилцуулгуудыг л зузаан ном болгосон. Түүнээс энэ дотор чинь ямар ч төлөвлөгөө, судалгаа, дүгнэлт байхгүй байгаа байхгүй юу. Тэрийгээ хийгээд оруулж ирээд.

Хуулиа эхлээд баталъя гэхээр гайхаад байгаа юм л даа. Ямар хууль дээр ямар асуудал үүсээд хувийн хэвшил өмч хувьчлал дээр хөрөнгө оруулагчдад асуудал үүсгээд эхлээд судалчхаад энэ энэ хууль дээрээ ийм өөрчлөлт оруулъя гээд орж ирэх ёстой юм биш үү?

Тэгээд нөгөө судалгаагүй хуулиа хийдэг. Багцаагаараа. Тэгээд нөгөөх нь хувьчлагддаггүй. Тэгэнгүүтээ нөгөө тогтоолын хэрэгжилт 10, 15 хувьтай болдог. Тэр дотор нэг зорилтот бүхий хэдэн компани л хувьчлагдах гээд байна.

Н.Учрал: Санал хэллээ. Гомбын Ганбаатар гишүүн.

Г.Ганбаатар: Өдрийн мэнд.

Төрийн мэдлийн өмчийг хувьчлах гэж байгаад талархаж байгаа. Мэдээж болгоомжтой хандах ёстой, бэлтгэлээ сайн хангах ёстой гэдэг дээр санал нэг байгаа.

Ер нь энэ хулгай нүүрлэсэн салбаруудыг хувьчилж, засаглал, менежментийг нь сайжруулах нь зөв. Түрүүнд яах вэ, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтаас дуудлага худалдаа, тэр засаглал хоёр яах вэ, тэгээд болох байх.

Хамгийн гол бидний энэ хуулийн гол агуулга чинь биржээр олон нийтэд худалдах гээд байгаа асуудал дээр Хөрөнгийн биржийн хувьчлал, хууль, эрх зүйн орчин хоёр чинь энэ гол суурь нь байгаа юм.

Энэ хуулийг хэлэлцэж байх явцад өнгөрсөн Мягмар гарагт Эдийн засгийн байнгын хорооны хурал дээр би Эдийн засгийн байнгын хорооны гишүүдийг юу ярьж байгааг сонсоод л байсан л даа. Тэнд хамгийн гол яригдаж байгаа юм нь Хөрөнгийн биржийн. Одоо бид чинь 34 хувийг нь хувьчилсан юм байна. Гэтэл тэр байрлал, байшин хоёрт нь болоод байдаг. Салгаж хувьчилъя ч гэнэ үү.

Энэ 2022 оны 34 хувийн хувьчлал чинь байшин, байртай нь хувьчилсан юм уу? Аль эсвэл Та бүхний зарим гишүүдийн яриад байгаа шиг системийн биржийнх нь эрхийг нь, байшин савыг нь тусад нь хувьчилсан юм уу? Тэр 34 хувийн чинь хувьчлал ямар юм? С.Бямбацогт дарга аа, би танаас үүнийг асуух гээд байгаа юм.

Ер нь хэрвээ ингэж хувьчлах юм бол 2022 оны 34 хувь чинь 119 мянга 509 ширхэг хувьцаа арилжаалсан юм байна шүү дээ. 100 төгрөгөөр. 11.9 тэрбум төгрөг татан төвлөрүүлсэн юм байна. Тэгвэл жижиг хувьцаа эзэмшигчдийн чинь эрх ашиг яах юм? Ингэж хувьчилчхаад ингээд жижиг хувьцаа эзэмшигчдээ ингээд орхиж болох юм уу? Цогцоор нь хувьчилбал энэ чинь үнэ цэнтэй юм биш үү? Энэ асуултууддаа С.Бямбацогт даргаас хариулт авна.

Хоёр дахь зүйл нь, сая Ч.Анар гишүүн асууж байх шиг байна. Энэ хувьчлалаа хэрхэн яаж явуулах, тэр ROADMAP буюу зураглал чинь хаана байгаа юм? Энэ хувьчлалыг хэрхэн амжилттай явах замын зураглалаа Та бүхэн гишүүдэд танилцуулаад өгнө үү. Тэгээд тодруулгаа авъя. Дараа нь.

Н.Учрал: С.Бямбацогт гишүүн хариулна.

С.Бямбацогт: 34 хувийг хувьчилсан. Хөрөнгийн биржийн. Тэгэхдээ яг одоо байгаагаар нь үндсэн хөрөнгө, эргэлтийн хөрөнгө, программ, тоног төхөөрөмж, лиценз, патент гээд бүх зүйлтэй нь тусгай зөвшөөрөл гээд хувьчилсан.

Одоо нэмээд бид 15 хувийг нь хувьчлаад 49-ийг болгоё гэсэн. Энэ дээр Сангийн яамны санал үндсэндээ 51 хувь нь төрд байх ёстой шүү гэсэн санал ирсэн учраас бид 49 гэж байгаа.

Их Хурлын гишүүд маань ярьж байгаад цаашаагаа 66 болох юм уу, 100 хувь байх юм уу, эсвэл орж ирснээр л явуулах юм уу. Энэ бол Их Хурлын гишүүдийн бүрэн эрх.

Байрны хувьд хувьчлал нэрээр тэр сайхан байршил, тэр сайхан байрыг авах. Тэрэнд л үнэ цэн явах вий гээд хардаад байгаа учраас тэрийг нь аваад үлдэж болно. Үүнийг Их Хурлаас чиглэл өгөх юм бол энэ ингэж болно л гэсэн тийм саналууд хэлсэн гэдгийг хэлье.

Та бүхэнд энэ тогтоол тараагдсан байх. Энэ дээр үндсэн чиглэлийнийн зорилго гээд бичсэн байгаа.

- ▷ **Хоёрдугаарт нь**, үндсэн чиглэлийг хэрэгжүүлэхэд ямар зарчим баримтлах юм бэ гээд бичсэн байгаа.
- ▷ **Гуравдугаарт нь**, үндсэн чиглэл хэрэгжүүлэх зохион байгуулалт, арга хэлбэр гээд энэ дээр маш тодорхой бичсэн байгаа.
- ▷ **Дөрөвдүгээрт нь**, биржээр нээлттэй худалдах төрийн өмчит хуулийн этгээдүүд гээд бүгдийг нь тодорхой.

Үндсэндээ таны асуугаад байгаа арга зам, замын зураг энд байгаа. Энд үүнийг илүү сайжруулах, илүү нэмж хасах нээлттэй.

Энэ дотор тэгээд Засгийн газар жил бүр үүнийгээ тодотгоно. Их Хурал ерөнхийд нь батлаад өгнө. Тэрийг нь Засгийн газар жил бүр нөхцөл байдлаа харж тухайн үед нь асуудлаа шийднэ. Судалгаагүй байна гэж манай Ч.Анар гишүүд нар яриад байх шиг байна. Тийм зүйл байхгүй. Энэ дотор орсон байгаа.

Тэгэхээр Та бүхэн энэ юмнуудаа гүйцээж хийж ир, ингэсэн тохиолдолд тэрийгээ хий, тэгсэн тохиолдолд үүнийгээ хий гэдгийг бүгдийг нь тусгаад өгөх бүрэн нээлттэй бүрэн нээлттэй.

Тэгэхээр энд хэдүүлээ сайхан хамтраад сайжруулах тал дээр нь анхаараад ажиллацгаая.

- Эцэст нь үр дүн гараасай.
- Монгол Улсын эдийн засаг томорч тэлээсэй.
- Төрийн оролцоо эдийн засагт багасаасай.
- Хувийн хэвшил илүү томроосой.

Эцэст нь байгалийн баялгийн өгөөж, Төрийн өмчит компаниудын өгөөж энэ бүгдээс Монголын ард түмэн илүү өгөөжийг нь хүртдэг байгаасай гэдэг л бодлогын хүрээнд Засгийн газрын мөрийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх гэж Улсын Их Хурлын өгсөн үүрэг даалгаврыг биелүүлж Засгийн газар энэ тогтоолыг оруулж ирсэн гэдгийг Та бүхэндээ эцэст нь хэлье.

Н.Учрал: Г.Ганбаатар гишүүн тодруулна.

Г.Ганбаатар: С.Бямбацогт сайд яах вэ Улсын Их Хурлаас гарсан тэр тогтоол, тэр чиглэлээр л яриад байна л даа.

Уг нь яг одоо энэ төрийн өмчит 18 компанийг тус бүрээр нь хувьчлалаа хэрхэн яаж явуулах тухайгаа Та дэлгэрэнгүй ярьсан бол их зүгээр байх байлаа.

Хоёрдугаарт нь, наад Хөрөнгийн биржтэй чинь холбоотой яг үнэндээ байргүй Хөрөнгийн биржийг ямар стратегийн хөрөнгө оруулагч сонирхох юм?

Дээрээс нь жоохон үнэ цэнтэй цогцоор нь хувьчлах ёстой гэдэг байр суурьтай байгаа шүү дээ. Та бүхэн үүнийгээ бодож, энэ хувьчилж байгаа хөрөнгүүдээ жоохон үнэ цэнд хүргэх талаас нь бодооч.

Н.Учрал: Санал хэллээ. Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. /алх цохив/

Тогтоолын төслийн талаар Байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг дэмжсэн, эсрэг байр суурьтай намын бүлгийг төлөөлж болон бүлэгт харьяалагдаагүй гишүүдээс урьдчилан ирүүлсэн нэрсийн дагуу дэмжсэн, дэмжээгүй байр суурийг илэрхийлнэ.

Нэр өгсөн дарааллын дагуу гишүүд үг хэлнэ. Индэрт урья. Бат-Өлзийн Бат-Эрдэнэ гишүүн. Индэрт урьж байна. 1 дүгээр индэр.

Б.Бат-Эрдэнэ: Баярлалаа.

Хувьчлалыг дэмжиж байгаа. Гэхдээ маш дутуу дулимаг орж ирж байна гэж харж байна. Компани болгоноор асуудал бид ярих ёстой. Үнэ цэн нь ямар байгаа юм, ирээдүйн үнэ цэн ямар байх ёстой вэ гэдгийг бид тодорхойлох ёстой.

Хуучин Богдын хүрээ орж 108 мөргөчхөөд ирвэл сайхан гэж ярьдаг шиг өнөөдөр Сингапурын TEMASEK очиж 108 удаа туршлага судлаад ирвэл төрийн өмчит компаниуд нь сайн сайхан юм шиг байдалд очсон гэж хэлж байна.

Өнгөрсөн удаагийн тогтоолуудын хэрэгжилт 37 хувь. Өнөөдөр Төрийн өмчит компаниудын алдагдал маш өндөр хэмжээнд очиж байгаа. 2024 оны аудитын дүгнэлтээр 1 их наяд 29 тэрбум 500 сая төгрөгийн 1555 зөрчил илэрч байгаа. Төрийн өмчит компаниудын нөхцөл байдал өнөөдөр яг ийм байдалтай байгаа. Энэ бол засаглалтай холбоотой асуудал.

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар 2025 он эхэлж байхад бүх Төрийн өмчит компаниудын удирдлагыг сонгон шалгаруулалтаар томилно гэж ярьж байсан, амлаж байсан. Өнөөдөр нөгөө арын хаалгаар томилогдсон албан тушаалтнууд хэвээрээ л байна.

“МИАТ” компанийн захирал яаж томилогдов. Тухайлах юм бол. Өнөөдөр улс орон даяараа л энэ асуудлуудыг бид хөндсөн. Цааш цаашдаа бид засаглалтай холбоотой асуудал, мөн эрх зүйн тодорхой асуудлуудыг шийдвэрлэхгүй бол хэчнээн компанийг хувьчлаад, хэчнээн компанийг төрд байлгасан гээд үр дүн гарах нь юу л гэж бодогдож байна.

Эрх хэрэгжүүлэгч, төлөөлөл хэрэгжүүлэгчтэй холбоотой асуудлууд байгаа. Эрх хэрэгжүүлэгч, төлөөлөл хэрэгжүүлэгчдийн хязгаар хаана вэ гэдгийг бид нөгөө талдаа тогтоох ёстой, харах ёстой. Эрх зүйн харилцаагаар үүнийг шийдвэрлэж өгөх шаардлагатай байгаа.

Үүнээс улбаатайгаар эрх хэрэгжүүлэгчийн үзэмжээр, төлөөлөл хэрэгжүүлэгчийн тухайн өдрийн үзэмжээр төлөөлөн удирдах зөвлөлд тодорхой шийдвэрүүдийг гаргаж төрийн өмчит компаниуд дээр өнөөдөр алдагдал үүсэх бодит нөхцөл байдал явж байна.

Би дөнгөж сая мэдээлэл авлаа. Авто тээврийн үндэсний төв дээр хөгжимчин хүн аваачиж тавих гэж байгаа мэдээлэл байна. Бид сонгон шалгаруулалтыг хийхгүй бол цаашдаа төрийн өмчит компаниуд завхарсан хэвээрээ байна гэдгийг бид маш сайн бодож ажиллах ёстой гэдгийг хэлье.

Дээрээс нь Засгийн газраас оруулж ирсэн, ялангуяа Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын сайтаар олон нийт, иргэдээс төрийн өмчит хуулийн этгээдийн хувьцааг 2026-2028 онд биржээр олон нийтэд нээлттэй худалдах, төрийн өмчийг хувьчлах, өөрчлөн байгуулах үндсэн чиглэлийн төсөлд санал авах ажлыг зохион байгуулах ба 24 иргэнээс төрийн өмчийг хувьчлах, өөрчлөн байгуулах, төрийн өмчит хуулийн этгээдийн хувьцааг 2026-2028 онд биржээр олон нийтэд нээлттэй худалдах үндсэн чиглэлийн төсөлд дэмжсэн санал ирүүлсэн гэж байгаа юм.

24 иргэн. Тэгээд бүхэл бүтэн үнэ цэнтэй 18 компаниа хувьцаа болгож, нээлттэй болгож, хөрөнгө оруулалт татах гэж, биржээр арилжаалах гэж байгаа ийм цаг хугацаанд авч байгаа иргэдийнх нь дэмжиж байгаа, авч байгаа саналынх нь тоо нь 24 хүн.

Бид засаглалаас авхуулаад олон асуудлуудыг шийдвэрлэх ёстой гэдэг шиг бид цаашдаа хуулийн, мөн Улсын Их Хурлаас гарч байгаа тогтоолын хэрэгжилт Засгийн газар ямар түвшинд авч үзэж байгаа вэ гэдгийг ч гэсэн харах ёстой болж байгаа юм. 37 хувь гэдэг Үндэсний аудитын газраас тогтоож өгсөн тоо.

Тийм учраас Засгийн газар энэ тогтоолтой холбоотой асуудлаа дахин сайжруулж оруулж ирэхийг хүсэж байна. Баярлалаа.

Н.Учрал: Лувсанцэрэнгийн Энх-Амгалан гишүүн. Индэрт урья. 1 дүгээр индэр.

Л.Энх-Амгалан: Төрийн өмчит компаниудын хувьчлалын гол зорилго мэдээж бүтээмж, засаглал, ил тод байдлыг сайжруулах гол зорилго байгаа. Энэ ойлгомжтой.

Гэхдээ бид өнөөдөр 35 жилийн өнгөрсөн хугацаанд өмч хувьчлал яг юу болоод өнгөрсөн юм бэ гэдэг дээрээ хэд хэдэн тоон дээр их анхааралтай хандах ёстой болов уу гэж би ойлгож байгаа.

Бид өнгөрсөн хугацаанд 2 мянга гаруй, 2100 орчим төрийн өмчит компаниа 1991 оноос хойш хувьчилсан байна.

Гэтэл өнөөдөр эргээд яг хувийн хэвшилд суурилсан эдийн засгийг үүсгэж бий болгож чадсан уу гэвэл чадаагүй гэдэг нь өнөөдрийн үр дүнгээр бид нарт харагдаж байгаа.

Би Та бүхэнд хоёр, гуравхан тоо хэлье гэж бодож байна.

Өнөөдөр нийт манай Төрийн өмчит компаниудын нийт хөрөнгө нь 59 их наяд буюу дотоодын нийт бүтээгдэхүүний 74 хувьд хүрсэн байна. Энэ бол төрийн монопол тогтсон байна гэж ойлгож болно.

Ингээд нийт манай энэ Төрийн өмчит компаниудын хийж байгаа борлуулалт дотоодын нийт бүтээгдэхүүний 32 хувьд хүрсэн байна. Эргээд энэ компаниудын тавьсан өр нь 22.9 их наяд буюу дотоодын нийт бүтээгдэхүүний 28 хувь даруй хүрсэн байна.

Энэ юу гэж хэлж байна вэ гэхээр бид хувийн хэвшил давамгайлсан зах зээлийн эдийн засаг биш төрийн өмч, төрийн монопол давамгайлсан эдийн засгийг л өнгөрсөн хугацаанд бид бий болгосон гэж дүгнэлтийг хийж болох юм.

Тэгэхээр мэдээж хувьчлал дагаад янз бүрийн хардлага сэрдгүүд их байгаа. Би дэгсдүүлээд манайхан тэр Сингапурын TEMASEK компани дээр 108 удаа очсон юм билээ. Норвегийн Үндэсний компани баялгийн сан дээр бараг 100 гаруй удаа очсон юм билээ гэдгийг би дэгсдүүлээгүй шүү. Дэгсдүүлээгүй. Энэ бол бодитой тоо би хэлж байгаа юм.

Тийм учраас бид –

- маш их судалсан,
- маш их зөвлөгөө авсан,
- маш их сургамж хуримтлуулсан.

Өнгөрсөн хугацаанд бид тэр 2100 орчим компанийг хувьчлахдаа хувьчлалын бүх хэлбэрийг бид сонгосон.

- Нээлттэйгээр хувьчилж үзсэн.
- 100 хувь хувьчилж үзсэн.
- Ард иргэддээ цэнхэр, ягаан тасалбар тарааж үзсэн.

Маш их сургамж авсан.

- Компанид нь байгаа сейфийнх нь мөнгөөр компанийг нь худалдаж авч байсан түүх ч байгаа.
- Маш их газруудыг нь, лицензүүдийг нь худалдаж авч байсан ийм түүх ч өнөөдөр байгаа.

Тэгэхээр ганцхан жишээ дурдахад өнөөдөр талбайн хажуу талд хуучин хэвлэх үйлдвэрийн газрын үнэ 20 тэрбум төгрөг хүрч байгаа. Тэгэхэд магадгүй газраасаа хямдхан үнэлэгдсэн компаниудын үнэлгээ бид ерөөсөө ярьж болохгүй.

Би Боловсролын сайд байхдаа нийт төрийн өмчит их дээд сургуулиудын ерөнхий боловсролын сургуулиудын газрын тооллогыг хийж байсан юм. Нийт сургуулиудын 70 хувийн газар нь алдагдсан байсан. Одоо алдагдсан байгаа.

Тийм учраас бид газраар нь газрыг нь салгадаг, эсвэл лицензийг нь тусад нь аваад зардаг, лиценз нь, газар нь өөрийнх нь эргэлтийн хөрөнгөд байгаа бэлэн мөнгө нь компаниасаа хэд дахин их байдаг. Ингэж компаниуд авсан гашуун сургамж бидэнд байгаа.

Тийм учраас энэ алдаа давтагдах ёсгүй гэж ойлгож байгаа.

Эцэст нь хэлэхэд дэлхий нийтэд байгаа бизнесийн зарчмаараа тоглох ёстой. Монголд тохирсон тоглоомын дүрэм гэж ерөөсөө байхгүй.

Тийм учраас дэлхий нийтэд бизнесийн яг ямар зарчим байдаг юм тэр зарчмаар засаглал, үнэлгээ, хөрөнгийн зах зээлээ дэмжсэн бодлого байх ёстой болов уу гэж харж байгаа.

Одоо энэ бодлого дээр, энэ зарчим дээр үндэслэсэн өмч хувьчлалууд байх ёстой.

Өнөөдрийн хувьчлах гээд байгаа энэ компаниудыг яг юуг нь, альныг нь, ямар компанийг нь, ямар хэлбэрээр хувьчлах гээд байгаа гэдгийг ард иргэддээ бид илүү дэлгэрэнгүй, ил тод мэдээлэл өгөх ёстой.

Өнөөдөр Их Хурал дээр хоёр, гурван цаг нэг нь асууж, нэг нь хариулсан маягтай байж болохгүй. Би Улсын Их Хурлын гишүүдтэй санал нэг байна. Өнөөдрийн компани компаниар нь ярих ёстой гэдэг санал нэг.

Тийм учраас ард түмний мэдэх эрхийг олгох чиглэл рүү, хувьчлалд орох гэж байгаа, хувьчлах гэж байгаа компаниудын... /минут дуусав/

Н.Учрал: Төрийн өмчит компанийн хууль батлагдсаны дараа чиглэл орж ирэх ёстой.

Гишүүд анхааралтай байгаарай. Нэг гишүүн үг хэлээд санал хураалт явуулна.

Саруулсайханы Цэнгүүн гишүүн. 2 дугаар микрофонд урьж байна.

С.Цэнгүүн: Өдрийн мэнд хүргэе.

Төрийн өмчит компаниудын хувьчлалыг өнөөдөр бид ярьж байгаа нь маш сайшаалтай хэрэг. Яагаад гэхээр төрийн өмчит компаниуд 78 их наядын хөрөнгөтэй болсон. Алдагдал нь 20 гаруй их наяд гээд. Ямар их алдагдал байгааг бид бүхэн бүгдээрээ мэдэж байгаа.

Гэхдээ гол асуудал нь 5, 10 хувийн хувьчлал хийж байгаа нэрээр илээд өнгөрөх юм бол энэ өөрөө бэлгэ тэмдгийн чанартайгаар ямар ч өөрчлөлт гарч ирэхгүй.

Тэгэхээр 51 хувиас дээш байж байж тухайн менежмент үйл ажиллагаа дээр нь яг шийдвэр гаргах түвшний мэргэжлийн хөрөнгө оруулагч нар орж ирж байж тухайн компанийн үйл ажиллагаа бодитоороо өөрчлөгдөнө. Тухайн компани яг бодитоороо өөрөө бие дааж шийдвэр гаргаж явах боломж нь нээгдэнэ.

Тэгэхээр хувь дээр нь бид харах ёстой. Тэгээд энэ ардчиллын системээр дарангуйлагч нар сонгогддогтой адилхнаар чөлөөт зах зээлийн механизм буюу хамгийн чухал элемент болох төр өмчөөсөө татгалзах ёстой гэдэг бодлогыг бид дутуу дулимаг хийх юм бол энэ өөрөө маш аюултай үр дагавартай байдаг.

Эрчим хүчний компаниудын 49 хувийг нь эх үүсвэр талаас нь бид хувьчлахаар оруулж ирж байгаа нь энэ зах зээл чинь өөрөө чөлөөт зах зээл болоогүй. Үнийг нь төрөөс тогтоож байгаа юм.

Тэгэхээр хэн энэ компаниудын хувьцааг нь худалдаж авах юм бэ. Эрчим хүчний зохицуулах хороо нь бие дааж өөрөө шийдвэр гаргаж чадахгүй байгаа юм.

Тэгэхээр 5, 10 жилдээ үнийг хуурамчаар барьж байгаад гэнэт нэг өдөр босож ирээд хэд дахин, хэт өндрөөр нэмэх биш алгуурхнаар зах зээлийнх нь зарчмаар нь уялдуулаад явдаг байсан бол иргэд, аж ахуйн нэгжүүд ч гэсэн энэ эрчим хүч, цахилгаан дулааны үнэтэй үнэ тарифтай холбоотойгоор шийдвэрүүдээ гаргаад явах боломжтой байсан. Гэтэл тэгдэггүй. Бид бүхэн төрөөс барьж байгаад сүүлд нь иргэдээ аварч байгаа юм шиг царайлдаг л даа.

Суурь бодлогоо хийгээгүй байж, эрчим хүчний зах зээлийг чөлөөлөөгүй юм байж цахилгаан станц, ТЭЦ-3, станцуудтай холбоотой болон Багануур, Шивээ-Овоог хувьчлах асуудал орж ирж байгаа нь өөрөө бодит үр дүнд хүрэхгүй.

Хэдэн жилийн дараа энэ компаниудын үйл ажиллагаа доголдоно. Тэр үед нь хувьчлал буруу байсан юм байна гээд нийтээрээ буцааж буруу дүгнэлт хийх гээд байгаа юм. Тэгээд энэ өөрөө маш аюултай байдал үүсэх байх.

Бидний орж ирээсэй гэж харж байсан зүйл орон нутгийн өмчит компаниудын талаар огт яригдаагүй. Тэнд ямар нэгэн том бодлогогүйгээр 471 компаниас 100 хувь хувийн өмчит компаниуд хийх боломжтой 230-аад компани байгаа. Тэр нь –

- эмийн сан,
- зочид буудал,
- халуун усны газар,
- гутал засвар,
- аялал жуулчлал,
- спорт заал –

-гээд маш энгийн, ерөөсөө тухайн орон нутгийн иргэд өөрсдөө хийгээд явах юмыг Засаг даргын өмчид компаниуд байгаа юм.

Тэгэхээр эдгээрийг бид ямар нэгэн маргаангүйгээр оруулаад шууд хувьчлах боломжтой. Үүнийгээ давхар яриад явах шаардлагатай юм болов уу гэж харж байна.

Тэгэхээр аль нэг цаг үед асуудлуудаа шийдээд явах ёстой. Хувьчлалын талаарх асуудлыг хойш нь шийдэж болохгүй. Хүндрэлтэй ч гэсэн бид бодлогыг зөвөөр нь тодорхойлоод энэ цаг мөчдөө гаргах ёстой.

Эрчим хүчний салбар дээр үнэ чөлөөлөх гэдэг, төр оролцохгүй байх гэдэг бодлогоо бид гаргахгүй бол төрийн оролцоо байгаа газарт ямар нэгэн хөрөнгө оруулагч орж ирэх боломжгүй юм гэдгийг хэлмээр байна.

Н.Учрал: Гишүүд үг хэлж дууслаа. /алх цохив/

Гишүүд танхим цуглая.

Одоо Байнгын хорооны саналаар “Төрийн өмчит хуулийн этгээдийн хувьцааг 2026-2028 онд биржээр олон нийтэд нээлттэй худалдах, төрийн өмчийг хувьчлах, өөрчлөн байгуулах үндсэн чиглэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжих эсэх талаар санал хураалтыг явуулна.

Гишүүд санал хураалтад бэлтгэе. /алх цохив/

Энэ бол үндсэн чиглэл. Тэр хэлэлцэх эсэхийг дэмжээд, ажлын хэсгийг байгуулаад, төрийн өмчит компанийн бүтээмж, засаглал, ил тод байдлыг

сайжруулах хууль, Нийтийн өмчийн хууль батлагдсаны дараа анхны хэлэлцүүлэг явуулаад эцэслэнэ гэж ойлгож байгаа.

Тэгэхээр эцсийн байдлаар батлагдаагүй байна. Зөвхөн хэлэлцэх эсэх дэмжигдэнэ.

Зах зээл дэх төрийн оролцоог бууруулах чиглэлээр авч хэрэгжүүлж байгаа томоохон арга хэмжээнүүдийн нэг мөн.

Ардчилсан намын бүлгийнхнийг урья. Саналаа хураах уу? Санал хураалтыг явуулна шүү, нөхөд өө. Танхимд урьж байна.

Их Хурлын гишүүн бүр л зах зээл дэх төрийн оролцоог бууруулъя, төрийн өмчит компанийнхаа ашиг орлогыг нэмэгдүүлье, алдагдалтай ажиллаж байгаа нэгтгэе, өөрчилъе, зохион байгуулъя, нээлттэй болгоё л гэж л ярьдаг. Засгийн газар үйлдэл хийж байна. Үндсэн чиглэлээ оруулж ирсэн байна. Энэ бол мэдээж хэлэлцэх эсэх шүү дээ.

- Ажлын хэсэг байгуулна.
- Анхны хэлэлцүүлэг хийнэ.
- Эцсийн хэлэлцүүлэг хийнэ.

Ажлын хэсэг дээр хариуцлагатай хэлсэн. Энэ дотор –

- ▶ Эрчим хүчний компани ч байгаа.
- ▶ Харилцаа холбооны компани ч байгаа.
- ▶ Зам, тээврийн компани ч байгаа.

Тэгэхээр эдгээр компаниуддаа буюу энэ салбарууддаа ашиг сонирхлын зөрчилтэй нэг ч гишүүнийг энэ ажлын хэсэгт оруулахгүй.

Тийм учраас ажлын хэсэгт оруулах гишүүд дээр ашиг сонирхлын дүгнэлтийг нь авах хэрэгтэй. Өмч хувьчлалын асуудал дээр ашиг сонирхолтой хүмүүс орж болохгүй.

Тийм учраас ажлын хэсэг дээр бид Авлигатай тэмцэх газар луу тэр гишүүдийн нэрийг явуулаад энэ салбарт тухайн гишүүн ямар нэгэн ашиг сонирхлын зөрчилтэй эсэхийг тогтоолгоно. Тэгж байж энэ асуудлыг эцэслэнэ. Түүнээс биш энэ дотор зөрчилтэй хүмүүс зөндөө байгаа шүү дээ.

Тийм учраас бид анхааралтай байх ёстой.

Тийм учраас ажлын хэсгийг тэгж байгуулна.

Гишүүдийг танхимд урьж байна. Цаашдаа ч гэсэн хэрвээ ашиг сонирхол үүсэж болзошгүй гэж үзэж байвал санал хураалтаас татгалзах эрхтэй. Гишүүд санал хураалтаас татгалзах эрхтэй шүү. Энэ санал хураалтад оролцохгүй гэж үзэж байвал.

Одоо зөвхөн хэлэлцэх эсэхийг дэмжиж байгаа. Дөнгөж хэлэлцэх эсэхийг дэмжих гэж байна. 3 сарын 15-нд хаврын чуулган эхэлнэ. Чуулганаар 2 хууль батална. Тэр 2 хуультай хамтатгаад үндсэн чиглэлийг батална.

Тэгэхээр энэ өнөөдөр шийдэгдэж байгаа асуудал биш.

Ер нь энэ төрийн өмчит компаниуд дээр хувьцааг олон нийтэд нээлттэй арилжаалах эсэх асуудал дээр зарчмын хувьд дэмжиж байгаа эсэхийг л өнөөдөр дэмжих гэж байна шүү дээ. Үүнээс хойш батлагдах хугацаа байгаа. Гишүүд анхааралтай.

“Төрийн өмчит хуулийн этгээдийн хувьцааг 2026-2028 онд биржээр олон нийтэд нээлттэй худалдах, төрийн өмчийг хувьчлах, өөрчлөн байгуулах үндсэн чиглэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалтыг явуулна. Санал хураалт. /алх цохив/

51 гишүүн дэмжиж, 54.8 хувиар санал дэмжигдлээ.

“Төрийн өмчит хуулийн этгээдийн хувьцааг 2026-2028 онд биржээр олон нийтэд нээлттэй худалдах, төрийн өмчийг хувьчлах, өөрчлөн байгуулах үндсэн чиглэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг санал хураалтад оролцсон гишүүдийн олонх дэмжсэн тул төслийг анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Эдийн засгийн байнгын хороонд шилжүүллээ. /алх цохив/

Дараагийн асуудалд оръё.

**Хоёр.Монгол Улс болон Европын сэргээн босголт, хөгжлийн банк хоорондын
Зээлийн хэлэлцээр соёрхон батлах тухай хуулийн төсөл**
/Засгийн газар 2025.12.18-ны өдөр өргөн мэдүүлсэн,
соёрхон батлах/

Монгол Улс болон Европын сэргээн босголт, хөгжлийн банк хоорондын зээлийн хэлэлцээр соёрхон батлах тухай хуулийн төслийг хэлэлцэнэ.

Хууль санаачлагчийн илтгэлийг Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Хот байгуулалт, орон сууцжуулалтын сайд Энхтайваны Бат-Амгалан танилцуулна.

Индэрт урья.

Э.Бат-Амгалан: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2 дугаар зүйлд “Зүрх, судасны үндэсний төвийг төрөлжүүлэн байгуулна” гэж, Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөөний 3 дугаар зүйлд “Зүрх, судасны үндэсний төвийг барих” гэж тус тус заасан.

Үүний дагуу Засгийн газраас дээрх төслийг Европын сэргээн босголт, хөгжлийн банкны 34.9 сая ам.долларын зээл болон Люксембургийн Их Гүнт Улсаас олгох 26.3 сая ам.долларын буцалтгүй тусламжийн хамтарсан санхүүжилтээр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн бөгөөд Улсын Их Хурлын Эдийн засаг, Төсөв болон Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороодод танилцуулж, зээлийн хэлэлцээрт гарын үсэг зурах эрх олгох Ерөнхий сайдын захирамжийн төслийг дэмжсэнээр 2025 оны 10 дугаар сарын 29-ний өдөр зээлийн гэрээнд гарын үсэг зураад байна.

Төслийн хүрээнд 120 ортой тусгай зориулалтын зүрх, судасны эмнэлгийн барилгыг шинээр барьж, тоног төхөөрөмжөөр бүрэн ханган ашиглалтад оруулах бөгөөд төсөл хэрэгжсэнээр зүрх, судасны төрөлжсөн нарийн мэргэжлийн тусламж, үйлчилгээний хүртээмжийг хоёр дахин нэмэгдүүлж, жил бүр өсөн нэмэгдэж байгаа зүрх, судасны өвчлөл, нас баралтын хэмжээг бууруулах өндөр ач холбогдолтой болно.

Тус зээлийн хэлэлцээр нь олон улсын гэрээний тухай хуулийн 8.1.2-т заасны дагуу Улсын Их Хурлаар заавал соёрхон батлагдах олон улсын гэрээ тул Зээлийн хэлэлцээрийг соёрхон батлах тухай хуулийн төслийг хэлэлцэн дэмжиж өгөхийг хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Н.Учрал: Хуулийн төслийн талаарх Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Ганбатын Очирбат танилцуулна.

Индэрт урья.

Г.Очирбат: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2025 оны 12 дугаар сарын 18-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Монгол Улс болон Европын сэргээн босголт, хөгжлийн банк хоорондын зээлийн хэлэлцээр соёрхон батлах тухай хуулийн төслийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 78

дугаар зүйлд заасныг үндэслэн 2025 оны 12 дугаар сарын 24-ний өдрийн хуралдаанаар хэлэлцлээ.

Зээлийн хэлэлцээр соёрхон батлах тухай хуулийн төслийг Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх үед –

- Улсын Их Хурлын гишүүн Г.Хосбаяр төслийг дэмжиж байгаагаа илэрхийлээд, төслийг хэрэгжүүлэх хугацааг урагшлуулах боломжтой эсэх, зээлийн эргэн төлөлтийг төлөхөд үүсэх ханшийн зөрүүг хэрхэн тооцох, төсөвт дарамт учруулах эсэх талаар,
- Улсын Их Хурлын гишүүн С.Эрдэнэболд төслийг дэмжиж байгаа бөгөөд гадаадад эмчлүүлж байгаа иргэдийн тоо буурах, эрүүл мэндийн чанар, үйлчилгээний хүртээмж хэдэн хувиар нэмэгдэх талаар судалгаа хийсэн эсэх, бүсчилсэн хөгжлийн хүрээнд цаашид бусад бүс нутагт ижил төстэй төсөл, хөтөлбөрүүд хэрэгжүүлэх боломжтой эсэх, зүрх, судас, хорт хавдраас урьдчилан сэргийлэх оношилгоо хийх лаборатори шаардлагатай талаар,
- Улсын Их Хурлын гишүүн Д.Ганбат эрүүл мэндийн салбарын хувьд иргэддээ хүрч ажиллах, хариуцлага, үр дүнд анхаарах,
- Улсын Их Хурлын гишүүн Ж.Энхбаяр төслийг дэмжиж байгаагаа илэрхийлээд зүрх, судасны өвчлөл их байгаатай холбоотой гадагшаа гарах мөнгөн урсгалыг багасгах шаардлагатай,
- Улсын Их Хурлын гишүүн Г.Тэмүүлэн зээлийн хэрэгжилт, гүйцэтгэлтэй холбоотой гишүүдийн хэлсэн саналыг анхаарах, төслийг хэрэгжүүлснээр гадагш чиглэсэн мөнгөний урсгал саармагжих үр дүнтэй талаар асуулт асууж, үг хэлсэн болно.

Монгол Улс болон Европын сэргээн босголт, хөгжлийн банк хоорондын зээлийн хэлэлцээр соёрхон батлах тухай хуулийн төслийг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн болно.

Монгол Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Монгол Улс болон Европын сэргээн босголт, хөгжлийн банк хоорондын зээлийн хэлэлцээр соёрхон батлах тухай хуулийн төслийг хэлэлцсэн талаарх Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг Та бүхнээс хүсье.

Анхаарал хандуулсанд баярлалаа.

Н.Учрал: Г.Очирбат гишүүнд баярлалаа.

Ажлын хэсгийг танилцуулъя.

Сангийн сайд Болдын Жавхлан, Сангийн яамны Санхүүгийн бодлогын газрын дарга Солонгын Тулга, Сангийн яамны Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга Жамъяншаравын Дэлгэржаргал, Сангийн яамны Санхүүгийн бодлогын газрын Өрийн удирдлагын хэлтсийн дарга Лувсандоржийн Гантогтох, Сангийн яамны Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын Хөгжлийн санхүүжилтийн хэлтсийн дарга Б.Ганзориг, Эрүүл мэндийн сайд Жигжидийн Чинбүрэн, Эрүүл мэндийн яамны Санхүү, эдийн засгийн бодлогын хэрэгжилтийн газрын Санхүү, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга Нямдэлгэрийн Хүрэлбаатар, Улсын гуравдугаар төв эмнэлгийн захирал Цэдэв-Очирын Төмөр-Очир, Гуравдугаар төв эмнэлгийн Эмнэлзүй эрхэлсэн дэд захирал Болдбаатарын Нандинцэцэг гэсэн ажлын хэсгийн бүрэлдэхүүн байна.

Ингээд Улсын гуравдугаар төв эмнэлгийн дэргэд Зүрх, судасны үндэсний төв байгуулах санхүүжилтийн эрх зүйн үндсийг бүрдүүлэх Европын сэргээн босголт, хөгжлийн банкны зээлийн хэлэлцээрийг хэлэлцэхтэй холбогдуулж хууль санаачлагчийн илтгэл болон Байнгын хорооны санал, дүгнэлтээс гишүүд асуулт асууж, үг хэлнэ.

Б.Пүрэвдорж, С.Бямбацогт гишүүнээр тасаллаа. С.Бямбацогт гишүүний нэрийг татъя. Өөр нэрээ татах хүмүүс байж болно шүү. Ц.Мөнхбат гишүүнийг нэмье. Ингээд тасаллаа.

Ирцээрээ Цагаанхүүгийн Мөнхбат гишүүн.

Б.Пүрэвдорж: Энэ зээлийн хэлэлцээр үнэхээр ард иргэдийнхээ эрүүл мэндийн төлөө хийгдэж байгаа зээл учраас, олон хүмүүс өвчний улмаас гадаадад явж зайлшгүй эмчлүүлж байгаа учраас, маш их зардал гарч байгаа учраас, дээрээс нь иргэдийн гадаад эмчлүүлсэн төлбөртэй холбоотойгоор тодорхой хэмжээний зардал Монголоос гарч байгаа учраас зээлийн хэлэлцээрийг дэмжиж байгаа гэдгийг хэлье.

Хоёрдугаар асуудал байна. Н.Учрал дарга анхааралдаа аваач ээ гэж хэлмээр байна.

Тэгэхээр Булган аймгийн Засаг даргыг хууль бусаар томилсон асуудал байгаа юм. Өөрөөр хэлбэл төрийн албанд огт ажиллаагүй. Тэгсэн мөртөө төрийн албанд ажилласан мэтээр материалаа бүрдүүлээд хэргийг нь Булган аймгийн Ардын намын даргын хүсэл зөвлөгөөгөөр бичгээр томилсон асуудал гараад байгаа.

Тэгэхээр өнгөрсөн хугацаанд н.Пүрэв-Очир гэдэг хүнийг ажил үүргээ бүрэн дүүрэн биелүүлж чадаагүй гэж огцруулсан.

Н.Учрал: Хэлэлцэх асуудалтай холбоотой юм ярина шүү.

Б.Пүрэвдорж: Энэ жилийн юугаар..., таслахгүй шүү.

Энэ жил хангалтгүй гэж үзсэн. Гэтэл энэ хүн Иргэний нисэхийн ерөнхий газарт Санхүү, удирдлагын газрын даргаар ажилласан гэж хуурамч анкет бөглөөд, тэр дагуу төрийн алба хашаагүй байж энэ ажлыг хийгээд явж байгаа.

Иргэний нисэхийн үндэсний төв болон нисэх буудлын удирдах газар ажиллаж байсан гэж үзэж байгаа. Тэгэхдээ энэ бол аж ахуйн тооцоот газар гэрээгээр ажилладаг. Төрийн захиргааны болон төрийн үйлчилгээний албан тушаалд ажилладаггүй.

Тийм учраас хууль бусаар томилогдсон энэ хүн хүнээс болж Булган аймгийн ажил төрөл доголдож ажлынх нь үзүүлэлт маш их муудаж байгаа.

Тийм учраас энэ хүндээ хариуцлага тооцохыг Засгийн газрын тэргүүн Г.Занданшатраас шаардаж байна.

Н.Учрал: Хэлэлцэх асуудалтай холбогдуулж ярина шүү. Хуулиа барина. Дэгээ сахиулъя.

Гадаад хэлний “Master Brain” сургалтын төвийн төгсөгч сурагчид Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна.

Сурагч дүү нартаа сурлагын өндөр амжилтыг хүсье. /алга ташив/

Цагаанхүүгийн Мөнхбат гишүүн асуулт асууна.

Ц.Мөнхбат: Өнөөдөр бидний ярьж байгаа, авах гэж байгаа зээл чухал зээл. Монгол Улсад нэн шаардлагатай байгаа зүрх, судасны томоохон эмнэлэг барихад зориулагдаж байгаа зээл. Бид зарчмын хувьд дэмжих ёстой гэж бодож байна.

Тэгэхдээ ганц нэг юм асууя. Ер нь өнөөдөр манай Монгол Улсын гадаад өр зээл яг хэд байна? Манай Сангийн яам, Б.Жавхлан сайд хариулаад өгөөч.

- 2016 оноос хойш өнөөдрийг хүртэл манай гадаад зээлийн хэмжээ нэмэгдсэн үү, буурсан уу?
- Нэмэгдсэн бол яаж нэмэгдсэн бэ?
- Хэдээр нэмэгдсэн бэ?

Өнөөдөр бидний авах гэж байгаа зээлийн нөхцөл, хугацаа, хүү ямар нөхцөлтэйгөөр, ямар хэмжээний зээл авах гэж байгаа гэдэг талаар нэмэлт мэдээлэл авъя. Тэгээд дараа нь тодруулна.

Н.Учрал: Сангийн яамнаас товч мэдээлэл. Хэн бэ? Хариулъя. 4 дүгээр микрофон.

С.Тулга: С.Тулга. Сангийн яам. Гишүүний асуултад хариулъя.

Засгийн газрын гадаад өрийн хувьд нийт өрийн хэмжээ 35.6 их наяд буюу дотоодын нийт бүтээгдэхүүний 40.2 хувьд хүрэхээр энэ оны эцэст байна. 2016 оны хувьд гадаад өрийн нийт хэмжээ 22.2 их наяд буюу Засгийн газрын өр нь дотоодын нийт бүтээгдэхүүний 93.1 хувьтай тэнцэж байсан байна.

Энэ зээлийн хувьд нийгмийн шинж чанартай төсөл байгаа. Нийгмийн шинж чанартай төслийг өрийн удирдлагын хуулийн дагуу бид хөнгөлөлттэй зээлээр хэрэгжүүлнэ.

Нийт эх үүсвэрийн 34.8 сая ам.доллар нь EBRD-аас авч байгаа. Европын сэргээн босголт, хөгжлийн банкнаас авч байгаа. IBRD нөхцөлтэй зээл байгаа.

26.3 сая ам долларыг Люксембургийн Их Гүнт Улсын буцалтгүй тусламжаар аваад, ингээд өрийн удирдлагын хуулийн дагуу хөнгөлөлтийн түвшин 42 хувь буюу нэн хөнгөлөлттэй эх үүсвэрт хамрагдаж байгаа эх үүсвэр байгаа.

Н.Учрал: Ц.Мөнхбат гишүүн тодруулъя.

Ц.Мөнхбат: Сая хүү, хугацааны тухайд хэлсэнгүй. Ж.Чинбүрэн сайд дараа нь тодруулаад нэмэлт хариулт өгнө биз дээ.

Энэ зээлийг бид авах ёстой. Бидний хувьд зайлшгүй хэрэгцээ шаардлага нь байгаа төсөл дээр бид хөрөнгө оруулалт авах гэж байгаа учраас гэдэг дээр бүрэн дүүрэн санал нэг байгаа юм.

Манай гадаад зээлийн өрийн хэмжээ нэмэгдээд л байгаа л даа. Жилээс жилд. Тэгээд би зориуд зүгээр 2016 онтой харьцуулж би асуусан юм. 2016 онд нэг хүнд ногдох манай өрийн хэмжээ 15 сая билүү. Тэгж хэлдэг байсан. Манай Монгол Ардын намынхан. Өнөөдөр бараг 10 жилийн дараа 13 их наядар нэмэгдсэн байна. Манай Засгийн газрын зээл. Нийт гадаад зээлтэйгээ харьцуулбал энэ тоо илүү нэмэгдэнэ. Мэдээж.

Тэгээд жилээс жилд нэмэгдээд л байдаг. Бидний өнөөдрийн нөхцөл байдал сайжрахгүй байгаа.

Н.Учрал: Санал хэллээ. Аюушийн Ариунзаяа гишүүн асуулт асууна. Дараа нь хариулъя. А.Ариунзаяа гишүүнийх дээр.

Аюушийн Ариунзаяа гишүүн.

А.Ариунзаяа: Би дэмжиж байна. Төр өөрөө яг төсвөөрөө чадахгүй байгаа асуудлаа зээлээр ч гэсэн хамаагүй шийдэж байвал маш сайн.

Тэгээд нэн ялангуяа зүрх, судасны өвчлөлийн тархалт маш өндөр байгаа юм. Тэгээд би Ж.Чинбүрэн сайдаас асуумаар байна.

Нас баралтын 35 хувь нь 45-аас 65 насны хөдөлмөрийн насны иргэд яг энэ зүрх, судасны өвчлөлөөр нас барж байна.

- 2024 онд 5789 хүн зүрх, судасны өвчлөлөөр нас барсан статистик байгаа.
- 2030 он гэхэд манай улсын зүрх, судасны тусламж, үйлчилгээний шаардлага 2.6 дахин нэмэгдэнэ гэсэн тандалт судалгаа байна.

Бид асуудлаа мэдэж байгаа юм бол зөвхөн эмнэлэг бариад эмчилгээгээ нэмэгдүүлээд асуудал өөрчлөгдөхгүй.

- Тэгэхээр үндэс углуургаар нь шалтгаан юу байгаа юм бэ?
- Ямар учир шалтгааны улмаас хүмүүсийн даралт нь ихсээд зүрх нь хаагдаад байна вэ гэдэг дээр Эрүүл мэндийн яам яг тодорхой шалтгаануудыг судалсан уу?
- Олон нийтэд мэдээлэх арга байна уу?

Энэ чинь зүгээр хооллолт, хэрэглээтэйгээ холбоотой байгаа юм бол үүнийг өөрчлөхийн тулд бид өнөөдөр юу хийх вэ, ухамсарт ямар сонголт хийх вэ гэдэг үнэхээрийн чухал байна.

- Архи, тамхи, хоолны хэрэглээнээс болоод байгаа юм уу?
- Стрессээс болоод байгаа юм уу?
- Эсвэл далайн түвшнээс дээр түвшинд амьдардаг учраас байгалиасаа ийм байгаа юм уу?
- Яагаад эрэгтэйчүүд нь илүү өртөөд байгаа юм?

Яагаад ковидоос хойш маш олон залуучууд гэнэт гэнэт зүрх нь хаагдаад байгаа юм бэ гэдэг дээр иргэд өнөөдөр үнэхээрийн маш том асуултын тэмдэгтэй байна.

Үнэхээрийн харамсалтай. Үнэхээр залуучууд өнөөдөр нэг л өдөр инээж явж байгаад л тэгээд л зүрх нь хаагдаад байгаа байхгүй юу. Тэгээд энэ дээр бид ямар нэгэн өөрчлөлт хийх ёстой. Төрийн бодлого юун дээр дутагдаж байна вэ гэдгийг Эрүүл мэндийн яам онцгой мэдээлдэг баймаар байгаа юм. Энэ зөвхөн Эрүүл мэндийн яам ч биш, бүх нийтээрээ, төрийн бодлого үүнд чиглэх ёстой гэж бодож байна.

Тэгэхээр учир шалтгааныг судалсан асуудлууд байдаг уу? Яг юунаас болоод, нэн ялангуяа сүүлийн үед залуучуудын зүрх зогсоод байна вэ?

Н.Учрал: Ц.Мөнхбат гишүүн болон А.Ариунзаяа гишүүн нарын асуултад Ж.Чинбүрэн сайд хариулна.

Ж.Чинбүрэн сайд.

Ж.Чинбүрэн: А.Ариунзаяа гишүүний асуултаас хариулж эхэлье.

Чухал асуудал хөндлөө. Учир шалтгаан нь юу вэ гээд. Үүнээс урьдчилан сэргийлж чадах юм уу гэдэг асуудал асууж байна. Тийм ээ. Жилдээ бид 5500-аас 6000 хүн зүрх, судасны шалтгаантай нас баралттай. Үүний 62.2 хувийг эрэгтэйчүүд эзэлж байна. Насаар нь аваад үзэх юм бол 36.3 хувь нь буюу 45-аас 65 насны яг л ид хөдөлмөр хийдэг насандаа бид алдаж байгаа нь өнөөдөр энэ зүрх, судасны өвчлөлийн төв барих үндсэн гол шалтгаан болж байна.

2030 он гэхэд 2.6 дахин нэмэгдэх тооцоололтой. Үүнтэй холбоотойгоор бид халдварт бус өвчин, осол гэмтлийн шалтгаан, эрсдэлт хүчин зүйлсийн тархалтын үндэсний дөрөвдүгээр судалгаа гэдгийг 2019 онд хийсэн. Үүнийг англиар **STEPS**⁸ (STEPwise approach to Surveillance) судалгаа гэж нэрлээд байгаа.

Дараагийн судалгаа 6 жил тутам нэг хийдэг. Энэ судалгаагаар зүрх, судасны өвчлөлтэй холбоотой 4 эрсдэлт хүчин зүйл нөлөөлж байна гэдэг судалгааны хариу нотолгоотой гарч ирсэн.

Энэ судалгаа хүн амд суурилсан тэдгээрийн судалгааг нэлээн тийм нарийвчлалтай хийдэг.

4 хүчин зүйл гэдэг маань юуг хэлж байна вэ гэхээр –

- ▶ Архи, тамхи.
- ▶ Хөдөлгөөний хомсдол,
- ▶ Илүүдэл жин,
- ▶ Цусан дахь холестерин хэмжээ их.

⁸ Тандалт судалгааны шат дараалсан аргачлал.

Энэ 4 зүйл ерөөсөө л зүрх, судас, судсан доторх бөглөрөл, зүрх, судасны өвчлөлийг нэмэгдүүлж байгаа.

Та сая ковидтой холбож ярилаа. Тийм. Ковидын вирусийн халдварын онцлог нь залуучуудад, ялангуяа залуу хүмүүсийн нарийн, бүр **капилляр** (Capillary) гэж нэрлэдэг бүр жижиг судсан дотор бөглөрөл үүсгэх, цус өтгөрүүлэх үйлчилгээ илүү давамгай нөлөөтэй ийм муухай хорон вирус.

Тийм ч учраас ковид цар тахлын дараах гол зүрх, судасны өвчлөлөөс сэргийлэх зүйл бол цус шингэлэх, цусыг шингэн байлгах. Үүнд хамгийн энгийн зүйл нь ерөөсөө л –

- шингэн их хэрэглэдэг байх ёстой,
- хөдөлгөөн их хийдэг байх ёстой.

Энэ чиглэлд нийгмийн эрүүл мэндийн боловсролын чиглэлд бид илүү их ажиллаж, энэ мэдээллүүдийг иргэддээ, залуучууддаа сайн ойлгуулж, эдгээрийг арилгах чиглэлд уриалдаг, манлайлдаг чиглэлээр бид ажилламаар байгаа юм.

Одоо бид сошиалд маш олон нөлөөллийн ажлууд хийж чаддаг улсууд байж байна. Тэгвэл бид эрүүл амьдрах хэв маяг, эрүүл амьдрах зуршлаас хэвшилд шилжих, буруу зуршлыг арилгах, сайн хэвшилтэй болох чиглэлд, илүү амьдрах чиглэлд ажиллана.

Тэр ч утгаараа Нийгмийн эрүүл мэндийн тусламжийн тухай хууль батлагдсан. Үүнтэй холбоотой 2026 оноос нийгмийн эрүүл мэндийн чиглэлд, нийтийн биеийн тамирыг хөгжүүлэх чиглэлд архи, тамхи. Их Хурлаар Тамхины хяналтын тухай хуулийн шинэчилсэн найруулга хэлэлцэж байгаа. Энэ их чухал үүргээ гүйцэтгэнэ гэж найдаж байна.

Гэр бүлээрээ бид шинэ жилээ тэмдэглэх гэж байна. Тэгвэл шинэ жилийн баярыг архигүй тэмдэглэх, гэр бүлээрээ аз жаргалтай сайхан. Идэш уушиндаа хүртэл өөх тос хэрэглээгээ багасгах гэх мэтчилнээр олон нийтэд эрүүл мэндийн боловсрол олгох.

Энэ ажлыг бүр хар багаас нь сургууль наснаас нь эхлэх ёстой. Тэгж байж... /минут дуусав/

Н.Учрал: Болсон уу? А.Ариунзаяа гишүүн тодруулна.

А.Ариунзаяа: Ж.Чинбүрэн сайд нийгмийн эрүүл мэндийн буюу нийгэмд чиглэсэн, хэрхэн яаж урьдчилан сэргийлэх вэ гэдэг ажилдаа Засгийн газар нухацтайхан ажиллаасай.

Нийгмийн эрүүл мэндийн тухай хуулийг бид баталсан. Хэрэгжилт нь үнэхээрийн муу байгаа. Манай О.Саранчулуун гишүүн, манай Д.Ганмаа гишүүн яг энэ хуулиуд дээр, хэрэгжилт дээр нь маш анхаарч дуу хоолой болдог.

Засгийн газар өөрөө энэ дээр ажиллаж дуугармаар байгаа байхгүй юу. Бид өнөөдөр дандаа л том төсөл, мөнгө хөрөнгө л ярьж байна. Гэтэл цаана нь иргэдийнхээ амьдралд чиглэсэн ажлууд ерөөсөө хаягдаад байна.

Н.Учрал дарга аа, Тамхины хууль.

Тамхины хуулийг уг нь бид сая батлах ёстой байсан юм. 12 сарын 31 хүртэл орон зай, цаг хугацаа байна. Иргэдийн амь нас, эрүүл мэндтэй холбоотой юм гэдгийг сая Эрүүл мэндийн сайд хэллээ. Та хариулж болдог юм болов уу, болдоггүй юм болов уу? Тамхины хууль.

Н.Учрал: Би ажлын хэсгийг нь байгуулж өгсөн шүү дээ. Тийм. Байгуулсан шүү дээ.

Тамхины хуулийн ажлын хэсгийг байгуулсан. Аль аль намын бүлгийн төлөөллийг оруулсан. Одоо хурдан ажиллах хэрэгтэй шүү дээ. Ажлын хэсгийг байгуулсан. Бүх боломжоор хангаж байгаа. Яаралтай батлах хэрэгтэй.

Сүхбаатарын Эрдэнэбат гишүүн асуулт асууна.

С.Эрдэнэбат: Уг саналыг дэмжиж байгаа.

Гэхдээ байшин барилга барих нэг өөр. Хүний нөөцөө хэрхэн яг яаж бэлдэж байна вэ? Тухайлбал, манай улс шиг тархай, өргөн уудам нутагтай газар зүрхний яаралтай тусламж авах чадавхыг ирэх жилүүдэд яаж нэмэгдүүлэх юм бэ? Ядаж бүс болгонд зүрх, судасны нарийн мэргэжлийн эмч нарыг бэлтгэх, шилжүүлэн ажиллуулах, тэр цалин хөлс, тогтвор суурьшилтай холбоотойгоор цогц бодлого хэрэгжүүлж байж хүний нөөц нь тогтох юм шиг байгаа юм.

Тэгээд энэ тал дээр хэр зэрэг давхар ийм бодлого яаж байгаа вэ гэдгийг хэлмээр юм. Энэ зээлийн хэлэлцээр дотор хүний нөөцийг нь давхар бэлдэж сургахад дэмжинэ гэж би ойлгосон. Тэр зөв үү гэдгийг тодруулж асуумаар байна.

Манай улс эхний 10-д л явж байна даа. 100 мянган хүнд нас баралтаараа 283 гээд. Станы хэдэн орнуудтай эхний 10-д явж байна.

Дэлхий дээр хамгийн бага эрсдэлтэй орнууд гэхээр Солонгос, Япон, Франц гээд улсууд байж байна. Тэгээд түрүүний хэлдэг шиг тэр цаг уурын нөхцөл байдалтай холбоотой юу байна уу?

Захын зүрх, судасны удамшилтай эрсдэлтэй хүмүүс маань захын эмнэлгээр ороод наад захын мэдээллүүдийг системтэй авдаг зүйлийг ядаж бий болгох шаардлагатай байна гэдэг зүйлийг хэлмээр байна.

Ковидын дараа. Түрүүний хэлдэг үнэн. Олон залуучууд зүрх, судсаар манай 3 дугаар эмнэлэг дээр очоод харахаар залуучууд, залуу охидууд, хөвгүүд дүүрэн л байж байдаг. Зүрхний “**ишеми**”^[цус хомсдох] (ischemia) болсон гээд. Үүний учир шалтгаан, урьдчилан сэргийлэх арга хэмжээн дээр системтэй мэдээлэл, урьдчилан сэргийлэх тактик, төлөвлөгөө маш их чухал байгаа.

Тэгээд сум хооронд, аймгийн эмнэлгүүдийг чадавхжуулах, хүний нөөцийг нь дагаж сургах гэдэг асуудлыг магадгүй гурав, дөрвөн жилийн дараа энэ эмнэлэг ашиглалтад ороход дагаад тэнд ажиллах хүмүүс нь бэлэн байх төлөвлөгөөг давхар хийж байгаа биз дээ гэдэг зүйлийг тодруулж асуумаар байна.

Н.Учрал: Ж.Чинбүрэн сайд хариулъя.

Ж.Чинбүрэн: Баярлалаа. Чухал сэдэв хөндөж байна.

Ер нь зүрх, судасны өвчлөлийг бууруулахад ганцхан байшин бариад энэ дуусгүй. Ганцхан Улаанбаатар хотод нэг төв байгаад энэ амжилт олохгүй.

Тийм учраас ерөөсөө улс даяар, манай Монгол шиг дэлгэсэн тэрлэг шиг өргөн удам нутагтаа эмнэлгийн тусламж, үйлчилгээг аймаг, сум болгонд хүртээмжтэй байлгах бодлого Эрүүл мэндийн яамны том бодлого байгаа. Энэ чиглэлд ч гэсэн бид ажлууд хийж байгаа.

Түүний нэг хэсэг нь энэ Европын сэргээн босголтын банкны төслийн дараа Азийн хөгжлийн банкаар хэрэгжүүлэх хоорондоо уялдаа холбоотой төслүүд байгаа.

Хүний нөөцийг бэлдэх асуудал дээр манай Улсын гуравдугаар төв эмнэлэг Люксембургийн дараалсан төслүүдийн хүрээнд нэлээдгүй амжилттай хийж чадсан.

Европын сэргээн босголтын банктай холбоотой зээл. Би Сангийн яаманд зориуд баярлалаа гэж хэлмээр байгаа юм. Энэ зээлийн 58 хувь нь Европын сэргээн босголтын банкнаас, үлдсэн санхүүжилт нь Люксембургээс буцалтгүй тусламж. Буцалтгүй тусламж.

Энэ буцалтгүй тусламж дотор тоног төхөөрөмжүүдийг суурилуулах, боловсон хүчин, хүний нөөцийг бэлдэх, дээрээс нь үйл ажиллагааг жигдэртэл. Та бүхэн төслийн хэрэгжих хугацааг харж байгаа. Энэ удаан хугацаанд барилга байшин барих гээгүй. Үйл ажиллагаа жигдрүүлж Монгол улс даяар зүрх, судасны өвчлөлийг бууруулах том бодлогуудыг хэрэгжүүлэх үйл ажиллагаа явагдана.

Өнөөдөр өндөр хөгжилтэй орнуудад зүрхний шигдээсээр үхнэ битгий хэл хөгжлийн бэрхшээлтэй болохгүй байгаа юм. Хөдөлмөрийн чадвар алдалтгүй эмчлэгддэг болоод байгаа.

Тийм учраас энэ “know-how”-г бид Монголдоо нэвтрүүлж сэргийлж болох нас баралтыг бууруулах том зорилго тавьж байгаагийн нэг илрэл нь энэ сургалтын төв болох ёстой.

Дээрээс нь ахисан түвшний оношилгоо, эмчилгээ, зүрх шилжүүлэн суулгах хүртэл эмчилгээ хийж чаддаг ийм том төв болно.

Энэ том төв болсноороо бид Монгол Улсад зүрх, судасны өвчлөлийн эмчилгээг дэлхийн ямар ч улс орноос дутахааргүй хийж чаддаг том амбицтай төсөл.

Энэ төслийн бас нэг сайн тал нь бүтэн өнгөрсөн 20 жилийн хугацаанд Люксембургийн Вант Улсаас, Монгол Улсад гуравдугаар эмнэлэгтэй хамтран ажиллаж, байнгын сургалт явуулж, дээрээс нь цахим тогтолцоо бий болгоод, орон нутагт харвасан шигдээс болсон хүмүүсийг дэмий тээвэрлэхгүй аймгийн нэгдсэн эмнэлэгт нь эмчилгээний зөвлөмж, заавар өгч эмчилдэг. Хэдийд нь татах вэ. Татаад ирэхэд нь хүлээж авах тогтолцоонуудыг хийж чадсан.

Энэ болгон нэг ёсондоо ажлын фронтоосоо төсөл нь өөрөө бичигдээд гараад ирсэн ийм сайн төсөл гэдэгт Эрүүл мэндийн сайдын хувьд бахархууштай, бардам байгаа.

Энэ төсөл хэрэгжсэнээрээ дараагийн том зүйл бид иргэдээ гадаадад очиж эмнэлгийн тусламж авах гэж хамаг мөнгөө базаад орон гэрээ зараад явдаг биш эх орондоо эмчлүүлж чаддаг байх тогтолцоог хийх том алхам болно.

Барилгын ажил 3 жил үргэлжилнэ. Ингээд зүгшрээд ажил жигдрээд явна. Ажил хийж чаддаг улсууд... /минут дуусав/

Н.Учрал: Буланы Бейсен гишүүн асуулт асууна.

Б.Бейсен: Дэмжиж байгаа. Энэ асуудлыг. Ер нь зүрх, судасны асуудал Монголд хүнд байгаа нь үнэн.

Тэгэхээр энэ эмнэлэг оношилгооны төвд төхөөрөмжтэйгөө барих юм байна. Тэгэхэд гуравдугаар эмнэлгийн хашаан дотор барих юм уу, хаана барих гээд байгаа юм? Тийм талбай байгаа юм уу?

Үе үеийн эмнэлгүүд газар алдлаа шүү дээ. Энэ хотын захиргаа, энэ дарга нарын буруутай, эмнэлгийн дарга нарын буруутай үйлдлээс. Хашаагаа, бүр ингээд газар алдсан. Нэг доор.

Хоёрдугаарт, мэргэжилтэн, боловсон хүчин хэр хангалттай байна? Одоо гадаад, дотоодод заавал сургах шаардлагатай байгаа юм уу? Хэдэн жилийн өмнө ганц хоёр л хүн байсан. Одоо хэдэн хүн сургасан?

Гуравдугаарт, тоног төхөөрөмж гэхэд судсан доторх мэс засал, нөгөө талаараа зүрхний олдмол хавсарсан том гажгууд байж байна. Үүнийг хийдэг эмч нар хэр байна? Сургасан уу? Цаашдаа сургах юм уу? Эрүүл мэндийн сайд энэ дээр төсөв тавьж байна уу?

Одоо ашиглалтад ороход мэргэжилтнүүд нь бэлэн байх ёстой. Энэ тал дээр хэр анхаарч ажиллаж байна?

Нөгөө талаар гуравдугаар эмнэлэг 365 хоног гэхэд тасралтгүй ажиллаж байгаа шүү. Гуравдугаар эмнэлгийн тархи, тархины судасны мэс заслынхан, зүрх, судасны мэс заслынхан тасралтгүй ажилладаг.

Би оройдоо эмнэлгүүдээр явдаг. Энгийн хувцастайгаа. Байнга ачаалалтай. Аймаг болгоноос зүрхний шигдээстэй улсууд ирж байна. Харвалтай улсууд ирж байна. Тэд нарыг машинаар хот руу зөөж байна.

Тэгэхээр аймаг болгонд цаашлаад ангиографийн тасаг (Angiography Suite/Cath Lab) нээгээд ангиогийн шинжилгээг хийдэг болмоор юм. Энэ талаар Эрүүл мэндийн сайд цаашдаа баримтлах бодлого байна уу?

Тэгэхгүй хэчнээн юм бариад ч гэсэн хотын тэр гуравдугаар эмнэлгийн ачаалал нь багасахгүй. Энэ тал дээр анхаарч байгаа асуудал байна уу?

Баян-Өлгий аймагт том оношилгооны төв барьсан. Д.Дэлгэржаргал сууж байгаа юм байна. Өчигдөр очсон чинь тэр барьсан барилгынхан хүлээлгэж өгөхгүй. Миний санхүүжилтийг өгөөгүй гээд бүр хэл ам болоод би хүрээд ирлээ.

Үүний урд талын кодыг та нар яагаад өөрчлөөд явуулсан юм. Урд талын кодонд гэрээ хийхгүй гээд явуулсан байна. Худалдан авах ажиллагааны газар очсон. Эрүүл мэндийн яаманд хоёр удаа очсон. Тэгээд аймаг руу явуулсан.

Та нар арай ч дээ. Ийм юм хийж болохгүй шүү дээ. Алслагдсан аймаг. Тэнд чинь зүрх, судасны янз бүрийн шинжилгээ, тархины хагалгаа газар дээр нь орохоор вакумжсан 3 өрөө хийж өгсөн.

Өчигдөр тэр хүн хэлж байна. Би 100 ортой эмнэлэг гэсэн. 150 ортой болгоод барьж өгсөн шүү. Та нар анхаарахгүй байна гээд надтай бүр хэрүүл

хийгээд. Ийм асуудал гарсан. Энэ дээр та нар ямар хариулт өгөх юм. Дараа нь тодруулъя.

Н.Учрал: Ж.Чинбүрэн сайд хариулна.

Ж.Чинбүрэн: Эмч хүн чухал асуулт асууж байна.

Байршил Улсын гуравдугаар төв эмнэлгийн хашаан дотор зүүн урд талдаа байгаа. Энд одоо бас нэг тодорхой хэмжээний газар алдалгүй найдвартай хадгалсан.

Давуу тал нь дэд бүтэцтэйгээ шууд холбогдож байгаа. Энэ их том давуу тал байгаа.

Өнгөрсөн 24 жилийн хугацаанд 5 хөтөлбөр, төслийн хүрээнд 4 мянга гаруй давтан сургалтуудыг эмч, эмнэлгийн ажилчдыг сургасан байна.

Дээрээс нь өнөөдөр ганцхан Улсын гуравдугаар төв эмнэлэг судсан дотуур зүрх, судасны, дээрээс нь тархины ангиографийн эмчилгээ хийдэг биш олон эмнэлгүүд хийж чаддаг болсон. Тэр битгий хэл бүсийн төвүүд дээр хүртэл ангиографийн аппаратуудтай болоод хийж чадаж байгаа нь өнөөдөр тоног төхөөрөмж болон мэргэжилтний бэлтгэлжүүлэлт нэлээдгүй сайн явсан.

Гэхдээ энэ үргэлжилнэ. Тасралтгүй сургалт явж байж шинэ технологиудыг, шинэ эмчилгээний аргуудыг нэвтрүүлэх үйл ажиллагаа тасралтгүй явна.

Мөн бахархуштай зүйл Монгол Улсдаа манай Улсын гуравдугаар төв эмнэлэг, тэр битгий хэл хувийн эмнэлгүүд зүрхний гажгийн нээлттэй хагалгаа, мөн судсан дотуур хавхлагийн гажигтай, цоорхойтой хүүхдүүдийн хүртэл хагалгааг хийж чаддаг болсон явдал өнөөдөр манай Монголын анагаах ухаан өдий зэрэгтэй хөгжиж дэвшсэний нэг тод гэрч юм.

Тийм учраас энэ чиглэлд сургалтууд нэлээдгүй сайн бэлтгэгдээд үйл ажиллагаа амжилттай явж байгааг танд хэлье.

Баян-Өлгий аймгийн шинэ эмнэлэг баригдсан. Та бүхэн Их Хурлын гишүүд төсөв дээр ажлын нэмэгдэл цалин суулгахдаа шинэ төсөлд гээд тавьсан л бидний шийдэж чадахгүй болсон хамгийн том гацаа байлаа.

Тэгээд магадлангаар ажлын хөлс нэмэгдүүлэн олгох барилгын ажилтай холбоотой төсөв 3.4 тэрбум төгрөгийг шийдэж чадалгүй, ингээд байдал маш хүнд байдалтай байна.

Шинэ төсөл болохоор үндсэн төсвийнхөө 15 хувиас дээшгүй тохиолдолд нэмэлтээр гэрээ хийж болдог. Тэгтэл энэ нь “шинэ төсөл” гээд тавьсан учраас.

Тэгээд дээрээс нь анхны үндсэн гэрээний төслийн 15 хувиас хэтэрчхээд байгаа учраас Төсвийн тухай хуулиараа, Тендерийн худалдан авах үйл ажиллагааны хуулиараа бид үүнийг олгож чадахгүй байдалд хүрээд, үүнээсээ гарах гарц олдохгүй маш хүнд байдалд орсон.

Үүнтэй холбоотой барилга барьсан компани комисст хүлээлгэж өгөхгүй. Уг нь өчигдөр хүлээлгэж өгнө гэж бид харж байсан.

Тэгэхээр яг өчигдөр хүлээлгэж өгсөн эсэхийг би мэдээлэл аваагүй байна. Хэрвээ мэдэж байгаа бол манай Эрүүл мэндийн яамны Хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга Н.Хүрэлбаатар нэмээд хариулаарай.

Н.Учрал: Мэндчилгээ дэвшүүлье.

Улсын Их Хурлын гишүүн Халтмаагийн Баттулгын урилгаар Орхон аймгийн Эрдэнэт хотын ерөнхий боловсролын сургуулийн 12-ын “д” ангийн багш, сурагчид Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна.

Сурагч дүү нартаа сурлагын өндөр амжилтыг хүсье. /алга ташив/

Сайн байцгаана уу?

Н.Учрал: Буланы Бейсен гишүүн тодруулна.

Б.Бейсен: Тэр урд талын кодыг нь Сангийн яамныхан мэдэхгүй байгаа биш. Шинэ төсөл болгоод тавьсан. Тэрийгээ та нар яаж засах юм. Тэрийг засаад өгөхгүй бол өчигдөр би дутуу санхүүжилтээ авах гэсэн. Өгөхгүй гээд ярьж байна. Нэгдүгээрт.

Хоёрдугаарт, гуравдугаар эмнэлгийнхнээс асууя. Танайх нь хоёрдугаар эмнэлэг, нэгийнхэнд очоод зөвлөгөө өгөөд ажилладаг юм байна. Хагалгаанд ороод.

Цаашдаа нэгдүгээр эмнэлэг, эх нялхсын, хүүхдийн зүрхний мэс засал байна. Энэ эмнэлэгүүд дээр сургах, хамтран ажиллах тал дээр хамтраад цаашдаа ер нь хөгжүүлэхийн төлөө тэгж ажиллахгүй бол болохгүй нөхцөл байгаа юм байна шүү. Энэ дээр анхаараарай. Дэмжиж байгаа шүү гэдгээ хэлье.

Н.Учрал: Санал хэллээ. Даваасамбуугийн Ганмаа гишүүн асуулт асууна.

Д.Ганмаа: Сайн байцгаана уу? Би асуулт асуухгүй. Дэмжиж үг хэлье гэж бодож байна.

Бид өнөөдөр энд зөвхөн нэг эмнэлэг, нэг барилгын асуудал ерөөсөө яриагүй. Монгол хүний амь нас, хөдөлмөрний насжилт, эдийн засгийн ирээдүйн талаар шийдвэрлэх асуудлыг ярьж байна.

Түүрүүн ярьсан. 2024 онд л гэхэд зүрхний нас баралтаар 5789 хүнийг бид алдсан. Түүнээс 36.3 хувь байдаг байх. Дандаа 45-аас 65 нас буюу нийгэм, эдийн засгийн хамгийн идэвхтэй насан дээрээ байгаа хүн ам байгаа.

Хэд хэдэн тоо хэлье. Монгол Улсын зүрх, судасны тусламжийн хамгийн гол хүнд ачааг бидний хэлж заншсанаар Улсын гуравдугаар эмнэлэг үүрдэг.

Улсын хэмжээнд –

- зүрхний мэс заслын 95 хувийг,
- судасны дотуурх эмчилгээний 67 хувийг,
- хэм алдагдлын эмчилгээний 93 хувийг –

гуравдугаар эмнэлэг дангаараа хийж гүйцэтгэдэг.

Зөвхөн 2024 онд гэхэд 422 нээлттэй мэс засал хийсэн. Түүнээс 120 нь 0-ээс 16 насны хүүхэд буюу төрөлхийн гажигтай хүүхдүүдийн мэс засал.

Гэтэл энэ айхтар ачаалалтай ажлаа энэ төв нь маш хуучин барилга дээр. Давхарласан урсгал дээр гэдэг нь халдварын эрсдэлтэй гэсэн үг. Тэгээд өргөтгөх ямар ч боломжгүй ийм нөхцөлд ажиллаад байгаа юм.

Энэ тэгээд одоо ч орж ирж байгаа биш нэлээн олон жил яригдаж байсан. Маш олон хүний хүч хөдөлмөр, тооцоо орсон ийм төсөл юм.

Хоёрдугаарт, хэдийгээр барилга, байшин нь. Зөвхөн барилга, байшингийн асуудал биш. 8 давхар 8 мэс заслын өрөө, 12 үзлэгийн өрөө нэмэгдэж байгаа ч гэсэн хамгийн гол нь миний бодлоор “know-how” буюу оношилгоо, сургалт, судалгаа, урьдчилан сэргийлэлт. Эд нар бүгдээрээ бөөнөөрөө нэг доор орж ирнэ. Тэгснээрээ чадавх сайжирна. Энэ маш том юм.

Бас нэг чухал юм нь энд хүний нөөц буюу орны тоо огт нэмэгдэхгүйгээр тоног төхөөрөмж, урсгалын зохион байгуулалтын хүчин чадлаа хоёроос гурав дахин нэмж байгаа нь аягүй авууштай санагдаж байгаа. Жишээлбэл,

- ➔ нээлттэй мэс заслын өрөөг 2 дахин,
- ➔ судсан доторх мэс заслыг 2 дахин,
- ➔ үзлэг оношилгоогоо 3 дахин нэмэгдүүлэх боломж гарч байгаа.

Ингэснээр яаралтай тусламж, ахисан түвшний дүрс оношилгоо, сэргээн засах, өдрийн эмчилгээ бүгд бие биеэ даасан тийм unit_[тасаг, нэгж]-тэй болох боломж нь гарч байгаа.

Тэгээд өвчлөгч, эмчлүүлэгч, иргэд, эмнэлгийн хог хаягдал, ариутгал 100 хувь тусгаарлагдаж, олон улсын хяналтын стандарт бүрдэнэ. Энэ бас маш том асуудал.

Манайд эмнэлгийн халдвар хяналтын асуудал, аюулгүй байдал, үндсэн стандарт нь их тааруу байдаг.

Гуравдахь асуудал нь, миний бодлоор хэдийгээр төслийн нийт өртөг нь 60.2 сая доллар гэж байгаа боловч 42 хувь нь Люксембургийн буцалтгүй тусламж. Тэгээд бараг 2 хувь нь техникийн зөвлөх үйлчилгээ ороод байгаа.

Тэгэхээр Монгол Улсад урьд нь эрүүл мэндийн ийм том мега төсөл маш ховор орж ирж байсан.

Тэгэхээр энэ Засгийн газар нөгөө “Хүний хөгжил, хүний хөгжлийн мега төсөл байна” гэж яриад байдгийгаа ер нь биелүүллээ. Энэ төслөөр харуулж байна гэж би үзэж байна.

Зүрх, судасны урьдчилгааг үзэхэд зарцуулсан 1 евро тус бүрдээ 5 еврог буцалтаар авдаг гэж үздэг.

Ийм учраас эрхэм гишүүддээ хандан хэлэхэд энэ бол барилгын төсөл ч биш, салбарын өргөтгөл ч биш.

Энэ бол Монгол Улсын 2030 оны нас баралтыг бууруулах зорилтыг биелүүлэх гол тулгуур, хөрөнгө оруулалт гэж үзээд зүрх, судасны өвчин Монгол Улсад үндэсний аюулгүй байдлын түвшинд харсан байгаа шүү гэдгийг анхааран

- амь насыг аврах,
- эдийн засгийг хамгаалах,
- эрүүл мэндийн тусгаар тогтнолыг олох –

энэ төслийг дэмжиж өгөөрэй гэж хүсье. Баярлалаа.

Н.Учрал: Энэ бол маш чухал төсөл.

2029 он хүртэл хэрэгжих 427 өрөөтэй, 8 давхар, 120 ортой эмнэлэг байгуулагдана.

Гишүүдийг танхимд урьж байна. Санал хураалт явуулах ёстой.

Гишүүд асуулт асууж, хариулт авч, үг хэлж дууслаа. /алх цохив/

Санал хураалтыг нэгтгэж явуулъя. Гишүүдийг танхимд урьж байна. 65-аар батална шүү.

**Гурав.Монгол Улс болон Азийн хөгжлийн банк хоорондын
Санхүүжилтийн ерөнхий хөтөлбөр соёрхон батлах тухай хуулийн төсөл**
/Засгийн газар 2025.12.18-ны өдөр өргөн мэдүүлсэн,
соёрхон батлах/

Монгол Улс болон Азийн хөгжлийн банк хоорондын санхүүжилтийн ерөнхий хөтөлбөр соёрхон батлах тухай хуулийн төслийг хэлэлцэнэ.

Хууль санаачлагчийн илтгэлийг Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Монгол Улсын Шадар сайд Хассуурийн Ганхуяг танилцуулна.

Индэрт урьж байна.

Х.Ганхуяг: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Азийн хөгжлийн банкны 475.0 сая долларын санхүүжилтийн эрхийн хөтөлбөрт гарын үсэг зурах эрх олгох тухай Ерөнхий сайдын захирамжийн төслийг Улсын Их Хурлын Эдийн засаг, Төсөв болон Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороодод танилцуулж, хөтөлбөрт гарын үсэг зурах эрх олгосны дагуу 2025 оны 11 дүгээр сарын 04-ний өдөр санхүүжилтийн эрхийн хөтөлбөрт гарын үсэг зураад байна.

Санхүүжилтийн ерөнхий хөтөлбөрийн хүрээнд Монгол Улсын урт, дунд хугацааны хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт тусгагдсан дараах төслүүдийг хэрэгжүүлнэ. Үүнд:

1.17 Аймгийн нэгдсэн эмнэлгүүдийг өргөтгөн шинэчилж, аймаг бүрт яаралтай болон эрчимт үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлж, хоёрдугаар шатын тусламж, үйлчилгээ үзүүлэх боломжийг бүрдүүлнэ.

2.Нийслэл, орон нутгийн нэн шаардлагатай байршлуудад 32 сургууль, 9 цэцэрлэг барьж байгуулах бөгөөд ингэснээр сургууль, цэцэрлэгийн хүртээмжийг нэмэгдүүлж, сургалтын ангийн дүүрлэлтийг бууруулна.

3.Хөдөө аж ахуйн салбар дахь хүний нөөцийн ур чадварыг зах зээлийн эрэлтдээ нийцүүлж, мэргэжлийн болон техникийн боловсролын төрөлжсөн жишиг сургалтын тогтолцоог бий болгоно.

4.Онцгой байдлын байгууллагын гал түймэр, гамшигтай тэмцэх, эрэн хайх, аврах, хор уршгийг арилгах, гамшгийг сөрөн тэсвэрлэж чадахыг бэхжүүлэх төслүүдийг хэрэгжүүлнэ.

Санхүүжилтийн ерөнхий хөтөлбөр нь олон улсын гэрээний тухай хуулийн 8.1.2-т заасны дагуу Улсын Их Хурлаар заавал соёрхон батлагдах олон улсын гэрээ тул санхүүжилтийн ерөнхий хөтөлбөрийг соёрхон батлах тухай хуулийн төслийг хэлэлцэн дэмжиж өгөхийг хүсэж байна.

Анхаарал хандуулсанд баярлалаа.

Н.Учрал: Хуулийн төслийн талаарх Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Ганбатын Хосбаяр танилцуулна.

Индэрт урья.

Г.Хосбаяр: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2025 оны 12 дугаар сарын 18-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Монгол Улс болон Азийн хөгжлийн банк хоорондын санхүүжилтийн ерөнхий хөтөлбөр соёрхон батлах тухай хуулийн төслийг Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 78 дугаар зүйлд заасныг үндэслэн 2025 оны 12 дугаар сарын 24-ний өдрийн хуралдаанаараа хэлэлцлээ.

Байнгын хорооны хуралдаанаар хуулийн төслийг хэлэлцэх үед –

- Улсын Их Хурлын гишүүн Г.Хосбаяр төслийн санхүүжилтээр баригдах эмнэлэг, сургууль, цэцэрлэгийн барилгын байгууламжийн дотоодын компани төр, хувийн хэвшлийн түншлэлээр хэрэгжүүлэх боломжтой эсэх, орон нутгийн онцгой байдлын салбарын туулах чадвар сайтай машин механизмаар хангах эсэх,
- Улсын Их Хурлын гишүүн Х.Жангабыл Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн шаардлага хангасан эсэх, цаг үеэ олсон эсэх, хэлэлцээрийн төслийг дэмжиж байгаагаа илэрхийлээд аймгуудад эмнэлэг, сургууль, цэцэрлэгийн барилга барих төсөл, хөтөлбөр ямар сонгон шалгаруулалтаар сонгогдсон талаар, Баян-Өлгий аймагт хэрэгжих төсөл, хөтөлбөр байгаа эсэх, Баян-Өлгий аймагт сургууль, цэцэрлэгийн хүрэлцээ хангалттай бус байгааг, мөн багуудын өрхийн эрүүл мэндийн төвийг өргөтгөхөд анхаарах,
- Улсын Их Хурлын гишүүн Н.Батсүмбэрэл төслийг дэмжиж байгаагаа илэрхийлээд орон нутгийн дэмжлэгтэйгээр Чингэлтэй дүүрэгт шинээр

барих, буулгах, засварлах шаардлагатай сургууль, цэцэрлэг, сургуулийн өргөтгөлийн асуудлыг шийдвэрлэх,

- Улсын Их Хурлын гишүүн Д.Ганбат зээлийн үр ашгийг дээшлүүлэхэд анхаарах, хэрэгжилт, гүйцэтгэлд хяналт тавьж ажиллах талаар,
- Улсын Их Хурлын гишүүн Г.Тэмүүлэн боловсролын салбарт хийх хөрөнгө оруулалтыг дэмжих, сургууль, цэцэрлэг эрүүл мэндийн төвийн тоо, үйлчилгээний чанарт анхаарах, сургууль, цэцэрлэгийн барилга, тэдгээрийн тоо болон үдийн хоолны үйлдвэрлэлийн стандартыг нэг мөр болгон мөрдөх шаардлагатай байгаа талаар асуулт асууж, хариулт авсан болно.

Монгол Улс болон Азийн хөгжлийн банк хоорондын санхүүжилтийн ерөнхий хөтөлбөр соёрхон батлах тухай хуулийн төслийг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Монгол Улс болон Азийн хөгжлийн банк хоорондын санхүүжилтийн ерөнхий хөтөлбөр соёрхон батлах тухай хуулийн төслийг хэлэлцсэн эсэх талаарх Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг Та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Н.Учрал: Баярлалаа. Ажлын хэсгийн гишүүдийг танилцуулъя.

Сангийн сайд Болдын Жавхлан, Сангийн дэд сайд Бат-Эрдэнийн Хулан, Сангийн яамны Санхүүгийн бодлогын газрын дарга С.Тулга, Сангийн яамны Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга Ж.Дэлгэржаргал, Сангийн яамны Өрийн удирдлагын хэлтсийн дарга Л.Гантогтох, Эрүүл мэндийн сайд Жигжидсүрэнгийн Чинбүрэн, Эрүүл мэндийн яамны газрын дарга Нямдэлгэрийн Хүрэлбаатар, Боловсролын яамны Төрийн нарийн бичгийн дарга Ханджавын Батжаргал, Онцгой байдлын ерөнхий газрын дарга Гомбожавын Ариунбуян, Онцгой байдлын ерөнхий газрын Санхүү, ар талын газрын дарга Төмөрбаатарын Мөнхдорж, Онцгой байдлын ерөнхий газрын Бодлого, төлөвлөлтийн газрын дарга Буянтогтохын Баяннэмэх гэсэн ажлын хэсэг хүрэлцэн ирсэн байна.

Хууль санаачлагчийн илтгэлтэй холбогдуулж асуулт асууж, үг хэлэх гишүүд байна уу? Асуулт асууж, үг хэлэх гишүүн. Э.Болормаа гишүүнээр тасаллаа.

Цагаанхүүгийн Идэрбат гишүүн асуулт асууна.

Ц.Идэрбат: Та бүхэнд өдрийн мэнд хүргэе.

Энэхүү зээлийн хэлэлцээрийг дэмжиж байгаа.

- ▶ Боловсрол,
- ▶ Эрүүл мэнд,
- ▶ Онцгой байдал,
- ▶ Хөдөө аж ахуйн –

-гэсэн 4 чухал салбарууд руу салбарын үйл ажиллагааг сайжруулахад чиглэсэн хөрөнгө оруулалтууд хийгдэх нь гэж үзэж байна.

Ялангуяа эрүүл мэндийн салбар дээр эрүүл мэндийн яаралтай түргэн тусламжийн асуудлыг онцгой анхаарч үзэж байгаа юм байна. Энд нөгөө сумдын туулах чадвар сайтай автомашины асуудал туйлын чухал. Ялангуяа зам даах, гарын ая, нөгөө дөрөө даах гутал гэдэг шиг.

Тийм машины сонголтууд хэрэгтэй байна. Цас зуд болдог тэгээд байгаа машин нь нэг жоохон цасанд очоод суудаг эвдэрдэг, ингээд ийм төвөгтэй байдал руу орох гээд байдаг учраас туулах чадвар сайтай автомашин.

Дээрээс нь авто замын сүлжээ нэмэгдэж байгаатай холбогдуулаад ялангуяа улсын чанартай авто замын дагуу байдаг сумуудад аваар ослын дуудлагууд маш их гардаг. Ослын газар дээрээс тэр хүнийг ямар нэгэн байдлаар эрсдэлгүй зөөх хэрэгцээ шаардлагууд урган гардаг юм билээ.

Тэгэхээр яг энэ зам дагуу байгаа. Одоо жишээ нь манай Хэнтийн Жаргалтхаан шиг, Цэнхэрмандал шиг, Мөрөн шиг ийм сумууд руугаа, Сүхбаатарын Мөнххаан шиг гээд би жоохон онцгой анхаараад өгвөл яадаг юм гэж боддог юм.

Одоо бас нэг зүйлийг бид олон улсаас зээл, тусламж аваад хийж байгаагийнх энэ түргэн тусламжийн нисдэг тэрэгний асуудлыг ер нь ярих цаг болсон юм биш үү. Энэ чинь одоо нэлээн эрэл сурал болдог. Тэгж байж 20 гаруй сая төгрөг. Явах маршрут юмнаасаа шалтгаалдаг юм шиг байгаа юм. Тэгээд үүнийг өгч чадахгүй хүмүүс маш их байдаг. Хөдөлгөж болохгүй өвчинтэй байгаад байдаг.

Тэгэхээр энэ дээр ер нь Эрүүл мэндийн яам байх уу, нэг ийм онцгой үед ашиглах нисдэг тэрэг, ийм зүйлүүд рүү бас нэг шинэчлэл хийх зайлшгүй шаардлага байгаа юм болов уу гэж боддог юм.

Тэгэхээр би Эрүүл мэндийн сайдаас одоо жишээ нь манай Хэнтийн хэдэн сумдын, Жаргалтхааны, Батширээтийн гээд, Баян-Овоогийн гээд түргэний

машин, Дорнодын Дашбалбар, Сүхбаатарын Онгон, Дарьганга гээд л алслагдсан сумдын машины асуудал шийдэгдэх юм байна гэж би нэгдүгээрт асуумаар байна. Энэ яг хэзээгээр вэ гэдгийг зориуд асууя гэж бодож байна.

Дараагийн ээлжид хөдөө аж ахуйн боловсон хүчнүүдийг бэлтгэх гэдэг зорилуулалт байгаа юм байна.

Энэ дээр ер нь ямархуу зүйл төлөвлөж байгаа вэ? Нөгөө хөдөө аж ахуйн үйлдвэрлэл, тэр дундаа манай мал аж ахуй дээр үржил селекц, зоо техникч. Газар тариалан дээр бол ер нь агрономи. Энэ нарийн мэргэжил шаарддаг энэ зүйлүүд рүү ер нь сурах ч сонирхол багатай болсон, олон хүндрэлүүд гардаг юм билээ.

Тэгэхээр энэ рүү төлөвлөж байгаа зүйлүүд байгаа юу гэж асуухыг хүсэж байна.

Онцгой байдал дээр сүүлийн үед онцгой байдлын тоног төхөөрөмжүүд нэлээн сайн сайжирсан. Хуучин улаан гараараа шахуу л нэг улаан үлээгчээс өөр юм байхгүй байдаг байсан. Одоо бас харьцангуй аятайхан болж байгаа юм билээ гэж харж байгаа. Тэр дундаа төв суурин газруудад 12, 16 давхрууд баригдаад эхэлсэн. Тэр лүү хүрдэг шат, тэр лүү ашиглах дрон. Тийм зүйлүүдээ бид бэлтгэхгүй бол ийм төрлийн байшин байгууламж дээр гал түймрийн аюул гарлаа гэхэд шат нь 6 давхраас дээш явдаггүй ч байдаг юм уу ийм сөрөг үзэгдлүүд нэлээн гардаг юм билээ.

Энэ дээр ер нь онцгой байдлын газар яаж төлөвлөж байгаа юм бэ гэдэг үндсэндээ ийм гурван зүйлийг асууя.

Боловсрол дээр харьцангуй боловсролын хүртээмжийг сайжруулахаар манай Хэнтийд гэхэд 2 ч сургууль шинээр баригдахаар байгаа. Энэ бол бас зөв зүйтэй зүйл болж байна... /минут дуусав/

Н.Учрал: Ж.Чинбүрэн сайд хариулъя.

Ж.Чинбүрэн: Ц.Идэрбат гишүүний асуултад хариулъя.

Азийн хөгжлийн банкны зээлээр одоо хэрэгжүүлэх гэж байгаа энэ төслийн үндсэн гол зорилго бол түрүүний дөнгөж сая бидний хэлэлцээд дууссан Европын сэргээн босголтын банкны зүрх, судасны төв байгуулаад, аймаг бүрт тэдгээрийн үйл ажиллагааг дэмжих, ялангуяа түргэн тусламж, яаралтай тусламж, зүрх судасны өвчлөл, гэмтэл ослыг шийддэг, орон нутагт нь шуурхай шийдэж чаддаг байх энэ төслийг хэрэгжүүлэх гэж байгаа юм.

Энэ төслийг хийх үндсэн ерөөсөө л гол шалтгаан бол бид эмнэлэгт очиж чадахгүйгээр нас барж байгаа, сэргийлж болох нас баралтыг бууруулах үндсэн том зорилго л хэрэгжинэ.

Энэ зорилгыг хэрэгжүүлэхийн тулд бид 230 сая доллароор 21 аймаг хөгжүүлэх гэж байгаа нь энэ том тогтолцоог хэрэгжүүлэх ажил харьцангуй боломжийн бага үнээр хийгдэх гэж байгаа ийм зүйл юм.

Учир яагаад вэ гэхээр бий болсон энэ тогтолцоондоо суурилж аймаг бүр дээр тусгайлсан өөрийнх нь аймагт дутуу байгаа зүйлийг гүйцээж хийхээр төлөвлөж байгаа.

Энэ ажлын хүрээнд нийтдээ 135 явуулын эмнэлэг буюу туулах чадвар сайтай, интернэтээр тоноглогдсон, эмнэлгийн машин дотор нь амилуулах тусламж үзүүлдэг ахисан түвшний тоног төхөөрөмжүүдтэй. Дээрээс нь интернэтээрээ дамжуулаад удирдлагын төвөөсөө веб зөвлөгөө авдаг, хүнээ тээвэрлэж явахдаа эмчилгээгээ хийгээд явах энэ ажлуудыг хийдэг ийм 135 түргэний машин.

Энэ бол хараахандаа ирэх жилдээ шийдэгдэхгүй.

Харин Азийн хөгжлийн банкны одоо хэрэгжиж байгаа төслөөр 80 тоногдсон туулах чадвар сайтай машины худалдан авах үйл ажиллагаа эхэлсэн явж байгаа.

Энэ үйл ажиллагаа эхлээд дуусахаар бид судалгаа гаргаад ер нь 130 гаруй түргэн тусламжийн туулах чадвар сайтай машин нэн яаралтай хэрэгтэй байгаа. Эдгээрийнхээ 80-ыг нь хангах боломж бүрдэх юм. Энэ дээр таны хүсэлт, албан бичгийг авсан байгаа. Тэгээд үүнтэй холбоотой олгогдох тооцоололтой яваа шүү гэдгээ хэлье.

Н.Учрал: Дуламын Бум-Очир гишүүн асуулт асууна.

Д.Бум-Очир: Та бүхэнд өдрийн мэнд хүргэе.

Ер нь дэмжиж байгаа. Нэг зүйлийг тодруулмаар байна. Нийт манай сургуулиудын 45 хувь нь 2 болоод түүнээс дээших ээлжээр, 3 магадгүй, зарим нь түүнээс арай олон байхгүй болов уу гэж бодож байна. Ээлжээр хичээллэж байгаа.

Тэгэхээр энд орсон байгаа 41 сургууль, цэцэрлэг гэж байна. 32 сургууль байна. Ямар шалгуураар яаж сонгож авсан бэ? Газраа болоод, сургуулиудаа. Яг хамгийн түрүүнд нэн шаардлагатай байгаа нутаг дэвсгэрт сургууль баригдахаар байгаа юу? Яагаад гэхээр нийт сургууль 705 улсын сургууль байгаа юм байна. Тэрний 45 хувь нь гэхээр бид 300, 400 сургуулийн тухай асуудал ярьж байна шүү

дээ. 300 орчим сургуулийн тухай асуудал ярьж байгаа байхгүй юу. Ачаалал нь хэтрээд байгаа.

Бид тэгэхээр эндээс нийтдээ 108 сургууль гээд. Одоо эхний ээлжид 32 сургууль гэхэд яг хэрэгцээ шаардлагатай байгаа нутаг дэвсгэрт нь, бас сургуулиудад нь яг онож энэхүү дэмжлэгийг үзүүлж байгаа юу гэдгийг тодруулмаар байна. Ямар шалгуураар яаж шалгасан юм?

Жишээ нь, Улаанбаатар хотод Налайх дүүргийг оруулаад миний ойлгож байгаагаар 17, 18 орчим сургууль гэсэн байх жишээтэй. Аймгийн төвүүд харагдаж байна. Сумын төвүүд харагдаж байна. Миний ойлгож байгаагаар яг ачаалал нь хэтрээд байгаа Улаанбаатар хот болоод аймгууд дээр ачаалал хэтэрч байгаа.

Тэгэхээр ямар ямар шалгуураар энэхүү 31 сургуулийг, мөн 9 цэцэрлэгийг сонгож авсан бэ гэдгийг тодруулмаар байна.

Ингэж байж илүү их үр ашигтай болох байх. Нэн яаралтай байгаадаа энэхүү зээлийн хөрөнгө оруулалтаа хиймээр байгаа юм л даа. Ингэж чадсан уу гэдгийг тодруулж өгмөөр байна.

Н.Учрал: Хэн хариулах вэ? Х.Батжаргал дарга. Боловсролын яамны Төрийн нарийн бичгийн дарга Х.Батжаргал. 4 дүгээр микрофон.

Х.Батжаргал: Боловсролын яам. Х.Батжаргал. Гишүүний асуултад хариулъя.

Тэгэхээр төслийн боловсруулалт, хөгжүүлэлт хийгдэж байх явцад зэрэгцээд улсын төсвийн боловсруулалттай хамт судалгаа тооцооллууд хийгдэж, нийт 2028-2030 он хүртэлх хугацаанд хүүхдийн тооны өсөлт ерөнхий боловсролын сургуульд хамрагдалт 88 мянган хүүхдээр нэмэгдэхээр байгаа.

Тэгэхээр энэ хэрэгцээг хангах нийт хүүхдүүдийнхээ шаардлагатай хүртээмжид тохирсон шаардлагатай сургууль, цэцэрлэгийн тоо хэмжээг гаргаад, түүнээсээ нэн тэргүүнд гэж яг гишүүний хэлдгээр ингээд эрэмбэлсэн байгаа.

Ялангуяа Улаанбаатар нийслэл хотод ээлжийн коэффициент буюу 2 болон түүнээс дээш 2-оос илүү хэмжээнд хичээллэх энэ ээлжийн хэсэг эрсдэлийг дагуулж байгаа, гягтрал ихтэй, бүлэг дүүргэлт нь 34-өөс дээш байгаа энэ хүндрэлтэй байгаа сургуулиудыг байршлыг нэн тэргүүнд сонгож авсан.

Мөн түүнчлэн орон нутагт 15 байршил сонгогдож урьдчилсан судалгаа хийгдэж байгаа. Тэдгээр нь зөвхөн Улаанбаатараас ялгаатай нь орон нутгийн түвшинд ээлжийн коэффициент, бүлэг дүүргэлт нь харьцангуй улсын дунджаас доогуур байгаа ч гэсэн хүүхдийн сурч боловсрох аюулгүй байдалд эрсдэл үүсэх хэмжээнд мэргэжлийн хяналтын дүгнэлт гараад, мэргэжлийн байгууллагууд

дүгнэлтээ гаргаад сүүлийн 70 жил, 60 жил болсон барилгууд, тэгээд урсгал засвар дунд хугацаандаа хийгдээгүй эрсдэл хүлээсэн эдгээр үзүүлэлтүүд байгаа.

Мөн Азийн хөгжлийн банкны тавьж байгаа шаардлага, нийгэм, эдийн засгийн үнэлгээ, дэд бүтэц, хүн амын нягтаршил. Эдгээр асуудлуудыг эрэмбэд гол шаардлага, шалгуур болгож авсан байгаа.

Н.Учрал: Пүрэвжавын Сайнзориг гишүүн асуулт асууна.

П.Сайнзориг: Би зарчмын хувьд дэмжиж байна. Тэгээд Д.Бум-Очир гишүүнд баярлалаа. Уг нь зарчмын юм яриад байна.

4 багц төсөл байна шүү дээ. Энэ дээр “эдийн засгийн хүндрэлийн үед боловсролын чанар, хүртээмжийг сайжруулах төсөл” гэж нэрлэж байгаа юм. Тэгээд “эдийн засгийн хүндрэлийн үед” гээд тодотгодог нь ч бас юу юм. Би ойлгохгүй байна.

Ер нь тодорхой хэмжээнд боловсролын чанар, хүртээмжийг сайжруулах асуудал угаасаа байна. Бид хэд улсын төсвөөс болон орон нутгийн төсвөөс чадах бололцоотой хэмжээгээр энэ асуудлуудыг зохицуулаад явж байгаа.

Гэвч байршлын хувьд тэргүүн ээлжид авч үзэх ёстой анги дүүргэлтийн буюу 30, 40 хүүхдээс хэтрээд нийслэлийн хэмжээнд чинь 50, 60 хүүхдүүд нэг ангид суугаад хичээллэж байгаа юмнууд байна. 3 ээлжээр хичээллэж байгаа зүйлүүд байна.

Энэ нь Монгол Улсын Үндсэн хуулиар заасан сурч боловсрох эрхийг зөрчөөд байгаа асуудал байхгүй юу. Багш нарын хөдөлмөрийг мөлжөөд байгаа асуудал нийслэлийн хэмжээнд асар их байгаа.

Тэгэхээр энэ чиглэл рүүгээ хэр энэ төслүүд чинь орж чадаж байгаа юм бэ гэдгийг тодорхой хэлээч. Нийслэл дээр яг энэ төслийн чинь хэмжээнд хэчнээн сургууль цаашдаа баригдана гэж тооцож байгаа юм. Хамгийн их зөрчилтэй буюу суудал дүүргэлт гэдэг юм уу, анги дүүргэлт чинь нийслэл дээр байгаа шүү дээ.

Тэгэхээр энэ чиглэл рүү энэ төслөөр хэчнээн сургууль, цэцэрлэг баригдах юм бэ? Үүнийг тодорхой хэлээч.

Тэгээд нэг юм авдаг. Тараагаад л үр ашгийг нь мэдэгдэхгүй байдлаар явбал хэр зохистой юм бол доо. Би сайн мэдэхгүй байна. Энэ дээр Х.Батжаргал дарга тодорхой хариулж өгөөч.

Хоёрдугаар асуудал нь, “Монгол Улсын ажиллах хүчний үр чадварыг хөгжүүлэх төсөл” гээд тавьж. Энэ ер нь ямар учиртай төсөл вэ? Ямар салбарууд хамаарагдах вэ?

Төслийг хэрэгжүүлснээр юуг хараад зайлшгүй энэ төслийг хэрэгжүүлэе гэж байгаа юм. Ямар өртөгтэй төсөл байгаа юм бэ гэдэг зүйлийг товчхон хариулаач.

Бусад асуудал дээр Ц.Идэрбат гишүүн асуусан учраас би давхцуулаад яах вэ. Энэ хоёр асуултыг голлож хариулаад Сангийн яамнаас нэг зүйлийг асууя.

Гадаадын зээл, тусламжийн ашиглалтын асуудал чинь Төсвийн тогтвортой байдлын хуулийн тусгай шаардлагад нийцээд явахгүй байгаа шүү дээ. Бид зээл аваад л нэг хууль батлаад л, тэгээд альныг нь тэргүүн ээлжид хэрэгжүүлэх вэ? Эсвэл тухайн төслийг хэрэгжүүлэх тухайн жилийн санхүүжилтийг нь олгож чадахгүй дусаах байдлаар гэдэг юм уу, маш бага өчүүхэн жижиг хэмжээгээр яваад, энэ төслүүдийн чинь үр ашиг, ашиглалт асар удааширч байгаа шүү дээ. Ийм байж байхад бид яваад байж байгаа нь болж байгаа юу? Аваад л байдаг, аваад л байдаг.

Тэгэхээр Улсын Их Хурлын нэр бүхий гишүүдээс хуульд явж байгаа. Тэгэхдээ энэ бодлого зөрчилдөөд байгааг юу гэж бодож байгаа вэ? Энэ зээл, тусламж болгон чинь хууль байхгүй юу. Зээл, тусламж болгон чинь хуулийг хэрэгжүүлэх ёстой үүрэг хүлээж байгаа гэсэн үг. Тэгээд яг энэ ач холбогдлын хувьд энэ хуулиудыг эрэмбэлээд, үүнийг нь хэрэгжүүлэхгүй, тэрийг нь хэрэгжүүлнэ. Энэ төсөл дээр жишээ нь газрын төсөв дээр 1.7 их наяд төгрөг жилдээ хэрэгтэй байхад 200-хан тэрбумыг өгнө ч гэдэг юм уу. Ингээд бид хэд аваад байгаа мөртөө зээлээ ашиглалт чинь ерөөсөө болохгүй байна шүү дээ.

Тэгэхээр үүнийг бодлогын хүрээнд ер нь юу гэж харж байгаа вэ? Ингээд л авдаг. Яадаг юм бол доо. Хэдэн жил энэ багцаараа хэрэгжих вэ? Энэ асуудал дээр тодорхой Сангийн яам хариулж өгөөч. Ингээд гурван асуултад хариулж өгнө үү.

Н.Учрал: Х.Батжаргал дарга хариулъя. 4 дүгээр микрофон.

Х.Батжаргал: Х.Батжаргал. Боловсролын яам. Гишүүний асуусан эхний хоёр асуултад хариулъя.

Гишүүний асуусан ээлжийн коэффициент нь хамгийн чухал шаардлага, үзүүлэлт байгаа. Тухайлах юм бол Улаанбаатар хотод урьдчилсан судалгаа хийгдэж баригдахаар бэлтгэл хангаж байгаа.

17 сургуулийн. Тухайлбал –

- Баянгол дүүрэг ээлжийн коэффициент 1.8,
- Сонгинохайрхан дүүрэг ээлжийн коэффициент 2.1,
- Сүхбаатар дүүрэг ээлжийн коэффициент 1.6,

- 640 хүүхэдтэй гэх мэтчилэн энэ сургуулиудын ээлжийн коэффициентыг нэн тэргүүнд авсан.

Ээлжийн коэффициент 2 луу дөхөх тусам 3 ээлж рүү орох эрсдэл хамгийн өндөр байгаа.

Улсын төсвийн хэлэлцүүлгийн үеэр энэ төслийн санхүүжилтийн ерөнхий хэлэлцээр орж байсан. Тэр үеэр Улсын Их Хурлын гишүүдээс гаргасан саналын дагуу нэмэлт судалгаа хийгээд, ялангуяа нийслэл хотод ачаалал өндөртэй байгаа зарим нэгэн байршлууд дээр нэмэлт судалгаа хийгдэж байгаа. Ялангуяа энэ 3 ээлжийн эрсдэл рүү орж байгаа, орох эрсдэлтэй байгаа сургуулиуд. Тухайлах юм бол Чингэлтэй дүүрэг дээр нэмэлт судалгаанууд хийгдэж байгаа.

Яагаад гэвэл улсын төсвийн хөрөнгө оруулалтад нэмэлтээр зарим нэг төслүүд орсон учраас судлагдаж байсан тоог нэмэгдүүлэх байдлаар өөрчилсөн байгаа.

Хоёрдугаарх асуулт. Мэргэжлийн болон техникийн боловсролын салбараар дамжуулж хөдөө аж ахуйн салбар дахь хүний нөөц, мэргэжлийн салбарт ажиллах хүний нөөцийг хөгжүүлэх талаар гол зорилго, зорилт энэ төслийн хэрэгжилтэд хангагдаж байгаа.

Үндсэндээ 20 сая ам.долларын санхүүжилт чиглэж байгаа. Тухайлах юм бол хөдөө аж ахуйн салбарыг чиглүүлж авсан нь өөрөө сүүлийн жилүүдэд хөдөө аж ахуйн салбарын техник, технологи, хувийн хэвшлийн хөгжил асар хурдацтай явагдсан. Харин яг түүнийг дагасан хэрэгжилт, хөдөлмөрийнхөө зах зээлийн эрэлтийг хангахуйц боловсон хүчин дутагдалтай.

Түүний гол шалтгаан нь суралцах орчин. Ялангуяа заавал 4 жил бакалавр, дээд боловсрол гэлтгүйгээр яг мэргэжлийн боловсрол эзэмшээд 2 жил, 3 жилийн хугацаанд бэлэн ажлын байран дээрээ гарахад суралцах орчин, лаборатори, дадлагын бааз. Эдгээр боловсон хүчнийг хангах шаардлагатай орчныг бүрдүүлэх гол лабораториуд. Эдгээр зүйлсэд зээлийн зориулалт зарцуулагдахаар төлөвлөгдсөн байна.

Н.Учрал: Ажлын хэсгээс нэмж хариулъя. 4 дүгээр микрофон. Сангийн дэд сайд Б.Хулан.

Б.Хулан: Сайн байцгаана уу? Сангийн дэд сайд Б.Хулан.

П.Сайнзориг гишүүний асуултад хариулъя.

П.Сайнзориг гишүүний хөндөж байгаа асуудал яг тулгамдаад байгаа асуудал мөн үү гэвэл мөн. Бидний гадаад зээлийн асуудал Өрийн удирдлагын

тухай хууль болон Засгийн газрын журмаар зохицуулагддаг. Гэтэл ашиглалт болон гүйцэтгэл нь Төсвийн тухай хуулиар зохицуулагддаг.

Энэ хэрэгцээ шаардлага өнөөдөр тулгамдаад байгаа учраас хуулийн төсөл өргөн баригдаад явж байгаа. Тэгэхдээ цаашдаа бид илүү цогцоор нь шийдэх хэрэгцээ шаардлага байгаа.

1991 оноос 2025 оныг хүртэл нийтдээ бид 35.8 их наядын зээлийн хэмжээ баталж, ашиглалт нь 21.1 их наяд буюу 14.7 их наядын үлдэгдэлтэй байгаа.

Тэгэхээр энэ бол бас нэг талаас уялдаа холбоог хангах, дээрээс нь зээлийн ашиглалтыг бид мөнгөн сууриас аккруэль суурь луу шилжүүлснээр энэ асуудал шийдэгдэх боломж бий болох юм.

Зээлийн зориулалтын тухайд –

- ▶ 1991-1999 оны хувьд илүү зах зээлийн эдийн засаг руу шилжиж байгаа шилжилттэй холбоотой.
- ▶ 2000-2009 оны хооронд дэд бүтэц бий болгохтой холбоотой.
- ▶ 2010-2015 оны тухайд эдийн засгийн өсөлтийг даган авах зээлийн хэмжээ нэмэгдсэн.
- ▶ 2016-2025 оны хувьд энэ хэмжээ огцом нэмэгдсэн байгаа нь бидний ярьдаг хөгжлийн томоохон төсөл, хөтөлбөрүүдийг гадаадын зээл, хөнгөлөлттэй эх үүсвэрээр санхүүжүүлэх хэрэгцээ нэмэгдсэнтэй холбогдож бий болж байгаа гэж хэлж болно.

Нөгөө талаас хөгжлийн бодлогыг хэрэгжүүлэхийн тулд бид санхүүжилтийн эх үүсвэрийг шийдэх хэрэгцээ шаардлага зайлшгүй бий болоод байдаг.

Нөгөө талаас нь хөнгөлөлттэй эх үүсвэр олдох байдал нь тодорхой хэмжээгээр хязгаарлагдмал байдаг тул бид таны саналыг тусгаад цаашдаа энэ аккруэль суурь луу шилжих асуудлыг боловсруулаад шийдэл гаргаад явъя гэж бодож байна.

Н.Учрал: П.Сайнзориг гишүүн тодруулна.

П.Сайнзориг: Сангийн дэд сайдад баярлалаа. Маш чухал юм яриад байгаа байхгүй юу.

Тэгэхээр яг энэ суурь юм руугаа бид хэд, энэ парламент асуудлыг сууриар нь зөв болгох хэрэгтэй. Бие биеэ хуурч байгаа юм шиг баахан зээлийн хэлэлцээр баталчхаад яг тэрний нөгөө зарцуулалт, гүйцэтгэлийг ярих болохоороо энэ улсын төсвийн тусгай шаардлагатай холбоотойгоор болохгүй байна гээд явдаг ийм

нөхцөл байдлууд зээллэгийн үр ашиг, үр өгөөжийг ерөөсөө улам л багасгана гэсэн үг.

Өөрийн чинь саналыг 100 хувь дэмжиж байна гэдэг зүйлийг хэлье.

Х.Батжаргал дарга та тоо хэлсэнгүй. Энд нийслэлийн гэдэг юм уу, хамгийн их сурах эрх нь зөрчигдөж байгаа нийслэл дээр хэчнээн сургууль, цэцэрлэг баригдах вэ гэсэн. Та юм хэлсэнгүй.

Хоёрдугаарт, Ж.Чинбүрэн сайдад би нэг зүйлийг хэлж байгаа юм. Хэлмээр санагдаж байна.

Энэ туулах чадвартай эмнэлгийн тусламж, үйлчилгээг үзүүлэх автомашины хуваарилалт дээр төрийн тусгай албан хаагчдын эмнэлгийг хамруулж өгөхийг хүсэж байна. Энэ хилчдэд үйлчилдэг. Алс бөглүү газар нутагт байгаа хилчдэд наад захын эмнэлгийн тусламж, үйлчилгээг... /минут дуусав/

Н.Учрал: Х.Батжаргал дарга нэмж хариулна.

Х.Батжаргал: Гишүүний асуултад нэмж тодруулж хариулья.

Тэгэхээр нийслэл Улаанбаатар хотод төлөвлөгдөж, урьдчилсан судалгаа хийгдэж байгаа 17 сургуулийн –

- Баянгол дүүрэгт 960 хүүхдийн хүчин чадалтай 2 сургууль,
- Сүхбаатар дүүрэгт 320 болон 640, 960 хүчин чадалтай 4 сургууль,
- Сүхбаатар дүүрэгт 3 сургууль,
- Баянзүрх дүүрэгт 640 хүүхдийн хүчин чадалтай 2, 960 хүүхдийн хүчин чадалтай нийт 4 сургууль,
- Хан-Уул дүүрэгт 4 сургууль.

Эдгээр нь мөн ээлжийн коэффициент гэж үзээд байгаа 1.8-аас 2.3-ын хооронд ийм өндөр эрсдэлтэй зайлшгүй нэн шаардлагатай авах хэмжээнд байгаа.

Гэхдээ нийслэл Улаанбаатар хотод нэг том бэрхшээл бол газрын асуудал байгаа. Хэдийгээр ингээд маш тулгамдсан... /минут дуусав/

Н.Учрал: Ж.Чинбүрэн сайд П.Сайнзориг гишүүний саналыг анхаарна биз.

Ингээд Аюушийн Ариунзаяа гишүүн асуулт асууна.

А.Ариунзаяа: Тус Азийн хөгжлийн банкны зээлийн хэлэлцээрийг зарчмын хувьд дэмжиж байгаа.

Бид тулгамдсан асуудлаа шийдвэрлэх шаардлагатай. Ялангуяа онцгой гамшиг, эрүүл мэндийн яаралтай тусламж. Энэ дотроо боловсролыг онцолж үг хэлье гэж бодлоо. Азийн хөгжлийн банкны зээлийн хэлэлцээрийн хүрээнд 32 сургууль, 9 цэцэрлэг барихаар тусгасан байгаа.

Энэ сургууль, цэцэрлэгийг барихдаа стандартыг хангуулаасай гэж хүсэж байна.

2019 оны 5 сарын 30-ны өдөр Улсын Их Хурал ерөнхий боловсролын сургуулийн Хоол үйлдвэрлэл, үйлчилгээний тухай хуулийг баталсан байдаг. Энэ хууль нь 2020 оны 9 сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө гэсэн заалттай. 2021 оны 9 сарын 01-ний өдрөөс ахлах, дунд сургуулиудыг үдийн хоолоор хангах заалт хүчин төгөлдөр эхэлнэ гэсэн тусгайлсан заалттай. Монгол Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар гэсэн гарын үсэгтэй хууль байгаа.

Монгол Улсад хамгийн хэрэгжихгүй байгаа хуулиудын нэг.

Тухайн үед Ц.Мөнх-Оргил гишүүн ахалж энэхүү хуулийг батлуулж байсан. Н.Учрал дарга маань ч гэсэн тухайн Улсын Их Хурлын гишүүн байсан.

Тэгээд 2020 оноос хойш энэ хууль батлагдсанаас хойш нийт хэдэн сургууль ашиглалтад орсон юм бол оо? Улсын төсвөөр хэчнээн сургууль барьж байгуулсан бэ? Эдгээр сургуулиудад яг энэ заагдсан үдийн хоолоор хангах стандартын гал тогоо, техник, тоног төхөөрөмж хангагдсан байсан уу, үгүй юу гэдгийг асуумаар байгаа юм.

Ер нь стандарт байдаг юм уу, байдаггүй юм уу? Энэ сургуулиудад үдийн хоолоор хангадаг байх энэ зарчмыг бий болгох, энэ хуулийг биелүүлэх, энэ орчныг бий болгоход яг хэн хариуцаж байна вэ гэдэг нь ерөөсөө тодорхой биш байна.

Барилгын хөгжлийн яам зураг төсөв, ТЭЗҮ-г нь баталж өгдөг. Тийм үү? Стандартыг нь Стандарт, хэмжил зүйн газар баталж өгдөг. Төсвийг нь тэгээд Сангийн яам барьж боодог. Боловсролын яам төсвөө оруулдаг. Улсын Их Хурлын гишүүд баталж өгдөг.

Гэтэл яг энэ хууль батлагдсанаас хойш үдийн хоолоор хангах боломжтой сургуулиуд баригдаж чадаж байна уу, үгүй юу гэдгийг л бид өнөөдөр ярих ёстой байгаа юм.

Тэгэхээр нэгэнтээ бид бүр зээл аваад, тэгээд сургуулиудыг барих гэж байгаа юм бол ядаж энэ шинээр барих сургуулиуд энэ стандартаа хангадаг байгаасай гэдгийг тусгайлж бүр энэ протоколд тусгаж хэлмээр байгаа юм.

Тэгээд яг энэ асуудлыг Засгийн газрын түвшинд яг хэн нь хариуцаж, гарын үсэг зурдаг аль газар нь хариуцах вэ гэдгийг сонирхоод байгаа юм.

Одоо жишээлбэл 2020 оноос хойш орсон сургуулиудыг орхиё. Өнөөдрөөс хойш 2026 онд баригдах сургуулиуд дээр стандартын гал тогоо байхгүй сургуулиуд ашиглалтад орох юм бол хэн хариуцлага хүлээх вэ гэдгийг асуумаар байгаа байхгүй юу. Стандартаа мөрдүүлж чадаагүй Х.Ганхуяг уу, Боловсролын яам уу? Үүнийг баталж өгсөн Улсын Их Хурлын гишүүд үү?

Тэгэхээр энэ дээр анхаарч өгөхгүй бол болохгүй. Тэгээд бас нэг асуудлыг захиж хэлмээр байгаа юм. Бид ингээд төсөл, зээл хөтөлбөр гэж хэрэгжүүлээд байна. Гэтэл мөнгөндөө маш хайнга хандаж байна. Дотоодын зөвлөх сонгон шалгаруулах тендер зарлагдаж 88 өдөр ажиллах юм байна. 48 мянган ам.долларын цалин авах юм байна. Тоглоод байгаа юм уу? Өдрийн 2 сая төгрөг. Арай биш үү.

Н.Учрал: Хэн хариулах вэ? Ажлын хэсэг. Төрийн нарийн бичгийн дарга Х.Батжаргал хариулна.

4 дүгээр микрофон.

Х.Батжаргал: А.Ариунзаяа гишүүний асуултад хариулъя. Х.Батжаргал.

Гишүүний асуусан 2020 оноос хойш нийт 273 сургууль ашиглалтад орж үйл ажиллагаа явагдаж байгаа гэсэн статистик тоо байдаг.

Өнөөдрийн бидний хэлэлцүүлж байгаа зээлийн төслийн нэг онцлог нь өмнө нь 2018 оноос хэрэгжиж эхэлсэн ковид цар тахлын үед эдийн засгийн хүндрэлийг даван туулах төсөл эхэлсэн байдаг. Тэр үеэс хоёр удаагийн санхүүжилт Азийн хөгжлийн банкны зээлээр санхүүжээд 50 сая болон 15 сая долларын санхүүжилт дээр дандаа сургууль, цэцэрлэгийн хүртээмжийг нэмэгдүүлэх чиглэлд ажиллаад одоо хоёр дахь нэмэлт нь хэлэлцүүлж байгаа.

Тэгэхээр өмнө нь Азийн хөгжлийн банкны зээлийн санхүүжилтээр баригдсан болон баригдаж байгаа сургууль, цэцэрлэгүүд яг Азийн хөгжлийн банкны өөрийн шаардлага, шалгуурын дагуу зураг төсөв нь хийгдээд хянагдаад, зөвхөн гал тогоо биш ер нь бүхий л төрлийн стандарт, тэгш хамруулах боловсрол, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан стандарт гэх мэт бүхий л шаардлагуудыг бүрэн хангаж нийцүүлж MNS болон ISO стандартын гол шаардлагыг дагуулж байгаа.

Энэ жилийн хувьд нэг онцлогт төлөвлөгдөж байгаа асуудал бол сургууль, цэцэрлэгийн барилгын стандарт өөрчлөгдөөд нэг хүүхдэд ногдох талбайн хэмжээ нэмэгдэж дагаж төсөвт өртөг нэмэгдэх нэлээн санхүүгийн хувьд хүндрэлтэй нөхцөл байдал үүссэн учраас бид Барилга, орон сууц, хот байгуулалтын

яамтайгаа зөвлөлдөж ажлын хэсэг гарч ажиллаад зарим нэгэн барилгын стандартыг нийцүүлж зураг төслийг хийхдээ анхнаас нь зөвхөн 3 давхар, 2 давхарт хязгаарлагдахгүй гээд газрынхаа нөөцийг ашиглаад 4 давхар болгох. Мөн таны сая хэлсэн онцгойлон анхаарах ёстой хүүхдийн хоолны үйлчилгээнд зориулан тусгайлсан стандартыг бүрэн хангуулах арга хэмжээг зураг төсөл дээрээ анхаарч ажиллаж байгаа.

Азийн хөгжлийн банкны үнэлгээ давхар хийгддэг учраас энэ том түлхэц болж байгаа гэж хэлэх байна.

Н.Учрал: Хариулт болсон уу? А.Ариунзаяа гишүүн тодруулъя.

А.Ариунзаяа: Х.Ганхуяг сайд ороод ирсэн байна.

Х.Ганхуяг сайд Төсвийн Байнгын хорооны дарга байхдаа улаан, ногоон лааз өргөж байгаад 168 шинэ төсөл, хөтөлбөр оруулсан уу? Тэгээд тэр дотор маш олон сургуулиуд байгаа.

Тэдгээрийг одоо улсын төсвөөр нэгэнтээ барьж байгаа юм чинь яг энэ гал тогооны асуудлыг стандартынх нь дагуу барьж заавал оруулах тал дээр анхаарч өгөхийг хүсье.

Тэгэх юм бол тэр лаазны асуудлыг би дахиж ярихгүй. Стандартаа шинэчилъе. Яг энэ үдийн хоолны асуудлыг шийдвэрлэе.

2019 онд баталсан хууль одоо хүртэл хэрэгжихгүй байна.

Тэгээд магадгүй Улсын Их Хурлын дарга Н.Учрал хуультай холбоотой хэрэгжилтийг нь нэгэнтээ 5 жил болсон юм чинь 5 жилийн дараа тухайн хуулийн хэрэгжилтийг дүгнэх, үнэлгээ хийх хжлын хэсэг байгуулах хэрэгтэй болох байх.

Миний хувьд энэ ажлын хэсгийг ахалж ажиллаж болж байна. Тэгээд дэмжлэг үзүүлээд хүүхдүүдийнхээ төлөө анхаарсан нь зүйтэй байх гэсэн саналтай байна. Тийм. Ийм саналтай байна.

Н.Учрал: Санал хэллээ. Жанчивын Галбадрах гишүүн асуулт асууна.

Ж.Галбадрах: Та бүхэнд өдрийн мэнд хүргэе.

Энэ маш чухал зээл байгаа юм. Энэ зээлийг дэмжиж байгаа. Энэ зээл маань улсын төсөв өргөн баригдаж байх үед яригдаад тэгээд үүнийг богино хугацаанд оруулаад ирж байгаа явдалд Сангийн яаманд би талархаж байгаа. Сангийн яамныхан энэ дээр ажилласан.

Бид ирэх 2026 оныг “Боловсролыг дэмжих жил” болгосон. Дэмжих жил болгож байгаагийн учир шалтгаан ерөөсөө л даац ачаалал хэтрээд байгаа сургуулиуд. 40, 50, 60-аараа суугаад байгаа.

Уг нь норм, нормативаараа 35 хүртэл байдаг. 30 хүртэл байдаг. Тэгтэл энэ маань ингээд 40 давсан 214 мянган хүүхэд сургуульд сурч байгаа. Энэ 214 мянган хүүхдийн эрх зөрчигдөөд байгаа. Чанартай боловсрол олж авах эрх нь зөрчигдөөд байгаа учраас бид судалгаа хийгээд 108 сургууль, 95 цэцэрлэгийг бай ярих ёстой гэдэг тооцоог гаргасан.

Үүнийг хийж чадах юм бол 2028 онд бид нэг бүлэгт байх хүүхдийн тоог улс даяар 40-өөс доош оруулна. 40-өөс доош оруулсан үед бид сургалтын чанар ярьж болно. Ингээд бид чанартай боловсрол олгож чадна гэдэг үүднээс гаргасан.

Тэгээд жагсаалт гаргасан. 108 сургуулийн. Тэгээд 108 сургуулийн жагсаалт маань яриад байгаа ээлжийн коэффициенттой нь уялдуулаад, нэг ангид байгаа хүүхдийн тоотой нь уялдуулаад гаргасан.

Одоо ингээд Азийн хөгжлийн банкны зээлээр 41 төсөл, хөтөлбөр. Энэ дотроо 32 сургууль гээд үзэхэд эхний 32 дотор ерөөсөө орон нутгийн сургууль 2 л байгаа юм. Өөрөөр хэлбэл дийлэнх нь Улаанбаатар хотод. 90 гаруй хувь нь Улаанбаатар хотод байна гэсэн үг.

Тэгэхээр Улаанбаатар хотыг энд түлхүү оруулъя гээд бид бүхэн, сая П.Сайнзориг гишүүн хэллээ. Г.Лувсанжамц гишүүн байнга ярьж байгаа.

Бид нийслэлтэй яриад хаана, аль сургуулийн хажууд ачаалал нь ихдээд байгаа. Тэр 114 дүгээр сургууль гэхэд 6 мянга гарсан. Тэнд хажууд нь 2 сургууль шинээр барьж байж бидний яриад байгаа нөхцөлд орох юм гээд жагсаалтыг нь гаргаад өгсөн юм.

Тэгээд энэ тал дээр ерөөсөө манай Боловсролын яам хангалтгүй ажиллаж байна. Бид уг нь маш олон уулзсан. Нийслэлтэйгээ ярьсан. Нийслэл газрыг нь гаргая. Газар чөлөөлүүлэхэд тодорхой төсөв тавиад ороод ирсэн байгаа.

Тэгээд бид дээрээсээ эрэмбэлээд гаргаад ирсэн юм бол эрэмбийнхээ дагуу л явах нь ерөөсөө чухал. Бид нарт тооцоо судалгаа, эрэмбэлсэн юман дээр явах ёстой. Тэгэхээр энэ тал алдагдсан байна.

Тэгэхээр энд 17 сургууль яриад байна. Бид ядаж 32-ынхоо 22-ыг нийслэлд барья гэдэг саналыг өмнө нь тавиад л явсан. Тэгээд одоо яг энэ жагсаалт нь гараад ирэхээр 17 болсон байна. Үүнийг нэгдүгээрт хэлэх гэсэн юм.

Хоёрдугаарт, сургууль баригдана, цэцэрлэг баригдана гэж байгаа бол бэлтгэлээ хэр хангаж байгаа вэ гэдгийг асууя.

Өөрөөр хэлбэл газрыг нь чөлөөлүүлэх гэдэг асуудал. Зургаа зуруулсан уу? Сая А.Ариунзаяа гишүүний яриад байгаа шиг тэр гал тогооноос эхлээд, урлагийн заалнаас эхлээд, спорт заалнаас эхлээд хүүхдийнхээ багтаамжид тохирсон тэр зургаа зуруулсан уу? Техникийн нөхцөлүүд. Дулаан, цахилгааны нөхцөлүүдээсээ эхлээд авсан уу?

Өөр нэг том асуудал нь багшаа бэлдсэн үү гэдэг асуудал байгаа. Бид нийслэлд сургуулиуд шинээр баригдлаа. Тэгээд багш маш их дутагдалтай байгаа. Багш бэлдэх тал дээрээ хэр байна? Тэгээд сургууль баригдахад дагаад тоног төхөөрөмж, ширээ сандлын асуудал гарч ирдэг. Энэ асуудлууд нь энэ 41 төсөл, хөтөлбөрт тоног төхөөрөмж нь орж байгаа юу? Мэдээж багшийг би илтгэх асуудал тусдаа яригдаж байгаа байх.

Тэгэхээр бид зорьсон зорилготой юманд хүрнэ үү гэхээс биш тэр аймгуудаар, орон нутгуудаар барих. Энд улсын төсөвт нэлээн сайн суусан байгаа. Энэ үргэлжилж баригдах төсөл, хөтөлбөрүүд. Ийм асуултуудыг асууя. Тэгээд нэмэлт... /минут дуусав/

Н.Учрал: Х.Батжаргал дарга хариулъя. 4 дүгээр микрофон.

Х.Батжаргал: Гишүүний асуултад хариулъя. Х.Батжаргал. Боловсролын яам

Тэгэхээр бид хамтран боловсруулж, хамтарч ажилласан 108 сургууль, 95 цэцэрлэг төсвийн хэлэлцүүлгийн үеэр зэрэгцээд ерөнхий хэлэлцээр явж байх үед Улсын Их Хурлын гишүүдийн санал гараад энэ дээр бодитой судалгаа хийж дахиж судалгааны жагсаалтыг өөрчлөх, нэмэгдүүлэх шаардлагатай байна гэж үзээд зарим нэгэн орон нутгийн байршлууд дээр судалгаа хийж, Азийн хөгжлийн банктэй ч гэсэн хамтарч хийгдсэн байгаа.

Тэгэхээр энэ судалгаа хийгдэхдээ бид өмнө нь нэг зүйлийг шалгууртаа оруулаагүй байсан нь орон нутагт, ялангуяа ээлжийн коэффициент нь, бүлэг дүүргэлт нь стандарт боломжийн түвшинд байгаа мөртлөө мэргэжлийн байгууллагуудын дүгнэлт гараад, баригдаад 60 жил болсон, 70 жил болсон, эрсдэл аюул учруулж болохуйц сургуулиуд сүүлийн жилүүдэд олноор бий болсон. Орон нутгуудад.

Тэдгээрт нэн тулгамдсан зарим сургуулиудыг оруулсан өөрчлөлтүүд орсон байгаа. Урьдчилсан судалгаа үргэлжлээд хийгдээд явж байгаа.

Бэлэн байдал хангах тухайд аль болох хүртээмжийг тоогоо нэмэгдүүлэх үүднээс ажлын хэсэг дээрээ ярилцаад улсын төсвийн хөрөнгө оруулалтаар дотор байрлах тоног төхөөрөмж, сургалт, сурагчийн сандал ширээ, компьютер гэх мэт

тоног төхөөрөмжийг улсын төсвөөс үе шаттайгаар төслийнхөө хэрэгжилттэй уялдуулаад суурилагаар төлөвлөж байгаа.

Багшийн тухайд хөдөлмөрийн зах зээл дээр 20 мянга гаруй багш боловсролын салбараас өөр салбарт ажиллаж байгаа.

Тэгэхээр эдгээр багш нарынхаа эргэж мэргэжлийнхээ ажлыг хийх боломж бололцоо, хөшүүргүүдийг бий болгох, үе шаттайгаар хэрэгжилтийг хангах, мөн түүнчлэн Боловсролын зээлийн сангийн дэмжлэгтэйгээр суралцаж байгаа жил болгон 4 мянган сурагчид, оюутнууд багш мэргэжлээр төгсөж хатуу гэрээ хийсэн байгаа. Хатуу гэрээ гэдэг нь багш мэргэжлээрээ ажиллах.

Ингээд боловсон хүчин, хүний нөөцийн тухайд баригдаж байгаа шинэ сургууль, цэцэрлэгийн байгууламж дээр үндсэндээ мянга сурагч тутамд 81 багш ажилчид, албан хаагчид байх хувьсах зардлыг улсын төсөв дээр тооцож жил болгон хүүхдийн тооныхоо өсөлт болон хэрэгцээ шаардлагатай уялдуулж хувьсах зардлаар дамжуулж бэлэн байдлыг хангаж явахаар төлөвлөж байгаа.

Н.Учрал: Ж.Галбадрах гишүүн тодруулна.

Ж.Галбадрах: Тийм. Бид яриад яваад байдаг зүйлүүд маань л яригдаад яваад байна.

Одоо 2026 он “Боловсролыг дэмжих жил” гарахад долоохон хоног үлдсэн байна.

Одоо бид яг энэ дээр хүртээмжийн дэд ажлын хэсэг гаргаад. Үүнийг бид нэлээн ярьсан. Энэ асуудлууд маань үнэхээр зогсонги байдалтай байна. Та бүхэн боловсролын жилтэй уялдуулаад –

- хүртээмжийн ажлын хэсэг хэр ажиллаж байна?
- Ямар зорилго, зорилтуудаа тавив?
- Төлөвлөлт цаашаа хэр яригдаж байна?

Энэ ажлын хэсгүүд хуралдахгүй болоод байна шүү дээ. Энэ тал дээр мэдээлэл өгөөч ээ гэж хүсэж байна.

Цаашдаа нийслэлтэйгээ сайн хамтарч ажиллаж, нийслэлийн гаргаж ирж байгаа. Түрүүн газрын асуудал хүндрэлтэй биш, газрын асуудал нийслэл шийддэг юман дээр хамтраад яам явах. Сангийн яам бас их дэмжиж байгаа.

Тэгэхээр гурван тал дээрээ сайн ажиллах шаардлагатай байна.

Н.Учрал: Санал хэллээ. Ганзоригийн Лувсанжамц гишүүн асуулт асууна.

Г.Лувсанжамц: Өдрийн мэнд хүргэе.

Зарчмын хувьд Азийн хөгжлийн банкны зээлийг дэмжиж байна. Улсын төсвөөрөө зам бариад байдаг, тэгээд сургууль, цэцэрлэг барих болохоор мөнгө гуйгаад явдаг, зээлээд явдаг. Аргаа барсан л арга юм болов уу даа. Гэхдээ тэгээд авахаас өөр аргагүй болох байх.

Хот төлөвлөлтийн инженерийн хувьд, архитектор хүний хувьд Боловсролын яамны ажлыг ямагт дэмжиж ажиллаж байгаа.

Гэхдээ 9 сард Эдийн засгийн байнгын хороон дээр үүнийг хэлэлцэж байхад хэлсэн. Хуваарилалт нь шог байна.

- ✦ Нийслэлийн 5 дүүрэгт 17 сургууль,
- ✦ Налайхад 1 цэцэрлэг,
- ✦ Орон нутагт 15 сургууль, 8 цэцэрлэг –

барихаар танилцуулгад туссан байна.

Энэ жагсаалтыг шинэчлэх үү?

9 сард П.Наранбаяр сайдад уг нь үүнийг хэлээд Ж.Галбадрах гишүүн ч гэсэн бүх тооцоог нь гаргаж өгсөн.

- ▶ Нийслэлтэй цуг ажиллаад хотын дарга, хоёрдугаар орлогч даргатай яриад газар чөлөөлөх зардлыг нь ирэх оны төсөв дээр суулгалаа.
- ▶ Хаана, ямар байршилд сургууль, цэцэрлэг хэрэгтэй юм гээд бүгдийг нь хороогоор нь гаргаж өглөө.

Тэгээд эд нар ер нь хаана хэрэгцээ их байна, тэнд сургууль, цэцэрлэгээ барих ёстой шүү дээ.

Ж.Галбадрах гишүүн сая хэллээ. Орон нутагт одоогийн байдлаар хэцүү нөхцөлтэй байгаа 2 л сургууль байна. Тэд орон нутагтаа аваачаад 15 сургууль тавьчихаж байгаа юм. Нийслэл ачаалал нь хэтрээд байна шүү дээ. Энд.

- Нийт 108 сургууль хэрэгтэй.
— Үүний 84 нь нийслэлд хэрэгтэй байна.
- Нийт 95 цэцэрлэг хэрэгтэй.
— Үүний 39 нь нийслэлд хэрэгтэй байна.

Хэрэгцээндээ нийцүүлж бид энэ төсөв, төлөвлөгөөгөө хийж явах хэрэгтэй байгаа.

Хот төлөвлөлтийн стандартын дагуу хэрвээ бид үүнийгээ хийх юм бол одоо энэ 41 сургууль, цэцэрлэгийн барилгыг –

- нийслэлд 29,
- орон нутагт 12 болгож хуваарилах хэрэгтэй байна.

Хот төлөвлөлтийн стандартын дагуу.

Өнөөдөр нийслэлд ачаалал нь хоёр дахин хэтэрсэн сургуулиудад нийт 214 мянган хүүхэд сурч байгаа байхгүй юу. Нэг ангидаа шахцалдаад 50, 60, 70-уулаа суугаад, нэг ширээн дээр гурвуулаа зэрэгцээд сууж байна шүү дээ. Ийм нөхцөлд бид ямар ч боловсролын чанар ярих боломж нөхцөл байхгүй.

Багш нарын ачааллыг хараарай. Нийслэлд ажиллаж байгаа багш нарын ачаалал хүнд байгаа. Хамгийн эхнээс нь ачааллуудыг нь хэлж өгье дөө.

- ▶ Хан-Уул дүүргийн 7 дугаар сургууль 350 хүүхдийн суудалтай.
— 2200 хүүхэд сурч байна.
- ▶ Сонгинохайрхан дүүргийн 154 дүгээр сургууль 740 хүүхдийн суудалтай.
— 3273 хүүхэд сурч байна.
- ▶ Баянгол дүүргийн “Оюуны Ундраа” сургууль 1200 хүүхдийн суудалтай.
— 5000 хүүхэд сурч байна.
- ▶ Баянзүрх дүүргийн 133 дугаар сургууль 640 хүүхдийн суудалтай.
— 2600 хүүхэд сурч байна.
- ▶ Сонгинохайрхан дүүргийн 134 дүгээр сургууль 180 хүүхдийн суудалтай.
— 724 хүүхэд сурч байна.
- ▶ Хан-Уул дүүргийн 130 дугаар сургууль 920 хүүхдийн суудалтай.
— 3650 хүүхэд сурч байгаа юм.

Хэрэгцээндээ нийцүүлж байна гэдэг зүйлийг П.Наранбаяр сайд хэлсэн. Гэхдээ нийцэхгүй байна. Ямар дата дээр үндэслээд байгаа юм. Энэ жагсаалтыг шинэчлэх үү, үгүй юу? Одоо энэ чигээрээ бид батлаад өгөөд явуулдаг. Дахиад л орон нутагт илүүдэл гараад л нийслэлийн хүүхдүүд бүгдээрээ шахцалдаад суудаг.

Нийслэлд татвар төлж байгаа аав, ээж нар хүүхдэдээ чанартай боловсрол олгоё л гэж явж байгаа. Мөнгө нь илүүдээ гарсандаа хувийн сургуульд хүүхдээ явуулж байгаа хүн байхгүй байх.

Яалт ч үгүй сургууль, цэцэрлэг нь байхгүй учраас л хувийн сургууль руу, хувийн цэцэрлэгт хүүхдээ өгч байна шүү дээ. Энэ асуудлуудыг яаж шийдэх юм бэ гэдэг. Энэ жагсаалтыг шинэчлэх юм уу, үгүй юм уу? Саналаа сайдад өгсөн. Тэрийг л тодорхой хэлээд өг гэж хүсэж байна.

Н.Учрал: Х.Батжаргал Төрийн нарийн бичгийн дарга. 4 дүгээр микрофон хариулна.

Х.Батжаргал: Гишүүний асуултад хариулъя. Х.Батжаргал.

Төсвийн хэлэлцүүлгийн үеэр зээлийн ерөнхий хэлэлцээр хэлэлцэгдэж байх явцад Г.Лувсанжамц гишүүний саналын дагуу бид Азийн хөгжлийн банкнаас зөвлөхүүд үнэлгээ хийгээд тухайлан урьдчилсан байршлууд дээр ажиллаад байгаа.

Энэ бол эцсийн хувилбар биш. Энэ зөвхөн урьдчилсан судалгаа хийгдэж байгаа хувилбарууд дээр л явж байгаа. Үүнээс гадна орон нутгийн болоод улсын төсөв батлагдсанаас хойш тодорхой хэмжээний өөрчлөлтүүд гарсан. Жишээлэх юм бол нийслэл Улаанбаатар хот өөрийн төсвөөрөө 9 сургууль, 9 цэцэрлэг барьж байгаа.

Өнөөдрийн байдлаар хамгийн чухал асуудал газар чөлөөлөлт, бэлэн байдлын асуудал байгаа.

Тэгэхээр бэлэн газартай 34 байршил, бэлэн биш 7 байршил. Тэгээд сүүлийн үед зураг төслийн асуудал нь үе шаттайгаар хийгдэж байгаа. Нэг онцлог нь Азийн хөгжлийн банкны төслийн санхүүжилтээр өөрөө зураг төслөө хийгээд, хяналтаа тавиад зураг төслийг нийцүүлээд явж байгаа.

Дээр нь гишүүний өмнөх хэлэлцүүлгийн үеэр ярьж байсан дулааны алдагдал багатай ногоон эрчим хүчний хэмнэлттэй загварчлалыг тодорхой хэмжээний нэмэлт зардал гарч таарна. Тэрийг олон улсын байгууллагуудын туслалцаатайгаар нэмэлт санхүүжилтээр нөхөж оролцуулж хамтран ажиллах, энэ хэлэлцүүлгийн явцад үйл ажиллагаа явагдаж байгаа.

Тэгэхээр эцэст нь энэ урьдчилсан судалгааны жагсаалтад өөрчлөлт орж таарна. Азийн хөгжлийн банк өөрийнхөө тавьдаг шаардлага, шалгуур үзүүлэлтийн дагуу зөвлөхүүдийн баг бүс болгон дээр ажиллаж байгаа.

Мөн зэрэгцээд Улсын Их Хурлын гишүүд нь мөн ялгаагүй ялангуяа орон нутгаас сонгогдсон гишүүд хүчтэй шаардлага тавьж, бид тэр саналын дагуу мөн адилхан яг нарийвчилсан газар дээр нь гаднын зөвлөхүүдтэйгээ хамт зэрэгцээд ажиллаж байгаа.

Хамгийн тулгамдаж байгаа асуудал зээлийн санхүүжилт маань өөрөө тогтмол тоо нэмэгдүүлж чадахгүй. Болдогсон бид бүх тулгамдаж байгаа байршлуудаа баталгаажуулаад авбал боломжууд бүрдэхээр байгаа. Харамсалтай нь яг энэ тогтмол нөөцдөө шаардлагатай хэрэгцээгээ хангах гээд тал талд бүхий л судалгаагаа зэрэгцүүлээд хийж байгаа.

Улаанбаатар хотод яах аргагүй хамгийн ачаалал өндөр. Хамгийн их тулгамдсан асуудалтай. Ганцхан тулгамдаж байгаа гол асуудал нэгдүгээрт газрын асуудал байгаа. Газар чөлөөлөлт хийгдсэн ч гэсэн Азийн хөгжлийн банкны бас нэг том тулгамдаж байгаа бэрхшээл үүсгэж байгаа, сорилт болж байгаа асуудал газар чөлөөлсөн. Газар чөлөөлөгдсөн байршил дээр эргээд ямар нэгэн гомдол маргаан нөгөө газраа чөлөөлүүлсэн иргэд, аж ахуйн нэгжийн сэтгэл ханамж ямар байдаг вэ гэдгийг тухайлан удирдамжийн дагуу судалдаг юм билээ.

Тэгэхээр тэр сэтгэл ханамжид 100 хувь байсан нөхцөлд бас энэ байршил дээр төслийн санхүүжилтээр төсөл хэрэгжих бэлэн байдал хангагдана гэж үздэг.

Тэгэхээр үүнийг хугацаа орохоор байгаа. Тэгээд газрын асуудлыг бүрэн шийдэгдсэн Улаанбаатар хотын төслүүдийг... /минут дуусав/

Н.Учрал: Г.Лувсанжамц гишүүн тодруулна.

Г.Лувсанжамц: Баярлалаа.

Судалгаан дээр үндэслээд, яг хэрэгцээн дээр нийцүүлээд энэ жагсаалтыг шинэчилнэ гэж Та хариуллаа.

Хэдүүлээ тоо худлаа ярихгүй учраас тоогоо харж байгаад л хэдүүлээ хийцгээе. Газар чөлөөлөлт дээр та санаа зовох зүйлгүй. Хотын дарга Х.Нямбаатар болон хоёрдугаар орлогч н.Амартүвшин даргатай яриад нийслэлд ирэх 2026 онд 350.0 тэрбум төгрөгөөр газар чөлөөлөлтийн төсвийг суулгасан байгаа. Таны хэлж байгаа энэ 34 сургуулийг барих байршлыг нь бүгдийг нь тодорхой болгож өгсөн. Нийслэл өөрөө 9-ийг нь барьж чадна гэж байгаа. Үлдсэн 25-ыг нь улсын төсвөөр хийх хэрэгтэй байна.

Улсын төсөв дээр хоёр л байгаа байх. Тийм ээ.

Тэгэхээр нэмээд бид ядаж 23 сургуулийг Азийн хөгжлийн банкны зээлийн хэлэлцээрээр нийслэлд барих хэрэгтэй байна. Тэгж байж бид чанартай боловсрол ярих боломж нь бүрдэнэ.

Тэгэхээр Та нийслэлтэй энэ газар чөлөөлөлтийн асуудлаар уулзсан уулзсан уу? Танай яамнаас.

Н.Учрал: Х.Батжаргал дарга хариулна.

Х.Батжаргал: Нийслэлийн боловсролын газар, нийслэлийн ажил хариуцсан чиглэл, чиг үүргийнхээ дагуу ажил хариуцаж байгаа албан хаагчидтай байнгын уулзаж хамтарсан ажлын хэсэг ч гарсан.

Энэ боловсруулалтын явцад ажилласан байгаа. Ялангуяа байршил тогтоох газар чөлөөлөлтийнхөө уялдаа холбоог –

- альныг нь орон нутгийн төсвөөр,
- альныг нь улсын төсвөөр,
- альныг нь зээлийн санхүүжилтээр хийгдэх вэ –

гэдэг дээр нягт хамтын ажиллагаатай байгаа гэдгийг хэлье.

Н.Учрал: Г.Лувсанжамц гишүүн тодруулна.

Г.Лувсанжамц: Ажил хэрэгч ажиллаж байгаа юм байна.

Х.Батжаргал даргад баярлалаа. Амжилт хүсье.

Боломж бололцоогоор байгаад Боловсролын яамны бүх ажлыг л дэмжээд явж байгаа.

Нэг зүйлийг сануулж хэлмээр байна. Өчигдөр Боловсролын яамны Х.Тамир даргатай уулзсан. НҮБ-ын Хүүхдийн сантай яриад энэ 41 сургууль, цэцэрлэгийн 5-ыг нь эрчим хүчний хэмнэлттэй ногоон барилга болгоё. 1 сургууль дээр 1 сая доллар тавьж өгье. 5 сая долларын хэлэлцээрийг хийгээд сайдыг холбож өгсөн. Та холбогдсон байгаа байх. Тийм ээ. Үүнийгээ зэрэгцүүлээд хэлэлцээрээ. Шуурхай яваад. Ядаж 5-ыг нь бид өрөө тасалгаандаа цэвэрхэн агаар амьсгалж болдог, олон улсын стандартад нийцсэн ийм сургууль болгоод явъя гэж байгаа.

Тэгээд цаашдаа та хамгийн сайн мэдэж байгаа байх. Урсгал зардлын 80 хувь нь уурын зуухан дээр нүүрс шатаагаад яваад байдаг юм шүү дээ. Түүнийгээ хэдүүлээ хэмнэх том боломж гэж харж байгаа шүү. Тэгээд энэ дээр өндөр анхаарал өгч ажиллаасай гэж хүсэж байна.

Н.Учрал: Маш чухал санал хэллээ шүү. Х.Батжаргал дарга анхаарах хэрэгтэй.

Энхбатын Болормаа гишүүн асуулт асууна.

Э.Болормаа: Азийн хөгжлийн банкны санхүүжилтийн ерөнхий хөтөлбөрийг дэмжиж байгаа.

Би дэмжиж байгаа шалтгаанаа өнөөдөр олон нийтэд яригдаж байгаа Оюу Толгой төсөлтэй харьцуулж хэд хэдэн үзүүлэлтийг энд хэлье гэж бодож байна.

Азийн хөгжлийн банкны нийт бид 475.0 сая ам.долларын эх үүсвэрийг ярьж байгаа. Үүний тал хувь нь буюу 243.8 сая нь хөнгөлөлттэй эх үүсвэр буюу 2 хувийн хүүтэй. Тогтмол 2 хувийн хүүтэй. Үлдсэн нь энгийн нөхцөлтэй эх үүсвэр буюу **SOFR** (Secured Overnight Financing Rate) дээр нэмэх нь 0.6 хувь.

Өнөөдрийн байдлаар сүүлийн 90 хоногийн дунджаар бодох юм бол энэ нийтдээ 4.6 хувь гэсэн үг.

Гэтэл Оюу Толгой төсөл маань SOFR дээр нэмэх нь 6.5 хувь.

Мэдээж хөгжлийн түнш болон зах зээлийн зээл хоёр тусдаа гэж нэг талаас хэлэх боловч нэг зүйлийг онцлон хэлэхэд Оюу Толгой төсөл өөрөө хөгжлийн түншүүдээс нийтдээ 2015 оны 4.4 тэрбум долларын хөрөнгө босгохдоо үүнд Дэлхийн Банк, EBRD.

Дэлхийн банкны тэр дундаа **IFC MEGA 2** (Managed Co-Lending Portfolio Program) энд оролцсон.

Би өөрөө Дэлхийн банканд ажиллаж байсан. Дэлхийн банкны аль ч байгууллагын төслийн үндсэн шалгуур нь энэ байгууллагын эрхэм зорилго болох “хэт ядуурлыг эцэслэх”, мөн “хүртээмжтэй өсөлтийг дэмжиж байгаа юу” гэдэг. Энэ шалгуураар орох ёстой байдаг.

Тэгэхээр өнөөдөр Монгол улсад яригдаж байгаа Оюу Толгойн асуудал зөвхөн Монгол Улс, “Рио Тинто” хоёрын хоорондох асуудал биш ээ. Үүнд санхүүжилтээр оролцсон бүх хөгжлийн түншүүдэд холбоотой асуудал.

Энэ өнөөдөр яригдаж байгаа Азийн хөгжлийн банкны зээл бол одоо нөгөө Оюу Толгойн жишээлбэл Рио Тинтогийн тэр нэг болхи хүүгээс хүү боддог аргаар биш. Нийлмэл хүн арга гэдэг. Тийм ээ. Яг л үндсэн төлбөр дээрээ саяын хэлсэн 2 хувь байна уу, 4.6 хувийн хүү нь бодогдоод явдаг.

Өнөөдөр бид хэлэлцэж байгаа энэ зүйл бол энэ 4 төслийн ТЭЗҮ-г нь баталсан байгаа байхгүй юу. Өнөөдрийн ийм түвшинд finance paramount ирнэ гэдэг бол аль хэдийн энэ 4 төслийнхөө ТЭЗҮ-ээ батлаад тэгээд бид эцэстээ нөгөө хувь нийлүүлэгчдийн гэрээ гэдэг шиг энэ санхүүгийн асуудлаа эцэслээд баталж байна л гэсэн үг.

Тэгэхээр бид энэ төслүүдээ харьцуулж харах ёстой. Өнөөдөр зарим гишүүд маань жишээлбэл гаднаас зээл аваад байдаг. Болж байна уу гэдэг зөв талаас нь ярьж байгаа боловч үүнийгээ бодитой бид харьцуулж авч үзэх ёстой шүү.

Нэг талд энэ болхи аргаар, нөгөө нийлмэл хүүгийн аргаар SOFR дээр нэмэх нь 6.5-аар бид зээл явж байдаг. Үүнд бас энэ олон улсын хөгжлийн түнш байгууллагууд оролцсон. Би үүнийг өнөөдөр яагаад онцлон Улсын Их Хурлын танхимд хэлж байна вэ гэхээр Оюу Толгой төсөлд оролцсон EBRD, IFC MEGA, бусад мөн санхүүгийн байгууллагад энэ сонсгол болоод Улсын Их Хурлаас гарах тогтоол хамаатай зүйл юм шүү.

Тэгэхээр үүнийг онцолж анхаараарай. Ийм харьцуулсан үзүүлэлттэй байгаа учир өнөөдрийн энэ орж ирж байгаа санхүүжилтийн ерөнхий хөтөлбөрийг Азийн хөгжлийн банк, Монгол Улс хоорондын санхүүжилтийн ерөнхий хөтөлбөрийг дэмжиж байгаагаа илэрхийлье.

Н.Учрал: Энхбатын Э.Болормаа гишүүн санал хэллээ. Гишүүд асуулт асууж, хариулт авч, үг хэлж дууслаа.

Санал хураалтыг нэгтгэж явуулна. Гишүүдийг танхимд урья.

Дараагийн асуудалд оръё.

Дөрөв. “Засгийн газарт чиглэл өгөх тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл

“Засгийн газарт чиглэл өгөх тухай” Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэнэ.

Тэгэхээр Та бүхэн мэдэж байгаа. Аливаа улс эдийн засгаа төрөлжүүлж, гадаадын хөрөнгө оруулалт татахын цаад гол зорилго бол улсынхаа хараат байдлыг багасгаж, эдийн засгийн дархлааг бэхжүүлэх явдал байдаг.

Гэтэл манай улсад жил бүр ойролцоогоор –

- 200 сая ам.долларыг эрчим хүч импортлоход,
- 2.2 тэрбум ам.долларыг шатахуун импортлоход зарцуулж байна.

Энэ хэмжээний валютыг гадагшаа урсгаж байгаа атлаа хэзээ ч тасалдал, хомсдолд орох эрсдэлтэй хэвээр байгаа тул бид анхаарлаа хандуулах шаардлагатай.

Тийм учраас газрын тосны бүтээгдэхүүний хамаарлыг бууруулах зорилгоор эрчим хүчний найдвартай байдлыг хангах, өрхийн болон орон нутгийн цахилгаан хангамжийн хүртээмжийг нэмэгдүүлэх хүрээнд ногоон эрчим хүчний бодлогыг хэрэгжүүлэх хүрээнд “Засгийн газарт чиглэл өгөх тухай” тогтоолыг Эдийн засгийн байнгын хороо баталсан.

Ингээд Их Хурлын тогтоолын төслийг өнөөдөр Их Хурал батална.

Энэ хүрээнд өрхийн эрчим хүчний хэрэглээг дэмжих “100 мянган нарны гэр” хөтөлбөр, мөн цахилгаан тээврийн хэрэгслийн цэнэглэх дэд бүтцийг 100 байршилд хөгжүүлэх чиглэлээр 20 киловатт хүртэл хүчин чадалтай нарны панел, баттерны системийг техникийн нөхцөл шаардахгүй нэг стандартад нийцүүлж, түгээх сүлжээнд шууд холбох, мөн “**Carbon credit**”-ийн хэлэлцээрүүдийг амилуулах чиглэлээр “Засгийн газарт чиглэл өгөх” тогтоолыг Эдийн засгийн байнгын хорооноос Та бүхэнд өнөөдөр танилцуулж байна.

Энэ хүрээнд төслийн талаарх Эдийн засгийн байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Мөнхчулууны Энхцэцэг танилцуулна.

Индэрт урья.

М.Энхцэцэг: Улсын Их Хурлын дарга, Эрхэм гишүүд ээ,

Монгол Улсыг 2026-2030 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл батлах тухай Улсын Их Хурлын тогтоол батлагдсантай холбогдуулан “Засгийн газарт чиглэл өгөх тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэх асуудлыг Эдийн засгийн байнгын хороо 2025 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн хуралдаанаараа хэлэлцлээ.

“Засгийн газарт чиглэл өгөх тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг Монгол Улсыг 2026-2030 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл болон Монгол Улсыг 2026-2030 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөрт туссан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэх, ногоон эдийн засгийг дэмжих ногоон төслүүдийг хэрэгжүүлэх хүрээнд боловсруулжээ.

Тогтоолын төслийн хүрээнд ногоон эдийн засгийг дэмжих, ногоон төслийг хэрэгжүүлэх, сэргээгдэх эрчим хүчний тархмал эх үүсвэрийг хөгжүүлэх замаар эрчим хүчний болон газрын тосны импортын хараат байдлыг бууруулж, үндэсний эрчим хүчний аюулгүй байдлыг бэхжүүлэх чиглэлээр холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг төлөвлөжээ.

Эдийн засгийн байнгын хорооны хуралдаанаар тогтоолын төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Г.Очирбат айл өрх болон албан байгууллагуудад сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэр суурилуулахад төрийн байгууллагаас олон тооны зөвшөөрөл авч, шат дамжлага дамжиж, хугацаа алддаг байдлыг хэрхэн сайжруулах талаар асуулт асууж, хариулт авлаа.

- Улсын Их Хурлын гишүүн Г.Лувсанжамц тогтоол хэрэгжсэнээр төрийн байгууллагаас олгодог олон тооны зөвшөөрөл, техникийн нөхцөл шаарддаг шат дамжлага багасаж, айл өрх болон албан байгууллагууд сэргээгдэх эрчим хүчний тархмал эх үүсвэрийг нэвтрүүлснээр төрийн

эрчим хүчний системээс үл хамаарсан бие даасан эх үүсвэрээр хангагдах ач холбогдолтой талаар, мөн өөрсдийн эрчим хүчний эх үүсвэрээ шийдэхээс гадна илүүдэл эрчим хүчээ төвийн эрчим хүчний системд нийлүүлж ашиг олох боломжтой талаар,

- Улсын Их Хурлын гишүүн Г.Дамдинням энэ тогтоолоор одоо тулгамдаж байгаа газрын тосны импортын хараат байдлыг бууруулах, үндэсний эрчим хүчний аюулгүй байдлыг бэхжүүлэх чухал ач холбогдолтой талаар,
- Улсын Их Хурлын гишүүн Ч.Анар сэргээгдэх эрчим хүчний тархмал эх үүсвэрийг нэмэгдүүлэх замаар төвийн эрчим хүчний системийн доголдол, дамжуулах сүлжээний алдагдлыг богино хугацаанд шийдвэрлэх боломжтойг дурдаад, шинэ технологи, шийдлийг нэвтрүүлэхэд санаатайгаар хүнд суртал гаргадаг, ашиг сонирхлын зөрчил үүсгэдэг нэгдмэл ашиг сонирхолтой хамаарал бүхий этгээдүүд нөлөөлдөг байдлыг анхаарах талаар,
- Улсын Их Хурлын гишүүн Р.Сэддорж иргэд, аж ахуйн нэгж, албан байгууллагууд сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэрээр өөрсдийн хэрэглээгээ хангах боломжийг бүрдүүлэхэд онцгойлон анхаарч, төрөөс зохих санхүүгийн дэмжлэг, татаас, хөнгөлөлт үзүүлэх нь зохистой талаар тус тус санал хэлсэн болно.

Байнгын хорооны хуралдаанаар тогтоолын төслийг чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэхийг дэмжих эсэх талаар санал хураалт явуулахад 63.6 хувийн саналаар хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

“Засгийн газарт чиглэл өгөх тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцсэн талаарх Эдийн засгийн байнгын хорооны санал, дүгнэлт тогтоолын төслийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг Та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Эдийн засгийн байнгын хорооны дарга Р.Сэддорж.

Н.Учрал: Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулж үг хэлэх гишүүд байвал нэрээ өгье. Байхгүй байна.

Сүхбаатарын Эрдэнэбат гишүүнээр тасаллаа. Г.Очирбат гишүүнд нэмж өгье. Ингээд 3 гишүүнээр тасаллаа. /алх цохив/

Их чухал асуудал хэлэлцэж байгаа шүү.

Пүрэвжавын Сайнзориг гишүүн асуулт асууна.

П.Сайнзориг: С.Бямбацогт сайд аа, би санаа зовоод л хэлж байгаа юм.

Та шинэ гишүүдийг хөөрхөн өхөөрдөөд байгаа ч юм шиг, даапаалаад байгаа ч юм шиг. Битгий тэг л дээ. Би зүгээр л байр сууриа хэлэх гэсэн юм.

Хоёрдугаарт, гол асуудал юу вэ гэхээр би энэ тогтоолын төслийг дэмжиж байгаа юм аа, Н.Учрал дарга. Гол асуудал. Маш олон Засгийн газарт чиглэл өгөх тогтоолууд бид хэд баталж өгөөд байгаа юм. Хэрэгжилт яаж байгаа вэ гэдэг дээр жоохон санаа зовоод байгаа юм.

Ер нь Байнгын хороо болгоноос тогтоолууд өгөөд байгаа. Орж ирэх нөгөө бүтээгдэхүүн. Жишээ нь, энэ ногоон эрчим хүч болон тархмал эх үүсвэрийг дэмжих энэ чиглэлийн Засгийн газрын тогтоолыг өглөө гэхэд хэчнээн хууль үүнийг дагаж орж ирэх ёстой вэ? Үүнийг тооцож байгаа юу?

Ер нь цаг хугацааны хувьд Засгийн газрынхаа потенциал, ажиллах тэр цаг хугацаа энэ тэрийг бодоод цаг хугацаатай өгмөөр байна. Тэгээд өгчхөөд байдаг. Үүнийг дагаад магадгүй бие даасан ямар ямар хуулиуд орж ирэх юм, аль аль хуулиуд нэмэлт, өөрчлөлт орж ирэх юм. Бас нэг ерөнхий хар зураг гараад үүний араас жоохон хөөцөлдөж явъя. Чухал асуудлыг нэг Улсын Их Хурлын тогтоол гаргаад хаячхаж болохгүй байгаа юм.

Энэ магадгүй өргөн уудам газар нутагтай Монгол Улсын аятай тухтай эрүүл орчинд амьдрах бас нэг шийдэл байхгүй юу. Тархмал эх үүсвэр.

Тэгэхээр үүнийг баримжаалсан зүйл байна уу гэдэг зүйлийг М.Энхцэцэг гишүүн хариулж өгөөч гэж хүсэж байна.

Тэгээд ногоон орон сууцын стандарт. Үүнийг ногоон барилга байгууламж гэж юуг хэлэх вэ гэдэг стандартыг шинэчлэх ажил Барилгын яаман дээр явж байсан юм. Энэ ажил ер нь ямар явцтай байгаа юм бол?

Байнгын хорооны тогтоол боловч Барилгын сайд энэ дээр мэдээлэл өгч болох уу? Ногоон орон сууцын зээл авъя гэхэд ямар орон сууцыг ногоон орон сууц гэж тооцож, ийм ийм шаардлагуудыг хангасан орон сууцуудыг ногоон орон сууц гэж тооцоод ипотекийн зээлд хамруулах бодлогын юмнууд дээр стандарт мэдээллийн сан бүрдүүлэх ажил ер нь хэр явцтай байгаа юм? Иргэд, олон нийтэд мэдээлэл өгөөч л гэж зүгээр хүсэж байгаа юм.

Яагаад гэхээр нийслэлийн иргэдэд их чухал асуудлууд байгаа учраас би асууж байгаа юм.

Н.Учрал: Энэ тогтоолтой холбогдуулаад хууль тогтоомж, тогтоолуудын хэрэгжилтийг шалгах ажлын хэсгийг Их Хурал дээр байгуулна.

П.Сайнзориг гишүүний хэлж байгаа зөв. Тогтоол гараад хэрэгждэггүй.

Тэгэхээр энэ “Засгийн газарт чиглэл өгөх” тогтоолыг С.Бямбацогт дарга байна, Засгийн газрын гишүүд байна. Тэгээд энэ тогтоолыг хэрэгжүүлэх ёстой шүү.

Өнөөдөр заавал хууль гаргахгүйгээр шийдэх асуудал энэ дотор багтсан. Нэг айл нарны хавтан суурилуулаад төвийн эрчим хүчний сүлжээнд холбох гэж 10 гаруй шат дамжлага зарцуулдаг. 6 сар хүлээдэг. Ийм байж болохгүй шүү дээ.

Тэгээд цахилгаан машинуудыг дэмжье гэж байгаа мөртлөө тэр хурдан цэнэглэгчээ дэмжихгүй байна. Ногоон дугаарыг нь ч олгохгүй юм. Энэ яамд дээр байгаа хүнд суртал нь бүр хэтэрлээ гэдэг ийм л гомдол тавиад байдаг.

Тийм учраас энэ тогтоол хэрэгжих ёстой. Энэ тогтоолын араас би өөрөө хариуцлагатай нэхэж явна. Тэгээд М.Энхцэцэг гишүүн өөрөө мэргэжлийн хүн. Мэргэжлийн хүний дуу хоолойг сонсоод бид харин энэ тогтоолынх нь хэрэгжилтийн араас өөрсдөө сайн шаардах хэрэгтэй. Тэгээд өөрөө энэ дээр шаардаж явна. Тэгээд М.Энхцэцэг гишүүн та тогтоолынхоо талаар нэг мэдээлэл өгөөч. М.Энхцэцэг гишүүн.

М.Энхцэцэг: Та бүхэнд энэ өдрийн мэндийг хүргэе.

Тэгэхээр Улсын Их Хурлаас ногоон эрчим хүч, тэр дундаа тархмал эх үүсвэрийг дэмжих чиглэлийг Засгийн газарт өгөх тогтоолыг гаргаж байгаа.

Тэгэхээр энэ тогтоолын хүрээнд гурван төрлийн тархмал эх үүсвэрийн хөгжлийг эрчимжүүлэх шаардлагатай байна гэж үзэж байгаа.

- ▷ **Нэгдүгээрт нь,** айл, өрхийн тархмал эх үүсвэр.
- ▷ **Хоёрдугаарт нь,** аймаг, сумдын тархмал эх үүсвэр.
- ▷ **Гуравдугаарт нь,** автомашиныг цэнэглэх тархмал эх үүсвэр.

Тэгэхээр айл, өрхийн тархмал эх үүсвэрийн хувьд Та бүхэн мэдэж байгаа. Сүүлийн үед айлууд нарны панел, батарей суурилуулаад, халаагуур суурилуулаад, яндангаа буулгаж агаарын бохирдлыг бууруулахад хувь нэмэр оруулж байгаа.

Мөн цэвэр, аюулгүй орчинд амьдрах, эрчим хүчээ хэмнэх гээд олон үр дүнтэй ийм ажлуудыг хийж байгаа. Гэхдээ энэ ажил маань төдийлөн далайцтай болж болохгүй байгаа л даа. Яагаад гэхээр цөөхөн айлууд хэрэгжүүлж байгаа учраас нэг айлын хөрөнгө оруулалт өндөр байгаа.

Мөн сүлжээнд энэ нарны системийг холбох холбоход техникийн нөхцөлөөс авхуулаад асар хүндрэлтэй байна. 6 сар болж байж холбож байна гээд олон асуудлууд байгаа.

Тийм учраас цаашдаа энэ төрлийн төслийг ядаж жилдээ 10 мянган айлыг энэ нарны панел халаагуур суурилуулах төслийг хэрэгжүүлбэ. Ингэсний үндсэн дээр бид агаарын бохирдлыг дорвитой хэмжээгээр бууруулж чадах юм байна.

Дээрээс нь энэ олон айлууд илүүдэл цахилгаанаа сүлжээ рүү борлуулаад орлого олох ийм боломжийг бий болгоно. Эрүүл аюулгүй орчинд амьдрах боломжийг бий болгоно.

Дээрээс нь 10 мянган айлыг дунджаар нэг айл 10 киловатт гэж үзэхэд жилд бараг бүхэл бүтэн дулааны цахилгаан станц 4-ийн нэг генератортай тэнцүү хэмжээний 100 мегаваттын шинэ эх үүсвэрийг хэрэглэгч маань өөрөө бий болгох боломжтой юм.

Тийм учраас цаашдаа энэ төслийг далайцтай хэмжээгээр хэрэгжүүлэх, дээрээс нь тэр тулгамдаад байгаа асуудлуудыг шийдвэрлэх ба санхүүгийн тодорхой хэмжээний дэмжлэг үзүүлэх механизмыг хөгжүүлэх, мөн ногоон зээлд хамруулах гэх мэтчилнээр энэ ажлыг эрчимтэй хөгжүүлэх нь бид эрчим хүчний хараат байдлыг бууруулах, хэрэглэгчийн цахилгаан хангамжийг хоёр талын тэжээлтэй болгож найдваржуулах, тэр 220 вольт хүчдэл нь 140 болтлоо уначхаад байгаа хүчдэлийг өсгөх гэх мэтчилэнгээр маш олон үр дүнтэй ажил бий болох байгаа юм.

Хоёрдугаарт нь, аймаг, сумдын тархмал эх үүсвэр.

Та бүхэн мэдэж байгаа. Маш олон аймгууд төвлөрсөн эрчим хүчний системээс хол байрладаг. Хэт урт цахилгаан дамжуулах, түгээх сүлжээгээр тэжээгддэг энэ аймгуудын хувьд цахилгаан хангамж нь өнөөдөр найдвартай байдал нь эрсдэлтэй байдалтай байгаа.

Саяхан өнгөрсөн 9 сард жишээ нь Эрдэнэт дэд станц дээр тасралт гарахад 8 аймаг, тэгээд 143 сум цахилгаангүй болсон. /минут дуусав/

Н.Учрал: Эрчим хүчний сайд байвал сонсох хэрэгтэй.

М.Энхцэцэг гишүүн нэмэлт 1 минут.

М.Энхцэцэг: Хэрвээ энэ асуудал өвөл тохиолдох юм бол энэ олон аймаг, сум хөлдөх эрсдэлтэй байна.

Тэгэхээр энэ эрсдэлийг хаах хамгийн чухал асуудал аймаг, сумын төв дээр нарны панелаасаа өөрөө цэнэглэгддэг, өөрөө бие дааж ажиллах батарейн систем суурилуулах явдал.

Саяхан Замын-Үүдэд шугам тасрахад тэнд байгаа нарны станц Замын-Үүдийг түр хугацаанд цахилгаанаар хангаад байж чадсан. Ийм төслүүдийг хэрэгжүүлж бид аймаг, сумдын цахилгаан хангамжийг найдваржуулах хэрэгтэй байна. Алдагдлыг багасгах хэрэгтэй байна.

Гуравдугаар асуудал, автомашиныг цэнэглэх. Сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэрүүдийг гол гол замуудын дагуу байршуулах хэрэгтэй байна. Өнөөдөр бид түлшний хувьд хараат байдалтай байна. Үүнийг бууруулах гол асуудал ерөөсөө л цахилгаан машины хэрэглээ. Цахилгаан машины хэрэглээг хязгаарлаж байгаа нэг зүйл цэнэглэх байгууламж.

Тэгэхээр бид цаашдаа цэнэглэх байгууламжийг энэ сэргээгдэх эрчим хүчний тархмал эх үүсвэр дээр үндэслэж байгуулах хэрэгтэй байна гэсэн ийм чиглэлүүдийг Засгийн газарт өгч байгаа. Хэрэгжилтэд нь онцгой анхаарах... /минут дуусав/

Н.Учрал: Тийм. “Засгийн газарт чиглэл өгөх” тогтоол батлагдсанаар 20 киловатт хүртэл хүчин чадалтай нарны панел, батарейн системийг суурилуулбал техникийн нөхцөл шаардахгүй.

Тэгээд түгээх сүлжээ нь шууд холбоно. Хэрэглээнээс илүү гарсан цахилгааныг сүлжээнд нийлүүлж орлогыг нь авах боломжийг өрхүүдэд бүрдүүлж өгнө шүү дээ. С.Бямбацогт дарга аа, ийм тогтоол гарч байгаа шүү дээ.

Тэгэхээр энэ хэрэгжих хэрэгтэй.

Зарим гишүүд байгаа. Э.Батшугар сайд хүртэл нарны панел, батарей тавьчхаад төвийн дулаанд нийлүүлээд яваад байгаа байхгүй юу. Тэр чинь сард 2 сая 500 төлдөг байсан тэр төлбөр чинь байхгүй. Хямдраад өрх орлоготой болох нөхцөл бүрдэж байгаа байхгүй юу даа. Ийм чухал ажлыг М.Энхцэцэг гишүүн санаачлаад явж байгааг бид сайн дэмжих хэрэгтэй шүү.

Э.Бат-Амгалан сайд хариулах уу? Э.Бат-Амгалан сайд нэмэлт мэдээлэл өгөөч. П.Сайнзориг гишүүний асуултад.

Э.Бат-Амгалан: П.Сайнзориг гишүүний асуултад хариульъя.

Барилгын тухай хуульд хаврын чуулганаар шинэчилсэн найруулга, өөрчлөлт оруулахаар, өргөн барихаар манай салбар яаман дээр ажлын хэсгүүд гарсан ажиллаж байгаа.

Энэ хууль дээр тодорхой орно гэж бид бэлтгэлтэй ажиллаж байна. Ер нь ногоон орон сууц, ногоон амины орон сууцад ипотекийн зээлийн эх үүсвэрийг хүү багатай, урьд ажиллагаа багатайгаар оруулах чиглэлийн асуудлуудыг нэлээдгүй судалж оруулж байна.

Барилгын тухай хууль 2016 оноос хойш шинэчилсэн найруулга ерөөсөө ороогүй явж байгаа юм байна лээ.

Тэгэхээр сүүлийн 10 жилийн хугацаанд өөрчлөлт ороогүй Барилгын хуулийг хаврын чуулганаар өргөн барьж оруулна гэсэн бодолтой байгаа.

Н.Учрал: П.Сайнзориг гишүүн тодруулна.

П.Сайнзориг: Маш чухал асуудлууд явж байна. Тэгээд манай нийслэлчүүд хараад сууж байгаа байх.

Тэгээд үүний зохион байгуулалтыг Засгийн газар дээр яг иргэдэд сэргээгдэх эрчим, тархмал эх үүсвэрийг ашиглах тэр мэдээллийг өгдөг нэг тийм төв ч гэдэг юм уу, яг тодорхой тийм нэг центр баймаар байна.

Тэгээд иргэд сонирхоод –

- яаж холбох вэ,
- ямар байдлаар явбал аюулгүй байдлаа хангах вэ,
- ямар хэмнэлтүүд өрхийн орлого дээрээ гаргаж болох вэ –

- байгууллагууд ямар ямар технологиуд оруулж ирж байгаа талаар нэгдсэн мэдээлэл өгдөг.

Иргэдэд чирэгдэлгүйгээр явбал энэ их эрчимтэй хэрэгжээд явах бололцоо байгаа юм. Ялангуяа манай гэр хорооллын иргэд болон лагерийн бүсийн иргэд энэ чиглэл рүү ороход бололцоо байгаа.

Сүүлийн үед Засгийн газарт тодорхой хуулийнх нь үзэл баримтлал, бодлогыг нь эндээс л чиглүүлж өгөөд байх шиг байна шүү. Тэгээд хэрэгжүүлж тэр холбогдох хууль тогтоомжуудаа яаралтай оруулж ирээрэй гэж хүсэж байна.

Н.Учрал: Сүхбаатарын Эрдэнэбат гишүүн асуулт асууна.

С.Эрдэнэбат: Өнөөдөр маш чухал асуудал. Амьдралд нэлээн ойрхон. Хэрэгжүүлж чадах юм маш олон иргэд яг энэ сэргээгдэх хүчнийг яаж хэрэглэх юм бол. Магадгүй аягүй их технологи шаарддаг, аюултай, олон зөвшөөрөл шаарддаг гэдэг байдлаар хойш суугаад, болгоомжлоод байдаг.

Нордикийн орнууд, ялангуяа манайхтай төстэй хүйтэн улс орнууд үүнийг аль хэдийн хэрэгжүүлээд, илүү олон байх тусмаа үнэ нь хямдраад, эдийн засгийн үр өгөөж улам нэмэгддэг гэдэг үндсэн логиктой юм билээ. Энэ тал дээр иргэд сая зөвшөөрөл шаардахгүй гээд тогтоол дээр ороод ирсэн. Магадгүй үүнийг нөгөө талд нь зөвшөөрөл шаардахгүй болохоор эргээд аюултай, гал усны аюултай гээд л маш олон үгүйсгэх хандлагууд байхыг үгүйсгэх аргагүй. Энэ тал дээр яг ямар эрсдэл гарч болох вэ гэдэг талаас, нөгөө талаас нь нэг асуумаар байна.

Хоёрдугаарт нь, өчигдөр хурлын дарга уулзалтаар ярьж байгаа мэдээлэл гарч байсан. Цахилгаан, хосолсон хөдөлгүүртэй маш олон машинууд бий болсон. Тэгээд яг ний нуугүй хэлэхэд Улаанбаатар хотод, би ч гэсэн өөрөө яг тийм машин унадаг. Тэгээд хайгаад олдоггүй. Цэнэглэх юм ерөөсөө байхгүй. Манай ордонд байсан, манай ордны хашаанд байсан юмыг хүртэл тэгээд мулт татаад аваад явсан юм билээ. Цэнэглэх юм байдаггүй.

Тийм. Ажилладаггүй юм уу? Ажилладаггүй л гэж надад хэлсэн.

Тийм учраас үүнээсээ авахуулаад бид яг ийм ногоон эко зүйлийг яахгүй бол. Колонкуудаас асуухаар байдаг юм байна лээ. Тэгээд ерөөсөө ашиггүй. Нэгдүгээрт төвөгтэй ч гэнэ үү, нэг тийм байдлаар жоохон тээрч хийх байдалтай.

Тийм учраас бид бензинд очерлож суухаас гадна 160 мянган цахилгаан машин байгаа гэсэн. Үүнийг ойрын хугацаанд тодорхой ямар чиглэлээр үүрэг даалгавар өгдөг юм. Эдийн засгийнх нь үр өгөөж талаас нь чиглэл өгөөд, ялангуяа өвлийн улиралд. Хот хооронд ч гэсэн явахад цахилгаан машин цэнэглэх станц ховор байгаа учраас эргээд хүмүүсийн хэрэглээ, хосолмол хөтөлбөртэй машиныг оруулж ирэх, худалдан авах сонирхол гэдэг юм уу, унах эрсдэл байгаа юм болов уу гэж хараад байдаг.

Тэгэхээр энэ тал дээр хариуцсан холбогдох сайд нар машины цэнэглэх станцуудыг бий болгох тал дээр нь яг ямар ажил хийдэг юм? Зүгээр хаясан юм уу? Нэг хэсэг бужигнуулж байгаад хаясан юм уу гэдэг ийм асуултыг асуумаар байна.

Тэгээд М.Энхцэцэг гишүүндээ баярлалаа. Би жил гаруй хажууд нь суусных эрчим хүч, сэргээгдэх эрчим хүчний талаар маш их мэдлэгтэй болж байгаа. Бараг Австралийн тэр төгссөн сургуулийнх нь хэмжээний, диплом хамгаалах хэмжээний мэдлэгтэй болж байгаа учраас энэ их чухал байна.

Аялал жуулчлалыг хөгжүүлэе гэхээр манай олон аялал жуулчлалын компаниуд тоггүй, цахилгаангүй, өртөг өндөртэй учраас аялал жуулчлал хөдөө хөгждөггүй. Эрчим хүч татна гэхээр асар их хөрөнгө оруулалт шаарддаг. Тийм учраас энэ бол манай ирээдүйд маш чухал юм.

Дээрээс нь сэргээгдэх эрчим хүчний мэргэжилтнүүд ирэх 10 жил хамгийн эрэлттэй өндөр цалинтай мэргэжил байна гэдгээр олон улсын хөдөлмөрийн байгууллагын хүний нөөцийн эрэлттэй мэргэжлээр орсон юм билээ.

Тэгэхээр хүний нөөцийг бэлдэх тал дээр манай дээр хэр зэрэг бэлддэг юм оо? Тэгээд тогтоолын төслийг бүрэн дэмжиж байна.

Н.Учрал: Тийм. Засгийн газарт чиглэл өгөх тогтоол дээр саяын С.Эрдэнэбат гишүүний хэлээд байгаа “Hybrid Electric Vehicle” буюу цахилгаан, бензин хосолсон машиныг ногоон дугаартай болго гэсэн чиглэл өгч байгаа шүү дээ. Зам тээврийн сайд байвал. Тийм юм өгч байгаа шүү дээ.

Дээрээс нь тэр 100 байршил дээр түншлэлийн төслөөр байршил дээр хурдан цэнэглэгчтэй, нарны панелтай тийм байгууламжийг барихыг төр, хувийн хэвшлийн түншлэлээр хийе гэдэг чиглэлийг өгч байгаа шүү дээ.

Араас нь манай ажлын хэсэгт орсон гишүүд нэхэл хатуутай шаардана шүү дээ. Тэгээд М.Энхцэцэг гишүүн хариулъя.

М.Энхцэцэг: Энэ тогтоол дээр 20 киловатт хүртэл хүчин чадалтай айл, өрхийн нарны панел, батарейн системийг түгээх сүлжээнд техникийн нөхцөл шаардахгүйгээр нэг стандартыг хангуулж, сүлжээнд холбуулах боломжийг бүрдүүлэх гэж маш хүчтэй заалт орж ирсэн.

Тэгэхээр энэ дээр ямар эрсдэл байгаа вэ гээд С.Эрдэнэбат гишүүн маань асууж байна л даа.

Сүлжээнд холбоход маш хүндрэлтэй байгаа. Эрчим хүчний салбарт ажиллаж байсан хүн өөрийнхөө нарны панелыг сүлжээнд холбох гэж 6 сар явж байна шүү дээ. Тэгэхээр энэ бол бүр асар хүндрэлтэй асуудал учраас энэ дээр ийм онцгойлон заалт оруулж өгсөн.

Дээрээс нь “техникийн нөхцөлгүй” гэдэг нь “техникийн шаардлага хангахгүй” гэсэн үг биш юм. Яагаад гэхээр “техникийн нөхцөл” гэдэг нь тэнд та сүлжээнд холбохын тулд ямар шаардлагыг хангаж байх ёстой юм бэ гэдэг ийм заалтуудыг бичсэн цаас байгаа юм. Гэтэл энэ ижилхэн цаасыг хүн болгонд өгөөд, тэр нь хүнд суртлын үүр уурхай болоод явж болохгүй.

Түгээх сүлжээ бол түгээх сүлжээнд холбогдох нарны панел, батарей ямар техникийн шаардлагыг хангасан байх ёстой вэ гэдэг юмаа олон нийтэд нээлттэй. Яагаад гэвэл энэ бол бүх нарны панелийн хувьд адилхан.

Тийм учраас үүнийгээ нээлттэй. Олон улсад ерөөсөө түгээх сүлжээний дүрэм. Одоо “Grid Code”⁹ гэж ярьдаг.

Тэгэхээр тэрийгээ л тасралтгүй хөгжүүлээс сайжруулаад явж байх ёстой. Тэр нь олон нийтэд нээлттэй байх ёстой. Тэгээд энэ системийг угсарч байгаа барилга угсралтын компаниуд тэр шаардлагыг хангасан байж байж л тэр системийг сүлжээндээ холбоод явах ёстой.

Түүнээс биш холбохоосоо өмнө тэр цаасыг авахын төлөө 2, 3 сар зарцуулдаг байж болохгүй гэдэг утгаараа үүнийг оруулсан байгаа. Энэ дээр эрчим хүчний салбар талаасаа нэлээн юутай хандаж байгаа.

Тэгэхээр энэ дээр тийм эсэргүүцэж хандах шаардлага байхгүй. Яваандаа бид “техникийн нөхцөл” гэдэг хүнд суртлын үүр уурхай болсон энэ алгын чинээ цаасыг халах ёстой. Олон улс ийм алган чинээ цаасаар хүнд суртлын үүр уурхай болгоод явдаггүй. Олон улсад түгээх сүлжээний “Grid Code” гээд нэг бичиг баримт байдаг. Тэр нь тасралтгүй сайжирч байдаг. Түүнийгээ хангасан систем л сүлжээндээ холбогдож явдаг юм гэж хэлмээр байна.

Тэгээд дараагийн асуудал болохоор ер нь энэ нарны панел, батарейн систем дээр чанарын асуудал маш чухал.

Тийм учраас хэрэглэгч аль болох чанартай батарей, чанартай нарны панел суурилуулах талдаа өөрсдөө л анхаараад явж байх ёстой. /минут дуусав/

Н.Учрал: Ганбатын Очирбат гишүүн асуулт асууна.

Г.Очирбат: Энэ үнэхээр ач холбогдолтой тогтоолын төсөл орж ирж байгаа.

Их Хурал бодлого боловсруулах ёстой. Яг Засгийн газар луу ийм чиглэл өгсөн тогтоолын төслүүдийг сайн явуулж байх ёстой.

Энэ тийм иргэдээ бодсон, ялангуяа сум, орон нутаг, гэр хороололд амьдарч байгаа иргэдээ бодсон их тийм зөв чиглэл өгч байгаа тогтоол шүү. Их Хурлын гишүүд маань бүгдээрээ энэ дээр анхааралтай хандаасай гэж хүсэх гэсэн юм. Нэгд.

Хоёрт гэх юм бол, энэ дээр асуух нэг юм байгаа юм. Би Байнгын хороон дээр энэ “5 киловатт” гэж орж ирснийг “20 киловатт” болгуулаад, Эрчим хүчний тухай хуульд нийцүүлээд, санал хураалгаад Их Хурлын гишүүд дэмжээд 20 болгосон.

⁹ Эрчим хүчний нэгдсэн сүлжээний техникийн дүрэм/стандарт.

Энэ тогтоолын 4.3-т “иргэд сүлжээнд илүү эрчим хүчээ нийлүүлээд, холбогдох орлогыг тухай бүр авах боломжийг бүрдүүлэх” гээд Засгийн газар луу чиглэл өгч байгаа шүү. “Тухай бүрд” гэдгийг М.Энхцэцэг гишүүн яг тодорхой хариулаад өгмөөр байгаа юм.

Тэгэхгүй бол иргэд дээр асуудал үүсдэг. Би 7, 8, 9 сард илүү эрчим хүчээ өгөөд эрчим хүчний түгээхээс, нийслэлийн түгээхээс ч юм уу авах авлагатай болдог. 2, 3 сая төгрөгийн авлагатай болдог. Тэрийг нь өгдөггүй. Өгөхгүй байж байгаад өвөл болонгуут чамд дүйцүүлэхээр явна гээд хасдаг. Хэрвээ тэгж дүйцүүлэх гэж байгаа бол иргэдийн орлого дээр хүү ч юм уу, бодож өгөх ёстой шүү дээ. Тийм биз. М.Энхцэцэг гишүүн ээ? Тийм. Одоо тийм гэж байна.

Тэгэхээр яг үүнийг аягүй тодорхой болгох хэрэгтэй.

Тэгэхгүй бол Их Хурлын дарга аа, энэ дээр чинь дундын “гар”¹⁰ үүсгээд тэгээд иргэдийг дахиад өөрөө эрчим хүчээ үйлдвэрлээд, өөрөө орлого олох боломжийг нь олгож өгч байхад асуудал үүсэх вий дээ. Энэ дээр М.Энхцэцэг гишүүн тодорхой яг тэр “тухай бүрд” гэсэн дээр нэг хариулаад өгөөч гэж байгаа юм. Нэгд.

Хоёрт гэх юм бол, эрчим хүчний асуудал. Одоо яг энэ тогтоолоор Монгол Улс эрчим хүчнийхээ тусгаар тогтносон байдлыг хангаж бараг бүрэн чадахаар болно шүү. Яг үүнтэй холбоотой асар их хэмжээний хөрөнгө оруулалт орж ирэх гээд хүлээгдээд байгаа. Яаман дээр нь хаадаг, боодог. Жил гаруй үглэсэн.

Харин ёстой энэ залуу гишүүд, Их Хурлын даргадаа маш их баярлалаа гэж хэлье. Н.Учрал дарга аа. Та энэ ажлын хэсгийг хуралдуулаад, мэргэжлийн экспертүүдийн зөвлөгөө аваад, ер нь цаашдаа дэлхийн хөгжлийн чиг хандлага яаж явах гэж байгаа юм гэдэг дээр их тийм санаа тавьж ажилласан байна лээ. Би сүүлд сонссон.

Тэгээд мэргэжлийн М.Энхцэцэг гишүүн маань Их Хурлын тогтоолын төсөл дээр ажиллаад, олон экспертүүдийн саналыг аваад орж ирж байгаад нь маш их баярлаж байгаа шүү.

Тэгэхээр тэр яг төлбөр тооцоотой холбоотой –

- сар бүр болгох юм уу?
- улиралдаа нэг удаа болгох юм уу?

“Тухай бүр” гэдгийг нэг сайхан тайлбарлаад өгье. Тэгээд тодруулж асууя. Тэгэх үү?

¹⁰ "Гацаа", "саад", эсвэл "ойлгомжгүй байдал", "зохицуулалтын эрх зүйн хоосон зай" гэсэн ойлголт.

Н.Учрал: М.Энхцэцэг гишүүн хариулъя.

М.Энхцэцэг: Г.Очирбат гишүүндээ баярлалаа. Тийм.

Ер нь айл өрхүүд нарны панел, батарейгаараа сүлжээнд илүүдэл цахилгаанаа борлуулаад орлого олох боломжтой.

Тэгээд одоогийнхоо журмаар үнэхээр таны хэлж байгаа зөв. Үнэхээр бүр нэг ийм толгой эргүүлсэн. Тийм ээ. Ингээд өгснөөс чинь авсныг чинь хасаад ингээд ингэнэ шүү гээд. Тэгээд одоо хүртэл нэг ч айл бараг тэр зарсан цахилгааныхаа орлогыг авч чадахгүй байгаа.

Тийм ч учраас бид энэ дээр бүр онцгойлон сар болгон тэр хүний сүлжээ рүү зараад, өөрөөр хэлбэл “цахилгаан үйлдвэрлэгч” болоод олсон орлогыг өгдөг бол оо. Тэгж байж энэ маань цаашдаа, өөрөөр хэлбэл энэ нарны панел, батарей суурилуулах идэвхэжнэ. Өөрөөр хэлбэл хүн сардаа цахилгааныхаа тооцоог хараад “...хөөх.., би сүлжээнээс 50 мянган төгрөгийн цахилгаан худалдан авчээ, ...хүүш.., гэхдээ би 10 мянган төгрөгийн цахилгаан сүлжээ рүү худалдсан байна шүү дээ” гэдэг юмаа хүн харж байж, тэндээсээ хүн би чинь нээрээ “цахилгаан үйлдвэрлэгч” болсон байна шүү дээ гэдэг тэр сэдэл бий болно.

Тэгээд олон айлууд энэ систем рүү явдаг болно.

Түүнээс биш толгой эргүүлсэн, жилдээ бодож өгнө, улиралдаа бодож өгнө гэсэн юм байх ёсгүй. Олон улс ч гэсэн сардаа бодож өгдөг юм.

Тийм учраас үүнийг тусгаж өгч, ийм боломжийг бүрдүүл гэдэг утгаараа “тухай бүрд” нь гэдэг нь ер нь “сар бүрд” гэсэн үг.

- Сар бүрд цахилгааны тооцоо хийгдэнэ.
- Та системээс тийм хэмжээний цахилгаан авсан байна.
- Та системд тийм хэмжээний цахилгаан үйлдвэрлээд худалдсан –

гэдэг юм нь сар бүр тухайн хүний данс руу ордог байх ёстой.

Энэ бол энэ нарны панел, батарейг дэмжихэд маш томоохон хэмжээний түлхэц болох тийм бодлого гэж үзэж байгаа.

Н.Учрал: Г.Очирбат гишүүн тодруулна.

Г.Очирбат: Эрчим хүчний зохицуулах хорооноос дүн гаргасан байдаг. Аж ахуй нэгжүүдээс эрчим хүч худалдаж авахдаа монгол төгрөгөөр яривал 500-аас 700 төгрөгийн хооронд 1 киловаттыг нь авдаг.

Иргэд өөрөө эрчим хүч үйлдвэрлээд өгье гэхээр 220-оос 320 төгрөгийн хооронд билүү, авч байгаа. Энэ байдлыг бид засах хэрэгтэй.

Яагаад иргэд маань үйлдвэрлэл эрхлээд төвийнхөө эрчим хүчинд эрчим хүч нийлүүлэхэд тийм хямдхан үнээр буцаагаад эрчим хүчний төлбөрийг нь төлөөд байдаг юм. Аж ахуйн нэгжүүд болохоор тийм үнэтэй үнээр тэр мөнгийг нь буцааж өгөөд байдаг юм. Тэгээд энэ “гар”-ыг гаргах ёстой. М.Энхцэцэг гишүүн.

Тэгэхгүй бол яг одоо тийм байгаа шүү. Иргэдийн маань үйлдвэрлээд өгч байгаа 1 киловаттыг эрчим хүчийг 280, 300 төгрөгөөр худалдаж авна. Төр. Аж ахуйн нэгж үйлдвэрлээд өгөнгүүт 500, 600, 700 төгрөгөөр 1 киловаттыг нь авдаг. Гэрээнээсээ шалтгаалаад.

Тэгэхээр үүнийг нэмж өгөх ёстой. Тэгж байж иргэдийн энэ сэргээгдэх эрчим хүч рүү орох идэвхжил ихсэх ёстой байгаа юм.

Н.Учрал: Маш чухал асуудал дээр саналуудаа илэрхийлж байна. М.Энхцэцэг гишүүн хариулъя.

М.Энхцэцэг: Тэгэхээр Г.Очирбат гишүүнтэй санал нэг байна.

Гэхдээ таны тэр хэлж байгаа 700 төгрөг аж ахуйн нэгжүүд гэдэг маань нөгөө 2007 онд батлагдсан Сэргээгдэх эрчим хүчний тухай хууль дээр хүчээр маш өндөр тариф суулгаад өгсөн байдаг. Тэр тарифаар тийм өндөр байгаа.

2007 он гэдэг чинь өнөөдөр хэдэн он билээ. Тийм ээ. Одоо яаж байгаа гэхээр сэргээгдэх эрчим хүчний тариф бүр жилээс жилд буурчаа байгаа. Тэр 2007 онд хууль батлагдахад бид 50 мегаваттын салхин станцыг 100 сая доллароор барьдаг байсан бол өнөөдөр 50 сая доллар, 40 сая доллар гээд жил болгон буурч байгаа. 4 цент рүү орж байгаа.

Тэгэхээр тэр өндөр тарифтай Сэргээгдэх эрчим хүчний хуультай харьцуулж бид өсгөх ёстой гэдэг шаардлагыг тавьж болохгүй. Одоогийн байдлаар тэр оройн ачааллын хувьд 300 төгрөг буюу энэ маань ойролцоогоор 8 центээр явж байгаа. Энэ бидний хувьд хангалттай.

Дээрээс нь бид яагаад тархмалыг дэмжих гээд байгаа гэхээр энэ тариф нь төгрөгөөр илрэх... /минут дуусав/

Н.Учрал: Өрх бүр цахилгаан үйлдвэрлэгч болох зорилтын дагуу энэ “Засгийн газарт чиглэл өгөх тухай” тогтоолыг мэргэжлийн экспертүүд боловсруулсан.

Энэ хүрээндээ Засгийн газарт чиглэл өгч байгаа тогтоол уриа лоозонгийн шинжтэй биш. Чиглэл өгөгдсөний дараа хэрэгжих бүрэн бололцоотой. Заавал хууль орж ирэх шаардлагагүй.

Эдийн засаг хөгжлийн яаман дээр ажиллаж байхад бид Carbon Credit дээр Сингапур, Швейцартай гэрээ байгуулсан. Одоо Уур амьсгалын өөрчлөлтийн хууль орж ирэх ёстой.

Ингээд цаашдаа “өрх бүр цахилгаан үйлдвэрлэгч” болох зорилт дэвшүүлнэ. Үүнд саад тотгор учруулж байгаа дүрэм журам, саад тээг, зөвшөөрлүүдийг цуцлах хэрэгтэй.

Тийм ч учраас “чөлөөлье” гэдэг санаачилга маргааш Зөвшөөрлийн хууль гарна. Энэ хүрээнд 20 киловатт хүртэл тохиолдолд айл өрх өөрсдөө нарны панел, батарейгаа тавиад төвийн сүлжээнд нийлүүлээд “өрх бүр цахилгаан үйлдвэрлэгч” болох зорилт тавьж байж энэ эрчим хүчний бие даасан байдал, хамаарал багасна.

Г.Очирбат гишүүн тодруулж асууя.

Г.Очирбат: М.Энхцэцэг гишүүн ээ, би 2024 оны жилийн эцсээрх тоог хэлье.

Компанийнх нь нэрийг нь зарлаад яах вэ. Энд арван хэдэн компани байна. Хамгийн дээд талын үнэ 598 төгрөгөөр 1 киловатт эрчим хүчийг төр худалдаж авч байна. Дараагийнх нь –

- 597 төгрөгөөр,
- 563 төгрөгөөр,
- 561 төгрөгөөр,
- 529 төгрөгөөр.

Иргэдээсээ бид өнөөдөр Эрчим хүчний зохицуулах хорооны гаргасан тариф 300 орчим, 320 орчим төгрөг дээр л байгаа.

Энэ дээрээ анхаарах ёстой. Тэгж байж иргэд маань өөрсдөө тийшээ санхүүжилт хийх, өөрөө өөрийнхөө эрчим хүчийг өөрөө үйлдвэрлээд, дээрээс нь илүүгээ өгөөд орлого олоод, өөрөө өөртөө хэмнэлт хийдэг энэ юм руугаа орох ёстой.

Тэгэхээр яг энэ компаниуд. Би Б.Чойжилсүрэн сайд зөндөө хэлсэн. Тэгээд урьд урьдын баахан Их Хуралд байсан сайд дарга нар байсан хүмүүс шахалт дарамт үзүүлээд, энэ компанийнх нь хойно хамаарал бүхий л юм билээ шүү дээ.

Тэгээд хөдөлгөж болдоггүй юм гээд байгаа юм. Би бүр өрөөнд нь ороод хэлж байна шүү дээ. Болохгүй дэмжье, ярья, хэвлэл рүү гараад ярья. Иргэддээ боломж олгоё л доо.

Эрчим хүчний салбараас чинь иргэд мөнгө олох ганц... /минут дуусав/

Н.Учрал: М.Энхцэцэг гишүүн.

М.Энхцэцэг: Г.Очирбат гишүүний ярьж байгааг ерөнхийдөө ойлгож л байна л даа.

Саяын таны ярьж байгаа сэргээгдэхийн том том эх үүсвэрүүд тогтвортой байдлын гэрээ олон жилийн өмнө хийгдсэн гэрээнүүд.

Одоо хэрвээ бид ийм шинэ эх үүсвэр, сэргээгдэхийн том эх үүсвэрүүдийг л ийм өндөр тарифаар оруулах ямар ч боломжгүй. 4 цент рүү орж байгаа.

Одоо Эрчим хүчний яаман дээр дуудлага худалдаа зарлаад сэргээгдэхүүд баригдаж байгаа. Тэд нарыг бид ер нь 4 центээр орж ирнэ гэсэн хүлээлттэй байгаа.

Тийм учраас арван хэдэн жилийн өмнө баригдсан сэргээгдэхүүд. Яах вэ, тэр үед яалт ч үгүй л өндөр байсан учраас хөрөнгө оруулалт татахын тулд ийм л байсан.

Тэгэхээр хэрэглэгчийн тарифыг энэ рүү аваачих ёстой гэдэг тийм өнцөг гаргаж болохгүй гэж би хэлэхээр байна.

Н.Учрал: Гишүүд асуулт асууж, хариулт авч, үг хэлж дууслаа. /алх цохив/

Чуулганы завсарлагаанаар М.Энхцэцэг гишүүн, Г.Очирбат гишүүн гээд гишүүдтэй хамтраад чиглэл өгөх тогтоолын хэрэгжилтэд анхаарч ажиллана.

Ард түмний дунд орж, айл өрхүүдээр явж нарны панелд тавьж байгаа айлуудыг сайшаах, дэмжих бүх бололцоогоор хангах ёстой.

Санал хураалт явуулна. Гурван асуудал үлдээд байна. Гурван санал хураалт явуулна.

Зээлийн хэлэлцээр 2 байна. Дээрээс нь “Засгийн газарт чиглэл өгөх” тогтоол байна. Дараа нь хууль байна. Араас нь түр хороо байна.

18.00 цаг болох гээд байна.

Төлбөрийн чадваргүйдлийн тухай хуулийг хэлэлцээд явж байя даа.

Гурван асуудлын санал хураалтыг нэгтгэж санал хураая.

Европын сэргээн босголтын банкнаас авч байгаа зээлийн хэлэлцээр, Азийн хөгжлийн банкны зээлийн хэлэлцээр, мөн “Засгийн газарт чиглэл өгөх тухай” тогтоол гэсэн гурван асуудлын санал хураалтыг нэгтгэж явуулъя. Хойшлууллаа. /алх цохив/

Дараагийн асуудалд оръё.

**Тав.Төлбөрийн чадваргүйдлийн тухай хууль
/Шинэчилсэн найруулга/-ийн төсөл болон
хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд
/Засгийн газар 2025.05.27-ны өдөр өргөн мэдүүлсэн,
хэлэлцэх эсэх/**

Төлбөрийн чадваргүйдлийн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг явуулна.

Хууль санаачлагчийн илтгэлийг Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Хууль зүй, дотоод хэргийн сайд Баттөмөрийн Энхбаяр танилцуулна.

Индэр индэрт урья.

Б.Энхбаяр: Улсын Их Хурлын эрхэм дарга, гишүүд ээ,

Дампуурлын тухай хууль нь 1997 онд батлагдсан бөгөөд түүнээс хойш зарчмын шинжтэй бие даасан шинэчлэл хийгдээгүйгээр 28 дахь жилдээ хүчин төгөлдөр хэрэгжиж байна.

Хуулийг хэрэглэх, хэрэгжүүлэх явцад практикт тодорхой хүндрэл, зөрчил илэрч төлбөрийн төлбөрийн чадваргүйдлийн харилцааг зохицуулах өнөөгийн олон улсын чиг хандлага, стандарт, зарчимтай нийцэхгүй болсон талаар дотоод, гадаадын судалгааны байгууллагуудын дүгнэлт, олон улсын байгууллагын санал, зөвлөмжүүдэд удаа дараа дурдсан байдаг.

Үүний дагуу Дампуурлын тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийж, уг хуулийг шинэчлэн найруулах шаардлагатай гэсэн дүгнэлт гарсан.

1997 онд батлагдсан Дампуурлын тухай хуульд дампуурлын хэрэг, маргааныг хянан шийдвэрлэх явцад хөндөгддөг олон талт харилцаанаас цөөн хэсгийг өнгөц төдий дурдсан, ихэнх хэсгийг огт зохицуулаагүй нь дампуурлын эрх зүйн орчныг системгүй хийдэл ихтэй болгожээ.

Монгол Улс Дэлхийн банкны “**Doing Business**” (Бизнес эрхлэхүй) ерөнхий индексийн жагсаалтад 190 улсаас ойролцоогоор 74-өөс 81-д эрэмбэлэгддэг.

Харин дампуурлыг шийдвэрлэх салбар үзүүлэлтээр 152 дугаар байр эзэлдэг бөгөөд энэ нь тус салбарын эрх зүйн орчныг зайлшгүй сайжруулах шаардлагатайг илтгэж байна.

Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 181 дүгээр тогтоолоор батлагдсан Монгол Улсын хууль тогтоомжийг 2028 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэлийн 38-д хуулийн этгээдийн төлбөрийн чадвартай эсэхийг тогтоох, төлбөрийн чадваргүйдлийн хэргийг шүүхэд хянан шийдвэрлэх, төлбөрийн чадваргүйдлийн ажиллагаа эхлүүлэх, нэхэмжлэлийн шаардлага гаргах, түүнийг хангах, хэрэг гүйцэтгэгчийн эрх хэмжээ, түүнийг томилох, чөлөөлөхтэй холбоотой зохицуулалт, үүрэг гүйцэтгүүлэгчдийн хурал, түүний эрх хэмжээ, төлбөрийн чадваргүй хуулийн этгээдийг дахин зохион байгуулах, татан буулгахтай холбогдсон зохицуулалтыг боловсронгуй болгох зорилтын хүрээнд Дампуурлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулж Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхээр туссаны дагуу Төлбөрийн чадваргүйдлийн тухай хуулийн төслийг боловсруулж 2025 оны 5 дугаар сарын 27-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн.

Улс орны эдийн засаг, нийгмийн харилцаанд дампуурлын эрх зүйн орчин чухал үүрэг гүйцэтгэдэг. Иргэд, хуулийн этгээдийн эрхэлж буй бизнесийн үйл ажиллагаа олон шалтгаан, хүчин зүйлийн улмаас амжилтгүй болох бөгөөд энэ нь дан ганц тухайн этгээдийн бүтэлгүйтэл байгаад зогсохгүй түүнтэй бизнесийн тогтмол харилцаатай байсан бусад иргэд хуулийн этгээдийн бизнесийн хэвийн байдал, түүнд ажил хөдөлмөр эрхэлж цалин хөлс авч байсан олон ажилтан, албан хаагчдын өдөр тутмын амьдралд сөргөөр нөлөөлдөг.

Ийм ч учраас дампуурлын харилцааг хэн нэгэн хувь хүн, хуулийн этгээдийн төлбөрийн чадваргүйдлийн асуудал гэхээсээ илүүтэй улс орны нийгэм, эдийн засгийн хөгжлийн тогтвортой байдлыг хангах хүчин зүйл гэж үзэж зохицуулах хандлага өнөөдөр хүчтэй болжээ.

Өөрөөр хэлбэл дампуурлын үр дүнд аль нэг этгээдийг өрөөс чөлөөлж дахин аж ахуй эрхлэх боломж олгохоос илүүтэй харин эдгээр этгээдтэй шударга итгэл үнэмшлээр хамтран ажиллаж байсан бусад этгээдийн эрх ашиг, үйл ажиллагааны тогтвортой байдлыг хангах нь эн тэргүүний зорилго болж. Энэ ч агуулгаар гаднын улс орнууд хууль тогтоомжоо дампуурлын тухай бус харин төлбөрийн чадваргүйдлийн тухай гэсэн агуулгаар нэрлэх болсон байна.

Эдгээр үндэслэлийг харгалзан Дампуурлын тухай хуулийг олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн орчин үеийн аргачлал, стандарт, суурь зарчмын дагуу хийдлийг арилган шинэчлэн боловсруулж, дараах зарчмын шинжтэй өөрчлөлтүүдийг тусгалаа.

Нэгдүгээрт, хуулийн төслөөр хуулийн этгээдийн төлбөрийн чадвартай эсэхийг тогтоох, төлбөрийн чадваргүйдлийн ажиллагаа эхлүүлэх, төлбөрийн чадваргүй болсон хуулийн этгээдийг дахин хөрөнгөжүүлэх, татан буулгах, түүнчлэн төлбөрийн чадвартай боловч санхүүгийн хүндрэлд орж, төлбөрийн үүргээ зогсоосон хуулийн этгээдэд төлбөрийн чадваргүйдлээс урьдчилан сэргийлэх бүтцийн өөрчлөлт хийхтэй холбоотой харилцааг цогцоор нь зохицуулахаар тусгалаа.

Хоёрдугаарт, банкны системийн онцлогийг харгалзан банкны дампуурлын харилцааг банкны салбарын тусгай хуулиар зохицуулахаар хэвээр үлдээж, банк, даатгал, банк, санхүүгийн байгууллага зэрэг санхүүгийн байгууллагын төлбөрийн чадваргүйдэлтэй холбоотой нарийвчилсан харилцааг салбарын холбогдох хуулиар, харин нийтлэг харилцааг энэ хуулиар зохицуулахаар тусгасан болно.

Гуравдугаарт, одоо хүчин төгөлдөр үйлчилж буй хуульд төлбөрийн чадваргүйд тооцох үндэслэлийг хуулийн этгээдийн өөрийн хөрөнгөтэй уялдуулан тодорхойлсныг олон улсын жишигт нийцүүлэн өөрчилж, төлбөрийн чадваргүйдлийг оройтохоос нь өмнө эрт илрүүлэх зорилгоор бэлэн мөнгөний урсгалын арга болон балансын аргыг хослуулсан шалгуураар төлбөрийн чадваргүйдлийг тогтоохоор төсөлд тусгалаа.

Дөрөвдүгээрт, нэхэмжлэлийн шаардлагыг баталгаажуулах ажиллагааг хуульд нарийвчлан зохицуулаагүйгээс нэхэмжлэгч нэхэмжлэлийн шаардлагаа үндэслэлгүйгээр нэмэгдүүлэх сөрөг практик бий болсон тул нэхэмжлэлийн шаардлага гаргах, баталгаажуулах, хангуулахтай холбоотой ажиллагааны зохицуулалтыг бүрэн шинэчлэн боловсрууллаа.

Тавдугаарт, төлбөрийн чадваргүй болсон хуулийн этгээдээс авлагатай нэхэмжлэгчдийн эрхийг тэгш хангах, аль болох олон нэхэмжлэгчийг ажиллагаанд хамруулах зорилгоор нэхэмжлэгч нарт мэдээлэл хүргэхтэй холбоотой зохицуулалтыг илүү өргөн хүрээнд тодорхой болгож тусгалаа.

Зургадугаарт, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны гол оролцогч болох хэрэг гүйцэтгэгчид тавигдах шаардлага, түүний эрх, үүрэг, томилгоо, урамшуулал, хариуцлагын зохицуулалтыг олон улсын жишигт нийцүүлэн шинэчилж, хэрэг гүйцэтгэгчийн эрх зүйн байдлыг тодорхой болголоо.

Долдугаарт, дампуурлын хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагаа нь онцгой болон ердийн ажиллагааны аль алиных нь шинжийг агуулдаг онцлогтой тул уг процессын зохицуулалтыг хуулийн төсөлд нарийвчлан тусгаж, энэ хуульд заагаагүй харилцааг Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулиар зохицуулахаар шийдвэрлэлээ.

Наймдугаарт, хуулийн төсөл нь төлбөрийн чадваргүй болсон хуулийн этгээдийн үйл ажиллагааг зогсоож, татан буулгахаас гадна дахин зохион байгуулж, үйл ажиллагааг нь сэргээх, мөн төлбөрийн чадваргүйдлээс урьдчилан сэргийлэхэд чиглэсэн харилцааг зохицуулах зорилготой тул хуулийн нэрийг олон улсын жишигт нийцүүлэн Төлбөрийн чадваргүйдлийн тухай хууль гэж өөрчилсөн болно.

Хуулийн төсөл батлагдсанаар зах зээлийн эдийн засгийн зайлшгүй үзэгдэл болох төлбөрийн чадваргүйдлийн асуудлыг олон улсын жишигт нийцсэн үр нөлөөтэй эрх зүйн орчноор дэмжих боломж бүрдэж байна.

Ингэснээр төлбөрийн чадваргүйдлийг аль болох эрт илрүүлж, үйл ажиллагаагаа үргэлжлүүлэх бодит боломжтой хуулийн этгээдийг авран дэмжих. Харин ийм боломжгүй тохиолдолд бизнесийн харилцаанд оролцогч авлагатай нэхэмжлэгчдийн шаардлагыг тэгш шударгаар хангуулж, хуулийн этгээдийг зохих журмаар татан буулгах нөхцөл бүрдэнэ.

Үүний үр дүнд өрийн гинжин хэлхээ үүсэхээс сэргийлж, нэг этгээдийн төлбөрийн чадваргүйдлээс шалтгаалан олон иргэн, хуулийн этгээд дамжин төлбөрийн чадваргүй болох эрсдэлийг бууруулах, улмаар эдийн засгийг цэвэршүүлэх, эдийн засгийн гацааг арилгах, ажлын байрыг хадгалах, хөрөнгө оруулагчийн эрхийг хамгаалах, чанаргүй зээлээс урьдчилан сэргийлж, зээлийн хүү буурах, санхүү, зах зээлийн харилцааны ил тод байдал, хариуцлагыг дээшлүүлэхэд чухал ач холбогдолтой.

Хуулийн төслийг дагалдуулан хуулийн нэр өөрчлөгдсөнтэй холбоотой 33 хуулийн төсөл, Хууль хүчингүй болсонд тооцох тухай, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуульд нэмэлт оруулах тухай зэрэг нийт 40 хуулийн төслийг боловсрууллаа.

Хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжиж өгөхийг Та бүхнээс хүсье. Баярлалаа.

Н.Учрал: Б.Энхбаяр сайдад баярлалаа.

Төслүүдийн талаарх Хууль зүйн Байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн, Өргөдлийн байнгын хорооны дарга Одсүрэнгийн Номинчимэг танилцуулна.

Индэрт урья.

О.Номинчимэг, Улсын Их Хурлын дарга, Эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2025 оны 5 дугаар сарын 27-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Төлбөрийн чадваргүйдлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн бусад хуулийн төслүүдийн хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг Хууль зүйн байнгын хороо 2025 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн хуралдаанаараа явууллаа.

Хууль санаачлагч хуулийн этгээдийн төлбөрийн чадвартай эсэхийг тогтоох, төлбөрийн чадваргүйдлийн ажиллагаа эхлүүлэх, төлбөрийн чадваргүй хуулийн этгээдийг дахин хөрөнгөжүүлэх, татан буулгах, төлбөрийн чадвартай боловч санхүүгийн хүндрэлд орж төлбөрийн үүргээ зогсоосон хуулийн этгээдэд төлбөрийн чадваргүйдлээс урьдчилан сэргийлэх бүтцийн өөрчлөлт хийхтэй холбоотой харилцааг зохицуулах зорилгоор хуулийн төслийг боловсруулсан байна.

Хууль санаачлагч хуулийн төсөл батлагдсанаар төрийн байгууллагад хэрэг гүйцэтгэгчийн эрх олгох шалгалт болон сургалт зохион байгуулах, цахим мэдээллийн сан бий болгох, холбогдох шийдвэрийг нийтэд мэдээлэх чиг үүрэг нэмэгдэж, үүнтэй холбоотой хүний нөөцийн ачаалал болон нэг удаагийн цахим сангийн зардал, хэвлэл мэдээллийн төлбөр үүсэхээр, мөн иргэнд хэрэг гүйцэтгэгчийн сургалтад хамрагдах, шалгалт өгөхтэй холбоотойгоор баримт бичиг нотариатаар гэрчлүүлэх, сургалтын болон шалгалтын хураамжийн төлбөр зэрэг нэмэлт зардал гаргахаар тооцсон байна.

Уг хуулийн төслийг d-parliament цахим сайтад байршуулж, иргэд олон нийтийн саналыг авч байгаа болно.

Байнгын хорооны хуралдаанаар хуулийн төслийг хэлэлцэх үед –

- Улсын Их Хурлын гишүүн О.Номинчимэг төлбөрийн чадваргүйдлийн үйл ажиллагааны эцсийн зогсоол болох дампуурлын процессын асуудлыг уг хуулиар хэрхэн шийдсэн талаар, хувь хүний төлбөрийн чадваргүйдлийн зохиц зохицуулалтын талаар,
- Улсын Их Хурлын гишүүн Норовын Алтанхуяг төлбөрийн чадваргүйдлийн үе шат болон хувь хүний төлбөрийн чадваргүйдлийн талаар,
- Улсын Их Хурлын гишүүн Пүрэвжавын Сайнзориг хуулийн төсөлд хэрэг гүйцэтгэгчийг бэлтгэх асуудлыг хэрхэн зохицуулсан талаар, арилжааны шүүх байгуулах асуудлаар хууль санаачлагчийн байр суурийн талаар,
- Улсын Их Хурлын гишүүн Саруулсайханы Цэнгүүн Шүүхийн ерөнхий зөвлөл болон бусад байгууллагуудын саналыг төсөлд тусгасан эсэх талаар, төлбөрийн чадваргүйдлийг тодорхойлсны дараах процессыг хэрхэн зохицуулсан талаар,

- Улсын Их Хурлын гишүүн Цэндийн Сандаг-Очир 1997 оны Дампуурлын тухай хуулиар өнөөг хүртэл хэдэн компани эцсийн шүүхийн шийдвэрээр дампуурлаа тогтоолгосон, хохирол нь хэрхэн шийдэгдсэн талаар тоо баримт байгаа эсэх, мөн хуулийн үзэл баримтлал нь дампуурсан хойно нь биш урьдчилан сэргийлэх зөвлөгөө, дэмжлэг үзүүлэхэд чиглэсэн нь зөв эсэх, дампуурах эрсдэлд орсон байдлыг хэн тогтоох, урьдчилан сэргийлэх, зөвлөгөө дэмжлэгийг хэн үзүүлэх талаар хуулийн засалд хэрхэн тусгасан талаар,
- Улсын Их Хурлын гишүүн Л.Соронзонболд төлбөрийн чадваргүйдлийн ажиллагааг эхлүүлэх үндэслэлд тусгасан өөрийн хөрөнгийн 30.0 хувийн зохицуулалтын талаар,
- Улсын Их Хурлын гишүүн Бөхчулууны Пүрэвдорж зээлийн маргааныг хурдан шийдвэрлэх боломж, түүнд үндэслэн зээлийн хүүг бууруулах бодлогын нөхцөлийн талаар, арилжааны буюу санхүүгийн маргааныг шийдэх тусгай шүүх байгуулах боломжтой эсэх талаар тус тус асуулт асууж хариулт авсан болно.

Түүнчлэн Байнгын хорооны хуралдаанаар хуулийн төслийг хэлэлцүүлэх үед –

- Улсын Их Хурлын гишүүн Пүрэвжавын Сайнзориг арилжааны хуультай болсон эсэхээс үл хамаараад арилжааны шүүхтэй болох асуудлын талаар,
- Улсын Их Хурлын гишүүн Хишигдэмбэрэлийн Тэмүүжин хуулийн төсөлд эдийн засаг дахь төрийн оролцооны хүрээ, бизнесийн эрх чөлөөний зарчмыг тодорхой болгож, зөвхөн туслах чиг үүргийг захиргааны хариуцлагын механизмтай андуурахгүй байх нь чухал, эс бөгөөс компаниудын эрх чөлөөг дэмжиж байгаа мэт боловч захиргааны дарамт бий болгосон хоёрдмол зохицуулалт үүсэх эрсдэлтэй талаар,
- Улсын Их Хурлын гишүүн Одсүрэнгийн Номинчимэг төлбөрийн чадваргүйдэл, дампуурлын ойлголтыг ялган тодорхой болгож процессыг нарийвчлан чамбайруулахын зэрэгцээ амины эрхийн харилцааны суурь болох Иргэний хуулийн үзэл баримтлалтай уялдуулан бизнесийн орчин, хувийн хэвшлийн орон зайг тэлэх чиглэл бодлогын түвшинд цогцоор нь үнэлж ажиллах шаардлагатай талаар,
- Улсын Их Хурлын гишүүн Л.Соронзонболд Монгол Улсад бизнесийн орчныг сайжруулах, компаниудын хоорондын харилцан итгэлцэлтэй бизнес хийх боломжийг нэмэгдүүлэх зохицуулалтад ажлын хэсэг цаашид онцгой анхаарах шаардлагатай талаар,

- Улсын Их Хурлын гишүүн Дамдины Цогтбаатар Төлбөрийн чадваргүйдлийн тухай хуулийн төслөөр хувь хүн болон хуулийн этгээдийн зохицуулалтыг тусад нь авч үзэх, татан буулгах үйл явцыг сунжруулахгүй болгох, 3 сар 30 хувь гэсэн босгыг эдийн засгийн хямралын нөхцөлтэй уялдуулан уян хатан шийдэх, гадаадын хөрөнгө оруулалтад саад болж буй эрх зүйн гажуудлыг засах талаар, Хууль зүйн болон Эдийн засгийн байнгын хорооны өргөн бүрэлдэхүүнтэй ажлын хэсгийг Улсын Их Хурлын даргын захирамжаар байгуулах нь зүйтэй талаар тус тус үг хэлж, байр сууриа илэрхийллээ.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1 дэх хэсэгт заасны дагуу санал хураалт явуулахад Төлбөрийн чадваргүйдлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн бусад хуулийн төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаан хуралдаанаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэж үзлээ.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Төлбөрийн чадваргүйдлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн бусад хуулийн төслүүдийн хэлэлцэх эсэх талаар Хууль зүйн Байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг Та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Н.Учрал: О.Номинчимэг гишүүнд баярлалаа.

Ажлын хэсгийг танилцуулъя.

Улсын Их Хурлын гишүүн, Хууль зүй, дотоод хэргийн сайд Баттөмөрийн Энхбаяр, Хууль зүй, дотоод хэргийн дэд сайд Дэмбэрэлцэрэнгийн Мөнх-Эрдэнэ, Хууль зүй, дотоод хэргийн яамны Хууль зүйн бодлогын газрын дарга Ядамсүрэнгийн Жавхлан, Монголбанкны Хууль, эрх зүйн газрын Банк, санхүүгийн хэлтсийн захирал Өлзийбатын Мөнх-Ундарга, Хууль зүй, дотоод хэргийн яамны Хууль зүйн бодлогын газрын Хувийн эрх зүйн хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Оюунбаатарын Оюунзул, Монголын өмгөөлөгчдийн холбооны гишүүн өмгөөлөгч Амгалангийн Энхболд гэсэн ажлын хэсэг хүрэлцэн ирсэн байна.

Улсын Их Хурлын гишүүд Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулж бүлэг болон бүлэгт харьяалагдаагүй гишүүдээс урьдчилан ирүүлсэн нэрсийн дагуу асуулт асууж, хариулт авна.

Х.Баасанжаргал гишүүнээр тасаллаа. Бөхчулууны Пүрэвдорж гишүүн асуулт асууна.

Б.Пүрэвдорж: Ихэнх дампуурч байгаа компаниудын асуудал юунаас болж үүсэж байна гэхээр маш их өндөр хүүтэй зээлийн хүүнээс болж байгаа.

Өөрөөр хэлбэл Монголын дундаж зээл 16, 17 хувьтай байна. Банк бус санхүү болон Хадгаламж, зээлийн хоршооны зээл 36 хувиас багагүй байна. Үүнээс болж олон компаниуд дампуурч байгаа юм.

Тэгэхээр зээлээ төлөхгүй, түүнээсээ болж банк, компани, аж ахуйн нэгж, иргэний хооронд шүүхийн маргаан болдог. Шүүхийн маргаан нь дунджаар 4.7 жил болж байгаа юм. Дээд тал нь 20 жил шүүхдэж маргалдаж явж байгаа компаниуд байна.

Тэгээд үүнд бүр хамжигчаар оролцдог бүлэг хүмүүстэй болсон. Тэр нь үнэлгээчин, өмгөөлөгч гээд. Жишээ нь, банк нэг үнэлгээ ч авдаг. Маргаж байгаа аж ахуйн нэгж нэг үнэлгээчин авдаг, шүүх нэг үнэлгээ ч авдаг. Тэр болгон дээрээ маргалдаад яваад байдаг, яваад байдаг. Энэ нь зээлийн хүүг өндөр болгоход маш их нөлөөлж байгаа.

Хэрвээ зээлийн шүүхийн маргааны асуудлыг богино хугацаатай, өөрөөр хэлбэл –

- бага зээлийг 6 сарын дотор,
- дунд зээлийг 8, 9 сарын дотор,
- их хэмжээний зээлийг 12 сарын дотор –

хэрвээ шийдэх юм бол өнөөдрийн байгаа хүүг даруй 4.2 пунктээр буулгах боломж байна гэж яригдаад байгаа юм.

Тэгэхээр зээлийн хүү өндөр байгаа нь бусад аж ахуйн нэгжүүд, өөрөөр иргэн, аж ахуйн нэгжүүд сайн төлдөг, тэр хүмүүсийн зээлийн хүү өндөр болгож тэр зардлыг нь ихэсгээд байна.

Тийм учраас шүүх дээр очингуут нөгөө маргаж байгаа аж ахуйн нэгжийн зээлийн хүүг нь зогсоодог. Түүнээсээ болоод зардал нь өсөөд байгаа байхгүй юу даа.

Тийм учраас ер нь гэрээний эрх зүйтэй хэдэн зуун жил явсан энэ улс орнуудад “**Commercial Court**” ч юм уу, аль эсвэл “**Financial Court**” гээд янз янзын нэртэй шүүхүүд байдаг. Өөрөөр хэлбэл санхүүгийн юм уу, аль эсвэл арилжааны шүүхүүд байж байдаг.

Тэд нар маш богино хугацаанд зээлийн шүүхийн маргааныг доор нь шийддэг тогтолцоонууд маш их байгаа.

Тэгэхээр Монголд яг энэ дагнасан шүүхийг –

- арилжааны шүүх юм уу,
- санхүүгийн шүүх юм уу,
- бизнесийн шүүгчид юм уу –

тийм нэртэйгээр ийм шүүхийг байгуулах боломж юу байна аа?

Тэр шүүх байгуулагдлаа гэхэд жишээ нь компани, аж ахуйн нэгжүүдээс маш бага шимтгэл аваад тэгээд түүнийхээ дагуу санхүүжээд явах, тэгээд асуудлыг хурдан шийдвэрлэх боломж нь байгаа юм л даа.

Тийм учраас энэ дээр нэг тодорхой хариулт өгөөч. Зээлийн хүү бол монголчуудыг дампууруулах үндсэн шалтгаан болоод байгаа юм.

Тийм учраас шүүхийн маргааны асуудлыг эхлэн шийдвэрлэж байж дараа дараагийн компаниудаа дампууруулахгүй, аж ахуйн нэгжүүдээ, дампууруулахгүй иргэдээ дампууруулахгүй тэр хөрс суурийг бий болгох юм.

Энэ дээр хариулт авъя.

Н.Учрал: Б.Энхбаяр сайд хариулна.

Б.Энхбаяр: Б.Пүрэвдорж гишүүний хэлж байгаа яг бодитой асуудал.

Энэ нь их олон жил яригдаж байгаа. Сүүлийн 10, 20 жил л шүүхийн дээр явж байгаа шийдвэр гүйцэтгэлийн ажиллагаа, арилжаа, гэрээ, зээлийн маргаанууд удаан хугацаагаар явдаг нь зээлийн хүүд нөлөөлж байгаа гэдгийг Монголбанкны жил болгоны мөнгөний бодлогын тайланд ч гэсэн энд дурдагддаг.

4.7 жилийн дунджаар шийдвэр гүйцэтгэлийн ажиллагаа явагдаж байгаа гэдэг Монголбанкны жил болгоны мөнгөний бодлогын тайланд байгаа тоо.

Энэ хүрээнд бидний оруулж байгаа хуулиас гадна хэд хэдэн багц хуулийн өөрчлөлт хийгдэх учиртай.

Таны хөндөж байгаа “худалдааны шүүх” гэнэ үү, “арилжааны шүүх” гэнэ үү, энэ бие даасан хэлбэрээр ажиллахаас гадна бид одоо байгаа эрх зүйн орчныхоо хүрээнд юу хийж болох вэ гэдгийгээ үзэж байгаа.

Хууль зүйн сайд ажлаа аваад долоо хоногийн дараа Улсын дээд шүүхийн нийт шүүгчидтэй уулзсан. Хялбар ажиллагааны шүүх байгуулсан байгаа. Тэнд

тэгэхдээ зохиомол ачаалал үүссэн байгаа. Тэр нь шүүхийгээ оролцогчийг гомдол гаргах, маргаанаа мэдэх эрхээр хангахын тулд нөгөө хүндээ хаягаар нь яаж шүүх хуралдаан болох гэж байгааг нь хүргэх вэ гэдэг энэ зохицуулалт их түвэгтэй учраас бүр хэдэн арван мянгаар хэрэг овоорсон байгаа юм.

Цахимаар нь юм уу, мэйл хаягаар нь зарыг нь хүргэснээр шүүх хурал зарлагдсанд тооцох юм уу, яах юм. Заавал гэрийн хаягаар нь хүргэснээр тооцох юм уу гэдэгтэй холбоотой маргаан үүсээд байгаа.

Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн цогц өөрчлөлт шаардлагатай байгаа.

Улсын дээд шүүх ер нь шүүхийн хэрэг маргааны гуравны хоёр нь дангаараа иргэний хэрэг байгаа. Иргэний шүүхийн ачаалал хэт өндөр байгаа. Монгол Улсын Дээд шүүхийн иргэний танхим ажлын 5 өдрийн 4 өдөр нь өглөө 9-өөс орой хүртэл шүүх хурал хийдэг. Бүр ийм хэтийдсэн ачаалалтай болоод байгаа. Бусад шүүхтэй харьцуулахад.

Тийм учраас магадгүй Улсын дээд шүүх нэг танхимаа гэрээ, арилжааны маргаануудыг шийдвэрлэх чиглэлээр Иргэний танхимаа хоёр хуваах шаардлага би байгаа юм байна даа гэж харсан.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны хуулийг Засгийн газар өчигдөр Засгийн газрын хуралдаанаар хэлэлцээд татаж авахаар шийдвэрлэсэн. Энэ хуулийг татаж авч байгаа нь Б.Пүрэвдорж гишүүний ярьж байгаа Иргэний шүүхийн шийдвэрийг шүүхийн процессын нэг хэсэг гэдэг байдлаар оруулж ирэх концепцыг барина.

Өөрөөр хэлбэл шийдвэр гүйцэтгэлийн ажиллагаа дээр гомдол гаргаж, давж... /минут дуусав/

Н.Учрал: Нэмэлт 1 минут өгье.

Б.Энхбаяр: Шийдвэр гүйцэтгэлийн ажиллагаа дээр гомдол гаргаж хугацаа хождог жишиг тогтсон байна.

Жишээлбэл, сая хоёр долоо хоногийн өмнө Улсын дээд шүүх нэг маргаан шийдвэрлэсэн. 300 сая төгрөгийг банк бус санхүүгийн байгууллагаас зээлсэн этгээд 8 жилийн хугацаанд 80 мянган төгрөгийн шүүхэд зардал гаргаад зээлээ төлөхгүй шийдвэр гүйцэтгэлийн ажиллагааг эргээд шүүхэд нь хандаж гацаасан.

300 сая төгрөгийг 8 жилийн хугацаанд 80 мянган төгрөгийн зардалтайгаар төлөхгүй байх боломжтой эрх зүйн орчинд бид байна гэсэн үг.

Тийм учраас шийдвэр гүйцэтгэлийн ажиллагааны үе шат дээр эргээд шүүхэд нь гомдол маргаан гаргадаг энэ процессыг бид болиулах ёстой юм билээ. Шүүхийн шийдвэр бол эцсийн шийдвэр байж, шууд хэрэгждэг жишиг рүү явуулна гэсэн бодолтой байгаа.

Н.Учрал: Хишигдэмбэрэлийн Тэмүүжин гишүүн асуулт асууна.

Х.Тэмүүжин: Дампууралтай холбоотой, төлбөрийн чадваргүйдэлтэй холбоотой хуулийн шинэ орчин үүсгэх гэж байна.

Концепц, бодлогын хувьд хуулийн төслийг дэмжиж байгаа.

Гэхдээ зөвхөн энэ хуулийн төсөлтэй холбогдуулаад биш, бид төрд байгаа буруу хандлага, жишгийг янзлах ёстой юм байна гэж харагдаж байгаа. Тухайлбал, манай төрийн хяналт шалгалт хэрэгжүүлдэг татвар, гааль гэх мэтчилэн байгууллагуудад суусан байгаа нэг буруу хандлагыг зогсоомоор байна.

Өчигдөр фэйсбүүк дээр харагдаж байна. Татварын байцаагч нэг эмэгтэйн хэлж байгаа үг. Ерөөсөө аж ахуй, бизнес эрхлэлтийн амьдарч байгаа нийгмээсээ бүр тасраад алга болж. Уг нь ямар нэгэн хуулийн этгээд бизнес эрхлээд, ажлын байр нэмэгдүүлээд, иргэдийг орлогожуулаад, дээр нь эдийн засгийг тэлэхэд хувь нэмэр оруулаад, тодорхой хэмжээний татвар төлөөд явна гэдэг чинь улс орны хамгийн эрхэм үнэ цэнтэй зүйл байхгүй юу.

Гэтэл манай байгууллагууд чинь юу болоод хувирав гэхээр ерөөсөө л сааж амьдарч байгаа үнээгээ л алж идэх гээд л, аль болох л хуулийн этгээдийг татан буулгах гээд, төсөв мөнгө гэдэг юм уу, татварынхаа дарамтыг хамгийн чухал гээд ойлгосон юм уу, дансыг нь хааж байгаад ч болтугай, ер нь үйл ажиллагааг нь боомилж байгаад ч болтугай ирэх жил энэ байгууллага байсан ч яалаа, байгаагүй ч яалаа, өнөөдөр л би авах ёстой юмаа авч байвал гэдэг хандлагаар хардаг байдлыг зогсоомоор байна.

Хоёрт нь, төр хувийн хэвшилтэй байгуулсан гэрээ хэлцэл, хэлсэн үгэндээ хүрмээр байна. Төрийн буруутай хариуцлагагүй үйл ажиллагаанаас болоод компаниуд дампуурч байна шүү дээ.

Төрийн тендерт ороод уг нь тоног төхөөрөмжтэй байсан юм. Тендерт ороод ажлаа хийсэн. Одоо юу болсон гэхээр банкныхаа зээл, хүүг дийлж чадахаа байсан. Төр мөнгөө өгөхгүй. Сүүлдээ тоног төхөөрөмжөө хураалгаад шалдан гарч байна шүү дээ гэдэг компаниуд бий болоод эхэллээ.

Тэгэхээр компаниуд өөрсдөө хариуцлагаа үүрээд дампуурч байгаа биш, төр үүргээ гүйцэтгээгүйгээсээ болоод, төр хэтэрхий дарамталсанаасаа болоод хуулийн этгээдүүд дампуурдаг байдлууд бий болжээ.

Үүний ард дахиад нэг алдаа байна. Тэр нь ямар алдаа байна вэ гэхээр хуулиудад Сангийн яамны амбиц яагаад хуульчлагдаад байна аа? Уг нь хуулийн этгээдийг татан буулгах гуравхан л арга зам байгаа.

- ▶ **Нэгд нь**, Эрүүгийн хуульд заасан гэмт хэрэг үйлдээд татан буугдсан.
- ▶ **Хоёрт нь**, Дампуураад татан буугдаж байгаа.
- ▶ **Гуравт нь**, Өр зээл, төлбөргүйгээр өөрөө хүсээд хуулийн этгээдээс хасагдаж байгаа бол.

Гэтэл 4 дэх зүйл гараад ирсэн.

Сангийн яаманд санхүүгийн тайлан гаргаж өгөөгүйгээс болоод хуулийн этгээд, компаниуд хуулийн этгээдийн бүртгэлээс жагсаалтаараа алга болдог жишиг тогтоод.

Ер нь татварын байгууллага, Сангийн яамны амбицыг хууль руу хяналтгүйгээр оруулж ирэхгүй байх хэрэгтэй байна.

Татварын тайлан гаргаагүй гээд шийтгэдэг зохицуулалт нь шударга ёсны хэмжүүрээр зөвтгөгдөж болох боловч Сангийн яамны шаардаж байгаа баримт бичгийг өгөхгүй байгаа гэдэг нь, эсвэл санхүүгийн тайлангаа Сангийн яаманд гаргаагүй гэдэг, эсвэл татварын байгууллагатай таагүй хандсан гэдэг нь тэр хуулийн этгээдийг шийтгэх, яллах, дарамтлах хэрэгсэл болоод байна.

Хууль зүйн яам энэ дээр нэг бодлого гаргаад, яах гэж Зөрчлийн хууль, Эрүүгийн хуулийг Хууль зүйн яамны хяналтаас гадуур хэн ч шийдэхгүй гэдэг хуулийн соёл бий болж байгаагийн нэг илэрхийлэл гэдгээрээ Сангийн яамны нэг цензур тогтоох хэрэгтэй болжээ.

Тэгэхгүй бол хуулийн этгээдүүд, аж ахуйн нэгжүүдэд чинь дарамт нь... /минут дуусав/

Б.Пүрэвдорж: Сайд Баттөмөрийн Энхбаяр хариулъя.

Б.Энхбаяр: Х.Тэмүүжин гишүүнтэй санал нэг байгаа.

Сая хоёр долоо хоногийн өмнө Монгол Улсын Засгийн газраас **“Мянган журмыг цэгцэлье”** гэдэг шийдвэр гарсан.

- ▶ Манай улс үндсэндээ 3500 орчим журамтай байна. Бүртгэлгүй 800 гаруй журам байна.
- ▶ 800 гаруй журмынх нь 350 нь Монгол Улсын Засгийн газрын тогтоолоор батлагдсан журмууд байгаа.

- ▶ Нийтдээ Монгол Улсын 400 гаруй хуулийн 350 хуульд нь 2420 журам гаргана гэдэг эрх олгосон заалт орсон байна.

Энэ юунаас үүдэлтэй байна вэ гэхээр бид хориод жилийн өмнө ер нь захиргааны хэм хэмжээний нийтээр үйлчилж байгаа журмуудыг “хуульд эрх олгоогүй бол нийтээр дагаж мөрдөхгүй” гэдэг бид стандартыг хуульдаа бариад эхэлсэн чинь сүүлийн 10 гаруй жил орж ирж байгаа, эсвэл Их Хурал дээр хэлэлцэгдэж байгаа хуулиуд дандаа “үүнийг нь журмаар зохицуулна”, тэрийг нь “журмаар зохицуулна” гэдэг хуулийн төслүүд бид сүүлийн 10 гаруй жил их хурдацтай баталсан байна.

Зөвхөн ковидоос хойш буюу сүүлийн 5 жилийн хугацаанд манай улс дахь журмын тоо 4 дахин нэмэгдсэн байна.

Энэ дотор таны хөндөж байгаа санхүү, эдийн засгийн чиглэлийн, гааль, татварын журмууд 130 орчим байна. Зөвхөн –

- ➔ гаалийн байгууллага дээр 70 орчим журам,
- ➔ татварын байгууллага дээр 60 орчим журам байна.

Бүр ийм журам манай Хууль зүйн сайдын эрхлэх асуудлын хүрээнд баталсан байна. Жишээлбэл, “**Persona Non Grata**” буюу Монгол Улсын хувьд “тааламжгүй этгээд” гэж тогтоогоод албадан гаргах шийдвэр гарсан этгээдийг манай Сангийн яамныхан мөн Засгийн газрын тогтоолоор журамдаа “тэр хүн нь татварын өртэй байвал гаргахгүй” гэдэг заалт оруулсан байна.

Монгол Улс “тааламжгүй этгээд” гээд албадан гаргах гэж байгаа этгээдийг хүртэл “татварын өртэй байна, таныг гаргахгүй” гээд.

Сангийн яамныхан тэр хүн тагнуул байх нь ч хамаагүй мөнгийг нь л авч байх ёстой гэдэг нүдээр бүх юмыг хардаг болж.

Ийм нөлөөллүүдээ –

- татварын хуулиуд дээр,
- хуулийн этгээдийн бүртгэлийн хуулиуд дээр,
- зөрчлийн хуулиуд дээр –

Сангийн Яам, татвар, гаалийн байгууллагууд –

- оруулж ирдэг,
- баталдаг,
- лоббиддог –

гэдэг Х.Тэмүжин гишүүний санал бодит үнэн.

Үүнийг хэдүүлээ хамтдаа цэвэрлэе.

Би Сангийн сайдтайгаа ний нуугүй хэлэхэд хоёр долоо хоног Засгийн газар дээр энэ журмуудынх нь асуудлаар хэрүүл хийгээд сууж байна. /минут дуусав/

Б.Пүрэвдорж: Одоо Одсүрэнгийн Номинчимэг гишүүн асуулт асууж, үг хэлнэ.

О.Номинчимэг: Төлбөрийн чадваргүйдлийн тухай хуулийг хэлэлцэх эсэхийг дэмжиж байгаа.

Түрүүн Хууль зүйн сайдын танилцуулгад дурдагдаж байсан. Монгол Улс дахь бизнес эрхлэлтийн рейтинг гэдэг юм уу, үнэлгээгээр бидний үнэхээр сүүл мушгиж явдаг зүйл бол Дампуурлын хуулийн эрх зүй, Төлбөрийн чадваргүйдлийн хуулийн эрх зүйн орчин байгаа юм.

Олон жил яригдаад шинэчилж чадахгүй асуудал байгаа. Энэ бол үнэхээр Монгол Улсад бизнес эрхлэлтийг, дотоодын болон гадаадын хөрөнгө оруулагчдын хувьд ч гэсэн хамгийн том саад учруулдаг асуудал.

Тэгэхээр шинэ эрх зүйн орчныг бүрдүүлэх тал дээр энэ хуулийг хэлэлцэх эсэхийг нь дэмжээд, хууль дээр сайтар ажиллаад явах нь зүйтэй гэсэн байр суурьтай байгаа.

Дампуурал буюу төлбөрийн чадваргүйдлийн тухай хууль маань өөрөө цаад агуулга нь хувийн хэвшлийнхээ эрүүл, тогтвортой, шударга орчныг бүрдүүлэхэд л зорьж байгаа.

Бизнесийг шууд дампууруулаад дуусгана гэхээсээ илүү аврах боломжоор хангах хууль эрх зүйн орчныг бий болгоё гэдэг үзэл санаагаар орж ирж байгааг дэмжиж байгаа.

Амьдрах чадвартай бизнес нь зах зээлдээ үлддэг. Амьдрах чадваргүй бизнес нь байхгүй болдог тодорхой байдлыг бий болгохгүй бол энэ маань өөрөө эдийн засаг, зээлийн харилцаа, бизнес, хөрөнгө оруулалтын нөхцөлд маш их далд зардал, эрсдэлүүдийг авчирч, өөрөө түрүүний хэлээд байгаа тэр зээлийн хүү өндөр байх. Тийм ээ. Далд зардал өндөр байх нөхцөлийг бүрдүүлээд байдаг.

Амьдрах чадвартай бизнес маань өөрөө үлдээд, дампуурахаасаа өмнө арга хэмжээ аваад үлдэх юм бол ажлын байр ч гэсэн тогтвортой хадгалагдана.

Зах зээлийн эрүүл цэвэрлэгээний үр дүнд амьдрах чадваргүй компани байхгүй болохгүй бол Монгол Улс чинь компанийг дампууруулаад шүүхээр

эцэслэн шийдвэрлүүлэх нь бараг сар луу нисэхтэй адилхан хэцүү ховор зүйл болоод байгаа. Ерөөсөө чаддаггүй. Байхгүй. Тэр процесс ерөөсөө явж чаддаггүй.

Эцэст нь олон улсын нэршлээрээ “зомби компаниуд” гэж байдаг. Баахан дампуурсан, эцэслүүлж чадаагүй цаасан дээрх компаниудтай болсон.

Ингээд энэ дээр нэг хэлэх ёстой юм нь аж ахуйн нэгжүүдийг мэдээж бизнес орчныг сайжруулна. Дээр нь нэмээд хэрвээ аж ахуйн нэгжүүд төлбөрийн чадваргүй, эсвэл бизнес нь дампуурах юм блд түүнээс авлагатай нэхэмжлэгчдийн эрхийг тэгш хангах асуудал маш чухал.

Тэгэхээр энэ бол хэн түрүүлж нөгөө барьцаагаа авсан, хэн түрүүлж хүчтэй нь илүү өр төлбөрөө хангуулаад, хүчгүй нь энэ өр төлбөрөө авч чадахгүй үлддэг энэ нөхцөлийг сайжруулах зорилготой байх ёстой.

Тэгэхээр шударга хуваарилалтын асуудал Төлбөрийн чадваргүйдлийн тухай хуулийн хамгийн том бас нэг зорилтын нэг байх ёстой.

Тэгэхгүй бол бас энэ асуудлуудыг харахаар компаниуд дампуурахаасаа өмнө өөрийн мэддэг таньдаг хүмүүстээ хөрөнгүүдээ тараагаад гаргадаг. Тэгээд нөгөө ажиллаж байсан ажилчид нь нийгмийн даатгалын шимтгэлээ ч төлж чадахгүй хохироод үлддэг кэйсүүд гардаг.

Тэгэхээр энэ бол ийм ач холбогдолтой хууль байгаа учраас хэлэлцэх эсэхийг дэмжиж байна. Тэгээд Хууль зүйн байнгын хороон дээр нэлээн асуудлаа сайн хэлэлцсэн учраас асуулт гэхээсээ илүү үг хэлж байна.

Б.Пүрэвдорж: Баярлалаа. Нямтайширын Номтойбаяр гишүүн алга байна.

Пүрэвжавын Сайнзориг гишүүн асуулт асууна.

П.Сайнзориг: Оройн мэнд ээ. Хуулийн төслийг хэлэлцэхийг дэмжиж байна.

Өнөөдөр Монгол Улсын хөрөнгө оруулалтын орчин дээр нэг томоохон хойш татдаг үзүүлэлт бол энэ дампуурал буюу төлбөрийн чадваргүйдлийн асуудлыг танай улс маш ерөнхий байдлаар зохицуулснаас шалтгаалаад хөрөнгө оруулалт хийж байгаа этгээдүүд аливаа санхүүгийн эрсдэл хүлээхэд яаж бизнесээс exit хийх вэ буюу гарах арга зам нь тодорхойгүй учраас хөрөнгө оруулалт хийхэд том эрсдэлтэй гэдэг үнэлгээг удаа дараа олон улсын байгууллагууд өгч байсан. Энэ асуудлыг шийдье гэж байгаа.

Тэгээд энэ дампуурал, төлбөрийн чадваргүйдлийн асуудал гэдэг бол нэг их татвар, нийгмийн даатгалын өр төлбөрөөс зугтах гээд байгаа асуудал биш.

Тэр хууль бус дампуурал, зохиомол дампуурал чинь угаасаа гэмт хэрэг. Энэ нь өөрөө эргээд бизнес болгон амжилттай байдаггүй. Тодорхой гадаад, дотоод нөхцөл байдлаас болоод оруулсан хөрөнгө оруулалтууд болон байгаа компанийн өрийн хөрөнгө багасаж байдаг.

- Санхүүгийн тодорхой шалгуур дээр хөрөнгө оруулсан этгээд буцааж байгаа хэмжээнд нь эрсдэлийг томруулахгүйгээр хөрөнгөө авъя л гэсэн санаа.
- Энэ үйл ажиллагааг шүүхийн оролцоотой хийе л гэсэн санаа.
- Тэр ажлын байрыг аваръя гэсэн санаа.
- Тэнд ажиллаж байгаа 5 хүнийг ч гэсэн ажлын байртай нь үлдээе.
- Илүү дутуу чиг үүргийг дахин зохион байгуулалт хийж, шийдье л гэсэн санаа.

Энэ санхүүгийн эрсдэл өрийн сүлжээг ихэсгэхгүйгээр шүүхийн оролцоотой байгаа хөрөнгүүдийг нь яг түрүүн манай О.Номинчимэгийн хэлдэг шиг тэгш зөв хуваарилаад дуусгая. Бизнес хийж байгаа хүмүүс дараагийн боломжийг нь олгоё гэсэн хууль байхгүй юу. Тэгээд та хэд маань дэмжиж өгөөрэй гэж хүсэж байна.

Хоёрдугаарт, би Б.Пүрэвдорж даргын түрүүн хэлсэн санааг үргэлжлүүлмээр байна. Маш чухал санаа хэлээд байгаа.

Бизнес эрхлэгчдийн хоорондын маргаан буюу B2B (Business-to-Business) дээр үүсэж байгаа маргааныг иргэний маргаан шийдэж байгаа юм шиг явж болохгүй байгаа юм.

Манай арилжааны эрх зүй, иргэний хэрэг, Иргэний хууль болон Иргэний хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль дээр явж байгаа. Энэ өмгөөлөгч солих төдий хэрэг маргаан шүүх дээр зогсдог. Энэ ерөөсөө байж болохгүй. Цаана нь мөнгөний эргэлт буюу цусны эргэлт зогсож байгаатай ялгаагүй байхгүй юу. Хүний.

Тийм учраас энэ хариуцлагатай мэргэжлийн оролцогч нар бас гэрээ контракт хийж байгаа учраас энэ өмгөөлөгч сольё ч гэдэг юм уу, тодорхой маргаан үүсгэнгүүт л шүүх дээр бүх зүйл нь зогсдог энэ байдлаас ангижраад, илүү их мөнгө, бизнесийн асуудлыг мэддэг мэргэшсэн шүүгч нар энэ маргааныг нь шийдэж өгдөг. Тэнд эрх зүйч гэхээсээ илүүтэй санхүүчид, нягтлан бодогч нар ажиллаж байдаг ийм шүүхийг бид байгуулж бизнес эрхлэгчдэдээ тусалмаар байна, дэмжмээр байна.

Тэгээд манай ажлын хэсгээс асууя. Яг энэ хууль гарснаар бизнесийн орчин дээр эерэг нөлөө үзүүлэх 5 нөхцөл гэдэг юм уу, 5 эерэг үзүүлэлтийг хэлээч. Яг энэ хууль батлагдаад өгвөл бизнесийн орчинд ямар эерэг өөрчлөлтүүд авчрах вэ. Та бүгд хэлээч?

Тэгээд энэ хуулийг нэг амилуулах асуудал тэр мэргэшсэн шүүгчээс гадна шүүгчид тусалж байгаа тэр хэрэг гүйцэтгэгчийн асуудал байгаа юм. Энэ шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн асуудал биш шүү. Хэрэг гүйцэтгэгчийн ажлыг шийдэхийн тулд бид Худалдаа, аж үйлдвэрийн танхимын хуулийг зайлшгүй ярих ёстой.

Хэрэг гүйцэтгэгчид яг компанийн захирал шиг хүмүүс байхгүй юу. Бизнес авч явж чадах мэдлэгтэй, ур чадвартай, шүүхтэй харилцах хуулийн мэдлэгтэй. Энэ тал дээрээ тэр нэхэмжлэлийн шаардлага гаргаж байгаа хүмүүсийн эрэмбийг зөв тогтоодог, асуудлыг нь сонсож чаддаг, шийдэл хувилбаруудыг танилцуулж чаддаг хүмүүс байх ёстой юм. Энэ хүмүүсийг хэрхэн яаж бэлтгэх вэ, чадавхжуулах вэ, энэ дампуурлын эрх зүйг үр нөлөөтэй ажиллуулахад хамгийн чухал хүний нөөц нь эндээ байгаа.

Тэгэхээр энэ дээр ямар бодлогын асуудал байгаа вэ? Ажлын хэсэг хариулж өгөөч.

Доод эрэмбийн болон дээд эрэмбийн нэхэмжлэлийн шаардлагууд байгаа.

Энэ дээр манай татвар, нийгмийн даатгалынхан хамгийн түрүүнд авна гээд байгаа учраас гадаадын хөрөнгө оруулагч нар бид энэ төрийн чинь араас нь бид хөрөнгөө татах энэ ажиллагаа явах юм бид хэд Монгол Улсад хөрөнгө оруулалт хийхгүй л гэж байгаа байхгүй юу. Яг шулуухан ярихад. /минут дуусав/

Б.Пүрэвдорж: Индэрийн 4 дүгээр микрофон. Ажлын хэсэг. Албан тушаал, нэрээ хэлээд хариулаарай.

Д.Мөнх-Эрдэнэ: Хууль зүй, дотоод хэргийн дэд сайд Д.Мөнх-Эрдэнэ. Их Их Хурлын гишүүн П.Сайнзориг асуултад хариулъя.

Үнэхээр энэ хууль хөрөнгө оруулалтын эрх зүйн орчныг сайжруулах чиглэлээр хийгдэж байгаа томоохон шинэчлэлийг агуулсан ийм хуулийн төсөл байгаа.

Төлбөрийн чадваргүйдэл гэсэн том цогц ойлголтын жижигхэн хэсэг болсон дампуурал гэсэн агуулгаар өнөөг хүртэл энэ харилцааг зохицуулж ирсэн бид өргөн агуулгаар нь таны түрүүний хэлсэн бизнес эрхлэгчид боломж олгох, хөрөнгө оруулалтын орчныг сайжруулах энэ чиглэлээр энэ концепц Засгийн газраас боловсруулагдаж оруулж ирсэн байгаа.

Тэгээд таны асуусан 5 давуу талаас ярих юм бол энэ бол өөрөө төлбөрийн чадваргүйдлийг эрт илрүүлснээрээ үйл ажиллагаагаа үргэлжлүүлэх бодит боломжийг, хуулийн этгээдийг аврах тэр боломжийг энэ хуулийн төслөөр бий болгож байгаа.

Үнэхээр боломжгүй нөхцөл байдал үүсэж байгаа тохиолдолд авлагатай нэхэмжлэгчдийн шаардлагыг хангаж тэр оруулсан хөрөнгө оруулалтаа нөхөх, хохирохгүй байх, бага хохирох боломжийг бас бүрдүүлж өгч байгаа.

Ингэснээрээ өрийн гинжин хэлхээ үүсэхээс сэргийлж, нэг этгээдийн төлбөрийн чадвар гүйлгээгээс шалтгаалан олон иргэн, хуулийн этгээд хохирохоос сэргийлж өгч байгаа давуу талтай.

Хөрөнгө оруулалтын эрх зүйн орчин сайжирснаар бизнесийн орчин сайжирч зээлийн хүүгээс авхуулаад бизнес эрхлэх орчин сайжрах үр дүн гарна гэж үзэж байгаа юм.

Дэлхийн банкнаас 2003-2020 оны хооронд явагдсан “Doing Business” (Бизнес эрхлэхүй) индексийн 10 шалгуур үзүүлэлтийн нэг болсон төлбөрийн чадваргүйдлийг зохицуулах шалгуур үзүүлэлтээр манайх дэлхийн улс орнуудаас сүүл мушгиж байгаа. 154 дүгээр байранд байгаа. Одоо шинээр хэрэгжиж эхэлж байгаа бизнесийн бэлэн байдлын индексийн эхний 10-т ялгаагүй 10 шалгуур үзүүлэлтийн нэг нь энэ төлбөрийн чадваргүйдлийг хэрхэн зохицуулж байна вэ гэдэг байгаа.

Бид хөрөнгө оруулалтыг сайжруулах, дотоод гадаадын аль алинд хамааралтай. Хөрөнгө оруулагчийн эрх ашгийг хамгаалах, нөгөө талаасаа бизнес эрхэлж байгаа хүмүүсийнхээ эрх ашгийг хамгаалах боломж олгох энэ эрх зүйн орчныг бүрдүүлье л гэвэл энэ хуулийг баталж гаргахаас өөр арга байхгүй. Үүнийг хөрөнгө оруулагчдын эрх ашиг ч шаардаж байгаа, зах зээлийн орчин ч шаардаж байгаа.

Тийм учраас цагаа олсон зайлшгүй шаардлагатай хуулийн төсөл орж ирсэн гэж хэлье. Баярлалаа.

Б.Пүрэвдорж: П.Сайнзориг гишүүн тодруулъя.

П.Сайнзориг: Баярлалаа. Тэгээд ер нь хуулийн төслийг хэлэлцэх явцад ч гэсэн олон нийтэд бизнесийнхэндээ сайн ойлгуулж өгөөрэй.

Тэгээд аливаа юмыг монголчууд хэлдэг дээ. Хоёр чихнээс өөр өгөх юмгүй болтлоо найз нөхдийнхөө итгэлийг алдаж явахаасаа илүүтэйгээр байгаа эрсдэл үүссэн. Таны оруулсан 100 төгрөг 80 төгрөг дээр хүрчхээд байна. Миний оруулсан 100 төгрөг бас 80 төгрөг дээр л хүрчхээд байна.

Бид хоёрын нийлж байсан 200 төгрөг бизнес хийх явцад 160 төгрөг болтлоо эрсэдчхээд байна. Үүнийгээ хэрхэн яаж хоёулаа татвар, нийгмийн даатгалынхаа өр төлбөрийг төлөөд ч юм уу, эсвэл тэр банкны зээлээ төлчхөөд үлдэгдлээ яаж зохистой хэмжээнд хуваарилаад гарах вэ гэдэг зүйлийг, энэ итгэлцлийг л авч үлдэх гээд байгаа юм.

Бизнес гэдэг чинь дандаа танилуудын хооронд байдаг. Дандаа итгэлцэл дээр явж байдаг. Бие биеэ сайн мэддэг хүмүүсүүдийн хооронд явж байснаа энэ хууль эрх зүйн процесс байхгүйгээс болоод бие биеэ бүр үзэхгүй болтлоо муудалцаж байна шүү дээ. Тэгээд энэ процесс дээрээ шүүхийг ашиглаж байна. Шүүхийн нэр хүнд унаад байна. Баярлалаа.

Б.Пүрэвдорж: Лхагвасүрэнгийн Соронзонболд гишүүн асуулт асууна.

Л.Соронзонболд: Одоо үйлчилж байгаа Дампуурлын тухай хууль яг тэр дампууруулах тавьж байгаа шалгуур нь их чанга юм би лээ. Өөрөөр хэлбэл тухайн аж ахуйн нэгжийн өөрийн хөрөнгийн 10 хувь, тэгээд ямар нэгэн төлбөр тооцоо, үүргээ биелүүлээгүй нэг сар болсон гээд.

Тэгээд 1990-ээд оноос хойш үйлчилсэн хууль гэхээр хэрэглэсэн тохиолдол нь их бага. Ийм л юм байна лээ л дээ.

Тийм учраас төлбөрийн чадваргүйдлийн тухай гэж хуулийг шинэчилсэн найруулгаар оруулж ирж байгааг нь дэмжиж байгаа.

Тэгээд энэ төлбөрийн чадваргүйдлийн хүсэлт гаргагч гээд. Хүсэлт гаргагч нь татвар, нийгмийн даатгалын байгууллагууд, өөрөөр хэлбэл төрийн байгууллагууд байхаараа тухайн хүний төлбөрийн чадваргүйдлийн талаарх мэдээлэл сайтай байгаа учраас хүсэлт гаргаж чадаад байдаг. Харин хувийн сектор буюу аж ахуйн нэгжүүд болохоор нөгөө үүрэг гүйцэтгэгчийнхээ талаарх мэдээлэл багатай учраас хүсэлт гаргахдаа мэдээлэл багатайгаар оролцдог гээд танай танилцуулга дээр ч байх шиг байна лээ.

Тэгэхээр одоо энэ төлбөрийн чадваргүйдлийн энэ хуулийн төсөл дээр энэ асуудал ер нь яаж туссан бэ? Өөрөөр хэлбэл төлбөрийн чадваргүйдлийн талаарх мэдээллийн нэгдсэн сан байх юм уу гээд байхгүй юу. Ямар ч тохиолдолд төлбөрийн чадваргүйдлийн ажиллагаа эхлүүлээ гэдэг мэдэгдлийг төрийн захиргааны байгууллагууд, шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, хэд хэдэн газрууд өгөөд байх шиг байгаа юм.

Тэгэхдээ Монгол Улсын зээлийн мэдээллийн сан шиг нэгдсэн мэдээллийн сан руу өгөхгүй л бол компаниуд хоорондоо зөндөө л ажлууд хийж байгаа шүү дээ. Хоорондын мэдээллээ шалгадаг боломжийг нь нээх ёстой байх. Тэр утгаараа нэгдүгээр асуулт тийм байгаа юм.

Хоёрт нь, утга агуулгын хувьд анхаарах юмнууд байх шиг байна. Жишээлбэл, хуулийн төслийн 22.1 дүгээр заалтыг уншихаар би яг шууд сайн ойлгохгүй байгаа юм. Төлбөрийн чадвартай гэж дүгнэлт гаргасан, эсвэл төлбөрийн чадваргүй дүгнэлт гаргасан бол эхлүүлэхгүй ч гэж байх шиг. Тийм ээ.

Тэгэхээр утга найруулгын хувьд анхаарах юмнууд байна уу даа гэж хараад байна.

Тэгээд энэ хэрэг гүйцэтгэгч дээр ерөнхийдөө хуулийн байгууллагаас хувь хүнийг сонгох талын асуудал илүү тусгагдсан байна.

Гэтэл Санхүүгийн зохицуулах хорооноос хөрөнгийн удирдлагын мэргэжлийн компаниудад зөвшөөрөл өгөөд явж байгаа. Би бодохоор жишээлбэл энэ төлбөрийн чадваргүйдлийн асуудал чинь маш жижиг хэмжээний компани ч учирч болно, том хэмжээний компани ч учирч болно.

Тэгэхээр хөрөнгийн хэмжээтэй нь уялдуулаад хуулийн этгээдийг ч сонгох боломжийг нь нээх ёстой болов уу л гэж харж байгаа байхгүй юу. Тэгээд энэ дээр манай хуулийн төслийн ажлын хэсгийнхэн дээр ямар бодол байгаа юм бэ гэдэг.

Тэгээд дараагийн асуулт, үүрэг гүйцэтгүүлэгч гэж хүн хүсэлт гаргачхаад аль ч үе шатад хэдэн ч удаа буцааж болохоор харагдаад байгаа байхгүй юу. Тэгээд бүртгэлийн хураамжийнхаа мөнгийг төлдөг. Тэгээд л дахин дахин байнга гаргаад байвал яах вэ?

Тэгэхээр энэ дээр нэг тийм хязгаарлалтын зүйлс, заалт байх уу, үгүй юу гээд нэг тийм асуудал байгаа юм.

Тэгээд дараагийн асуудал. Энэ 20.1 дүгээр заалтыг уншихаар түр хэрэг гүйцэтгэгч ямар ч дүгнэлт гаргасан шүүх төлбөрийн чадваргүйдлийн ажиллагааг эхлүүлэхээс татгалзаж, хэргийг хэрэгсэхгүй болгоно, захирамж гаргана гэсэн байна. Үүнийг тайлбарлавал зүгээр байна. 20.1 дээр. Ийм хэдэн асуултууд байна.

Б.Пүрэвдорж: Ажлын хэсгийн 4 дүгээр микрофон. Дэд сайд Д.Мөнх-Эрдэнэ хариулна.

Д.Мөнх-Эрдэнэ: Хууль зүй, дотоод хэргийн дэд сайд Д.Мөнх-Эрдэнэ. Л.Соронзонболд гишүүний асуултад хариулья.

Таны эхний асуулт дээр хариулахад одоо яг үнэхээр тийм нөхцөл байдалд байгаа. Үүрэг гүйцэтгүүлэгч нэхэмжлэгч үнэхээр тэр балансын 10 хувь, энэ балансын шалгуур үзүүлэлтээр тэр гүйцэтгэх ёстой үүргийн нэхэмжлэлийн шаардлага 10 хувьдаа хүрсэн хүрээгүй эсэхийг тодорхойлох боломжгүй учраас хэтэрхий оройтож шүүхэд нэхэмжлэл гаргадаг. Тэгээд үүнээс болоод хөрөнгө оруулагч, зээлдүүлэгч, бараа бүтээгдэхүүн нийлүүлэгч хохирдог.

Шинэ бидний боловсруулж оруулж ирж байгаа хуулийн төсөл дээр үүнээс гадна өөр төлбөрийн чадваргүйдэл дээр энэ дээр нэг дахиад нэг шалгуур үзүүлэлт нэмж байгаа. Энэ бол хууль болон гэрээнд заасан үүргээ хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр 3 сараас дээш хугацаагаар гүйцэтгэж чадаагүй, биелүүлж

чадаагүй гэсэн бэлэн мөнгөний төлбөрийн чадвартай холбоотой ийм шалгуур үзүүлэлтийг оруулж ирж байгаа.

Тэгэхээр олон улсад байдаг балансын болон бэлэн мөнгөний энэ хоёр шалгуур үзүүлэлт хоёулаа манай хуулийн төсөлд орж ирснээр хөрөнгө оруулагч, нэхэмжлэгчийн зүгээс эрхээ хангуулах боломжийг бий болгож байгаа юм.

Тэгэхээр энэ бол бас нэг давуу тал гэж үзэж байна. Олон улсад байдаг шинэ жишиг бий болж байна.

Дараагийн асуулт. 20.1 дээр байгаа дүгнэлт. Түр үүрэг гүйцэтгэгч, хэрэг гүйцэтгэгч, үүрэг гүйцэтгэгч нь төлбөрийн чадвартай, эсвэл үүрэг гүйцэтгэгч төлбөрийн чадваргүй, түүний хөрөнгө төлбөрийн чадваргүйдлийн ажиллагааны зардлыг төлөх боломжгүй гэсэн дүгнэлт гаргасан бол шүүх төлбөрийн чадваргүйдлийн ажиллагаа эхлүүлэхээс татгалзаж, хэргийг хэрэгсэхгүй болгох тухай захирамж гаргана гэсэн ийм зохицуулалт байгаа.

Тэгэхээр энэ бас олон улсад байдаг жишиг. Өөрөөр хэлбэл төлбөрийн гүйцэтгэлийг хангуулах ажиллагааг эхлүүлэх нь өөрөө тодорхой зардалтай байдаг. Тодорхой зардалтай.

Тэгэхээр энэ зардлыг гаргах боломжгүй байх юм бол, үүнийг хангах боломжгүй байх юм бол үүнийг ердийн журмаар буюу хуулийн этгээдийг татан буулгах өөр бусад аргаар шийдвэрлүүлэх нь зүйтэй гэж үздэг ийм олон улсын жишиг байдаг.

Төлбөрийн чадваргүйдлийн ажиллагааг эхлүүлэх энэ зардал, энэ хэрэг гүйцэтгэгчийн явуулах үйл ажиллагааны тодорхой хэсгийн зардлыг санхүүжүүлэх боломжтой хөрөнгөтэй байх нь өөрөө энэ төлбөрийн чадваргүйдлийн үйл ажиллагаанд эхлүүлэх зайлшгүй... /минут дуусав/

Б.Пүрэвдорж: Нэмж хариулъя.

Д.Мөнх-Эрдэнэ: Дахин хэлэхэд олон улсад байдаг жишиг. Ямар нэгэн байдлаар ямар ч хөрөнгөгүй болсон нөхцөлд энэ төлбөрийн чадваргүйдлийн ажиллагааг эхлүүлэх шаардлагагүй. Үүнийг харин өөр бусад аргаар хуулийн этгээдийг татан буулгах арга замаар энэ ажиллагааг явуулах нь зүйтэй юм. Өөр арга замаар шийдвэрлэх хуулийн зохицуулалт байгаа.

Бидний энэ хуулийн концепцын үндсэн агуулга нь нэг талаасаа төлбөрийн үүрэг гүйцэтгэгчийг боломж олгож, дахин хөрөнгөжүүлэх, дахин зохион байгуулах, зээл олгох замаар нэг боломж олгох. Нөгөө талаасаа нэгэнт авлагатай байгаа нэхэмжлэгч талыг эрх ашгаа хангуулах тэр боломжийг олгох.

Тэгэхээр тэнд тодорхой хөрөнгө байх ёстой. Тодорхой эд хөрөнгө мөнгөн хөрөнгө байх ёстой. Огт байхгүй бол энэ ажиллагааг явуулах шаардлагагүй болж байгаа юм. Ингэж тайлбарлая. Баярлалаа.

Б.Пүрэвдорж: Л.Соронзонболд гишүүн тодруулъя.

Л.Соронзонболд: Тэр төлбөрийн чадваргүйдлийн нэгдсэн мэдээллийн сан байх талаар асуусан шүү дээ. Тийм ээ. Хэрэг гүйцэтгэгч чинь өөрөө зөвхөн хувь хүн байх юм шиг ойлгогдоод байна л даа.

Тэгэхээр энэ дээр Санхүүгийн зохицуулах хорооны хөрөнгийн удирдлагын компани ч юм уу байвал хуулийн этгээд байж болохгүй юу гэдэг асуулт асуусан.

Дээрээс нь нэг тодруулах асуудал байгаа нь хүсэлт гаргагч чинь өөрөө үүрэг гүйцэтгэгч байж болох юм шиг. Тэгэхдээ өөрийнхөө төлбөрийн чадваргүйдлээ мэдсэнээс хойш 45 хоногоос хойш хүлээж авахгүй юм шиг байгаа юм. 45 хоногийн дотор хүлээж авахаар юм шиг. Гурван асуултад нэмээд хариулаадхаач.

Б.Пүрэвдорж: Индрийн 4 дүгээр микрофон. Д.Мөнх-Эрдэнэ дэд сайд.

Д.Мөнх-Эрдэнэ: Хуулийн төсөл дээр хэрэг гүйцэтгэгч хувь хүн, хуулийн этгээд аль аль нь байж болохоор тусгасан байгаа. Одоо байгаа практик дээр хувь хүмүүс байгаа.

Тэгэхээр бид энэ шинэ хуулийн төсөл дээрээ аль аль нь байж болохоор ингэж оруулж ирсэн. Тэр мэдээллийн сан гэдэг агуулгаар шүүх энэ үйл ажиллагааг, энэ төлбөрийн чадваргүйдлийн ажиллагааг эхлүүлэхээс эхлээд бүх шатанд шүүх оролцож ирснээрээ шүүгчийн захирамж, мэдээлэл дандаа ил тод нээлттэй байх ийм зохицуулалт байгаа. Шүүхийн мэдээллийн сан гэж практикт хэрэгжээд явж байгаа. Энэ дээр шүүгчийн гаргасан бүх захирамж, шийдвэрүүд, энэ төлбөрийн чадваргүйдлийн ажиллагаатай холбоотой бүх мэдээллүүд ороод явах учраас ил тод нээлттэй байдал хангагдана гэж хэлье.

Б.Пүрэвдорж: Одоо Даваасамбуугийн Ганмаа гишүүн асуулт асууна.

Д.Ганмаа: Төлбөрийн чадваргүйдлийн шинэчилсэн найруулга дээр 3.4-д зааснаар төрийн болон орон нутгийн өмчит төрөлжсөн мэргэжлийн болон нэгдсэн эмнэлгийн төлбөрийн чадваргүйдэлтэй холбоотой харилцааг хуулиар тусгайлан зохицуулснаас бусад харилцааг энэ хуулиар зохицуулна гээд заасан юм байна.

Тэгэхээр манайх Монгол Улсад эмнэлгийн төлбөрийн чадваргүйдэл, дампуурлыг тусгаарлан зохицуулсан бие даасан хууль байдаггүй. Одоогоор.

Тэгэхээр дампууралд орсон тохиолдолд ялангуяа энэ төлбөрийн асуудалтайгаар зайлшгүй шаардлагатай тусламж, үйлчилгээ хэвтэн эмчлүүлж байгаа өвчтөн, яаралтай тусламж, эдгээр асуудлыг яаж төлбөрийн чадваргүйдлийн хуулиараа зохицуулсан бэ? Энэ боломж нь бүрдсэн үү? Тасралтгүй эмнэлэг, тусламжийн үйлчилгээ алдагдсан тохиолдолд ямар заалтаар зохицуулахаар энэ хууль дээр тусгагдаж байгаа вэ гэдэг нь нэгдүгээр асуулт байна.

Хоёрдугаар асуулт. Эрүүл мэндийн яамнаас уг нь сайд байж байвал зүгээр их байсан байх даа гэж бодож байна. Тэгэхдээ ажлын хэсгээс хариулах байх. Хууль дээр ажилласан хүмүүс бодвол. Би бүлэг дээр бичсэн. Сайдыг орж ирээсэй гээд.

Америкийн Нэгдсэн Улсад жишээлбэл эмнэлгийн дампуурлын хуулийг энгийн аж ахуйн нэгж гэж үздэггүй. Түүгээр адилтгадаггүй.

Ер нь эмнэлэг, эрүүл мэндийн тусламж гэдэг тусгай объект. Хүний амь нас, эрүүл мэндтэй холбоотой.

Тийм болохоор тасралтгүй, зайлшгүй үйлчилгээ гэсэн ойлголт байдаг. Энэ тасралтгүй, зайлшгүй үйлчилгээ буюу яаралтай тусламж, өвчтөн, хэвтэн эмчлүүлж байгаа хүмүүст үзүүлэх тусламжийг дампуурлын явц үзүүллээ гэхэд Японд ч юм уу, Америкт ингээд шууд төр оролцоод тэр өвчтөнүүдийг шилжүүлэн өөр газар хэвтүүлэх, үзүүлэх, эмчилгээ таслахаас урьдчилан сэргийлдэг бүхэл бүтэн механизм ажилладаг. Өвчлөлийн хөдөлгөөний шилжилт гэж механизм байдаг.

Манай төлбөрийн чадваргүйдлийн тухай хуулийн шинэчилсэн найруулга гэхэд олон улсын жишигт нийцсэн зүйл, заалт орсон уу? Ороогүй юм бол эрүүл мэндийн онцгой объект гэж үзсэн тусгай зохицуулалтыг яаж тусгах юм. Тэр боломж нь байсан уу? Би олж хараагүй учраас хэрвээ энэ асуудал цаашид ямар хууль тогтоомжоор ер нь зохицуулагдаж явах юм бэ гэдэг дээр нэг хариулт авъя.

Б.Пүрэвдорж: Ажлын хэсгийн 4 дүгээр микрофон. Дэд сайд Д.Мөнх-Эрдэнэ хариулна.

Д.Мөнх-Эрдэнэ: Хууль зүй, дотоод хэргийн дэд сайд Д.Мөнх-Эрдэнэ.

Д.Ганмаа гишүүний асуултад хариулья.

Таны хэлж байгаа үнэн. Үнэхээр хувийн хэвшлээс гүйцэтгэх боломжгүй, төрөөс нийтийн хэрэгцээг хангах зайлшгүй шаардлагатай салбарт үйл ажиллагаа явуулж байгаа төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн хувьд энэ хууль хамаарахгүй байхаар бид дагалдах хуулийн төсөлд тусгасан байгаа.

Нөгөө талаасаа төрийн болон орон нутгийн өмчид, ялангуяа эрүүл мэндийн салбарт үйл ажиллагаа явуулж байгаа байгууллагуудын хувьд төлбөрийн чадваргүйдлийн байдал үүссэн тохиолдолд эндээс Засгийн газар төрөөс тодорхой дэмжлэг үзүүлж зохион байгуулдаг учраас үүнтэй холбоотой нийтлэг харилцааг нь тухайн төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулиар, эрүүл мэндийн тухай хуулиар тэнд Засгийн газрын бүрэн эрх, Эрүүл мэндийн яамны бүрэн эрх гээд холбогдох байгууллагуудын бүрэн эрхүүд байдаг учраас энд санхүүгийн дэмжлэгтэй, төсвөөс санхүүжүүлдэг, төсвөөс дэмжлэг үзүүлдэг, Эрүүл мэндийн даатгалын сангаас дэмжлэг үзүүлдэг зохицуулалтууд байдаг учраас энэ дээр тодорхой зохицуулалт байгаа гэж танд хариулъя.

Б.Пүрэвдорж: Баярлалаа. Д.Ганмаа гишүүн тодруулъя.

Д.Ганмаа: Энэ асуултын хариулт ч хаашаа ч юм бэ дээ. Хувийн эмнэлгүүдийг жишээлбэл зохицуулалтаа яах юм?

Б.Пүрэвдорж: 4 дүгээр микрофон. Индэр.

Д.Мөнх-Эрдэнэ: Ер нь нийтлэг байдлаар зохицуулж байгаа. Өөрөөр хэлбэл аль нэг салбарыг онцгойлон авч үзсэн зүйл байхгүй.

Яагаад гэхээр “төлбөрийн чадваргүйдлийн ажиллагаа” гэдэг бол –

- үүргийн гүйцэтгэлийг хангахтай холбоотой,
- нэхэмжлэгчийн шаардлагыг хангахтай холбоотой,
- хөрөнгө оруулагчийн эрх ашгийг хамгаалахтай холбоотой –

харилцаа байдаг учраас нийтлэг байдлаар зохицуулсан байгаа.

Таны хэлж байгаа эрүүл мэндийн салбарын онцлогтой холбоотой асуудлыг бид ажлын хэсэг дээр ярьж нарийвчилж тусгах талаар анхааръя гэж бодож байна.

Б.Пүрэвдорж: 18.00 цаг өнгөрсөн байна.

Тийм учраас өнөөдрийн хэлэлцэх асуудлаа дуустал чуулганы хуралдааныг сунгалаа. /алх цохив/

Одоо Хүрэлбаатарын Баасанжаргал гишүүн асуулт асууна.

Х.Баасанжаргал: Би Д.Ганмаа гишүүний асуултыг тодруулаад, бас үг хэлчихье.

Ер нь яах вэ дампуурлын энэ харилцаан дээр онцгой анхаарч үзэх ёстой хэдэн салбарын асуудлууд байгаа. Эрүүл мэндийн салбар байгаа. Хувийн

эмнэлэг дампуурвал яах вэ, үйлчлүүлэгчдийн асуудал яах вэ, эрүүл мэндийн мэдээлэл яах вэ гээд маш олон нарийн юмнууд гарч ирнэ.

Хувийн сургуулиуд дампуурвал яах вэ, хүүхдүүд нь хаачих вэ. Нөгөө боловсролын зөрүүтэй байдлууд яах вэ гээд нарийн юм гарч ирнэ.

Тэгэхээр энэ салбаруудын асуудал дээр нэлээн анхаарах ёстой гэж харж байгаа.

Түүнчлэн бидний анзаарахгүй өнгөрөөд явж байгаа нэг салбар энэ олон нийтээс хөрөнгө босгож байгаа компаниудын асуудал. Ялангуяа биржийн бус зах зээл дээр хөрөнгө босгосон энэ олон банк бус санхүүгийн байгууллагууд дампуурвал энэ хөрөнгийн зах зээл, биржийн бус зах зээлийн асуудал дээр байгаа олон хувьцаа эзэмшигчийн эрх ашгийн асуудал хөндөгдөнө. Үүний хяналтыг нь яг энэ хууль дээр яаж харж байгаа вэ гэдгийг нэгдүгээрт тодруулъя.

Хоёрдугаарт, хөдөлмөрийн эрх зүйтэй холбоотой нэг зохицуулалт орж ирсэн байна. Ажилтнуудын цалин хөлсийг тэргүүн ээлжид өгнө гэдэг байсныг хүчингүй болгож орж ирж байгаа юм байна.

Тэгэхээр ажилтнуудын эрх ашгийн асуудал яах вэ? Үүнийг яагаад ингэж оруулж ирж байгаа вэ? Яагаад Хөдөлмөрийн хуулийн энэ зохицуулалтыг хүчингүй болгож оруулж ирж байгаа вэ гэдэг хоёр дахь асуулт.

Гурав дахь асуулт. Хөөн хэлэлцэх хугацаатай холбоотой. Иргэний хуулийн хөөн хэлэлцэх хугацаатай холбоотой зарим зохицуулалт. Одоо энэ дампуурлын хууль дээр байгаа гэрээ хэлцлийн хөөн хэлэлцэх хугацаа хоёр хоорондоо зөрөөд байна. Жишээ нь, “үндэслэлгүй хөрөнгөжих”. Хөөн хэлэлцэх хугацаа Иргэний хуулиар 10 жил байгаа. Хуулийн төслөөр 2 жил болоод байна.

Тэгэхээр энэ хоорондох энэ гар, энэ зүйлүүд чинь хоорондоо зөрчилдөөд байна. Үүнийг Та бүхэн яаж харж байгаа вэ? Юугаараа ялгаатай гэж харж байгаа вэ гэдэг ийм гурван асуулт тодруулъя.

Б.Пүрэвдорж: Хэнээс хариулт авмаар байна? Индэрийн 4 дүгээр микрофон. О.Оюунзул дарга гэж байна. Дэд сайд Д.Мөнх-Эрдэнэ хариулна.

Бас О.Оюунзул дарга тодруулж хариулж болно шүү.

Д.Мөнх-Эрдэнэ: Хууль зүй, дотоод хэргийн дэд сайд Д.Мөнх-Эрдэнэ.

Х.Баасанжаргал гишүүний асуултад хариулъя.

Нэхэмжлэлийн шаардлага хангах дарааллын хувьд бид хуулийн төслийн 82.1 дээр нарийн тусгасан байгаа. Тухайлбал, 82.1.1 дээр бусдын амь нас, эрүүл

мэндэд учирсан гэм хор, хохирлыг арилгах төлбөр тэргүүн ээлжид. Энэ шаардлагыг хангахаар бичигдсэн байгаа.

Төлбөрийн чадваргүйдлийн ажиллагааны зардал, хэрэг гүйцэтгэлийн зардал.

Гуравт нь, ажилтны цалин олговор болон хөдөлмөрийн болон хамтын гэрээгээр хүлээсэн бусад өр төлбөр гэж дарааллыг нь тогтоосон байгаа. Цаашдаа нийгмийн даатгал, эрүүл мэндийн даатгалын шимтгэл, алданги, хүү, торгууль, татварын болон гаалийн албаны тодорхойлолтоор баталгаажсан татварын ногдол, татварын өр гэх мэтчилэн.

Тэгэхээр таны асуугаад байгаа хөдөлмөрийн харилцаанд ажилтны эрх ашгийг хамгаалахтай холбоотой асуудал нэхэмжлэлийн шаардлагыг хангах дарааллын хувьд гуравт байгаа.

Тийм учраас бид хохирохгүй байх талаас нь бичсэн байгаа. Ер нь төлбөрийн чадваргүйдлийн тухай хуулийг нэг хуулиар маш тодорхой зохицуулахгүй бол маш олон хуульд харилцан зөрчилтэй заалтууд ороод шүүхээс хэрэглэхэд түвэгтэй байдал үүсдэг.

Тэгэхээр үүнийг нэг мөр зохицуулах, ойлгомжтой болгох үүднээс ингэж дарааллыг нь тогтоосон юм. Үүнтэй холбоотой Хөдөлмөрийн хуулийн түрүүний таны дурддаг заалт хүчингүй болохоор тусгагдсан.

Тэгэхээр ажилтны эрх ашгийг энэ дарааллын дагуу хангана гэж танд хариулъя.

Хувьцаа эзэмшигчтэй холбоотой асуудлын хувьд банк, санхүүгийн байгууллагууд тухайн тухайн хуулиараа харилцааг нь нарийвчлан зохицуулдаг. Жишээ нь, Төв банк арилжааны банк төлбөрийн чадваргүй болсон нөхцөлд хадгаламж эзэмшигчдийн эрх ашгийг хамгаалах, хувьцаа эзэмшигчдийн эрх ашиг хамгаалах зорилгоор шуурхай арга хэмжээнүүдийг авч байдаг. Монголбанкнаас. Нөгөө талаасаа Санхүүгийн зохицуулах хорооноос бас арга хэмжээ авч байдаг.

Энэ хуулиар нарийвчилсан харилцаа нь –

- Банкны тухай хуулиар,
- Төв банкны тухай хуулиар,
- Банк, санхүүгийн байгууллагын тухай хуулиар,
- Санхүүгийн зохицуулах хорооны тухай хуулиар,
- Эрх зүйн байдлын тухай хуулиар зохицуулагдахаар туссан байгаа.

Тэгэхээр хувьцаа эзэмшигчдийн... /минут дуусав/

Б.Пүрэвдорж: Нэмж 1 минут тайлбарлая. Дараа нь О.Оюунзул дарга 1 минутаар үг хэлнэ шүү.

Д.Мөнх-Эрдэнэ: Хөөн хэлэлцэх хугацааны хувьд бид ажлын хэсгийн шатад анхаарч үзье.

Ер нь гол барьж байгаа концепц дахиад хэлэхэд энэ төлбөрийн чадваргүйдлийн ажиллагааг эхлүүлэхдээ энэ процесстой холбоотой бүх харилцааг нэг хуулиар зохицуулах нь, энэ хуулиар зохицуулах нь өөрөө хууль хэрэглээний нэгдмэл байдлыг хангах, хууль хэрэглэхэд шүүхийн зүгээс ч гэсэн үүнийг бусад энэ харилцаанд оролцож байгаа нэхэмжлэгч, үүрэг гүйцэтгэгч бүх талуудын хувьд ойлгомжтой байдал үүсгэх давуу талтай гэж үзэж байгаа юм. Олон улсын жишиг ч гэсэн ийм байгаа.

Тийм учраас бид энэ концепцын хүрээнд боловсруулж оруулж ирсэн. Хэрвээ хөөн хэлэлцэх хугацаатай холбоотой тодруулах, засах зүйл байвал бид ажлын хэсэг дээр анхаарч үзье гэж хэлье.

Б.Пүрэвдорж: Хөөн хэлэлцэх хугацаатай холбоотойгоор сайд Б.Энхбаяр хариулъя.

Б.Энхбаяр: Уучлаарай, асуулт сайн ойлгоогүй юм. Сая хөөн хэлэлцэх хугацаа асуугаад байгааг.

Төлбөрийн чадваргүйдлийн хууль дээр хөөн хэлэлцэх хугацаа 2 жил байна. Эрүүгийн хуулийн гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацаа 10 жил байна гээд асуув уу? Яав.

Иргэний хууль дээр “үндэслэлгүйгээр хөрөнгөжих” гэж гэмт хэрэг байхгүй шүү дээ. Үгүй үгүй. “Үндэслэлгүйгээр хөрөнгөжих” юу гэж юу ярив. “Үндэслэлгүйгээр хөрөнгөжих” гэдэг чинь гэмт хэрэг шүү дээ. Эрүүгийн хууль дээр л байгаа шүү дээ. Аан?

Тэгвэл би энэ асуултыг сайн ойлгоогүй юм байна шүү. Энэ юун хоёр хууль ярив гэж ойлгосон байна.

Б.Пүрэвдорж: Хууль зүй, дотоод хэргийн яамны Хувийн эрх зүйн газрын дарга О.Оюунзул. Индрийн 4 дүгээр микрофон нэмж тайлбарлая.

О.Оюунзул: Х.Баасанжаргал гишүүний асуултад хариулъя.

Иргэний хууль дээр хөөн хэлэлцэх хугацааг ерөнхий хугацаа 10 жил, тэгээд тусгай гэрээнүүд дээр өөр өөр хүн хэлэлцэх хугацаанууд тавьсан байгаа. Гэхдээ дампуурлын хуулийн хүрээнд дампуурлын хэрэг үүсгэхээс өмнө ер нь дампуурлын хэргийг үүсгэхдээ дампуурлын 1997 оны хуулиас өөр нь гэрээний

үүргээ 3 сарын хугацаанд биелүүлж чадаагүй байх юм бол шуурхай байдлаар хөрөнгө оруулсан, зээлдүүлсэн зээлдүүлэгч нар маань хандаж эрхээ гялс хамгаалж эрсдэлээ, тэр хөрөнгө орлогоо нааш цааш нь болгож шилжүүлж ямар ч хөрөнгө үлдэхгүй байх тэр байдлаас сэргийлж шуурхай хандах байдлыг бүрдүүлэх нь энэ хуулийн төслийн зорилго байдаг.

Тийм учраас маш шуурхай. Гэрээний үүргийн гүйцэтгэл 3 сарын хугацаанд л биелэгдээгүй байх юм бол хандах боломжийг олгож өгч байгаа юм.

Дээрээс нь хүчин төгөлдөр бусад тооцох... /минут дуусав/

Б.Пүрэвдорж: Нэмж 1 минут.

О.Оюунзул: Хүчин төгөлдөр бусад тооцох хэлцэл гэж байгаа.

Тэгэхээр одоогийн хуулиар хүчин төгөлдөр бусад тооцох юм бол үүнийг тусдаа иргэний хэргийн шүүх дампуурлын хэрэг шийдэж байгаа шүүгч биш өөр шүүгч шийдээд явдаг.

Харин манай хуулийн төслөөр дампуурлын хэрэг үүсгэхээс өмнө хоёр жилийн хугацаанд зах зээлийн ханшаас доогуур үнээр хамааралтай этгээд рүүгээ шилжүүлсэн, хөрөнгө орлогоо нуун далдлах зорилгоор шилжүүлсэн энэ шилжүүлгийг хүчин төгөлдөр бусад тооцуулахаар хэрэг гүйцэтгэгч шүүхэд хүсэлт гаргаад тэр дампуурлын хэргийг шийдэж байгаа шүүгч маань буцаагаад 2 жилийн өмнө нааш цааш нь зориудаар дампууруулж, зориудаар нуун далдалсан энэ хөрөнгийг буцааж хүчин төгөлдөр бусад тооцоод гэрээнийх нь дагуу буцаагаад шилжүүлж авах. Ингээд нэхэмжлэгчдийн эрхийг хангуулах ийм боломжийг олгож өгч байгаа.

Тэгэхээр Дампуурлын хууль товчхондоо маш шуурхай тухайн үүргийн гүйцэтгэл гүйцэтгэх боломжгүй 3 сар үргэлжлэхэд л хандах боломжийг олгож өгсөн байгаа.

Үүнийг улам нээлттэй болгож 3 сарын хугацаанд... /минут дуусав/

Б.Пүрэвдорж: Х.Баасанжаргал гишүүн тодруулъя.

Х.Баасанжаргал: Иргэний хуулийн 3 дугаар дэд бүлэг дээр үндэслэлгүйгээр хөрөнгөжих гээд 492 гээд зохицуулалтууд байгаа сайд аа.

Би ерөөсөө Эрүүгийн хууль яриагүй байна.

Асуултаа тодруулаад асууя. Дэд сайдын хувьд эсвэл энэ хуулиар зохицуулна гээд, эсвэл нарийн салбартай холбоотой асуудлыг ярихаар тухайн

салбарын хууль нь зохицуулна гээд хоёр өөр ялгаатай байдлаар тайлбар хэлээд байна л даа.

Ялангуяа хөрөнгийн бус зах зээл дээрээс, биржийн бус зах зээл дээрээс хөрөнгө босгож байгаа банк бус санхүүгийн байгууллага. Жишээ нь нэг.

Одоо банк бус санхүүгийн байгууллага зах зээл дээрээс 3 их наяд төгрөг, 4 их наяд төгрөг босгосон байгаа гэдэг мэдээлэл байгаа байхгүй юу. Гэтэл энэ олон банк бус санхүүгийн байгууллагууд дампуурвал цаана нь байгаа хувьцаа эзэмшигчдийн эрхийн асуудлыг яаж зохицуулах вэ л гэж асуугаад байгаа. Нэг.

Үүнтэй яг адилхан боловсролын салбар, эрүүл мэндийн салбар гээд нарийн салбаруудын асуудлуудаа бид энэ хуулиар яаж харж байгаа вэ л гэдгийг тодруулаад байгаа юм.

Тэр хөөн хэлэлцэх хугацаатай... /минут дуусав/

Б.Пүрэвдорж: Х.Баасанжаргал гишүүн.

Х.Баасанжаргал: Хөөн хэлэлцэх хугацаатай холбоотой асуудал дээр Иргэний хууль дээр түрүүн хэлж байна.

Хөөн хэлэлцэх хугацаа ерөнхий хугацаа 10 жил байгаа гээд. Яг энэ хуулиар нарийвчлаад 2 жил гээд. Тэгэхдээ 2 жилээр оруулахдаа та хэд маань хэлцлүүдээ ялгаж оруулж ирээгүй байгаа байхгүй юу. Төрлүүдээ ялгаагүй гэсэн үг. Тийм ээ.

Тэгэхээр зарим хөөн хэлэлцэх хугацаанууд 3 жил гээд дотроо дахиад ялгаатай байгаа. Иргэний хуулиар чинь. Энэ хоорондын зөрчлүүдээ яаж, юугаараа ялгаж харах вэ л гэж асуугаад байгаа гэсэн үг.

Иргэний хууль дээр 3 жил, 10 жил, 5 жил гэж хараад байдаг. Дампуурлын хууль дээр бүх төрлийн гэрээ контракттай холбоотой асуудал дээр бид 2 жилээр нь харах гээд байна.

Тэгэхээр энэ хоорондын ялгаа заагийг шүүх энэ дээр чинь шийдвэр гаргахад нэлээн түвэгтэй байдалд оруулах уу. Цаад концепц нь өөрөө юу байгаа вэ гэдгийг тодруулж асуугаад байгаа гэсэн үг.

Эсвэл яваандаа Иргэний хуулийн хөөн хэлэлцэх хугацааны заалтууд эсвэл өөрчлөгдөх ёстой юм уу, юу гэж харж байгаа вэ? Дампуурлын тохиолдолд өөрчлөгдөх ёстой гэж харж байгаа юу гэж асуугаад байгаа юм.

Б.Пүрэвдорж: Индэрийн 4 дүгээр микрофон. Дэд сайд Д.Мөнх-Эрдэнэ.

Д.Мөнх-Эрдэнэ: Х.Баасанжаргал гишүүний асуултад хариулъя.

Хуулийн төслийн 3.3 дээр банк, санхүүгийн байгууллага даатгагч, хадгаламж, зээлийн хоршоотой холбоотой, төлбөрийн чадваргүйдэлтэй холбоотой хуулиар тусгайлан зохицуулснаас бусад харилцааг энэ хуулиар зохицуулна гэж байгаа юм.

Тэгэхээр энэ юу гэсэн үг вэ гэхээр Төв банкны тухай хууль. Түрүүний хэлсэн Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хууль, Банк, санхүүгийн байгууллагын тухай хууль дээр энэ хяналт шалгалттай холбоотой харилцаанууд нь тодорхой зохицуулагдсан байдаг.

Өөрөөр хэлбэл тэнд байгаа зээлдүүлэгч, зээлдэгчийн эрх, хувьцаа эзэмшигчийн эрх ашгийг хамгаалах, хадгаламж эзэмшигчийн эрх ашгийг хамгаалахтай холбоотой зохицуулалтууд нь тэр хуулиуд дээрээ нарийвчлан зохицуулагдсан байдаг.

Үүгээр тухайн төлбөрийн чадваргүйдэл үүссэн үед банк, санхүүгийн байгууллагуудад төлбөрийн чадваргүйдлийн процессыг нь яаж зохицуулах юм бэ, хэзээ, хэн ямар... /минут дуусав/

Б.Пүрэвдорж: Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. /алх цохив/

Хуулийн төслүүдийн талаар Байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг дэмжсэн, эсрэг байр суурьтай намын бүлгийг төлөөлж болон бүлэгт харьяалагдаагүй гишүүдээс урьдчилан ирүүлсэн нэрсийн дагуу гишүүд дэмжсэн, дэмжээгүй байр сууриа илэрхийлж үг хэлнэ. 3 гишүүн үг хэлэх байна.

Одсүрэнгийн Номинчимэг гишүүн алга байна.

Нямтайширын Номтойбаяр гишүүн алга байна.

Пүрэвжавын Сайнзориг гишүүн 1 дүгээр микрофон дээр.

П.Сайнзориг: Гишүүддээ үүнийг дэмжиж өгөөч ээ л гэж байгаа юм.

Нэрнээсээ эхлээд анхаарал татдаг. Яг ойлгохгүйгээр ингээд бизнест халтай хууль батлах гээд байгаа ч юм шиг ийм зүйлүүд байгаа юм.

Тэгэхээр гол асуудал юу вэ гэхээр үүний цаана бизнесийн орчныг л цэвэр байлгах, эргээд бизнесийн орчин дээр явж байгаа итгэлцлийг хамгаалах гээд л байгаа асуудал.

Ер нь бизнесийг дандаа –

— танилууд хийдэг,

- гэр бүлийнхэн хийдэг,
- найз нөхөд хийдэг.

- Мөнгө төгрөгийн асуудал гардаг.
- Шийдэх арга зам нь тодорхойгүй учраас хоёр тийшээгээ хардаг.
- Насан туршдаа бие биеэ үзэн яддаг.

Тэгэхээр үүнээс урьдчилан сэргийлж байгаа хууль зүйн нэг алхам нь Дампуурлын хууль байгаа юм.

Дээрээс нь монголчууд нийтээрээ ойлгох хэрэгтэй. Хийж байгаа бизнес болгон амжилттай болдоггүй. Энэ магадгүй байгалийн гамшигтай тулж ч болно, бизнесийн гадна, дотно хүчин зүйлүүдтэй тулж болно, оруулсан хөрөнгө оруулалт багасаж болно.

Багаслаа гэж үзвэл тодорхой хэмжээний хөрөнгөө татах тэр эрх зүйн орчин нь тодорхой байх ёстой.

Тэгэхээр боломжийг л олгоё. Хуучин “балансын арга” буюу “өөрийн хөрөнгө багасаж байгаа” эсэхийг зөвхөн компанийн эзэн л мэднэ. Бусад этгээдийн мэдэх боломжгүй байсан.

Энэ хуулиар энэ аргаас гадна “мөнгөн урсгалын хэмжээ” болон “цаг хугацааг” нарийн зааж өгч байгаа.

Ингэх юм бол тодорхой хэмжээний “гэрээний төлбөр” өгөхгүй байна гэдэг цаана нь юм болж байна шүү гэдэг сигнал өгнө.

Тэгээд энэ асуудал дээр очоод компанийн үүд сахих биш, шүүхийн оролцоотой, маш зөв, мэргэжлийн этгээдээр энэ маргааныг шийдүүлье л гэж байгаа юм.

Эрсдэлийг зөв зохистой томроогүй дээр нь хуваарилъя гэж байгаа ийм хууль байгаа гэдэг зүйлийг хэлье.

Тэгээд “e-business” аппликэйшн гэж байгаа. Үүний дэд бүтцийг сайн угсрах ёстой. Хэнтэй бизнес хийж байгаагаа шалгах тэр бололцоог нь олгох ёстой.

Магадгүй хувь этгээд П.Сайнзориг нэг “А” гэдэг хүнтэй гэрээ хийх гэж байхдаа тэр “А” гэдэг этгээд намайг шалгах ёстой байхгүй юу.

- ▶ Урьд нь компани дампууруулж байсан уу,
- ▶ Энэ компанийг ер нь хэр удирддаг байсан юм,
- ▶ Энэ хүнтэй холбоотой дампуурлын хэрэг шүүх дээр яваа болов уу –

-гэдгийг бид хуулийн дагуу үүсгэх цахим платформоос шалгаж байж энэ гэрээ контрактаа ордог баймаар байна. Энэ эрсдэлийг нь багасгаж өгнө.

Тийм учраас энэ хуулийг хэдүүлээ дэмжээд ажлын хэсэг гаргаж өгөөч ээ гэж хүсэж байгаа.

Энэ хуулийг мэргэжлийн шүүгч нараар хэлэлцүүлэх боломжийг олгоё гээд сая Б.Пүрэвдорж дарга хэлж байна. Үүнийг үнэхээр дэмжиж байна.

- ➔ Арилжааны шүүх дампуурлын хэргүүдийг шийдэж болж байна.
- ➔ Татварын маргаануудыг шийдэж болж байна,
- ➔ Оюуны өмчийн маргаануудыг шийдэж болж байна.

Энэ бизнес эрхлэгчдийн хооронд буюу B2B-ийн хооронд үүсэж байгаа маргаануудыг маш богино хугацаанд, цаг хугацаа, зардал багатайгаар шийдэх арга механизмыг бүрдүүлж өгөх ёстой.

Түүнээс биш өнөөдөр олон хүмүүс ярьж байна. 80 мянган төгрөг төлөөд 8 жил бизнесийн үүргээ биелүүлэхгүй, гэрээний үүргээ биелүүлэхгүйгээр шүүхийг ашиглаад байж болохгүй.

Ийм орчинд монголчууд хувийн хэвшил дээр бизнес хийх гэхээсээ илүүтээр төрд орохыг зүтгэнэ. Төрийн компанид менежер хийхийг зүтгэнэ.

Тийм учраас хувийн хэвшил дээрх –

- бизнесийн тэр соёл,
- бизнесийн тэр хариуцлага,
- бизнесийн тэр итгэлцлийг авчрах ийм хууль байгаа.

Тийм учраас Та бүгдийг дэмжиж өгөхийг хүсье. Баярлалаа.

Н.Учрал: П.Сайнзориг гишүүнд баярлалаа.

Төлбөрийн чадваргүйдлийн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн үзэл баримтлалыг хэлэлцэх эсэхийг дэмжих талаар санал хураалтыг түрүүчийн гурван асуудалтай хамтатган явуулна.

Санал хураалтыг хойшлуулъя. /алх цохив/

Ер нь 44 хууль дээр санал хураалт явах юм байна.

Хэлэлцэх асуудал руугаа оръё.

**Зургаа.Хянан шалгах түр хорооны тайлан, санал, дүгнэлт,
Улсын Их Хурлын тогтоолын төсөл /үргэлжилнэ/**

Хянан шалгах түр хорооны сонсголын тайлан санал, дүгнэлт, Улсын Их Хурлын тогтоолын төслийг үргэлжлүүлэн хэлэлцэнэ.

Хянан шалгах түр хорооны тайлан болон санал, дүгнэлтийг танилцуулсан.

Одоо “Оюу Толгойн бүлэг ордын ашиглалтад Монгол Улсын эрх ашгийг хангуулах, хүртэх өгөөжийг нэмэгдүүлэх хүрээнд хийсэн тусгай шалгалт, нээлттэй сонсголын мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн талаарх Хянан шалгах түр хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн, Хянан шалгах түр хорооны дарга Отгоншарын Батнайрамдал танилцуулна.

Таныг индэрт урьж байна.

О.Батнайрамдал: Улсын Их Хурлын дарга, Эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Их Хурлын 2025 оны 7 сарын 02-ны өдрийн 62 дугаар тогтоолоор байгуулагдсан Оюу Толгой бүлэг ордын ашиглалтад Монгол Улсын эрх ашгийг хангуулах, үр өгөөжийг нэмэгдүүлэхтэй холбоотой баримт бичиг, үйл ажиллагаанд хяналт шалгалт хийх Хянан шалгах түр хороо Улсын Их Хурлын гишүүн М.Бадамсүрэн, О.Батнайрамдал, Б.Бат-Эрдэнэ, Б.Баярбаатар, Э.Болормаа, Ш.Бямбасүрэн, П.Ганзориг, Б.Жаргалан, С.Зулпхар, Д.Пүрэвдаваа, Ө.Шижир нарын 11 гишүүний бүрэлдэхүүнтэйгээр Монгол Улсын Их Хурлын тогтоолд заасан сэдэв, хүрээ, хязгаарын дагуу 6 сарын хугацаанд ажиллалаа.

Хянан шалгах түр хороо нь тайлан, санал, дүгнэлт болон түр хорооноос боловсруулсан Улсын Их Хурлын тогтоолын төслийг 2025 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх үед хуралдаан даргалагчаас тогтоолын төслийг Байнгын хороогоор хэлэлцүүлэх чиглэл өгсний дагуу Эдийн засгийн байнгын хороо 2025 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн хуралдаанаараа “Оюу Толгой бүлэг ордын ашиглалтад Монгол Улсын эрх ашгийг хангуулах, хүртэх өгөөжийг нэмэгдүүлэх хүрээнд хийсэн тусгай шалгалт, нээлттэй сонсголын мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийн хэлэлцүүлгийг явуулсан.

Хянан шалгах түр хорооны 2025 оны 12 дугаар сарын 24-ний өдрийн хуралдаанд Улсын Их Хурлын тогтоолын төслийн хэлэлцүүлэг явуулсан талаарх Эдийн засгийн байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Б.Жаргалан танилцуулсан.

Хянан шалгах түр хорооны хуралдааны хэлэлцүүлгийн үед тогтоолын төсөлтэй холбогдуулан –

- Улсын Их Хурлын гишүүн Б.Уянга, Г.Лувсанжамц нар төслийн 1 дүгээр зүйлийн 1.1 дэх дэд заалтаас “шаардлагатай тохиолдолд тусгай зөвшөөрлийг цуцлах хүртэл арга хэмжээ авах” гэснийг хасах,
- Улсын Их Хурлын гишүүн Ц.Даваасүрэн тогтоолын төслийн 1.1 дэх заалтаас “Ашигт малтмалын тухай хууль” гэснийг хасаж, “Монгол Улсын Үндсэн хууль болон бусад хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулж, үр өгөөжийн дийлэнх нь ард түмэнд ногдож байх зарчмыг хангаж байхаар” гэж өөрчлөх. Мөн заалтын “нөхцөлийг бүрдүүлэх” гэсний дараа “баяжмалын агууламжийг уурхайн амнаас лабораториор хянан баталгаажуулж, экспортод гаргах” гэж нэмэх. Мөн заалтад “Монгол Улсын Үндсэн хуулийн өөрчлөлтийн дагуу иргэд үр өгөөжийн дийлэнх хувийг хүртэх нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор орд баялгаа үнэлэн эзэмших хувь хэмжээг тогтоох, “Онтрэ”-гийн ашиглалтын талбайг ашиглахад зээлээр бус хөрөнгө оруулалтаар санхүүжүүлэх” гэж нэмэх,
- Улсын Их Хурлын гишүүн Г.Тэмүүлэн төслийн 1.2 дахь дэд заалтаас “зах зээлийн зарчим, жишигт нийцүүлэн” гэснийг хасах,
- Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдорж төслийн 1.2 дахь дэд заалтаас “зах зээлийн зарчим, жишигт нийцүүлэн бодитоор бууруулах” гэснийг хасаж, “SOFR +3 хувиас хэтрүүлэхгүй байх” гэж нэмэх,
- Улсын Их Хурлын гишүүн Г.Тэмүүлэн, Б.Жаргалан нар төслийн 1.4 дэх дэд заалтыг “Монголын талын хүртэх үр өгөөжийг хөрөнгө оруулалтын гэрээнд тусгагдсан техник, эдийн засгийн үндэслэл, хаалтанд 2010 оны анхны тооцооллын дагуу нэрлэсэн үнээр 53 хувиас доошгүй байх нөхцөлийг баталгаажуулан холбогдох гэрээнд тусгах, уг хувь хэмжээг 3 жил тутам харилцан хянах зарчмыг нэвтрүүлж, Оюу Толгой хариуцлагатай хувьцаат компанийн үйл ажиллагааны жилийн тайланд талуудад ногдох үр өгөөжийн тооцоог тусгайлан тайлагнах” гэж найруулах,
- Улсын Их Хурлын гишүүн Э.Болормаа, С.Зулпхар, Ө.Шижир Б.Жаргалан нарын төслийн 1.4 дэх заалтын “5 жил тутам харилцан хянан үзэх” гэснийг “3 жил тутамд харилцан хянан үзэх” болгож өөрчлөх,
- Улсын Их Хурлын гишүүн Л.Соронзонболд, Ц.Даваасүрэн нар 1.5 дахь дэд заалтад “Оюу Толгой хариуцлагатай хувьцаат компанийн экспортын борлуулалтын орлогыг Монгол Улсын Төв банк болон арилжааны банкуудаар бүрэн дамжуулж авдаг болох” гэж нэмэх,

- Улсын Их Хурлын гишүүн Л.Мөнхбаясгалан тогтоолын төсөлд “Монгол Улсын Их Хурлын хянан шалгах түр хорооноос Оюу Толгой бүлэг ордын ашиглалтад зохион байгуулсан хяналт шалгалт, нээлттэй сонсголын явцад ил болсон гэмт хэрэг, зөрчлийн шинжтэй үйлдэл, эс үйлдэхүйг хууль тогтоомжид заасан үндэслэл, журмын дагуу шалгах, шийдвэрлэхийг эрх бүхий хяналтын байгууллагад зөвлөх агуулгатай 2 дахь заалт нэмэх” зарчмын зөрүүтэй саналууд гаргасныг хэлэлцээд, хуралдаанд оролцсон гишүүдийн олонхын санал авч дэмжигдсэн саналуудыг тогтоолын төсөлд тусган эцсийн хувилбарыг бэлтгэсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Их Хурлын 2025 оны 62 дугаар тогтоолоор байгуулагдсан Оюу Толгой бүлэг ордын ашиглалтад Монгол Улсын эрх ашгийг хангуулах, хүртэх өгөөжийг нэмэгдүүлэхтэй холбоотой баримт бичиг, үйл ажиллагаанд хяналт шалгалт хийх үүрэг бүхий Хянан шалгах түр хороо бүрэн эрхээ хэрэгжүүлж санал, дүгнэлтээ танилцуулсан тул түр хороог татан буугдсанд тооцож, Хянан шалгах түр хорооноос боловсруулсан “Оюу Толгой бүлэг ордын ашиглалтад Монгол Улсын эрх ашгийг хангуулах, хүртэх өгөөжийг нэмэгдүүлэх хүрээнд хийсэн тусгай шалгалт, нээлттэй сонсголын мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг Та бүхнээсээ хүсье. Баярлалаа.

Б.Пүрэвдорж: Хянан шалгах түр хорооны тайлан, санал, дүгнэлт болон Улсын Их Хурлын тогтоолын төсөлтэй холбогдуулан асуулт асууж, үг хэлэх Улсын Их Хурлын гишүүд нэрээ өгнө үү.

Ж.Батсуурь гишүүнээр тасаллаа.

Өчигдөр би Байнгын хороон дээр зээлийн хүүг “SOFR (Secured Overnight Financing Rate) +3 хувь” гэдэг санал гаргасан. Би нэлээн судалж байж хийсэн санал байгаа юм.

Анх Оюу Толгой гэрээг байгуулахдаа “LIBOR (London Inter-Bank Offered Rate) дээр +6 хувь” гээд түүнд нь бүгдийг нь тултал нь өндөр хүүгээр 11 аравны хэдэн хувиар бүх зээлүүдээ өнгөрсөн хугацаанд явуулсан.

Тэгэхээр LIBOR гэдэг бол Лондонгийн банк, санхүүгийн байгууллагуудын дундаж жигнэсэн зээлийн хүүгийн ханшийг хэлдэг.

Гэтэл 2023 оноос LIBOR-ыг хэрэглэхээ больсон. Одоо хамгийн их идэвхтэй хэрэглэгдэж байгаа зээлийн хүүгийн харилцааг Америкийн банк хоорондын харилцаанд хэрэглэдэг SOFR гэдэг тэр үнэлгээгээр хэрэглэдэг.

Тэгэхээр SOFR бол өнөөдрийн байдлаар 3.68 хувь байгаа юм. Энэ 3.68 дээр нэмэх нь 3 хувь гэхээр өөрөөр хэлбэл 6.68-аас дээшгүй хүүтэй байх гэсэн заалтыг л энэ дээр хэрэглэж байгаа юм.

Өөрөөр хэлбэл таны яриад байдаг өдөрт 10 тэрбум төгрөгийн зээл гарч байна гэж байгаа. Тэгэхээр энэ 10 тэрбум төгрөгийн зээлийн хүүг чинь 5.5 тэрбум руу буулгаж авчрах, 55 хувиар бууруулах заалт байсан юм.

Өнгөрсөн хугацаанд “Рио Тинто” дунджаар 4.9 хувийн хүүтэйгээр бонд босгодог. Тэгээд тэр босгосон бондыгоо дахин санхүүжүүлж Оюу Толгой руу 11 аравны хэдэн хувиар өгдөг. Өөрөөр хэлбэл зардлаасаа бүх ашгаа олдог ийм л компани болоод байсан юм л даа.

Тийм учраас “SOFR +3” буюу ойролцоогоор 6.8-аас дээшгүй байх ийм заалтыг оруулж өгсөн. Өнгөрсөн хугацаанд хангалттай тэр зээлийн хүүнээсээ ашиг олсон.

Одоо тэгэхээр бид дээд талын хүүг нь тавьж өгөхгүйгээр зах зээлийн шугамаар шийднэ гэдэг ийм битүү хатуу юм тавьчхаад. Тэгэнгүүт нь Засгийн газар дээр энэ нь шаардлага болж хувирч чадахгүй. Засгийн газрын гишүүд нь янз бүрийн асуудалд ороод тэр өндөр хүүгээ буулгаж чадахгүй нөхцөл байдал руу орох гээд байгаа байхгүй юу даа.

Тэгээд “Рио Тинто” чинь өөрөө. Түрүүн хэлсэн 4.9 хувиар дээд тал нь хүүтэй байгаа. Тэгээд нэмэх нь 1 байхад ингээд 6 хувиар зээл өгөөд байхад болох байхгүй юу даа. Дахин санхүүжүүлэхэд. Тийм их зардал тэр дахин санхүүжүүлэх зардалдаа гарахгүй.

Ер нь Засгийн газрын бодлого ч гэсэн ойролцоогоор 6, 7 хувь дээр буулгах сонирхол байгаа.

Гэтэл энэ саналыг маань унагаагаад явах юм. Ийм чухал санал шүү дээ. Өөрөөр хэлбэл та нарын гаслаад байсан. О.Батнайрамдал гишүүн ээ, таны гаслаад байсан өдөрт 10 тэрбум төгрөг бид зээлийн хүүд төлж байна гэдгийг чинь 5.5 руу буулгах. 5.5 тэрбум болгох заалт шүү дээ. Гэтэл ийм тодорхойгүй “зах зээлийн шугамаар шийднэ” гэдэг ийм юмаар хүүг бодитой буулгана гэдэг заалтаар өлгөр, мөлгөр ийм заалт өгөхөөр чинь болохгүй байхгүй юу даа.

Ер нь Рио Тинтогийн чинь ард өөрөө “A1” зэрэглэлийн, Moody’s зэрэглэлийн маш бага санхүүгийн эх үүсвэр татах боломжтой компани.

Гэтэл Монгол дээр яагаад ингээд байгаа юм бэ. Өөр бусад хөнгөн цагаан, төмрийн хүдрийн гол уул уурхайн бүтээгдэхүүнүүдийг санхүүжүүлдэг. Дэлхий даяар уурхайтай.

Тэгээд тэд нар дээрээ болохоор маш бага хүүтэй өгдөг. Тэгсэн мөртлөө манай Монголд болохоор бид араас нь гарсан хүүхэд юм уу? Яагаад ингэж 11 арваны хэдэн хувиар бид нарт зээл өгдөг юм бэ?

Тийм учраас энэ асуудлыг би Их Хурал дээр орж ирж энэ асуудлыг босгоё гэж бодсон чинь түр хороон дээрээ тэр чигээрээ хураагдаад явдаг юм байна шүү дээ.

Тэгээд өчигдөр танай түр хорооны хурал харж байхад гишүүд санал гаргаад, тэр гарсан гишүүн нь саналаа тайлбарлаж болдог. Тэгээд шууд санал хураалт явдаг. Гэтэл Та нэг гишүүний саналыг ард нь бараг арван хэдэн минут хоорондоо ярилцаж, хувь хүний сонирхол оруулж, ийм байдлаар санал хураалтуудыг явуулж л байна шүү дээ.

Тэгэхээр миний гаргасан, өөрөөр хэлбэл зээлийн хүүг бараг даруй нэг дахин буулгах, төлбөрийг нэг дахин буулгах тэр саналыг яаж шийдвэрлэх юм бэ? Энэ дээр тодорхой хариу өгнө үү?

О.Батнайрамдал: Б.Пүрэвдорж гишүүний асуултад хариулъя.

62 дугаар тогтоолоор байгуулагдсан Хянан шалгах түр хорооны хоёр үндсэн сэдвийн нэг нь хүү л дээ. Зээлийн хүү.

Оюу Толгой төсөл ойролцоогоор 22 орчим тэрбум долларын санхүүжилтээр босож байна. Үүний бараг 78 орчим хувь нь зээлийн санхүүжилтээр хийгдэж байна. Тэр дундаа дийлэнх нь хувь нийлүүлэгчийн зээл буюу “Рио Тинто” компаниас Оюу Толгой компани руу. Та түрүүн хэллээ. “SOFR +6.5” гэсэн зээлийн хүүгээр явж байгаа.

Өнөөдрийн ханшаар бодоход ойролцоогоор жилийн дунджийг нь аваад үзэх юм бол 11 орчим хувь.

Анх төсөл эхэлж байхад мэдээж төслийн эрсдэл хамгийн өндөр байлгүй яах вэ дээ. Тэр үед тохирсон “LIBER +6.5” төсөл өнөөдөр бараг далд уурхайн бүтээн байгуулалт нь дуусаж байхад яг адилхан томъёололтой л яваад байгаа юм л даа.

Үүнийг бууруулах. Тэгээд цаашаага энэ өөрөө Оюу Толгой компанитай хийсэн үндсэн хоёр гэрээний яг “хувь нийлүүлэгчийн гэрээ”-гээр зохицуулагддаг.

Б.Пүрэвдорж гишүүн өчигдөр Хянан шалгах түр хороон дээр өөрийн биеэр ирж энэ саналаа гараараа бичиж өгсөн. Хянан шалгах түр хорооноос таны бичиж өгсөн саналд бид талархалтай хандаж байгаа. Б.Пүрэвдорж гишүүнд баярлалаа. Та саналаа өгсөн.

Бусад Улсын Их Хурлын гишүүд ч гэсэн, Хянан шалгах түр хорооны гишүүд ч гэсэн бүрэн эрхийнхээ хүрээнд Хянан шалгах түр хороон дээр өөрсдийн биеэр ирээд зарчмын зөрүүтэй саналаа өгөөд хураалгасан байгаа.

Таны томъёолол дээр хоёр санал хураагдсан. Г.Тэмүүлэн гишүүний санал. Тэгээд таны санал. Тэгээд ганцхан О.Батнайрамдал Хянан шалгах түр хорооны даргын шийдэл биш шүү. Энэ бол Хянан Шалгах түр хороон дээр ирсэн гишүүдийн зарчмын зөрүүтэй саналаар хураагдаад явсан санал юм.

Зээлийн хүү бодитоор буурах ёстой. Засгийн газар дээр ч гэсэн хэлэлцээрт орж байгаа үндсэн асуудлуудынх нь нэг байгаа. Тэр “SOFR +3” байна уу, “SOFR +2” байна уу, “SOFR +1” байна уу үүнийгээ яг хэлэлцээрт орж байгаа Монгол Улсын Засгийн газар илүү өөрсдөө тодорхойлох ёстой.

Бид Хянан шалгах түр хорооны сонсгол дээр харьцуулсан дүгнэлтүүдийг мэргэжлийн шинжээчид маш олон талаас нь гаргаж өгсөн.

Тэгэхээр бид сонсгол хийсэн энэ Хянан шалгах түр хорооны гаргаж байгаа тогтоол ч гэсэн хэлэлцээрт орж байгаа Засгийн газарт бид ташуур болж байгаа ийм л асуудал байгаа.

Б.Пүрэвдорж: Тийм учраас манай Монгол Улс чинь парламентын засаглалтай орон. Парламентаас байгуулагдсан Засгийн газартай. Оюу Толгойн гэрээ ч гэсэн Засгийн газраар санал нь орж ирээд тэгээд Их Хурлаар хэлэлцэгдэж дэмжигдсэн. Өнгөрсөн хугацаанд алдаа оноо зөндөө байгаа.

Тийм учраас өөрөөр хэлбэл парламентын засаглалтай орны хувьд парламент Засгийн газартаа тодорхой чиглэл өгч энэ зээлийн хүүг бууруулах дээд хязгаарыг нь тавьж өгч. Өөрөөр хэлбэл 6.68 буюу 11.5-аас доошоо 6.68 руу буюу өдөрт 10 тэрбум төгрөг төлдөг байсан тэр хүүг 5.5 тэрбум төгрөг болгох энэ заалтыг маань унагасанд харамсаж байна.

Тийм учраас таныг энэ санал, дүгнэлтдээ миний гаргасан асуудлыг протоколд тусгаж оруулахыг хүсэж байна.

Ер нь аливаа Улсын Их Хурлаас гаргасан хууль тогтоолын хүрээнд тэр Их Хурлын гишүүдийн гаргасан санал, асуулт, дүгнэлтүүд тогтоолыг хэрэглэх явцад тодорхой шаардлага болж хувирдаг юм.

Тийм учраас энэ дээр Та анхаарч ажиллахыг хүсэж байна. Баярлалаа.

Их Хурлын даргыг урьж байна.

Н.Учрал: Цагаанхүүгийн Идэрбат гишүүн асуулт асууна.

Ц.Идэрбат: Их Хурлын гишүүдэд оройн мэнд хүргэе.

Ер нь цаг хугацаа үнэний шүүх ч юм гэж. Оюу Толгойн гэрээг 17 жилийн өмнө хийхэд монголчууд 20 мянган хувьсгалчийнхаа учрыг олохгүй байгаад л хийсэн. Тухайн үедээ хийх нь зөв байсан байж магадгүй юм.

Гэхдээ өнөөдөр 17 жилийн дараа харахад Монгол Улс ямархуу хэмжээний өр ширэнд орсон, ямархуу хүнд байдалд орсон бэ гэдэг нь тодорхой харагдаж байна шүү дээ.

Би Монголын парламентад өөрийн улсын хууль эрх зүйн хүрээнд ч тэр, олон улсын хууль эрх зүйн хүрээнд ч тэр үндэстэн дамнасан корпорацийн нарийн ширийн юмыг гаргаад ирэх чадалтай сайхан залуучууд орж ирсэнд би баяртай байгаагаа хэлье.

Манай О.Батнайрамдал Э.Болормаа, Ө.Шижир, Б.Жаргалан, П.Ганзориг гээд л олон залуучууд Оюу Толгойн асуудал дээр нэлээн тийм зориг гаргаж ажиллах шиг боллоо.

Мөн 17 жилийн хугацаанд Оюу Толгойг Монголын ард түмний анхаарлын төвд байлгаж ирсэн, олон удаа сонгогдсон гээд л янз бүрээр яригддаг Их Хурлын гишүүд, манай Б.Бат-Эрдэнэ аварга, Ц.Даваасүрэн гишүүн, Д.Тэрбишдагва гээд л олон гишүүд. Манай С.Ганбаатар гишүүн гээд л. Энэ хүмүүст би талархал илэрхийлэх зүйтэй гэж бодож байна.

Эргээд харахаар өнөөдөр Оюу Толгой бид гаднын хөрөнгө оруулалтууд хэрэгтэй, янз янзын улс оронд ашигтай л гэж ярьсан. Тэгээд үнэхээр бас тийм харамсалтай л дүр зураг сая гарч ирлээ шүү дээ.

Би бас шинжээчдэд талархал илэрхийлье гэж бодож байна. Маш сайн ажилласан байна. Улс төрчид үгийг нь авах авахгүй нь л байдгаас биш Монгол Улсын шинжээчид маш сайн, төрийн албаныхан сайн ажилладаг юм байна гэж харж байгаа.

Дээрээс нь ТУЗ-ийн гишүүнээр ажиллаж байсан н.Баясгалан гээд эмэгтэйд талархал илэрхийлэх нь зүйтэй болов уу. Үнэхээр Монгол Улсын эрх ашгийг тэнд хангуулахын төлөө нэлээн хичээж чармайж ажилласан юм байна. Тэрийгээ ч энэ сонсгол дээр нүүрийг нь харж байгаад илэрхийлж чадаж байна лээ.

Хэрэг эрхлэхийн сайдаар ажиллаж байсан, дэд сайд, дэд даргаар ажиллаж байсан одоогийн Гэр бүл, хөгжлийн дэд сайдаар сонгогдоод удаагүй байгаа н.Солонгоо гээд. Би сайн ажиллаж байна гэж бодож байна.

Одоо харин Засгийн газар, С.Бямбацогт дарга тэргүүтэй хүмүүс гэрээ хийж байгаа процесс явж байгаа учраас би илүү айхтар нарийн юм руу ороод яах вэ. Эндээс уул уурхай Монголыг тэжээж байгаа гэдэг том малгай өмсгөөд яс үнэндээ “Эрдэнэт”, “Эрдэнэс Тавантолгой” хоёр нь тэжээгээд, бусад томоохон төсөл, хөтөлбөрүүд нь Монгол Улсад тийм ашигтай явдаггүйн тод илэрхийлэл эндээс гарч ирж байна гэж харж байгаа юм.

Үүнээсээ болоод ард түмэн говьд байгаа Оюу Толгойгоо ингээд тавиад туусан. Зүүнтээ байгаа нефтийнхээ, Тамсагийн нефтиэ тавиад туусан.

Тэгээд уул уурхай чинь ингээд томоохон төслүүд нь ашгаа өгөхгүй болохоор ард иргэд дараагийн том төслүүдийг чинь хөдөлгөхийг эсэргүүцэхээр уул уурхайгаар л бид тэжээгдэж байна гэж яриад байж боломгүй юм шиг санагдаад байдаг юм. Эндээс харж байхад.

Тэгээд хоёр асуулт байгаа юм. Их Хурлын тогтоолын төсөл дээр 2026 оны намрын чуулган гэдэг чинь одоогоос бараг жилийн дараа гэсэн үг шүү дээ. Орж ирэх л юм байна шүү дээ. Засгийн газарт чиглэл өгч байна.

Мөн заавал ганцхан Эдийн засгийн байнгын хороо биш одоо нэгэнт Монголыг тэжээх Эрдэнэтээс хэд дахин илүү энэ том ордныхоо асуудлыг Их Хурал дээрээ ер нь ярьж байвал яасан юм. Засгийн газрын хэлэлцээр юмнууд нь яваад гэдэг нэг ийм асуулт.

Ард түмэн яг хэлэхийг, мэдэхийг хүсээд байгаа зүйл бол Оюу Толгойн ордын анх тогтоогдсон нөөцөөсөө хэдийг нь ухаж гаргачхаад цаана нь хэд нь үлдээд байгаа юм? Энэ Онтрэг нь хасаад шүү. Одоо “Онтрэ” рүү орно гээд байгаа шүү дээ. Тэрийг эрт илрүүлээд ашигтай болгохоор.

Тэгэхээр би энэ жилийн хугацаа гэдэг нэг асуулт байна.

Хоёрдугаарт, Оюу Толгойн нөөц хэд байна.

Н.Учрал: О.Батнайрамдал гишүүн хариулна.

О.Батнайрамдал: Ц.Идэрбат гишүүний асуултад хариулья.

Тогтоолын төсөл дээр бид 2026 оны намрын чуулган буюу тэгээд таны хэлж байгаа яг зөв л дөө. Жилийн дотор энэ асуудлуудаа шийдээд Улсын Их Хуралд оруулж ир гэж чиглэл өгч байгаа.

Ингэхдээ ер нь бид урьд урьдын тогтоолоос суралцсан нэг зүйл хэрэгжилтийн үйл явцаа буцаад мэргэжлийн Байнгын хороондоо танилцуулж бай.

Тэгэхээр 2026 оны намрын ээлжит чуулганд багтаан танилцуулж шийдвэрлүүлэх явцдаа улирал тутам сая бид Эдийн засгийн байнгын хорооноос санал, дүгнэлт авсан шиг хамаарах Эдийн засгийн байнгын хороондоо улирал тутам танилцуулж, хамгийн гол нь олон нийтдээ нээлттэй, ил тод бай байдлыг хангаж танилцуулж ажилла гэсэн чиглэлийг давхар өгч байгаа юм.

Тэгэхээр хэлэлцэх явц нь ч гэсэн олон нийтэд нээлттэй байх ёстой. Эдийн засгийн байнгын хороон дээр хэлэлцээд тэрийг Улсын Их Хурал руу, чуулган руу, Байнгын хорооноос нь оруулж ирэх бүрэн эрх нь байгаа гэж ойлгож байгаа.

Тантай санал нэг байна. Оюу Толгойн томоохон асуудлууд дээр, ялангуяа Монгол Улсын эдийн засаг талаас ч, олон талаасаа ач холбогдолтой том төслүүдийг чуулган дээрээ бид жилд хэд ч хамаагүй ярьж байх ёстой. Олон нийтэд нээлттэй байх ёстой.

Тэгэхээр мэргэжлийн Байнгын хороондоо улирал тутам танилцуулаад жилийн дотор энэ асуудлуудаа шийдээд урагшильга гэж байгаа юм. Олон жил ужгирч улс төржиж явлаа. 30 жилийн гэрээ байгуулсан. 16 жил нь өнгөрсөн байна. Хагасаас илүү хугацаа нь өнгөрсөн.

Тэгэхээр энэ 3 өдрийн сонсголоор юу ойлгомжтой болсон бэ гэхээр нэг үнэлэлт дүгнэлт өгөөд урагшаа хараад явах цаг нь болжээ.

- Илүү нээлттэй явах ёстой юм байна.
- Олон нийтдээ ойлгуулж явах ёстой юм байна.
- Хөрөнгө оруулагч болон Монголын талын мэдээллийн тэнцвэргүй байдлыг цаашдаа арилгаж явах ёстой юм байна.

Энэ зүйлүүд ер нь сая сонсголоор олон нийт ч гэсэн нэлээн ойлголт авлаа. Мөн энэ Оюу Толгой төсөл дээр анх гэрээ байгуулахаас эхлээд сүүлийн 16 жилийн туршид оролцсон шийдвэр гарагчид ч гэсэн бүгдээрээ хамтдаа хүлээн зөвшөөрсөн байгаа.

Та хоёр дахь асуулт. Нөөцийн талаар асуулаа. Тийм ээ. Өнөөдөр чуулган дээр манай хянан шалгах шинжээчид нийтдээ 18 хүн одоог хүртэл нүүр царай нь Та бүхэнд харагдаагүй. Яагаад гэх юм бол нөлөөлөл орж болохгүй гэсэн үүднээс харуулаагүй. Өнөөдөр чуулганы танхимд Та бүхний нэмэлт асуултад хариулах боломж олгох ёстой.

Тогтоосон нөөцтэй холбоотойгоор манай шинжээчдээс хариулах уу? Д.Бат-Эрдэнэ шинжээч.

Н.Учрал: Шинжээчдээс хариулна. 4 дүгээр микрофон.

Д.Бат-Эрдэнэ: Бүгдээрээ сайн байцгаана уу? Намайг Д.Бат-Эрдэнэ гэдэг юм. Би шинжээч. Геологи мэргэжилтэй. Асуултад би хариулъя.

2021 онд Эрдэс баялгийн зөвлөлөөр ороод Оюу Толгойн бүлэг ордын нөөцийг нь албан ёсоор бүртгэж авсан.

- 6.2 тэрбум тонн хүдэрт,
- ▶ 43.2 сая тонн зэс,
- ▶ 1800 тонн алт,
- ▶ 11 мянга 745 тонн мөнгө,
- ▶ 250 мянган тонн молибден гэж авсан.

Энэ бол яг Монгол Улсад албан ёсоор бүртгэсэн тоо байгаа юм.

Бид танилцуулгадаа хийхдээ мөн судалгаа явж байхад нь нөөцийн тухай асуудлыг би Та бүхний сонорт чинь товчхон хэлье.

Өнөөдрийн байдлаар Оюу Толгой компанийн хийсэн тооцоогоор ерөнхийдөө Оюу Толгой ордын 43 сая тонноос ерөнхийдөө 24 сая тонныг нь олборлоод, 19 сая тонныг нь үлдээхээр төсөөлсөн байгаа.

Энэ бол маш том, маш чухал асуудал байгаа. Энэ бол Үндсэн хуультай... /минут дуусав/

Н.Учрал: Нэмэлт 1 минут өгье.

Д.Бат-Эрдэнэ: Товчхон ярья. Энэ асуудлыг бид их онцгойлж гаргасан шүү. Үүнийг Та бүхэнд бидний хийсэн танилцуулгад сайн судална биз дээ.

Саяын асуултад хариулъя.

- ➔ 2014-2021 оны хооронд Оюу Толгойгоос 1.1 сая тонн зэс олборлосон.
- ➔ 2021 оноос өнөөг хүртэлх 4 жилийн хугацаанд ерөнхийдөө хүчин чадлаа нэмсэн учраас төдий дайны олборлосон байгаа.

Тийм учраас албан ёсны бүртгэсэн нөөцөөс 41.9 хавьцаа сая тонн зэс газрын хэвлийд үлдсэн байгаа.

Миний хэлдгээр 50 хувийг нь үлдээнэ гэж байгаа нь маш том асуудал. Оюу Толгой дээр их том тооцоо байдаг. Их мөнгө авсан. Түүнийгээ төлнө гэхэд тал нь газрын хэвлийд үлдэх юм бол бид юутай үлдэж байгааг бодох хэрэгтэй.

- Энэ нь Үндсэн хуультайгаа ч зөрчилдөж байгаа.

➤ Ашигт малтмалын хуультай ч зөрчилдөж байгаа.

Энэ асуудлыг Та бүхэн сайн бодож тунгааж авна уу. /минут дуусав/

Н.Учрал: Ц.Идэрбат гишүүн тодруулна.

Ц.Идэрбат: Тийм. Үндсэн хуультай ч нийцэх хэрэгтэй. Иргэдийн хүсээд байгаа цалин 1 сая доллар болгох хүсэлт шаардлагууд төрийн албан хаагч нар тавьдаг. Тэтгэврийг сая 500 мянган төгрөг болго гэдэг энэ шаардлагыг биелүүлэх юм бол өнөөдрийн татварын эрх зүйн орчин тулдгаа тулаад, татвараа яаж буулгах вэ гэж байгаа энэ үед боломжгүй. Гэхдээ бид ийм ордууд дээрээ эзэн болж чадаж байж л энэ юм руугаа хүрнэ шүү дээ.

Тийм учраас үүнийг би ганцхан Эдийн засгийн байнгын хороо биш Их Хурлын чуулган дээр хүртэл яриулаад, тэгээд энэ нээлттэй байх тусмаа янз янзын шахалт дарамтаас Монголчууд би хол байж, энэ ажлын хэсэг, шийдвэр гаргах түвшний хүмүүс нь ч хол байж чадна гэж би харж байгаа учраас Байнгын хорооны тогтоол дээр Эдийн засгийн байнгын хороонд танилцуулна гэснийг ард нь Их Хурал гэж нэмэх санал нэгдүгээрт надад төрж байгаа юм.

Энэ бол Монголчуудын цаашдын л хувь заяаны том асуудал. Хэдэн Эрдэнэтийн талаар бид ярьж байна шүү.

Н.Учрал: Лувсанбямбаагийн Мөнхбаясгалан гишүүн асуулт асууна.

Л.Мөнхбаясгалан: Улсын Их Хурлаас байгуулагдсан Хянан шалгах түр хороо бүтэн 6 сар ажилласны эцэст Та бүхний улс даяар нээлттэй сонсгол явуулсны хүчинд бид юу мэдэж авсан бэ гэвэл энэ гэрээ –

- Монгол Улсын эрх ашигт илт хохиролтой,
- Үндэсний эрх ашгийнхаа эсрэг,
- Улсын Их Хурлын удаа дараагийн тогтоолыг үл биелүүлсэн,
- Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн зөвлөмжийг хэрэгсээгүй –

-ийм гэрээ байгуулсан юм байна гэдгийг бид мэдэж авсан.

2010-2037 он хүртэл зээлийнхээ хүүнд –

➔ Рио Тинто 31.2 тэрбум долларыг авна.

Харин Монгол Улс баялгаа өгөөд 34 хувиа эзэмшиж байгаа хэрнээ 20 тэрбум долларын өрөнд орсон ийм гэрээ.

Дээрээс нь борлуулалтын орлого нь Монголын банкнуудаар дамждаггүй.

Тийм учраас бид борлуулалтын орлогод хяналт тавих ямар ч боломжгүй. Ийм гэрээ байгуулсныг Та бүхэн илчилж Монголын ард түмний, Монгол Улсын Их Хурал, Засгийн газрын эгдэх эрхийг бүрэн хангаж өглөө.

Тийм учраас энэ гэрээг байгуулж улсынхаа эсрэг ажилласан нөхдүүдэд бид хариуцлага тооцох ёстой.

Бид хүүгээ буулгах, сорчлон олборлолтыг болиулах хэлэлцээрийг Засгийн газар хийгээд явах байх. Харин Монгол Улсад илт хохиролтой, урьдчилан тохиролцсон, Монгол Улсын эдийн засгийг хорлон сүйтгэх ажиллагаа явуулсан. Гадаадын байгууллагад төрийн нууцыг задалсан, гадаадын байгууллагатай хамтран ажилласан гэмт хэргийн шинжтэй үйлдэл, эс үйлдэхүйд бид хариуцлага тооцох ёстой.

Төр ард түмний хохирлыг Монгол Улсын Ерөнхий прокурор нэхэмжлэх үүрэгтэй.

Шударга хуулийн ёсоор тангараг өргөсөн Тагнуулын ерөнхий газар, Улсын ерөнхий прокурор, Авлигатай тэмцэх газар үүнийг ухамсарлаж, энэ тогтоолын дагуу, зөвлөсний дагуу ажлаа хийж буцааж, нийт ард түмэнд тайлагнах ёстой.

Ингээд Улсын Их Хурлаас байгуулагдсан Хянан шалгах түр хороо О.Батнайрамдал даргатай Э.Болормаа, С.Зулпхар, Б.Бат-Эрдэнэ, Б.Баярбаатар, Б.Жаргалан, Ш.Бямбасүрэн, Ө.Шижир, П.Ганзориг. Үүний дээрээс хамтран ажилласан бүх шинжээчид, төрийн албаныхан Та бүхэнд баяр хүргэе.

Та бүхний энэ тогтоолд өнөөдөр хариуцлага тооцохыг оруулсан байна.

Дээрээс нь Монголын банкаар явдаггүй Оюу Толгойн борлуулалтын тэр гүйлгээг Монголын банк, Төв банк, Монголын арилжааны банкуудаар дамжуулах зөвлөмж тогтоолд тусгаж өгч байгаа нь энэ бол түүхэн гавьяа.

Үүнийг Монголын төр хоёр парламент дараалан чаддаггүй байсан юм.

Та бүхнийг маш их доромжиллоо, маш их гүтгэлээ, маш их дарамталлаа. Бид харж байсан. Гэхдээ Та бүхний өнөөдөр Монголын ард түмний өмнө, Монголын төрийн өмнө байгуулж байгаа энэ гавьяаг үнэлэх цаг ирнэ. Айх хэрэггүй. Та бүхэнд баярлалаа. Амжилт хүсье.

Н.Учрал: Баярлалаа. Болдын Уянга гишүүн. Л.Мөнхбаясгалан гишүүн санал хэллээ. Болдын Уянга гишүүн.

Б.Уянга: Энэ өдрийн мэнд хүргэе.

Би бараг санал хэлэх юм. Өөрийнхөө асуултыг –

- Монгол Ардын намын бүлгийн хурлаар,
- Эдийн засгийн байнгын хорооны хурлаар,
- Хянан шалгах түр хорооны хурлаар орж –

- мэдээллээ,
- өөрийнхөө бодлыг,
- тэгээд саналаа хэлэлцүүлсэн байгаа.

Энэхүү Оюу Толгойтой холбоотой сонсгол 2024 оны 6 дугаар сард шинэчлэн найруулагдсан Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн дагуу зохион байгуулагдсан. Шинэхэн шинэчилж байгуулсан хууль юм байна.

Ер нь гол концепц нь иргэдийг мэдэх эрхээр нь хангая. Яг энэ үүргийг түр хорооны гишүүд бүрэн дүүрэн хангасан гэж үзэж байгаа.

Оюу Толгойн бүлэг орд дээр сонсгол хийе гээд О.Батнайрамдал гишүүнийг гарын үсэг цуглуулаад явж байхад ер нь аливаа үйл ажиллагаа ил тод, нээлттэй, мэдээллээ хүргэж байх ёстой гэдэг үүднээс дэмжиж зурсан гишүүдийн нэг.

Тэгэхдээ цааш цаашдаа ер нь ямар нэгэн төслөөр, өөр үйл ажиллагаагаар хянан шалгалт явахад хуульд өөрчлөлт орох юм байна гэж харсан. Үүнийг заавал тэмдэглэн үлдээмээр байгаа юм.

- ▷ **Нэгдүгээрт**, маш олон гишүүд түр хороог, сонсголыг мэдээллийн ил тод байдлаас нь дэмжсэн боловч яг сонсголын гурван өдөр Улсын Их Хурлын гишүүд түр хороонд л ороогүй бол орж нээлттэйгээр асуултаа асуух, саналаа хэлэх боломж огт байгаагүй.

Юу сонсогдсон бэ гэхээр ерөөсөө урьд өмнө нь ажиллаж байсан улс төрчид ирээд л микрофон олдсон дээр гэсэн шиг л бөөн хэрүүл ярьсан. Бие биедээ дуртай дургүйгээ ярьсан, би үүнийгээ гүтгэсэн. Энэ мэдээлэл нь маш их дамжсан юм

Тэгэхээр энэ дээр жаахан харамсаж хүлээж авсан. Цааш цаашдаа яах вэ гэдгээ яримаар байсан. Тэгээд дараа дараа хийгдэх хяналт шалгалтын түр хороонууд хүлээгдэж байх шиг байна. Энэ дээр үүнийгээ анхаармаар санагдсан.

Ер нь Оюу Толгойн асуудлыг ойлгоё гэж бодож байгаа иргэд байвал тэр хэрүүлийг нь сонсоод байхгүй, бүгдийг нь сайхан хасаж байгаад шинжээчдийн дүгнэлтийг, тэр илтгэлийг л сонсмоор юм шиг байгаа юм. Тэгэхэд бараг хангалттай мэдэх эрхээ авмаар юм шиг.

Тэгэхээр дэг дээр нь, хуульд нь холбогдох өөрчлөлтүүдийг оруулах нь зүйтэй байсан.

Ер нь тэгээд Оюу Толгойн энэ сонсголыг хоёр агуулгаар хийж байгаа.

Зээлийн хүүгийн талаар гээд гишүүд нэлээн сайн ярьсан. Тэгэхдээ Оюу Толгой төсөл ер нь Human Capital гэж ярьдаг.

- Хүний хөгжилд хэр их нөлөө үзүүлж байгаа юм бэ?
- Монгол инженерүүдэд юу үлдэж байгаа юм бэ?
- Өмнөговь аймгийн Ханбогд сум яаж хөгжсөн юм?

Энэ талаар ерөөсөө мэдээлэл байгаагүй. Иргэд энэ мэдэх эрхээ эдлээгүй. Энэ сонсголын чинь үндсэн үүрэг нь Улсын Их Хурал, Засгийн газарт мэдээлэл өгөхдөө биш Монгол Улсын иргэдэд мэдээллийг өгөхдөө байгаа шүү дээ. Мэдэх эрхээ хангахдаа.

Тэгэхээр магадгүй сонсголын хоёр гол зорилгод нь “хүний хөгжил” ороогүй юм гээд хааж магадгүй л дээ. Гэхдээ яг энэ тогтоолын төслийн хэд хэдэн заалт. 3, 5, тэгээд 2 дугаар зүйл. Эдгээр нь үндсэн хоёр сонсголын хүрээний асуудал биш шүү дээ. Халиад ороод ирсэн тогтоолын заалт, зүйлүүд.

Тэгээд ер нь энэ тогтоолыг дэмжихгүй байгаа үндсэн шалтгаанаа хэлэхэд Эдийн засгийн байнгын хороо болоод өчигдөр Түр хорооны хурал дээр ороод хад мөргөсөн нэг зүйл нь бүхэл бүтэн Монгол Улсын Их Хурал 126 Улсын Их Хурлын гишүүдээс Монгол Улсад хэрэгжиж байгаа энэ төслийн үргэлжилж байгаа хоёр тусгай зөвшөөрлийг шаардлагатай бол тусгай зөвшөөрлийг нь цуцлах арга хэмжээг ав гээд Засгийн газарт даалгаж байгаа байхгүй юу.

Яг энэ тусгай зөвшөөрөлтэй холбоотой асуудал Монгол Улсын Үндсэн хууль, Ашигт малтмалын тухай хуулиараа угаасаа бүгд зохицуулагдсан байтал тэрийг нь заавал оруулж бичиж байгааг дэмжихгүй байгааг албан ёсоор... /минут дуусав/

Н.Учрал: Санал хэллээ. Цэндийн Сандаг-Очир гишүүн.

Ц.Сандаг-Очир: Улсууд их баярлаад алга ташаад байх шиг байна. Би баярлах болоогүй байна л гэж харагдаж байна.

Оюу Толгойн бүлэг ордын ашиглалтад –

- ▶ **Нэгд,** Монгол Улсын эрх ашгийг хангуулах.
- ▶ **Хоёрт,** Хүртэх өгөөжийг нэмэгдүүлэх –

-гээд маш тодорхой хоёр хүрээ заагийн хүрээнд нээлттэй сонсгол явсан.

3 өдөр нээлттэй сонсгол хийлээ. Эндээс ард түмэн юу мэдэв, ямар дүгнэлтэд хүрэв гэхээр үндсэндээ Оюу Толгойн гэрээ Монголын эрх ашигт хохиролтой юм байна гэдэг үндсэн ойлголтыг авсан.

Монголын эрх ашгийг хангуулж чадаагүй юм байна гэдгийг ойлгосон. Энэ нээлттэй 3 хоногийн сонсголоос. Үүнийг олон нийтэд мэдээллийг хангах үүднээсээ өгч байгаа мэдээлэл нь энэ.

Тэгвэл цаашид яах юм. Ашиггүй гэрээ юм байна. Цаашид яах юм гэхээр сонсгол чинь сайн боллоо гэхэд хамгийн гол юм нь цаашид авах арга хэмжээний тогтоол байхгүй юу. Авч хэрэгжүүлэх арга хэмжээний тогтоол. Тэгээд сонсгол нь сайн болоод авч хэрэгжүүлэх арга хэмжээнийх нь тогтоол шол гээд унах шиг болох юм. Зөөлөн байх юм, мөлгөр байх юм.

Үнэхээр бүгдээрээ муу гэрээ, алдагдалтай гэрээ болсон юм бол үүнийгээ засаж залруулах асуудал чинь тогтоол дээр маш тодорхой орж ирэх ёстой шүү дээ. Хариуцлагын асуудлыг маш тодорхой ярих ёстой шүү дээ. Тэгтэл энэ асуудлууд ерөнхий, мөлгөр. Наад зах нь ерөнхий 2 дугаар зүйл дээр ингэж байгаа байхгүй юу.

Хянан шалгах түр хорооноос Оюу Толгой бүлэг ордын ашиглалтад Монгол Улсын эрх ашгийг хангуулах, хүртээх өгөөжийг нэмэгдүүлэх сэдвийн хүрээнд зохион байгуулсан хяналт шалгалт, нээлттэй сонсголын явцад ил болсон гэмт хэрэг, зөрчлийн шинжтэй үйлдэл, эс үйлдэхгүйг хууль тогтоомжид заасан үндэслэл журмын дагуу шалгах, шийдвэрлэхийг прокурор, Авлигатай тэмцэх газар, Цагдаагийн ерөнхий газар, тагнуулд зөвлөсүгэй гэж байгаа юм.

Зөвлөнө гэдэг чинь өөрөө зөвлөмж л байхгүй юу. Зөвлөмжийг авч ч болно, авахгүй ч байж болно, хэрэгжүүлж ч болно, хэрэгжүүлэхгүй ч байж болно.

Энэ байгууллагууд чинь энэ байгууллагад хүсэлт мэдээлэл ирж байж түүний мөрөөр тодорхой хяналт шалгалт хийнэ. Тэгвэл тэр байгууллагууд дээр үүнийг шалгаж өг, хариуцлагын арга хэмжээ, хяналт шалгалт хийж өг гээд мэдээлэл очихгүй бол яах вэ? Энэ мөрөөр ямар нэг арга хэмжээ явахгүй нь байна шүү дээ, авахгүй нь байна шүү дээ. Зөвлөсүгэй гэдэг бол. Би бол даалгасугай гэсэн байдлаар хатууруулж, чангаруулж өгмөөр санагдаад байгаа юм.

Тэгээд яагаад авах арга хэмжээний тогтоолоо зөөлрүүлээд, сулруулаад, мөлгөр болгоод оруулаад ирж байгаа юм. Эцсийн үр дүн нь –

- Монголын эрх ашгийг хангуулж чадсан юм уу?
- Хүртэх өгөөжийг нэмэгдүүлж чадсан юм уу?
- Алдагдал, зээлийн хүүг нь бууруулж чадсан юм уу?
- Монголчуудын хүртэх үр ашгийн хугацааг нааш нь татаж чадсан юм уу?

Гээд яривал эцсийн үр дүн нь ингэсний хойно энэ ажлын хэсэгт баярлалаа гэж хэлж болно. Түүнээс өнөөдөр ямар нэг баярлах юм болоогүй. Ард иргэд алдагдалтай байдлыг нь л мэдсэн болохоос биш үүний авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар тодорхой процесс явж байж, тодорхой гэрээг засах, сайжруулах үйл ажиллагаа явж байж, тодорхой субъектүүдэд хариуцлага оногдуулах асуудал яригдаж, тодорхой арга хэмжээ авагдаж байж үр дүн гарна.

Ингэж байж Хянан шалгах түр хорооны үйл ажиллагаанд, үүнийг хийсэн, зохион байгуулсан улсуудад баярлалаа гэх ийм асуудал үүсэх байх. Түүнээс наана өнөөдөр бид нэг их баярлаад. Өнөөдөр бахь байдгаараа л байж байна шүү дээ. Өнөөдөр. Тийм.

Тийм учраас баярлах болоогүй байна л... /минут дуусав/

Н.Учрал: Ц.Сандаг-Очир гишүүн санал хэллээ. Лхагвасүрэнгийн Соронзонболд гишүүн.

Л.Соронзонболд: Ямар ч байсан түр хорооныхон маань 3 өдөр монголчуудыг маш сайн мэдээллээр хангасан гэж би ойлгож байгаа.

Тэгээд тогтоолоосоо гадна санал, дүгнэлт гээд 6 хуудас нэлээн нарийн заасан зөвлөмжтэй бичиг баримт байгаа гэж ойлгож байгаа.

Би түр хорооны дарга О.Батнайрамдал гишүүнээс асуугаад байгаа нь менежментийн төлбөрийн хувь хэмжээн дээр ерөнхийдөө 6 хувийг тухайн жилийн хөрөнгө оруулалтын зардал болон үйл ажиллагааны зардлын нийлбэрээс Монгол Улс Оюу Толгой компани, “Рио Тинто” төлөөд байх шиг байгаа юм.

Тэгэхээр үүнийг ер нь цаашдаа бууруулах чиглэлээр түр хорооны санал, дүгнэлтдээ оруулсан гэж байгаа.

Тэгэхээр энэ дээр яг ямар утгаар оруулсан бэ? Энэ дээр нэг тайлбар өгөөч ээ.

Ер нь цаг хугацааны хувьд бодоод үзэхээр өнөөдөр 2025 он дуусаж байна. 2009 онд эхэлсэн төсөл 16 жил явлаа. Одоо хүртэл ашиггүй байна. Одоо ерөнхийдөө бүтээн байгуулалтын ажил дуусаж байгаа гэж ойлгож байгаа.

Тийм учраас менежментийн төлбөрийн хөрөнгийн зардал болон үйл ажиллагааны зардлын нийлбэрээс тооцож байгаа аргачлалыг ашгаас ч байдаг юм уу. Тийм ээ. Өөр үзүүлэлтээс тооцдог болох нэг.

Хоёрт, одоо энэ 6 хувь гээд байгаа чинь ер нь яах вэ, олон улсын менежментийн төлбөрийн дундаж жишгээр бодоод үзэхээр 2.5-аас 3 хувь, дээд

тал нь 3 хувь л байх шиг байна шүү дээ. Тэгтэл энэ хэмжээнд аваачих боломж байна уу? Энэ тал дээр ер нь санал, дүгнэлт дээр юу гэж туссан бэ гэж асууя.

Н.Учрал: Л.Соронзонболд гишүүн чинь түр хорооны гишүүн биш билүү?

О.Батнайрамдал гишүүн хариулъя.

О.Батнайрамдал: Ц.Сандаг-Очир гишүүн чухал асуулт хөндсөн учраас давхар хариулъя гэж бодож байна.

“Зөвлөсүгэй” гэж орсон байгаа. Тийм. Яагаад гэх юм бол хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд шууд чиглэл өгөх эрхгүй.

Тийм учраас хянан шалгалт, нээлттэй сонсголын явцад ил болсон гэмт хэрэг, зөрчлийн шинжтэй үйлдэл, эс үйлдэхүйг хууль тогтоомжид заасан үндэслэл, журмын дагуу шалгаж шийдвэрлэхийг яг тухайн хариуцаж байгаа субъектүүдэд зөвлөсөн байгаа.

Урьд өмнө нь 5 ч Хянан шалгах түр хороо гарч тогтоолууд гаргаж байсан.

Тэгэхээр бүгдээрээ “зөвлөсүгэй” гэдэг агуулгаар орсон байгаа. Анх Л.Мөнхбаясгалан гишүүний саналыг гаргаж байхад ч гэсэн “даалгасугай” гэдэг энэ яриа яг тань шиг бид ярилцсан юм, гарсан юм. “Даалгасугай” гэвэл илүү хүчтэй байна гээд.

Тэгээд Ерөнхий прокурор, Авлигатай тэмцэх газар, Цагдаагийн ерөнхий газар, Тагнуулын ерөнхий газар бүгдээрээ бие дааж мэргэжлийн хянан шалгах, шийдвэрлэх ажиллагаагаа явуулах ёстой.

Тийм учраас бид урдах хянан шалгах түр хорооны тогтоолуудыг ч харсан. Энэ дээр хуулийн мэргэжлийн зөвлөгөө авсан юм. Тэгээд “зөвлөсүгэй” гэдэг үгээр орох ёстой гэдэг агуулгаар орсон байгаа.

Л.Соронзонболд гишүүний асуултад. Тантай зарчмын хувьд санал нэг байгаа. “Менежментийн төлбөрийн асуудал” Монгол Улсын Засгийн газар, “Рио Тинто” хөрөнгө оруулагч талтай хийж байгаа хэлэлцээрийн бас нэг гол асуудлын нэг байгаа. Энэ нь өөрөө урьд өмнө гарч байсан 103 дугаар тогтоол дээр ч гэсэн ер нь орж байсан агуулгууд байгаа юм.

Ер нь Оюу Толгой дээр маш олон асуудлууд байгаа. Асуудал болгоныг бид тогтоолын төсөлдөө оруулах юм бол давхцалууд үүснэ.

Мөн Хянан шалгах түр хорооноос боловсруулсан тогтоолын төсөл бол бид эхлээд хүрээ хязгаарынхаа хүрээнд гаргасан тайлан тэнцэл, тайлан, хяналт шалгалтын үйл ажиллагаа дээрээ үндэслэж гаргасан байгаа.

Таны хэлсэн “менежментийн төлбөрийн асуудал” бидний 6 хуудас гарсан санал, дүгнэлт бас тусаж орсон байгаа.

Мөн Монгол Улсын Засгийн газар хэлэлцээрт орж байгаа учраас. Ер нь зарчмын хувьд тантай санал нэг байна. Зардлаас биш илүү ашгаас, гүйцэтгэлээс тооцож менежментийн төлбөр цаашдаа бодогдож явах ёстой.

Н.Учрал: Жамбын Батсуурь гишүүн асуулт асууна. Байхгүй байна.

Сайнхүүгийн Ганбаатар гишүүн.

С.Ганбаатар: Өнөөдөр баяртай өдөр байлгүй яах вэ. Баярлаж байна.

Монголчуудыг яаж тэнэгтүүлсэн, бид яаж тэнэгтсэн бэ гэдгээ мэднэ гэдэг бол асар том баяр. Гэхдээ анхнаасаа тэнэгтээгүй бол бүр том баяр л даа. Бид үүнийгээ мэдэх ч үгүй, ярих ч үгүй, тэгээд л бие биеийгээ хараагаад л яваад байгаа бол гунигтай.

Тэгэхээр би хувьдаа яагаад ийм байдалд оров, цаашид бид яах вэ гэдэг дээр хоёр, гуравхан санал хэлэхийг хүсэж байна.

Ер нь “Рио Тинто” асар том дэлхийн хэмжээний нинжа болж манай дээр ажиллалаа шүү дээ. Техник, эдийн засгийн үндэслэлгүйгээр ухна гэдэг Ноён уул дээр ухаж байгаа тэр нинжануудтай ямар ч ялгаагүй болсон гэсэн үг.

- Бидний хуулийг дээрэмдэж байна.
- Бидний хуулийг зөрчсөн.

34 хувийн хууль захиалгаар орж ирсэн. Хамгийн гол алдаа. Тэгээд дараа нь яаж гарц вэ гэдгээ ярья.

Монголын улс төрчид юу ч мэддэггүйгээ хэзээ ч мэддэггүй хамгийн том алдаа. Тэр 16 жилийн өмнө миний хамгийн их орилж байсан юм бол бие даасан хөндлөнгийн шинжээчийн дүгнэлтээ тойрч ярья. Өнөөдөр Улсын Их Хурал дотор их мэдэгч нар байдаг. Ямар муухай үзлийн үнэртэй, ямар муухай харагддаг гэж бодож байна.

- ▷ **Нэгдүгээрт**, хэлэлцүүлгийн хамгийн гоё юм нь шинжээч, экспертүүдийн дүгнэлтээ бид тойрч ярьсан.

Энэ нь цаашид гаргалгаа, гарц байгаасай л гэж би бодож байна. Уран дээр ч. Төрийн өмчийн компаниудын хулгайг өглөөжингөө ярьсан. Хөндлөнгийн шинжээчдийн дүгнэлтээ тойрч ярихгүй бол цээжээ дэлдээд л, бид хамгийн

ухаантай юм шиг л царайлаад байдаг нь бидний алдаа. Хойшид үүнийгээ анхааръя гэдэг гарц гаргалгаа маягтай ярьж байгаа юм. Нэгдүгээрт.

- ▷ **Хоёрдугаарт**, Рио Тинтогийн луйвар уг нь их хуучны, бүр хуучны, дээр үеийн, 100 гаруй жилийн өмнө хийж байсан арга шүү дээ.

“Transfer Pricing” гэж яриад байгаа. “Үнэ шилжүүлэх арга” гэж нэрлээд байх шиг байгаа юм.

- ▶ Үйлдвэр анх 1.7 тэрбум доллароор баригдана гэж яригдаж байсан.
- ▶ Одоо 22 тэрбум доллар.

Хариугүй баригдах гээд байна. Дахиад жоохон зээл хэрэгтэй байна л гэж явж байгаа. Энэ бол бид зардлаа хянаж чадаагүй гэсэн үг. Бидний гарц юу вэ гэвэл тэр 9 ТУЗ-ийн гишүүн дотор 3 хүн улс төрийн амралт, шагнал гэсэн үг. Ёс зүйтэй ганц нэг нь л орилдог байх.

Тэгэхээр тэр дотор ядаж бидний нэг саналыг авч байж гол гол асуудлууд дээр бидний саналыг нэг санал авч байж шийдэж байгаач гэж тухайн үедээ саналаа оруулж байсан шүү. Би 22 заалттай бичиг явуулж байсан. 7 удаа явуулсан. Гэхдээ гэрээ байгуулахаас өмнө.

Тийм учраас өнөөдөр ингэж ярих ёс зүйн эрх надад байгаа.

- ▷ **Гуравдугаарт**, 34 хувь гэдэг үхлийн цохилт байгаа юм шүү дээ.

51 хувь бараг хажууд нь ёстой зүгээр шүү дээ. Яагаад гэвэл хяналттай. 51 хувь гэдэг 9 хүний 5 нь манайд байна гэсэн үг байхгүй юу. 51 хувь гэдэг чинь. 34 хувь гэдэг 0-тэй адилхан. Бүр тэгээд өртэй.

Тэгэхээр үүнийг яаралтай ярилцахгүй бол тэгээд л тэнэгтээд л яваад байна л гэсэн үг.

Эцэст нь модоо бариад цалингаа ч тавьж чадахгүй хүнд байгаа үед арбитрын шүүх дээр байгаа ганц хэзрийг минь тэгээд буцаагаад, тохироод наймаалцав даа гэдгийг л эрх баригч нараасаа чин сэтгэлээсээ гуйя.

Тэр “Онтрэ” гээд “Онтрэ” дээр наймаалцав. Зэс 4200-д ашигтай байсан. Одоо 9 мянга, 10 мянга. /минут дуусав/

Н.Учрал: Сүхбаатарын Эрдэнэбат гишүүн асуулт асууна.

С.Ганбаатар гишүүнд нэмэлт 1 минут өгье.

С.Ганбаатар: Дээрэмдүүлснээ мэднэ гэдэг маань том аз юм. Ярихаас бүр баяр хүрээд байх юм.

Хамгийн гол гаргалгаан дээр нэг чухал юм байна. Одоо энэ баримт. Н.Бадамханд гээд Оюу Толгой Рио Тинтогийн Ерөнхий нябогийн гарын үсэгтэй бичиг байна.

Улиралдаа 30 тэрбум төгрөгөөр PR зарцуулдаг. Маркетингийн зардал гэж байгаа юм. Эд нар алт, зэсээ зарах гээд маркетинг хийгээд явдаггүй юм.

Монголчуудын тархийг угааж, үнэнийг ярьсан улс төрч болгоныг жадлан эсэргүүцэж гутаан доромжлах ажлаа хийдэг. Монголын төр ингэж хүчгүй, арчаагүй байж болохгүй. Үнэнийг ярих л юм бол зүгээр нэр хүндгүй болтлоо доромжлуулах нэг сонголт бий. Эсвэл чимээгүйхэн шиг нэр хүндтэй байх. Энэ тэнэглэлийг зогсоогооч. Монгол төр.

Үндсэн хуулийн 5.4-д заасан “эдийн засгийг Монголын төр зохицуулна” гэж заасан. Ширээний хоёр талд ижил тэнцүү суухын тулд нэг талаа 30 тэрбумаар улиралд, сард 10 тэрбумаар доромжлуулах энэ асуудлыг зохицуулаач ээ.

Н.Учрал: С.Ганбаатар гишүүн тодорхой санал хэллээ.

Цаашдаа бид өөрсдийнхөө санхүүгийн модель дээр өөрсдийнхөө хэлцлийг хийдэг жишиг рүү явах ёстой. Хүмүүсийн гэрээн дээр хүрч ирээд санхүүгийн модель дээр ярилцдаг биш, өөрсдөө санхүүгийн моделио гаргаад цаашид бидэнд ямар үр ашигтай, үр өгөөжтэй вэ гэдэг орчин үеийн корпорэйт хэлэлцээр хийх хэмжээний залуучууд зөндөө л төрж гарсан байна.

Тэр Оюу Толгойн гэрээг байгуулж байх цаг үеэс хойш боловсрол мэдлэг, ур чадварын хувьд манай залуучууд ахиц дэвшсэн. Тийм ч учраас сая хэд хэдэн гэрээ хэлцэл дээр Засгийн газрын зүгээс ажиллахад дэвшлүүд гараад явж байгаа.

Тийм учраас энэ удаагийн түр хороо ч гэсэн цаашдаа зөвхөн механик засвар хийгээд байхаасаа илүүтэйгээр өөрсдөө санхүүгийнхээ хэлэлцээрийг бие дааж хийдэг, моделио өөрөө гаргаж тавьдаг, үр ашиг, үр өгөөжийг нь тооцож чаддаг жишиг рүү авааын тулд О.Батнайрамдал даргатай түр хороо санаачилгатай ажилласан.

Тийм ч учраас Түр хорооны тогтоолд үндэслээд бид цаашдаа Монголын талын үр өгөөжийг нэмэгдүүлэхэд сайн дэвшлүүдийг Засгийн газар гаргахад энэ тогтоол бодитой хөшүүрэг болно гэдэгт эргэлзэхгүй байна.

Ингээд Сүхбаатарын Эрдэнэбат гишүүн санал хэлнэ.

С.Эрдэнэбат: Хянан шалгах түр хороог байгуулах саналыг анх дэмжиж гарын үсэг зурсан гишүүдийн нэг байна.

Хянан шалгах түр хороо маань богино хугацаанд боломжийн ажил гэж харж байна.

Мэдэх эрхийг нэлээн нээж өглөө. Олон экспертүүдийн чухал чухал саналууд энэхүү гэрээ хэлэлцээрийг урагшлуулах тал дээр дүгнэлтүүдийг уншсан. Тогтоолын төслийн 3 дээр би түрүүн манай шинжээч маш чухал мэдээлэл өглөө. “Сорчлох” гэдэг асуудал байгаа юм байна. Үндсэндээ манай нийт зэс, алт нөөцийн 50 хувь нь газар доороо үлдэнэ гэж.

Тэгэхээр энэ бол “сорчилно” гэсэн үг. 3 дугаар заалт дээр үүнийг сэргийлэх зорилгоор сорчлох гэдэг. Энэ тогтоолын “нөөцийг нэмэгдүүлэх” гэдэг байдлаар орж байна гэж ойлгож байна.

Тэгэхээр үг, үсгийн хувьд манай шинжээч нар маань тогтоолыг харж байгаа юу? Та нарт нэмж хэлмээр санал байвал хэлээч гэдгийг хэлмээр байна.

4 дүгээр заалт дээр 53 хувийн гээд. “Хоёр талын үр өгөөж” гээд яриад байгаа. “Монголын талын хүртэх үр өгөөж” гэж. Энэ тал дээр ойлголт дутуу, ерөнхий тавьсан. Яг юуг нь “үр өгөөж” гэж хараад байгаа юм. Юуг нь “үр өгөөж биш” гэж хараад байгаа юм гэдэг зүйлээ нарийвчлах хэрэгтэй шүү.

Хэт ерөнхий тавихаар л тэнд хулгай, луйвар, эсвэл буруу, зөрүү ойлголтын зөрүү гараад байдаг.

Тийм учраас 4 дүгээр заалт дээр 53 хувиас доошгүй байх. Тэгэхдээ “илүү хүртээмжтэй” байх.

- Монгол Улсын хэчнээн иргэн үр өгөөж хүртэх юм.
- Хэчнээн аж ахуйн нэгж, байгууллага худалдан авалт болон бусад бэлтгэн нийлүүлэх, ханган нийлүүлэлтээр үр өгөөж хүртэх юм –

-гэдэг зүйлийг илүү “хүртээмжтэй” гэдэг үгийг нэмэх саналыг хэлмээр байна.

Дараа нь Их Хурал дээр түрүүн хэн хэлэв. Зөвхөн Эдийн засгийн байнгын хороонд биш. Би яах вэ энэ тал дээр Монголын талын залуучуудад өгч байгаа үр өгөөж бий. Монголын Оюу Толгойд ажиллаж байсан залуучууд маань гадагшаа зарим нь гараад явсан юм билээ.

Дэлхийн том том уул уурхай руу ажиллаад явсан. Гүний уурхай руу нь орохоор бараг метро байтугай юм барьмаар тийм бүтээн байгуулалтыг манай залуучууд, монголын компаниуд, гаднын мэргэжилтнүүдээс сурч авсан. Энэ

хүмүүсийг ирээдүйд яаж ашиглах вэ гэдэг тооцоолол, энэ хүний нөөцийг яаж тогтоон барих вэ гэдэг асуудал чухал.

Хүний нөөц дээр түрүүн Б.Уянга гишүүн хэлэх шиг боллоо. Хүний нөөцийн тал дээр үнэлгээ, дүгнэлт хийх ёстой байсан юм. Цалин хөлсний асуудал, гадаад дотоод, монгол ажилчдын цалингийн зөрүү. Тэр нөгөө ростерын асуудал гээд байгаа. Үүнтэй холбоотойгоор Оюу Толгой үүнийг эргээд больё гэдэг маш их лобби хийдэг. Би нэгэнт хүрсэн юмнаасаа битгий ухраасай гэдэг зүйлийг тавьж байгаа.

Түүнээс болж цалин хөлсний зөрүү маргаан нэлээн гарсан байгаа. Тэгээд энэ зүйл дээр Оюу Толгой олон ажилчидтай би уулзаж байсан. Газар дээр нь танилцаж байсан. Олон зүйлийг нь захидаг юм нэг нь энэ байгаа.

Тийм учраас цаашдаа 15 жил контейнерт амьдарлаа шүү дээ. Энэ дээр хот үлдэх ёстой гэж бодож байгаа.

Хамгийн сүүлд Оюу Толгойн удирдлагуудтай уулзаж байхад 50 сая орчим доллароор орчин үеийн байшин барилга барих тал дээр хөрөнгө оруулах гэж байгаа гэж байгаа. Энэ хэвээрээ байгаа болов уу гэж би тодруулж асуумаар байна.

Дээр нь зээлийн хүүгийн асуудал дээр манай Засгийн газар хэлэлцээр хийхэд нэлээдгүй нэмэр боллоо гэж бодож байна. Болж өгвөл ирэх жилдээ багтаагаад нэг сарын өмнө ч гэсэн уг нь хийвэл. Бид чинь тэтгэврээ яаж 300 доллар болгох вэ, цалингаа яаж мянган доллар болгох вэ гээд үзэж тарж байгаа шүү дээ. Төсөв дээрээ.

Тийм учраас энэ асуудлыг шийдэх нь алсдаа Монголын хүртэх үр өгөөжийн хугацаа наашлах хэдий ч гэсэн Монгол Улсын төсөвт болон аж ахуйн нэгж, байгууллага, ажилчид 20 мянган ажилчин хүн ажиллаж байгаа. Шууд болон шууд бусаар. Энэ хүмүүст үр өгөөжийг наашлуулахад амжилт хүсье.

Н.Учрал: О.Батнайрамдал гишүүн түр хорооныхон анхаарах хэрэгтэй.

Сая С.Эрдэнэбат гишүүн бодитой санал хэлж байна. Уул уурхайн салбараас орж ирж байгаа өгөөж чинь –

- Шууд өгөөж гэж байна.
- Шууд бус өгөөж гэж байна.
- Дам өгөөжүүд байна.

Энэ чинь зөвхөн эдийн засгийн өгөөж биш шүү дээ.

Тэгэхээр наадхынхаа хүрээ хязгаарыг тодорхой болгож өгөхгүй бол цаашдаа эцэс төгсгөлгүй маргаан болох асуудал болох вий дээ. Цааш цаашдаа ч гэсэн ер нь манай улс хэлэлцээр хийхдээ эдийн засгийн өгөөжийнхөө хүрээг тодорхой болгох хэрэгтэй.

Тэгэхгүй бол “өгөөж”, “өгөөж” гэдэг үг оруулдаг. Тэгээд эндээс үүсэх эрх зүйн үр дагавар, маргааныг бид хэрхэн шийдэх вэ гэдэг асуудал үүснэ. Шаардлагатай бол хуулийг нь ч гэсэн оруулж ирээд яг “эдийн засгийн өгөөж” гэж юуг тооцох юм. Жишээ нь, “Орано”-гийн гэрээн дээр “15 өгөөж” гээд явсан шүү дээ. Тийм ээ. Тэр дотор татвар хураамж, усны төлбөр ч гэдэг юм уу, төлбөр, татвар хураана.

Энэ чинь нийлээд 53 хувь гэж үзээд байгаа шүү дээ.

Тэгэхгүйгээр “ерөнхий өгөөж” гэдэг. Тэгээд нэг тогтоол хэрэгжүүлэх гэхээр Засгийн газарт их төвөгтэй болно. Түүн дээр О.Батнайрамдал гишүүн нэг тайлбар хэлээч. О.Батнайрамдал дарга.

О.Батнайрамдал: С.Эрдэнэбат гишүүн, Н.Учрал даргатай 100 хувь санал нэг байгаа.

Яг бид энэ 6 сарын хяналт шалгалтын үйл явцад юу ойлгомжтой вэ гэхээр “үр өгөөж” гэдэг дотор юу багтахгүй, багтах вэ гэдэг маргаан ер нь сүүлийн 16 жил явж ирсэн.

Анх 2009 оны Хөрөнгө оруулалтын гэрээ байгуулахад, 2010 онд гэрээ байгуулсныхаа дараа л даа. 6 сарын дараа техник, эдийн засгийн үндэслэлээ баталсан. Эндээ “53 хувийн өгөөж” гэдгийг оруулаад, Монголын тал юу гэж ойлгосон бэ гэхээр эндээс “53 хувийн үр өгөөж” хүртэх юм байна.

Түүнээс хойш тэр “53 хувьд” юу орсон, дараа нь юу орох вэ гэдэг хоёр талын маргаан одоо хүртэл тасраагүй. Сая сонсголоор ч гэсэн маш ойлгомжтой харагдсан.

Оюу Толгой нэг талаасаа манай үр өгөөж “61” байна гээд байдаг. Гэтэл Монгол Улсын Засгийн газар “35” байна гэдэг.

Тэгэхээр үүнийг бид санал, дүгнэлтдээ маш ойлгомжтой тусгаж өгсөн байгаа. Санал, дүгнэлтийн 2.5 гэсэн хэсэг дээр яг Оюу Толгой төслийн Монголын болон гадаад хөрөнгө оруулагчийн талын үр өгөөжийн тодорхойлолт, түүнд хамруулж буй үзүүлэлтийг тооцох аргачлалын талаар байр сууриуд нэгдсэн ойлголтод хүрээгүй зөрүүтэй байгаа нь үр өгөөжийн хувь хэмжээ, тэр бүү хэл эдийн засгийн агуулгаар авах юм бол нэрлэсэн үнэ цэнээр хэсэг цаг хугацааны хувьд тодорхойгүй байна.

Үүнийгээ цаашаага илүү ойлгомжтой болгож, зүгээр тохиролцоод орхих биш холбогдох гэрээнд тусгаж албажуулж хоёр тал илүү ойлгомжтой явах юм байна гэж.

Сая сонсгол дээр ч гэсэн би буруу санаагүй бол 2009 оны хөрөнгө оруулалтын гэрээг байгуулсан С.Баяр Ерөнхий сайд асан ирж энэ талаар ярьсан. Үгэндээ ойлгомжтой хэлсэн л дээ. Ер нь энэ үр өгөөжийг бид анхнаасаа гэрээндээ тусгаагүй, ойлгомжтой болгоогүй нь бас нэг алдаа байжээ гэж.

Тэгэхээр үүнийг бид засаад л урагшлах ёстой.

Сая Н.Учрал дарга хэлж байна. “Орано” бид “үр өгөөж” гэдгийг юу гэж тодорхойлох юм гэдгийг гэрээн дээрээ маш ойлгомжтой тусгаж өгсөн.

Тэгэхээр үүнийг ч гэсэн бид заавал шийдэх ёстой. Энэ “үр өгөөж” гэдэг үг, агуулга Монгол Улсын Үндсэн хууль дээр бид тусгасан шүү дээ. Стратегийн ач холбогдол бүхий ордыг ашиглахдаа “үр өгөөжийн дийлэнх нь ард түмэнд ногдох” гэсэн зарчмыг тусгаж өгсөн. Тэгвэл энэ үр өгөөжийг бид Үндсэн хуулийн дагалдан хуулиар нь ч гэсэн харсан. Одоо хүртэл ойлгомжгүй байгаа.

Тийм учраас Оюу Толгой төсөл дээр хоёр тал үр өгөөжийн тодорхойлолт, тооцоолох аргачлалаа маш ойлгомжтой болгоод холбогдох гэрээндээ албажуулж тусгах ёстой. Тэгээд үүнийгээ бид 3 жил тутам харилцан хянадаг байя.

Мөн Оюу Толгой хариуцлагатай хувьцаат компанийн жилийн үйл ажиллагааны тайландаа үүнийгээ тусгаад тайлагнаад явдаг байя гэсэн зарчмыг бид Улсын Их Хурлын тогтоолын төсөлдөө тусгаж өгсөн байгаа.

Н.Учрал: Тэр “үр өгөөж” гэдэг дээр татвар, ногдол ашиг үр өгөөжид хамрагдана, эсвэл нийгмийн даатгалын шимтгэл хамаарагдах уу, үгүй юу гээд эцэс төгсгөлгүй маргаан болдог байхгүй юу.

Тийм учраас Оюу Толгойн түр хорооны тогтоолыг баталсны дараа ер нь ирэх жилээс О.Батнайрамдал гишүүнээр өөрөөр нь ахлуулаад энэ үр өгөөжид ер нь юу хамаарна, хамаарахгүй гэдгийг нь нарийвчлан заасан хуулийг хавар батлах хэрэгтэй.

Тэгэхгүй бол одоо бид чинь хөрөнгө оруулалтын гэрээ хэлцэл хийхэд, ерөөсөө хэлэлцээр хийхэд тулгараад ороод ирдэг юм билээ. Түүнээс шууд, шууд бус, дам өгөөжүүдийн тооцоо явбал 53 бүр даваад алга болно. Гэтэл яг “эдийн засгийн өгөөж” гэхээр тэр чинь нийгмийн даатгалын шимтгэлийг тооцох уу, үгүй юу гээд эхлэхээр 53 хүрэхгүй гээд байдаг байхгүй юу.

Тэгэхээр цаашаа энэ чинь АМНАТ-аар төрийн эзэмшлийн хувь хэмжээг орлуулах ч гэдэг юм уу, ингээд явах гэхээр яг тэр Үндсэн хуулийн заалтыг бид нар давах уу, үгүй юу гэдэг дээр тулна.

Тийм учраас О.Батнайрамдал гишүүнээр ер нь түр хороог удирдаад их туршлагатай ч боллоо. Тэгээд нэг ийм хууль боловсруулуулна. Энэ түр хорооны гишүүдүүдээр. Тийм захирамж гаргаж шийднэ гэдгээ хэлье. Тэгвэл цаашдаа Монгол Улс олон хэлэлцээр хийхэд сайн гарын авлага болох байх гэж би бодож байна.

Отгоны Саранчулуун гишүүн.

О.Саранчулуун: Сайн байцгаана уу?

Өмнө нь бид “Орано”-гийн асуудлаар ярилцаж байхад би нэг юм асууж байсан байхгүй юу. Монгол ажилтнууд их байх юм байна. Гадаадууд их байх юм байна.

Тэгэхээр энэ хоёр ажилтнуудын хоорондын хөдөлмөрийн гэрээний ялгааг яаж харж байгаа вэ. “Хөдөлмөрийн аюулгүй байдал” дээр ямар асуудлыг баталгаа болгож байгаа вэ гэдэг дээр харж байхад олон улсын гэрээ, конвенцоороо явна гээд бүдэг болсон.

Нөгөө талдаа гэрээний хавсралт материал дээр харахаар “эрүүл мэндийн нөлөөллийн үнэлгээ” гэдэг зүйлийг “байгаль орчны нөлөөллийн үнэлгээ” гэдэг бүлэг дотор орсон байсан байхгүй юу.

Тэгээд сая Оюу Толгойн түр хорооны сонсгол дээр асуулт асуух боломжгүй байсан шүү дээ. Ороод сонсоод суусан.

Тэгэхээр би жишээлбэл энэ дээр яг юуг асуух гээд байгаа вэ гэхээр олдмолоор өнөөдөр эрэгтэй хүмүүс осол гэмтлээр хөгжлийн бэрхшээлтэй болсон кэйс зөндөө байна.

- Барилгын салбараас,
- уул уурхайн салбараас,
- авто зам болон ахуйн ослоор их байдаг.

Тэгээд ихэвчлэн эргээд тэр ажилдаа орох тэр баталгаа энэ тэр байхгүй, эргээд уул уурхайн салбараас нөхөн олговор нь харьцангуй муу байдаг, хангалтгүй байдаг ийм асуудлууд ярьдаг.

Тэгэхээр нь сонирхоод тэгвэл энэ Оюу Толгой болон томоохон уул уурхай дээр үйлдвэрийн ослын дүн ер нь хэр байдаг юм бол, ямар арга хэмжээ байдаг вэ гээд судлаад үзэхээр тийм тухай мэдээлэл байхгүй. Манайх олон улсын

стандартын дагуу ажилладаг гэж байгаа. Нөгөө талд хэн осол гэмтлээр хөгжлийн бэрхшээлтэй болоод эргээд нөхөн сэргээгдэхгүй байна гэхээр туслан гүйцэтгэгч компаниудын ажилтнууд байгаад байсан. Голдуу.

Тэгэхээр туслан гүйцэтгэж байгаа буюу тэр талбайд ажилладаг тэр газрууд яг шууд утгаараа үндсэн Оюу Толгойн ажилтан биш, тухайн уурхайн ажилтан биш, гадаад ажилтан биш учраас эргээд нөхөж хөдөлмөрөө сэргээж авч чадахгүй, эргээд эрүүл бүтэн болж чадахгүй, олон улсын стандартын шаардлага хангасан хөл гараа ч авч чадахгүй хохирч байгаа кэйсүүд байгаа байхгүй юу.

Мэдээж олон биш л дээ. Магадгүй олноороо илэрч чадахгүй тэгээд чимээгүй больсон асуудал байгаа.

Яг энэ хэсэг дээр ямар ялгаа харагдаж байна гэхээр Монголд ер нь гадаадын хөрөнгө оруулалтаар ийм гэрээнүүдийг хийхдээ бид ер нь Монгол хүнээ хамгаалдаг, хөдөлмөрийн аюулгүй байдлыг нь хангуулдаг юмаа яагаад тусгахгүй дандаа орхиод байдаг юм бэ гэж бодогдоод байгаа юм л даа.

Тэгэхээр түр хороо иймэрхүү зүйлийг ярихдаа дараагийн удаа бид энэ шинжилгээ, энэ тайлан мэдээг сонсохдоо би энэ талаар түрүүн сонсмоор л байсан. Гэхдээ бид нарт ирсэн тайлан мэдээлэл дээр тэр талаар ерөөсөө байхгүй байгаа. Оюу Толгойн вебсайт дээр ч байхгүй байгаа.

Өнөөдөр энд хэдэн мянган ажилтан байгаа гэж байна. Хэдэн Монгол ажилтан үндсэн ажилтны хөдөлмөрийн гэрээ ямар байдаг юм.

Монгол хүмүүс Монголынхоо хөдөлмөрийн тухай хуулиараа даатгал, тэгээд хууль зүйн шаардлагаар явж байгаа бол гадаадаас Монголд ирж ажиллаж байгаа хүмүүс чинь олон улсын гэрээ, тусгай үйлчилгээ, байр, виз гээд ажлын нөхцөл нь хүртэл өөр байгаа байхгүй юу. Авч байгаа хангамж нь өөр. Хөдөлмөрийн аюулгүй байдал тэр хамгаалалт нь хүртэл монгол ажилтан, гадаад ажилтан хоёрын хувьд ялгаатай байна.

Бүр нэмээд тэр гэрээгээр гүйцэтгэж байгаа компаниудын хувьд энэ чинь бүр өндөр эрсдэлтэй байна.

Тэгэхээр бид цаашдаа ер нь иймэрхүү гэрээ хийхдээ энд ажиллаж байгаа монгол хүмүүсийнхээ төлөө анхаарах, хөдөлмөрийн аюулгүй байдлын баталгаа, эрүүл мэнд, амь насныхаа баталгааг харсан юм орохгүй бол зөвхөн эдийн засгийн агуулгаар үр өгөөжөө тодорхойлоод, зөвхөн эдийн засгийн асуудлуудаар ярьчихаад хөгжлийн бэрхшээл, нийгмийн асуудал ярих болохоор наадах чинь шууд утгаараа хамаатай биш шүү дээ гээд орхиод байж болохгүй л байх л даа. Тэнд чинь хүн л ажиллаж байгаа. Хүн тэндээс хөгжлийн бэрхшээлтэй болж байгаа. Тэр дата байхгүй байна гэдэг чинь ямар харамсалтай юм бэ гэж бодож байна.

Тэгэхээр энэ дээр цаашаа анхаараасай гэж бодож байна.

Н.Учрал: Энэ тогтоолыг хэрэгжүүлэхийн тулд яг хуулийг нь оруулж ирж нэг мөр арга хэмжээ авахгүй бол Засгийн газар биелүүлэхэд хэцүү заалтууд байгаа шүү. Тэрийг С.Бямбацогт дарга байгаа учраас анхаарах л хэрэгтэй.

Тэгээд “алдагдсан боломжийн өртөгийг тооцоолно” л гээд л явж байгаа шүү дээ. Тэгээд үүнийг чинь яаж тооцох вэ. Өнгөрсөн хугацааны тэр олон жилийн гэрээ хэлцэл хэрэгжээд явсан яаж тооцох вэ.

Тэгээд дараа нь тогтоол хэрэгжээгүй гээд асуудалд орох магадлалтай. Саяын тэр өгөөжийг яриад байгаа. Тэр өгөөжийг чинь яг хуулиар нь тодорхой болгож өгөхгүй бол дахиад л 53 хувьд нь хүргээгүй гэдэг асуудал руу орно.

Тийм учраас үүнийг хэрэгжүүлэх талд нь сайн анхаарах хэрэгтэй. Тэгээд тогтоол мэдээж хэрэгжүүлэхийг Их Хурал байнга хянаана шүү дээ. Дараа дараагийн үеийн парламент. Тэгэхээр Засгийн газар хэрэгжүүлэхэд давж чадахгүй шугам хийвэл их бэрхшээлтэй болно шүү.

Тэгэхээр протоколд Засгийн газар тайлбараа үлдээх л хэрэгтэй дээ.

Х.Баасанжаргал гишүүн.

Х.Баасанжаргал: Надад ажлын хэсгийнхнээс гурван багц асуулт байна.

Өмнө нь энэ талаар Х.Тэмүүжин гишүүн хөндөж байсан. Байгууллагын нууцын тамгатай мэдээллүүд маш их ирсэн гэж ойлгож байгаа. Сонсголыг сонсож байхад.

Тэгэхээр Оюу Толгойн үйл ажиллагаатай холбоотой, цаашид хөрөнгө оруулалтын гэрээн дээр ч гэсэн бид үүнийг анхаарах ёстой байх л даа. Одоо бид цаашид нээлттэй, ил тод байдал дээр ямар ахиц дэвшил гаргах вэ? Тогтоол дээр энэ тал дээр орж байгаа юу? Ялангуяа хөрөнгө оруулагч талаас, дээрээс нь Оюу Толгойн үйл ажиллагаатай. Ганцхан санхүүгийн үйл баримтаас гадна үйл ажиллагааны нээлттэй байдлыг бид анхаарах ёстой болж таарсан.

Тэгтэл хамгийн сонирхолтой нь сонсгол дээр нэг зүйл ажиглагдсан нь юу вэ гэвэл төрийн ажлыг үндсэн чиг үүргийнхээ хүрээнд хийж байсан хүмүүс маш их баримт материалууд гаргаж ирсэн. Тэгээд өөрсдийгөө баримт материалтай гэдгээ бараг гайхуулсан. Энэ чинь төрийн албан хаагч ч бай, наад захын хөдөлмөр эрхэлж байгаа хүмүүсийн ажлаасаа гарахдаа ажлынхаа баримт материалыг авч гарах нь өөрөө ёс зүйн асуудал шүү дээ. Гэтэл үүгээрээ гайхуулдаг болоод л. Эргээд өөрт байгаа мэдээлэл, авч гарсан мэдээллийнхээ давуу байдлыг давуу тал болгож ашиглаад л. Тийм ээ.

Тэгэхээр нэг талдаа нээлттэй байгаа юм шиг мөртлөө мэдээлэл олж авсан хүмүүст давуу тал үүсэх гээд байгаа юм.

Тэгэхээр энэ байдлыг цаашаа бид засах ёстой гэж би харж байгаа. Төрд ч байгаа мэдээлэл тэр, Оюу Толгойд байгаа мэдээлэл ч тэр, хөрөнгө оруулалтад оруулагчид байгаа мэдээлэл ч тэр бүгд нээлттэй байх ёстой, ил тод байх ёстой. Санхүүгийн мэдээллээс гадна үйл ажиллагааны мэдээлэл нээлттэй байх ёстой гэсэн байр суурьтай байгаа.

Тэгэхээр энэ тогтоол дээр орж байгаа юу. Засгийн газрын хувьд үүнийг анхаарах ёстой байх гэж бодож байна.

Хоёрдугаарт, Н.Учрал даргын хэлсэн дээр би үргэлжлүүлээд хэлье.

Засгийн газар тогтоол дээр ямар байр суурьтай байдаг юм бол оо? Ажлын хэсгийнхэнтэй ярилцсан зүйл байдаг уу? Зөвшилцсөн зүйл байдаг уу гэдэг дээр тодруулаад асууя.

Мөн Засгийн газар тогтоолын төсөл дээр байр сууриа илэрхийлэх нь зөв байх гэж бодож байна. Үүнийг би юутай холбож асууж байгаа вэ гэвэл эргэж дүгнэх хугацаа тогтоол дээр зааж байгаа юу? Тийм ээ.

Тэгэхээр тэр хугацааг яаж харж байгаа вэ гэдэг ийм зүйлийг тодруулж асууя.

Гуравдугаарт нь, ус бохирдуулсны төлбөрийн асуудал гээд байгаль орчны үр нөлөөтэй зүйлүүд нэлээн яригдсан. Сонсголын үеэр. Энэ засагдах уу? Цаашид. Миний асуулт дандаа цаашид гэдэг төлөв дээр, ирээдүй төлөв дээр дандаа асууж байгаа шүү.

Тэгэхээр ус бохирдуулсны төлбөр болон байгаль орчинд учруулж байгаа хохиролтой холбоотой асуудлууд дээр ахиц дэвшил цаашид гарах уу? Үүнийг ажлын хэсэг юу гэж харсан бэ гэсэн гурван асуулт байна.

Н.Учрал: О.Батнайрамдал дарга хариулъя.

О.Батнайрамдал: Х.Баасанжаргал гишүүний асуултад хариулъя.

Маш чухал гурван асуудлуудыг хөндлөө.

Ер нь бид энэ Хянан шалгах түр хорооны 6 сарын хугацаанд 94 мянга орчим хуудас нотлох баримт ойролцоогоор 30 орчим төрийн байгууллага болон аж ахуйн нэгжүүдээс авсан. Түүний 51 хувь нь ямар нэгэн байдлаар нууцын дардастай.

- Байгууллагын нууц.
- Төрийн нууц.
- Албаны нууц.
- Маш нууц.

Тэр битгий хэл ямар зөрчил гарсан бэ гэхээр “Онтрэ” компани Уул уурхайн яамны сайдын тушаал дээр хүртэл “Онтрэ” компанийн нууцын тамга дарсан байсан.

Нэг ёсондоо 16 жилийн туршид эн их баримтууд ер нь нууцын дардас гэдэг агуулгын цаана мэдэх эрх ноцтой зөрчигдөж байсан. Том том хохирлууд яригдах боломжгүй үлдэж байсан.

Та бод доо. Өнөөдөр Үндэсний аудитын газар Оюу Толгой төсөл дээр маш том гүйцэтгэлийн аудит 5 жилийн хугацаанд хийсэн. Бас нууцын тамгатай.

Тэгэхээр нууцын тамгатай гэхээр бид яах вэ гэхээр Улсын Их Хурлын гишүүд танилцсан ч гэсэн ярих эрхгүй. Нээлттэй авч үзэх эрхгүй.

Тийм учраас энэ асуудлыг бид цаашдаа шийдэх ёстой. Үүнийг илүү нээлттэй явуулах ёстой. Энэ нууцын тамгаас болж, энэ нотлох баримтуудаа нууснаас болж хоёр талын хоорондын үл ойлголцол, мэдээллийн тэнцвэргүй байдал өдөр шөнө шиг ялгаатай болсон байгаа.

Тийм учраас бид санал, дүгнэлтдээ үүнийг тусгаж өгсөн. Төсөлтэй холбоотой баримт мэдээллийг нууцалж, төр олон нийтийн хяналтаас гадуур байлгах сонирхол хандлага байсаар иржээ.

Тийм учраас төсөлтэй холбоотой шийдвэр баримт бичгийг хуульд зааснаас бусад тохиолдолд нууцаас гаргаж, ил болгох, цаашид нийтэд нээлттэй мэдээллийн зарчмыг баримталж, харилцан ойлголцол, итгэлцлийг урт хугацаанд бүрдүүлэх шаардлагатай. Энэ нууцын тамгын ард яадаг вэ гэхээр дандаа л үл ойлголцол яваад байгаа. Нэгнээ хардана. Өөр өөр мэдээлэлтэй болдог.

Тэгэхээр үүнийг цэгцлэх хэрэгтэй. Ер нь эндээс бид ямар дүгнэлт хийсэн бэ гэхээрээ Байгууллагын нууцын тухай хууль гээд 1994 онд батлагдсан нэг хуучирсан хууль байгаа. Төрийн болон албаны нууцын тухай хууль. Энэ хуулиудыг дахиад ер нь нэлээн том байдлаар шинэчилж өөрчлөлт хийхгүй бол энэ зөвхөн Оюу Толгой гэлтгүй бусад төрийн албанд нүүрсний хулгайгаас эхлүүлээд баахан нууцын тамгатай.

Тэгэхээр үүнийг цогцоор нь янзлахгүй бол энэ асуудал хэзээ ч дуусахгүй юм билээ. Оюу Толгой бол энэ дээр зүгээр нэг тод жишээ болоод л өнгөрсөн.

Тийм болохоор тантай санал нэг байна. Энэ хуулиуд дээр хамтарч ажиллахад бэлэн шүү. Хамтарч ажиллах ёстой гэж бодож байгаа.

Ус бохирдуулсан асуудал бас яригдсан. Нэмэлт 1 минут авъя.

Н.Учрал: О.Батнайрамдал дарга нэмэлт 1 минут.

О.Батнайрамдал: Мөн О.Саранчулуун гишүүн ч хөдөлмөр хамгааллын асуудлууд байгаа юм л даа.

Тэгэхээр бид хянан шалгах үйл ажиллагаа явуулж байгаа. Хянан шалгах түр хороо.

Тэгэхээр хуулиар бид яах ёстой вэ гэхээр Улсын Их Хурлаас бид нарт 2025 оны 7 сарын 02-нд баталж өгсөн Улсын Их Хурлын тогтоолын хүрээ хязгаарын хүрээнд бид үйл ажиллагаагаа явуулах ёстой болж байгаа юм.

Тийм учраас хөдөлмөр, нийгмийн хамгааллын асуудлууд энэ дээр ороогүй байгаа. Яагаад гэх юм бол бид Улсын Их Хурлаас өгсөн чиглэлээр олгосон хүрээ хязгаартаа л багтах ёстой. Тэр хүрээнд цуглуулсан нотлох баримт дээрээ үндэслэж бид сонсголоо зохион байгуулсан. Нотлох баримт дээрээ үндэслэж бид Та бүхэнд тайлан, санал, дүгнэлтээ гаргаж танилцуулсан.

Тийм учраас устай холбоотой асуудлууд урьд өмнө нь гарч байсан. Улсын Их Хурлаас одоо хүртэл хүчин төгөлдөр байгаа 92 дугаар тогтоол, 103 дугаар тогтоолууд дээр байгаль орчин, устай холбоотой асуудлууд байгаа юм. Өнөөдөр хүртэл... /минут дуусав/

Н.Учрал: Ганзоригийн Лувсанжамц гишүүн.

Г.Лувсанжамц: Би үг хэлнэ.

Юуны өмнө нийт уурхайчдадаа, геологичид, инженерүүд, уул уурхайн салбарт ажилладаг хамт олонд Монгол Улсад уул уурхайн салбар үүсэж хөгжсөний 103 жилийн ойн баярын мэндийг хүргэе. /алга ташив/

Өнөөдөр Монгол Улс уул уурхайн салбараар экспортоо тэлж байна. Энэ салбарт орж байгаа хөрөнгө оруулалтаар төгрөгийнхөө ханшийг барьж байна. Төсвийн орлогоо бүрдүүлж байна. Багш, эмч, сувилагч, цэрэг, цагдаагийн албан хаагчдын цалин, тэтгэвэр, тэтгэмж, хүүхдийн мөнгө зэргийг өгөх боломжийг бүрдүүлж байгаа гэхэд хилсгүй байх.

Цаашид илүү хариуцлагатай, Монгол түмэнд илүү ашигтай салбар болж хөгжихийг хүсэн ерөөе.

Энэ тогтоолын төсөлтэй холбоотойгоор. Сүүлийн хагас жилийн хугацаанд О.Батнайрамдал гишүүнээр ахлуулсан түр хороо маш сайн ажилласан. Түр хорооны дарга, бусад Их Хурлын гишүүд, дээрээс нь нэмээд нийт шинжээчдээ маш их баярлалаа.

Сонсол хийхийг дэмжиж гарын үсэг зурсан гишүүний хувьд сэтгэл хангалуун байна.

Өнгөрсөн хугацаанд гарсан алдаа, оноог тал бүрийн оролцоотойгоор олон нийтэд нээлттэй хэлэлцсэн нь цагаа олсон зүйл боллоо гэж бодож байна.

Мөн энд байхгүй ч гэсэн “Эрдэнэс Оюу Толгой” компанийн ТУЗ-д ажиллаж байсан, ажиллаж байгаа Баясгалан, Солонгоо, Мэндтүвшин, Цэрэнбат нарт баярлалаа гэж хэлмээр байна.

Гэрээний агуулгыг шинэчлэх, зээлийн хүүг бууруулах, Монгол Улсын эрх ашгийг хангуулах хэлэлцээрт Та бүхний мэдлэг туршлага маш хэрэгтэй гэдэг нь олон нийтэд харагдсан гэж бодож байна. Монголын залуу үе мэддэг, чаддаг гэдгийг харуулсанд баярлалаа.

Нөгөө талдаа Монгол Улсын эдийн засгийн цорын ганц багана гэж хэлэхэд алдахгүй энэ салбараараа бид улс төр хийж болохгүй.

Өчигдөр Болдын Уянга гишүүн бид хоёр түр хорооны хурлаар тогтоолын төслийн 1.1-д заасан “тусгай зөвшөөрлийг цуцлах хүртэл арга хэмжээ авах” гэсэн хэсгийг хасах санал гаргасан. Дэмжигдээгүй. Тогтоолын төслийн бусад агуулгатай бүрэн санал нийлж байна. Дэмжиж байна. Гэхдээ энэ заалт хэвээрээ үлдсэн болохоор энэ тогтоолын төслийг дэмжих боломжгүй байна. Үүнийгээ ч гэсэн О.Батнайрамдал даргад уламжилсан.

Монголчууд бид сиймхийгээд гэрээ шатаадаггүй. Бид алдаа байвал засаад явах ёстой. Гэрээгээ шинэчилж сайжруулах ёстой. Энэ хэлэлцээртээ бид анхаараад явахад болно байх гэж бодож байна.

Үүнээс цааш Засгийн газрын хийх ажил үлдсэн шүү. Их Хурал дээр хийх боломжтой бүх ажлыг хийлээ. Монгол Улсын хүртэх өгөөжийг нэмэгдүүлэх ажилд нь С.Бямбацогт сайд болон бусад хэлэлцээрт орж байгаа Монгол Улсын Засгийн газрын гишүүд, төрийн албан хаагчдын ажилд нь өндөр амжилт хүсье. Сайн мэдээтэйгээр Та бүхнийг хүлээж байя.

Н.Учрал: Манай Г.Лувсанжамц гишүүн шинэ үеийн залуучуудыг төлөөлөөд их сайхан үг хэллээ шүү. Тийм. Их сайхан үг хэллээ.

Одоо хэн бэ? Батбаярын Жаргалан гишүүн. Сая санал хэлсэн.

Б.Жаргалан: Өнөөдөр түүхэн үйл явдал болж байна.

Энэ удаагийн Улсын Их Хурал Монголын эдийн засгийн хамгийн том төсөл болох гуравдагч хөршийн анхны том хөрөнгө оруулалт болох Оюу Толгой төслийн талаар нэгдсэн байр сууриа гаргаад, Засгийн газарт тодорхой бодлого хэрэгжүүлэх талаар чиглэл өгөх түүхэн шийдвэр гаргах гэж байна.

Тэгэхээр Оюу Толгой төсөл яах аргагүй Монголын хувьд маш чухал ач холбогдолтой төсөл. 16 жилийн өмнө анх Хөрөнгө оруулалтын гэрээ байгуулагдсанаас хойш Оюу Толгойд Монголын эдийн засагт тодорхой үр өгөөжийг өгсөн.

Үүний үр дүнд дэлхийд үлгэр жишээ болсон гүний уурхай ашиглалтад орсон. Энэ жил Монгол Улс зэсийн экспортоос 5 гаруй тэрбум ам.долларын орлого олж байгаа. Анх удаагаа.

Энэ жилийн экспортын орлогын хэмжээгээр зэс анх удаа нүүрснээс илүү гарч байгаа. Сүүлийн олон жилийн дунджийг авч үзэх юм бол. Тэгээд бас энэ жилээс Оюу Толгой төслийн мөнгөн урсгал эерэг болж байгаа гэсэн. Гадаад зах зээлийн харьцангуй таатай нөхцөлд бид Оюу Толгой төслийн талаар тодорхой шийдвэрүүдийг гаргаж байгаа.

Оюу Толгойн хянан шалгах түр хороо өнгөрсөн 6 сарын хугацаанд ажилласан. Нийт иргэдийн хувьд 3 өдрийн сонсгол хамгийн их анхаарал татсан боловч энэ хугацаанд өнөөдөр Их Хурлын танхимд хүрэлцэн ирсэн нийт 20 гаруй шинжээч, хянан шалгагч нар маш олон хуудас баримт бичиг дээр дүн шинжилгээ хийж, түр хорооноос тайлан гэсэн баримт бичиг гарсан байгаа.

Мөн Хянан шалгах түр хорооны тогтоолоор түр хорооны санал, дүгнэлт батлагдсан. Түүнээс гадна өнөөдөр Улсын Их Хурлын тогтоолын төслийг Улсын Их Хуралд өргөн барьж батлуулахаар ажилласан.

Тогтоолын төсөлд юу гэж заасан байгаа вэ гэхээр түр хорооны санал, дүгнэлтийг харгалзан үзээрэй. Ер нь сонсголын явцад бий болсон мэдээлэл дээр маш сайн тулгуурлаж, Засгийн газар дараа дараагийн хэлэлцээр, дараа дараагийнхаа бодлогыг тодорхойлоорой гэж зорьж байгаа. Санал, дүгнэлтэд саяын дурдагддаг үр өгөөжтэй холбоотой асуудлуудыг тодорхой тусгахыг зорьсон.

Мөн сонсголын явцад протоколд энэ асуудлаар нэр бүхий өмнө нь шийдвэр гаргаж байсан хүмүүсээс тодорхой хариултуудыг авахыг зорьсон.

Тэгэхээр хэлэлцээрт орох Засгийн газрын гишүүд сонсголын протоколыг нэг бүрчлэн авч үзээрэй. Түр хорооны тайлан санал, дүгнэлтийг үг, үсгийг нь нэлээн сайн авч үзээрэй гэж хүсэх байна.

Тогтоол тусаагүй боловч санал, дүгнэлтэд туссан зүйлүүд юу вэ гэхээр компанийн засаглалтай холбоотой асуудлуудыг авч үзээрэй гэж хүсэх байна.

Ер нь энэ удаад Засгийн газар зөвхөн зээлийн хүүг бууруулах хэлэлцээр хийх даалгавар аваагүй. Ер нь Хувь нийлүүлэгчдийн гэрээнд тодорхой өөрчлөлтүүдийг хийх даалгавар өгөгдөж байгаа.

Тэгэхээр энэ хүрээнд компанийн засаглалын асуудал, үр өгөөжийг тодорхой томъёолох тухай асуудал, тэр яригдаад байдаг менежментийн төлбөрийг бууруулах тухай асуудал, давхар татварын асуудал, техник, эдийн засгийн үндэслэлээ шинэчлэн батлах асуудал байгаа. Гэх мэтчилэн маш олон зүйлийг хийх ёстой байгаа.

Мөн би тусгайлан нэг зүйлийг Засгийн газарт захихыг хүсээд байгаа юм. Хуримтлагдсан зээлийн хүүгийн төлбөр 6 орчим тэрбум доллар болсон байгаа.

Тэгэхээр зээлийн хүүг бууруулахын зэрэгцээ зээлийн хүүгийн хуримтлагдсан төлбөр дээр тодорхой хэлэлцээрийн нэг юуг бий болгохыг зориорой.

Н.Учрал: Нэмэлт 1 минут. Б.Жаргалан гишүүн.

Б.Жаргалан: Тэгэхээр 16 жил өнгөрсний дараагаар бид тодорхой ахиц дэвшил гарна гэдэгт маш ихээр итгэж байгаа шүү.

Өнгөрсөн хугацаанд Улсын Их Хурлаас гэрээ байгуулагдахаас өмнө 40, 57 дугаар тогтоолуудыг баталсан.

Мөн сүүлийн жилүүдэд 92, 103 дугаар тогтоолуудыг баталсан. Эдгээр тогтоолуудаа харж үзээрэй. Өнөөдөр батлагдах гэж байгаа тогтоол болон холбогдох бичиг баримтуудыг харж үзээд хамгийн чухал нь ирэх жилүүдэд Монголын талын өгөөж нь 53 хувиас доош буухгүй байх нөхцөл байдлыг Улсын Их Хурал, Засгийн газартайгаа хамтраад хийж чадах юм бол энэ бол бидний хувьд түүхэн гавьяа болно.

Тэгж байж дараа дараагийн том төслүүдийн үүд хаалга нээгдэж, Монголын хөрөнгө оруулалтын орчин сайжирч, бизнесийн орчин сайжирч, цаашаага бид урагшлах боломжтой болно гэж харж байгаа.

Тэгэхээр хэлэлцээр хийх хүмүүст ажлын амжилтыг хүсье.

Н.Учрал: Тийм. Зээлийн хүү бууруулах чухал хэдий ч бүтцээ харах хэрэгтэй. Тийм. Гол нь бүтцээ харах хэрэгтэй.

Өөрсдийнхөө санхүүгийн модель дээр хэлэлцээр хийе гээд байгаа.

Сүхбаатарын Эрдэнэболд гишүүн үг хэлнэ.

С.Эрдэнэболд: Асуулт, үг нь хамт явах уу?

Саяын сонсголыг зохион байгуулаасай гэж дэмжиж гарын үсгээ зурсан. Саяын сонсголыг нэгтгэн дүгнээд харахад хоёр хуваагдаж байгаа.

Баримт нотолгоо ба сэтгэл хөдлөл гэсэн.

Баримт нотолгоогоо түлхүү барьж яриад явах юм бол юун дээрээ алдсан, юун дээрээ оносон, цаашдын гарц гаргалгаа гээд олон зүйлүүдийг бид яриад явж болж байгаа.

Сэтгэл хөдлөл дээр тулгуурласан маш олон харилцан яриа, хувийн дүгнэлтүүд явсан.

Тэгэхээр Их Хурал эндээс сэтгэл хөдлөлийнх нь хэсгийг хасаад, цэвэр логик дээр суурилсан хувийн дүгнэлтүүдийнх нь хэсгийг буюу тэр баримт фактууд дээр түшиглээд хэн ярьсан, хэний амнаас ямар аргумент гарсан гэдгээр нь биш Монгол Улсын язгуур ашиг сонирхолд аль шийдэл нь зөв бэ гэдэг дээр тулгуурлаад цаашаагаа явах нь зөв гэж харж байгаа.

О.Батнайрамдал гишүүний хэлж байгаагаар 94 орчим мянган тийм нотлох баримт цаас байсан гэж хэлж байгаа. Түүний 51 орчим хувь нь нууцын дардастай, ямар нэгэн байдлаар үзэх боломжгүй байсан гэж хэлж байгаа.

Тэгэхээр ажлын хэсгийн ахлагчаас асуухад энэ 51 хувьтай нь буюу нийт 100 хувь гэж үзэх юм бол 51 хувийн нууц байна гэдэг чинь тэнд шинжээчид ажиллах, дүгнэлт гаргахад ээдрээтэй төвөгтэй байсан байж таараа шүү дээ. Энэ 51 хувьд хувиа 100 гээд үзэх юм бол хэчнээн хувьд нь жишээлбэл шинжээчид дүгнэлт гаргаж танилцаж чадсан бэ гэдэг асуултыг дахиад нэг тодруулмаар байна.

Тэгээд одоо Засгийн газарт чиглэл өгч байгаа тогтоол гарч байгаа цар хүрээнд ямар нэгэн байдлаар нууцаас нь хамаараад, нууцын дардсаас нь хамаараад, танилцах боломжгүйгээс үүдээд тогтоолын хамрах хүрээ, үйлчлэх хүрээнд бүрэн үйлчлэхэд нь саад учруулж байгаа нөхцөл байдал байна уу гэдгийг тодруулж асуумаар байна.

Мэдээж Төрийн болон Албаны нууцын тухай хууль, тэр 1994 оны хуулийг шинэчлэхтэй холбогдуулаад Ардчилсан намаас хуулийн төсөл боловсруулаад энэ дээр хамтран санаачлагчаар ороод явж байгаа.

Ер нь зөвхөн Оюу Толгойн кэйс ч биш маш олон асуудал дээр нууцын тэмдэг дардаг. Тэр нь тийм нууц байх шаардлагатай биш юман дээр хүртэл дардаг. Эргээд тэр нь нэг талдаа төрийн ажлыг гацаадаг. Нөгөө талдаа хууль, шүүхийн байгууллагын үйл ажиллагаанд чөдөр тушаа болдог. Эргээд хүний эрхийн томоохон зөрчил болдог. Эргээд хулгай хийх, төсвийг тонох шалтаг шалтгаан болоод байдаг. Арын хаалга болоод байдаг. Дарга нарт түлхүүр нь байдаг. Тийм арын хаалга болоод байдаг.

Тэгэхээр асуултдаа хариулт аваад тэгээд тодруулъя.

Н.Учрал: О.Батнайрамдал дарга хариулна.

О.Батнайрамдал: С.Эрдэнэболд гишүүний асуултад хариулъя.

3 өдрийн сонсгол явсан. Нэг зүйлийг хэлье.

Тэр сонсгол дээр дуудагдсан гэрчүүд дандаа баримт дээр үндэслэж дуудагдсан байгаа. Зарим хүмүүс буруу ойлгоод байх шиг байна лээ. Хүмүүс өөрсдөө шийдэж хүмүүсээ гэрчээ сонгож байна гэж. Тийм нэг ч хүн байхгүй. Тийм байх ёсгүй. Дан нотлох баримт дээр, нэмэлт нотлох баримт цуглуулах хүрээнд зайлшгүй гэрчээр дуудагдах хүмүүсийг бид гэрчээр дуудсан байгаа.

Шинжээчдийн дүгнэлт дээр сэтгэл хөдлөл гэхээсээ илүү тэр чигээрээ нотлох баримт дээр л үндэслэж бид дүгнэлт гаргасан. Тэр урьдчилсан дүгнэлтүүдийг бүгдийг нь презентаци хэлбэрээр шинжээчид тайлбарласан байгаа.

94 мянга орчим хуудас нотлох баримт цугларсан. Нууцын баримтыг бид нарт танилцах боломжгүй биш л дээ. Бүгд байгаа. Одоо энэ 94 мянган хуудас нотлох баримт бичгийг Улсын Их Хурлын даргад Хянан шалгах түр хорооноос албан ёсоор бүгдийг нь гардуулж өгнө. Бүгдийг нь тов дараалалтай нь бид бэлдсэн байгаа.

Шинжээчид бүх тэр 94 мянган хуудас материалтай бүгдтэй нь танилцсан гэсэн үг. Танилцсан. Тэр дотор нууцтай Оюу Толгойгоос ирсэн мөртлөө Эрдэнэс Оюу Толгойгоос тэр нь аль түрүүн нууцын тамгагүй материалууд зөндөө байгаа.

Тэгэхээр бид энэ дээр яасан бэ гэхээр нууцтай баримтыг нь бусадтай нь тулгаад, нээлттэй ирсэн баримтууд дээрээ үндэслээд дүн шинжилгээ хийгээд нууцтайгаа тулгаад баталгаажуулаад явах боломжтой байсан. Зарим график нь 2010 оны арай жоохон хуучин график. Гэхдээ 2024 оных нь нууцын тамгатай учраас 2010 оныхоо графикийг нь ашиглаад явж болж байгаа. Тэнд зарчмын хувьд ижилхэн байгаа учраас ашиглах боломжтой байсан гэсэн үг.

Тийм учраас бид ил байгаа баримтуудыг үндэслээд шинжээчид өөрсдийнхөө хүрээнд хангалттай дүгнэлтээ гаргаад явах боломжтой байсан

учраас энэ дээр бид нээлттэй сонсголыг явуулаад, нээлттэй хэлэлцүүлээд явж байгаа. Энэ боломжтой.

Гэхдээ нууцтай мэдээлэл ирэх тоолонд үүнд бас яг бусад компаниуд дээр явж байгаа асуудалтай ялгаагүй юм л даа. Тэр Онтрэгийн жишээ байна. Онтрэгоос 150 орчим төрийн байгууллагын албан тушаалтны гаргасан шийдвэрүүд, албан тоотууд дээр Онтрэгийн нууцын тамгатай ирсэн. Гэхдээ тэрийг нь тухайн байгууллагуудаас нь бүгдийг нь авч болж байгаа юм.

Тэгэхээр хамаагүй задгай ашигласаар байгаад хэвшсэн нэг ийм хандлага ажиглагдаж байгаа юм л даа.

Н.Учрал: Болох уу? Дахиад нэмэлт 1 минут авах юм уу? С.Эрдэнэболд гишүүнд нэмэлт 1 минут өгье.

С.Эрдэнэболд: Тодруулаад хэлэхэд О.Батнайрамдал гишүүн ээ, шинжээчдийн хувьд сэтгэл хөдлөл гэж би тэр утгаар хэлээгүй. Оролцогчдын хувьд сэтгэл хөдлөлтэй мэдэгдлүүд, хувь хүнтэй холбоотой асуудлууд яригдаж байсан эсэхийг нь хэлж байгаа шүү.

Өмнө нь нүүрсний сонсгол дээр Баттөмөрийн Энхбаяр гишүүн хэрэв надад дахиад жоохон хугацаа байсан бол, дахиад нэг сарын хугацаа байсан бол арай илүү гүйцэтгэлтэй нарийн судалгаа танилцуулга байлаа гээд хэд хэдэн удаа хэлж байсан санагдаж байна.

Түүнтэй адилхан саяын сонсголыг бэлдэх хугацаа. Мэдээж маш их цаасны ажил байгаа. Ойлгож байгаа. Тэгэхээр хугацаа өөрийн чинь хувьд хангалттай гэж ажлын хэсэг үзэж байгаа юу? Эсвэл дахиад хугацаа байсан бол дахиад илүү нарийсгах ч гэдэг юм уу, илүү сонсголын үр дүнд эерэг үр дүн авчрах тийм зүйл байсан уу гэдэг асуулт байна.

Н.Учрал: О.Батнайрамдал дарга хариулъя.

О.Батнайрамдал: Улсын Их Хурлын Хяналт шалгалтын тухай хуулиараа бид нарт 6 сарын хугацаа байдаг.

Бид цаг хугацаандаа сэтгэлээ гаргаад ажиллах юм бол хангалттай хугацаа байна лээ. 94 мянган хуудсыг бид 30 гаруй байгууллагуудаас бүгдийг нь цуглуулж аваад, удирдамжаа аваад, байгууллагууд дээр өөрсдөө очоод ажилласан. Яг энд сууж байгаа 18 хянан шалгагч шинжээч ялангуяа сүүлийн 3 сар өдөр шөнөгүй сэтгэлээрээ ажилласан.

Бидний хувьд өөрсдийн гаргасан тайлан дүгнэлтдээ сэтгэл хангалуун байгаа.

Мэдээж цаашдаа нэмэлт материалууд авч болох байсан уу. Магадгүй зарим материал үлдсэн байхыг үгүйсгэхгүй. Бид гэхдээ өөрсдийнхөө хэмжээнд боломжит бүх материалыг авч шаардаж ажилласан.

Н.Учрал: Баярлалаа. Ухнаагийн Отгонбаяр гишүүн үг хэлнэ.

У.Отгонбаяр: Та бүгдэд энэ оройн мэндийг хүргэе.

Тэгээд юуны түрүүн Хянан шалгах түр хорооны дарга, гишүүд, Хянан шалгах хороонд ажилласан бүх шинжээч нартаа ямар ч байсан баяр хүргэе.

Хянан шалгах хороог нээлттэй, ард иргэдэд, төрийн байгууллагуудад нэлээн тийм нээлттэй мэдээ мэдээллийг ил болгож чадсан, ажилласан ийм Хянан шалгах хороо гэж би хувьдаа үзэж байгаа.

Оюу Толгойн төсөл яах аргагүй Монгол Улсад гурав дахь хөрштэйгөө хийсэн хамгийн анхны томоохон гэрээ. 16 жилийн өмнөх алдаа оноог энэ хянан шалгах хороон дээр ний нуугүй, илэн далангүй ярилцсан ийм ажил болсон гэж үзэж байгаа.

Тэгээд мөн нэг том давуу тал бол талуудын байр суурийг маш олон талаас нь сонссон. Тэгээд би энэ дээр нэг зүйл тодруулж асуух гээд байна.

Тогтоолын төсөлтэй холбогдуулаад. Энэ тогтоолын төслийг боловсруулахдаа Оюу Толгой компанитай ширээний хоёр талд сууж ярилцсан уу? Ийм тогтоолын төсөл боловсруулж байна, Их Хурлаар оруулна гэдэг ийм ярилцлага хийж чадсан уу? Энэ нь Хянан шалгах хорооны бүрэн эрхт байсан уу, үгүй юу гэдэг дээр Та тодорхой хариулт хэлээч.

Хоёр дахь миний тодруулах зүйл гэвэл тогтоолын төслийн 1.5 дээр “Оюу Толгой компанийн экспортын борлуулалтын орлогыг Монгол Улсын Төв банк болон арилжааны банкаар бүрэн дамжуулна” гэсэн заалт орсон. Энэ хэрэгжих боломж байгаа юм уу? Юуг үндэслэж яг энэ заалтыг оруулав аа? Урьд нь яагаад үүнийг дамжуулж болоогүй юм гэдэг дээр тооцоо судалгаа, тодруулж тал талын мэдээлэл, байр суурийг авсан уу гэдэг дээр тодруулмаар байна.

Тэгээд хариултаа аваад тодруулъя.

Н.Учрал: О.Батнайрамдал дарга хариулна.

О.Батнайрамдал: У.Отгонбаяр гишүүний асуултад хариулъя.

Оюу Толгой компанитай манай шинжээчид нотлох баримт цуглуулах хүрээнд мэдээллээ авсан. Улсын Их Хурлын тогтоолыг боловсруулахдаа Оюу Толгойтой зөвшилцөөгүй. Улсын Их Хурал бүрэн эрхээрээ компанитай

зөвшилцөж болохгүй. Оюу Толгой компанитай Засгийн газар л яриа хэлэлцээрт орох ёстой.

Тийм учраас Улсын Их Хурлын тогтоол дээр байгаа үг үсгийг Оюу Толгой компанитай огтхон ч зөвшилцөөгүй гэдгийг хариуцлагатайгаар хэлье.

Хоёрдугаарт, 1.5 дугаар заалт. Оюу Толгой компанийн экспортын борлуулалтын орлогыг Монгол Улсын Төв банк болон арилжааны банкуудаар бүрэн дамжуулдаг болох.

Энэ саналыг Улсын Их Хурлын гишүүн Л.Соронзонболд Улсын Их Хурлын гишүүний бүрэн эрхийнхээ хүрээнд зарчмын зөрүүтэй саналаар оруулсан. О.Соронзонболд гишүүн нэмэлт зарчмын зөрүүтэй саналаар оруулсан гишүүний хувьд нэмэлт тайлбар өгөх ёстой байх.

Мөн нэмэлт тайлбараар Монголбанкнаас төлөөлөл ирсэн байгаа. Тийм ээ. А.Энхжин захирал ирсэн байна. Та Оюу Толгойн борлуулалтын орлого Монголбанк буюу Төв банкаар, арилжааны банкуудаар дамждаг эсэх талаар нэмэлт мэдээлэл өгөх хэрэгтэй байх.

Н.Учрал: Л.Соронзонболд гишүүн хариулж болохгүй л дээ. Дэгийн хуультай. 3 дугаар микрофон. Ажлын хэсгээс хариулья.

А.Энхжин: Монголбанкны Санхүүгийн зах зээлийн газрын захирал А.Энхжин.

У.Отгонбаяр гишүүний асуултад хариулья.

Оюу Толгой компанийн хувьд экспортын орлого нь гэрээнийхээ дагуу гадаадын данс дээр байршдаг. Монгол Улсад үйл ажиллагаагаа санхүүжүүлэх шаардлагатай валютын эх үүсвэрийг жил болгон оруулж ирдэг.

Энэ оны хувьд 2.3 тэрбум долларыг Монголын банкнуудаар дамжуулаад Монголбанк болон арилжааны банкнуудад худалдсан. Энэ нь энэ жилийн орлогынх нь 50 орчим хувь нь байгаа.

Монгол Улсад оруулж ирж байгаа, банк, санхүүгийн байгууллагаар дамжуулж байгаа экспортын орлогын хувь хэмжээ нь жил болгон нэмэгдэж байгаа. Яах вэ энэ хоёр талтай юм.

Нэгдүгээрт, Оюу Толгой компанийн зүгээс өөрийнх нь байгуулсан гэрээтэй холбоотой зүйл, заалтууд байдаг гэж хэлдэг. Нөгөө талдаа Монголын банкуудын санхүүгийн чадавх сайжрах шаардлагатай. Энэ хэмжээний эх үүсвэрийг даах тийм чадамж бүрдэх шаардлагатай байгаа юм. Энэ хэмжээ цаашдаа өснө.

Төв банкны хувьд Төв банкны тухай хуульд заасан этгээдээс өөр хуулийн этгээд данс байршуулж, үүнийг нь Монголбанк санхүүгийн үйлчилгээ үзүүлэх боломжгүй.

Тэгэхээр Төв банкны хувьд энэ бол... /минут дуусав/

Н.Учрал: Боломжтой юм уу, боломжгүй юм уу? 3 дугаар микрофон.

А.Энхжин: Тийм. Яах вэ Төв банкны хувьд Банкны тухай хуулиараа Засгийн газар банкуудад л санхүүгийн үйлчилгээ үзүүлэх боломжтой юм.

Монголын банкуудаар энэ эх үүсвэрийг оруулж ирэх боломжтой. Энэ хэмжээ ч жил тусам нэмэгдэж байгаа. Төв банкны хувьд Оюу Толгой компанийн экспортын зэсийн баяжмал дагуулагдаж байгаа алтыг ер нь цаашдаа авъя. Зэс хайлах үйлдвэр байгуулах болтол үүнийг ер нь Монголбанканд худалддаг, Монгол Улс буцааж оруулж ирдэг байх чиглэлээр ер нь ажиллая гэсэн саналтай байгаа.

Н.Учрал: Энэ Их Хурлын тогтоол дээр үүрэг болгож байгаа заалт биелэх бололцоотой юм байна гэж ойлголоо шүү дээ. Монголбанкнаас албан тайлбар хийлээ.

У.Отгонбаяр гишүүн тодруулъя.

У.Отгонбаяр: Саяын асуулт дээр маш тодорхой хариулаад өгөөч.

Монголбанк болон арилжааны банкны санхүүгийн чадавх ямар хэмжээнд байгаа юм? Би яагаад үүнийг асуугаад байна гэхээр хэрвээ энэ тогтоол дээр баахан зүйл, заалтууд орсон. Энэ нь хэрэгжих боломжгүй. Тийм ээ. Уриа лоозон хэлбэртэй үлдвэл яах юм бэ? Борлуулалтын орлого гэдэг чинь нэг их тийм бага хэмжээний мөнгө явахгүй шүү дээ.

Тийм учраас үүнийг дамжуулах, үүнийг байршуулах боломж бололцоо өнөөдөр манай арилжааны банк болон Монголбанканд байгаа юм уу, үгүй юм уу гэдгийг л. Байгаа, байхгүй гэдгээр маш тодорхой хариулт өгөөч.

Н.Учрал: 3 дугаар микрофон.

А.Энхжин: Тийм. Төв банкны хувьд хуулиар Оюу Толгой компанийн дансыг байршуулаад, мөнгөн урсгалыг нь удирдах хуулиараа хориотой. Боломжгүй зүйл.

Монголын банкуудаар тодорхой хэмжээгээр угаасаа орж ирж байгаа. Энэ оны хувьд 2.3 тэрбум доллар нь Монголын банкуудаар орж ирээд дотоодын зах зээлд нийлүүлэгдсэн.

Бүрэн нийт экспортын орлогынх нь хувьд одоохондоо манай банкууд цаашаа бэхжих шаардлагатай. Цаг хугацаа орно. Энэ нэмэгдэж байгаа.

Н.Учрал: У.Отгонбаяр гишүүн нэмэлт 1 минут.

У.Отгонбаяр: О.Батнайрамдал гишүүн ээ, асуугаад байгаа чинь яг үүнтэй л холбоотой байхгүй юу.

Одоо жишээ нь энэ бол яг ингээд уриа лоозонгийн хэлбэртэй зарим нэг зүйл, заалт нь ингэж ороод байна л даа.

Тийм учраас хэрвээ боломжуудаа дараа дараагийн шатад нь яаж сайжруулах юм бэ? Энэ дээр цааш цаашдаа тодорхой ажлууд хийхгүй бол болохгүй юм шиг санагдаж байгаа юм.

Түрүүн би санхүүгийнхэнтэй ярилцаад тэгээд үүнийг тодруулж асууж байгаа юм шүү.

Хоёр дахь асуудал. Би түрүүн яагаад Оюу Толгой компанитай тогтоолын төслийг ярилцсан уу, үгүй юу гэж асууж байгаа юм. Хэрвээ үүнийг Оюу Толгой компани энэ тогтоолын төсөл дээр заасан зүйл, заалтуудыг хэрвээ хүлээн зөвшөөрөхгүй яах юм? Хэрэгжих боломжгүй яах юм? Тэгвэл дараагийн алхам нь юу байх вэ гэдэг дээр тодорхой хариулт өгөөч. Баярлалаа.

Н.Учрал: О.Батнайрамдал гишүүн тодруулна.

О.Батнайрамдал: У.Отгонбаяр гишүүний асуултад нэмэлт тодруулга.

1994 оноос хойш мөрдөгдөж байгаа Валютын зохицуулалтын тухай хуулийн 12 дугаар зүйлд Монгол Улсын хуулийн этгээд орлогоо гадаад валютаар авсан бол арилжааны банкаар уг орлогыг дамжуулах ёстой гэсэн хуулийн заалттай.

2009 онтой харьцуулах юм бол Монголбанкуудын хөрөнгийн хэмжээ ам.доллараар 8 дахин өсөж, өнөөдөр 20 тэрбум болсон байгаа.

Сая Монголбанкнаас хэллээ. Оюу Толгой 2025 онд 4.2 тэрбум орчим долларын орлоготой байгаа. Үүний 50 хувь нь аль түрүүн Монголын арилжааны банкуудаар явж байгаа. Бид 2009 онтой харьцуулах юм бол ялангуяа санхүүгийн зах зээл хамаагүй тэлсэн. Боломжтой.

Тэгэхээр Валютын зохицуулалтын тухай хуулиараа ч гэсэн энэ үүрэг нь байгаа юм.

Хоёрдугаарт, бид энэ тогтоолоороо Оюу Толгой компанид үүрэг өгч байгаа биш. Энэ тогтоолоороо бид Монгол Улсын Засгийн газарт үүрэг өгч байгаа. Энэ бол Монгол Улсын Засгийн газар... /минут дуусав/

Н.Учрал: О.Батнайрамдал гишүүн.

О.Батнайрамдал: Тэгэхээр Улсын Их Хурлын тогтоолоор бид Оюу Толгой компанид үүрэг өгөхгүй. Энэ бол Монгол Улсын Засгийн газарт үүрэг даалгавар өгч байгаа юм.

Монголын үр өгөөж анх тэр амласан 53 хувь нь одоо хүртэл хэрэгжихгүй байна. Үүнийг хэрэгжүүлэх ёстой шүү дээ. Анх амласан амлалт. Үндсэн хуульдаа бид 6.2-т нь, стратегийн ач холбогдол бүхий орд бол үр өгөөжийн дийлэнх нь ард түмэнд ногдох Үндсэн хуульдаа оруулсан юм шүү дээ. Үндсэн хууль биелэх ёстой. Оюу Толгой байна уу, Тавантолгой байна уу, Эрдэнэт байна уу, стратегийн ач холбогдол бүхий орд л бол Үндсэн хуулийн заалт биелэх ёстой. Үүнийг Засгийн газар биелүүлэх үүрэгтэй.

Улсын Их Хурал чиглэлийнхээ хүрээнд Засгийн газарт үүнийг биелүүл гэж чиглэл өгөх эрхтэй.

Тийм учраас энэ асуудал дээр Хянан шалгах түр хороо байгуулсан.

Н.Учрал: Жигжидийн Батжаргал гишүүн үг хэлнэ.

Ж.Батжаргал: Гишүүдийнхээ оройн амгаланг айлтгая.

Оюу Толгой Хяналт шалгалтын түр хороо, түүний гишүүдэд талархал илэрхийлье. Сайн ажилласан байна.

Тов тодорхой ажиллаад Монголд үр өгөөжгүй гэрээ хэлэлцээр болжээ гээд дүгнэсэн. Хэдүүлээ.

Тийм учраас тэр 4 дээр байгаа заалт уг нь 1 дээр орж ирмээр санагдаад байх юм. О.Батнайрамдал гишүүн ээ, тогтоол дээр чинь юм ярьж болохгүй гээд байгаа. Өөрчилж чадахгүй юм билээ. Бид хэд.

Тэгэхээр 4-д байгаагаа 1 рүүгээ оруулж ирэх бололцоо байна уу гэж нэг ийм асуудал байгаа юм.

Хоёр дахь зүйл. Оюу Толгой төсөл, үүний санхүүжилт, үр дүн дээр Үндэсний аудитын газар маш сайн ажилласан юм билээ. 2021 оныг хүртэлх үйл ажиллагаанд нь 4 чиглэлээр шинжээчийн баг авч ажиллаад ёстой иж бүрэн харж дүгнэлт хийсэн.

Тийм учраас одоо би Засгийн газарт юу гэж хэлэх гэж байна гэхээр та хэд гэрээгээ сайжруулах гээд байгаа улсууд. Тэр аудитынхаа дүгнэлт, зөвлөмжийг бүтэн эргэж хараарай. Тэнд ер нь овоо юм дурдагдсан шүү.

Дээр нь энэ түр хорооныхоо тогтоолыг хараарай. Тэгж байж нэлээн гайгүй юм болох болов уу гэсэн бодол байгаа.

Зээлийн хүүгийн асуудал яриад байдаг юм. Зээлийг юунд аваад ашигласан юм бэ гэдэг асуудал байгаад байдаг. Гэтэл ер нь ний нуугүй үнэнийг хэлэхэд бараг 10-аад тэрбум нь хий хөрөнгө технологийн алдагдалд авсан зээл байгаад байдаг шүү дээ. Түүнийх нь учрыг олохгүй юм бол зээлийн хүү яриад сүйдтэй юм болохгүй.

Тэгэхээр Засгийн газар энэ талаас нь, тэр хөрөнгийн талаас нь, авч ашигласан зээлээ юунд ашиглав гэдэг талаас нь илүү хараарай гэж би зориуд хэлмээр байна.

Зээлийн хүүг бодитой бууруулах тухай хэдүүлээ яриад байгаа юм. Ер нь шударга үнэн нь уул уурхайн энэ том төсөлд олон улсын банк, санхүүгийн байгууллагууд ямар хүүтэй зээл өгдөг юм тэр хүүгээс л илүүгүй хүүгүй зээл л байх ёстой. Ер нь бараг шударга нь энэ нь дээр дээ.

Хөрөнгө дутагдаад зээл авч байгаа юм бол тэр олон улсын түвшинд олгодог зээлийн хүүгээс илүү өртөгтэй зээл авч таарахгүй гэдэг санааг хэлээд л, түүнээс доош болгох талаар анхаарч ажиллах нь бараг зөв юм болов уу гэсэн бодол байгаа юм.

Онтрэгийн асуудлыг бид хэд яриад байгаа юм. Энэ бол дөрөв, тав дахь асуудал. Одоо энэ тогтоолд ороход. Тав дахь асуудал нь ч байх би бодоод байна.

Оюу Толгой төсөлд чинь 5 тусгай зөвшөөрөл байгаа. Ганцхан тусгай зөвшөөрөл дээр нь Монгол Улсын хууль тогтоомжоор тавигдсан шалгуур шаардлагуудыг бүрэн хангаад, ТЭЗҮ-тэй ашиглалтын үйл ажиллагаа явагдаж байгаа. Цаад 4 тусгай зөвшөөрөл дээр ашиглалтын үйл ажиллагаа явагдаагүй байгаа. Энэ дээр хэрвээ явагдана гэж үзвэл тэр Монгол Улсын хууль тогтоомжоор заагдсан шалгуур шаардлагуудыг бүрэн хангаад, энэ гэрээндээ нэмэлт оруулж ашиглана шүү гэдгийг гэрээн дотор заагаад өгсөн юм.

Тэгэхээр юу гэж хэлэх гэж байна гэхээр энэ Онтрэгийн 2 тусгай зөвшөөрөл Оюу Толгой төслийн хамааралтай талбай мөн үү гэвэл мөн.

Тийм учраас Оюу Толгой төслийг хэрэгжүүлээд алдсан алдаа, сургамждаа тулгуурлаад үүнийгээ бүрэн арилгасан, ёстой даргын хэлээд байгаагаар тэр өөрсдийнхөө модель дээр тулгуурлаад үр өгөөжөө бүрэн авч чаддаг тийм нэмэлт гэрээгээ хийе гэдэг л үг байх ёстой. Ер нь бол. Тэгж байж... /минут дуусав/

Н.Учрал: Ж.Батжаргал гишүүн санал хэллээ. Сандагийн Бямбацогт сайд.

С.Бямбацогт: Их Хурлын гишүүнийхээ хувиар гэх үү, сайд нараас маань байхгүй байна. Төлөөлөөд үг хэлье.

Оюу Толгой төслийг Хянан шалгах түр хороо сайн ажилласан. Өнгөрсөн хугацаанд үе үеийн Улсын Их Хурал, Засгийн газар Оюу Толгой төслийн үр өгөөжийг нэмэгдүүлэх, гэрээг сайжруулах чиглэлээр тодорхой ажлууд хийж байсан.

Энэ удаа Монголын ард түмний мэдэх эрхийг хангасан. Улсын Их Хурлын гишүүд, Засгийн газрын гишүүд өмнө нь юун дээрээ яагаад алдав, цаашдаа юундаа яаж анхаарах вэ гэдэг дээр Монголчууд нэгдсэн ойлголттой болсон ийм сонголт болсон. Тийм болохоор үр дүнтэй сонголт болсон гэж үзэж байгаа.

Засгийн газар мэдээж Улсын Их Хурлаас өгч байгаа тогтоолыг хэрэгжүүлэхийн төлөө ажиллана. Хэрэгжүүлэх үүрэгтэй. Урьд нь ч энэ чиглэлээр тодорхой үүргүүд өгөгдөж байсан. Харамсалтай нь хэрэгжилт нь тийм хангалтгүй байсныг сая бид бүхэн мэдсэн.

Тэгэхээр хичээнэ. Монголчууд, Монголын ард түмэн, Монгол Улсын Их Хурал Монгол Улсын Засгийн газар нэг талдаа байгаа шүү. Бүгдээрээ л Монгол Улсын эрх ашгийн төлөө байгаа шүү гэдгээ харуулж чадсан. Цаашдаа үүнийхээ төлөө ард түмэнтэйгээ, Улсын Их Хуралтайгаа хамтраад Засгийн газраас бодитой ажил болгож Монголын талд ногдох үр өгөөжийг анх гэрээ байгуулж байх үед 53 хувийнх нь үр өгөөж нь Монголын талд ногдоно гэж ярьж гэрээ байгуулж байсан бол үүнд хүргэхийн төлөө ажиллана.

Энд гэхдээ бас нэг анхаарах нэлээн хүндхэн, хүндхэн хэд хэдэн заалт ороод ирсэн. Үүнийг Та бүхэн маань биелүүлсэнгүй гэж бүү зэмлээрэй. Биелүүлэхийн төлөө харин Засгийн газартаа Улсын Их Хурал маань дэм болж ажиллаарай гэдгийг Та бүхнээс хүсье.

Хянан шалгах түр хорооны санал, дүгнэлтэд нийцүүлэн авч хэрэгжүүл гэж байгаа юм. Гэтэл 40 дүгээр тогтоол, 57 дугаар тогтоол, 92, 103 дугаар тогтоол гээд олон тогтоол гарсан.

Энэ тогтоолууд нь хоорондоо зарим нь зөрчилтэй. Одоо энэ санал, дүгнэлт нь урьд өмнө гарсан тогтоолуудтай зарим нь зөрчилдөх юм байна лээ. Үүнийг бид зөрчилдүүлэхгүй байх, нийцүүлэх гээд нэлээн ажлууд хийгдэх байх. Энэ дээр дахиад Их Хуралтайгаа дахиж эргэж ярих асуудал гарах байх. Үүнийг Та бүхэн анхааралдаа аваасай гэж хүсэж байна.

Шаардлагатай тохиолдолд тусгай зөвшөөрлийг цуцлах асуудал. Сая нэлээн хэдэн гишүүн ярилаа. Энэ чинь гадна, дотнын хөрөнгө оруулагчдаас сөрөг дохио юм биш байгаа гэж.

Ерөөсөө л хөрөнгө оруулалтыг дэмжье. Гэхдээ Монгол Улсдаа ашигтай байх ёстой гэдэг л зарчмын байр суурь бүгд баримталж байгаа. Үүндээ л бид анхаарах ёстой. Үр өгөөжийн асуудал. Энэ үр өгөөж гэдэг дээр сая Их Хурлын дарга хэлсэн. Өөр өөр ойлголттой яваад байгаа.

2019 оны Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн нэг том давуу тал энэ үр өгөөж нь дийлэнхэд Монголын ард түмэнд ногдох гэж орсон. Энэ дээр бид нэлээн тодорхой нэгдсэн ойлголт болж үүнийг хуульчлах ёстой. Энэ дээр Их Хуралд дэмжлэг үзүүлээсэй гэж хүсэж байна.

“Алдагдсан боломжийн өртгийг тооцоолж” гээд орсон байгаа. Энэ алдагдсан боломжийн өртгийг тооцоолох гэдэг маань нэлээд хүнд даалгавар болно. Арбитр дээр. Мөн бусад байгууллага дээр тодорхой хяналт шалгалтууд, шүүхийн маргаан явж байгаа. Энэ бүгд дээр яригдана. Үүнтэй холбогдож яригдах байх. Энэ дээр хэдүүлээ хамтарч анхаарч ажиллах байх.

Сая У.Отгонбаяр гишүүн хэллээ.

Бүх орлогыг Монголбанкаар дамжуулаад, Монголын банкаар. Энэ дээр Монголбанк болон бусад байгууллагууд нэлээн эрсдэлтэй гэж хэлж байгаа. Гэхдээ мэдээж Монгол Улсын үр өгөөжийг нэмэгдүүлэхийн тулд, Монголын тал ашигтай байлгахын тулд хичээнэ. Энэ тал дээр Их Хурал маань дэмжлэг үзүүлээрэй. Биелүүлсэнгүй гэж... /минут дуусав/

Н.Учрал: Нэмэлт 1 минут өгье.

С.Бямбацогт: Дэмжлэг үзүүлээрэй. Хамтраад Монгол Улс, Монголын ард түмэн, Монгол Улсын Их Хурал, Засгийн газар нэг талдаа шүү гэдэг нэг л байр суурьтай байцгаая. Ямар нэг өөр байр суурь гаргахгүй. Энэ 53 хувийнхаа үр өгөөжийг л Монголын ард түмэн хүртэхийн төлөө л хамтраад ажиллацгаая.

Энэ тал дээр Засгийн газрын хэлцэл хийхэд энэ тогтоол нэлээн дэм өгсөн, ташуур өгсөн тогтоол боллоо гэж харж байгаа.

Тийм болохоор Засгийн газрын хэлэлцээр ч гэсэн амжилттай үргэлжлэхэд энэ тогтоол маань үр дүнгээ өгнө байх гэж бодож байна.

Түр хорооныхоо гишүүддээ, ажилласан шинжээч нартаа, түр хорооны даргадаа баярлалаа. Тэгээд нэгдмэл байр суурьтай байж нэг зүгт харж хамтарч бодлогоо нэгтгэж чадсан Та бүхэнтэйгээ хамтарч ажиллана. Баярлалаа Та бүхэндээ.

Н.Учрал: С.Бямбацогт гишүүн санал хэллээ.

Өнгөрсөн хугацаанд Хянан шалгах түр хороо сайн ажилласныг гишүүд хэлж байна.

Хянан шалгах түр хорооны бүрэлдэхүүнд шинжээчээр ажилласан, хянан шалгагчаар ажилласан ажлын хэсгийн гишүүдэд талархал илэрхийлье. /алга ташив/

Та бүхний ажилласан цаг хугацааны ажлын үр дүн, мэдээ мэдээллүүд нэгтгэгдээд түүх болж архивт хадгалагдана. О.Батнайрамдал даргатай Түр хорооны эрхэм гишүүдэд талархал илэрхийлье.

Хянан шалгах түр хорооны санал, дүгнэлт болон Улсын Их Хурлын тогтоолын төсөлтэй холбогдуулан гишүүд асуулт асууж, үг хэлж дууслаа. /алх цохив/

Санал хураалтыг өмнөх хоёр асуудалтай холбогдуулаад маргааш өглөөний 10.00 цагт хураана.

Өнөөдрийн нэгдсэн чуулганаар хэлэлцэх асуудал өндөрлөж байна. Маргаашийн чуулганы эхэнд санал хураалтаар үргэлжилнэ гэсэн үг.

Тэгэхээр ажлын хэсгийн гишүүдийг мөн маргааш өглөө 10.00 цагт урьж байна. Санал хураалт үргэлжилнэ.

Улсын Их Хурлын 2025 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн нэгдсэн чуулганы хуралдаан өндөрлөснийг мэдэгдье. /алх цохив/

Хуралдаан 9 цаг 11 минут үргэлжилж, 20 цаг 24 минутад өндөрлөв.

**БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ
БУУЛГАЖ, ХЯНАСАН:
ШИНЖЭЭЧ**

Ц.АЛТАН-ОД